

## ЭХЛЭЛ

Тэр жил зун орой тосгонд байхад минь, бидний суудаг байшингаас гол, голын цаадтайх тэгш тал, алсын уулс харагдаж, голын сайр хайрга дайргаар дүүрээд, наранд цайран хуурай дааж, устай газраа түргэн урсгалтай, тунгалаг, цэв цэнхэр байлаа. Байшингийн дэргэдүүрх замаар цувж байгаа цэргийн хөлөөр боссон тоос модны навчсыг хучна. Модны иш аанай л тоосонд дарагдан, тэр жил навчис эрт унаж эхэлсэн бөгөөд замаар цэрэг явах, тоос манарах, салхинд үлээгдсэн навчис унахыг бид ажиглан, цэргүүд алхалж өнгөрөхөд хувхай цагаан навчис л зам дээр үлддэгсэн.

Голын цаадтайх тэгш тал үржилт хөрстэй учир жимсний цэцэрлэг ихтэй, түүний цаадтайх нүцгэн бараан ууланд тулалдаан болж, шөнийн цагт тэсрэлтийн гэрэл үзэгдэж, цахилгаан цахих шиг болдог байсансан. Шөнөдөө сэрүүхэн авч хур буух шинж огт үгүй.

Харанхуй болохоор маай цонхон доогуур зэвсэг тээсэн машин, цэргүүд өнгөрөх нь үргэлж сонсогдоно. Шөнийн цагт замын хөдөлгөөн ихдээд янгирцаг тохож, цэргийн нөөцтэй хайрцаг тэгнэсэн луус бөөн бөөнөөр цувж, цэрэг ачсан саарал машүйн явах агаад берзентэн бүтээлгэтэй ачаа ачсан машин тун удаан хөдөлнө. Өдөр ч гэсэн хүнд зэвсэг ачсан чиргүүлтэй машин явахдаа урт зэвсгээ ногоон мөчрөөр хучаад, машины дээгүүр өтгөн ногоон мөчир, усан үзмийн нахиа тавиастай байна. Биднээс умар зүг орших хөндийн цаадтай туулайн бөөр модны төгөл, бүр цаана нь голын наад эрэгт нэгэн том уул байна. Тэр уулыг мөн эзлэх гэж тэмцсэн боловч амжилт олсонгүй. Намар болж, бороо цутгаад туулайн бөөр модны хамаг навч хийсэж, мөчир нь хувхайрахн, иш нь бороонд харлана. Усан үзмийн мод бас л навчаа гүвэн нүцгэрч, эргэн тойрон харих цагийн жамаар мөхсөн, норсон, бараан үзэгдэнэ. Голын дээгүүр манан хөшилдөөд, уулын оройг үүлс ороон, ачааны машин зам дээр шавхай үсэргэн, шавар шавхай болж норсон цувтай цэргүүд нойтон буутай явах бөгөөд сумны хоёр ширэн цүнх, бүсэндээ зүүсэн, 6, 5 миллиметрийн сумны нарийхан хүнд гэртэй саарал ширэн цүнх урдтай нь цуваан дор нь түнтэгнэн, замаар явж буй тэр цэргүүд зургаан сартай жирэмсэн эмэгтэй шиг ажээ.

Жолоочийн дэргэд ар талд нь хэдэн офицер суусан нэг суудлын жижигхэн саарал тэрэг тун хурдан дамхилдана. Тийм машин нь ачааны машинаас илүү шавхай үсэргэдэг бөгөөд хэрвээ атигар намхан офицер яваа бол ар талд нь хоёр генералын хооронд сууж, халхлагдаад нүүр нь харагдахгүй, зөвхөн малгайн орой, нарийнхан нуруу л цухуйна. Хэрвээ тийм машин онцгой хурдтай өнгөрвөл ван хаан явж байж таарна. Удинд ван хаан суудаг агаад бараг өдөр бүр энэ замаар явж, ажил байдлыг хардаг билээ. Ажил байдал нь тун ахицгүй байлаа.

Өвөл дөхөхөөр бүр ч их бороо цутгаад, бороотой хамт урвах тахал гарсан боловч тараалгүй дарж, тахал өвчнөөр нийтдээ долоон мянгахан цэрэг үхжээ.

[Тор](#)

---

Хойтон нь бид олонтаа ялав. Хөндийн нөгөө талын уул, туулайн бөөр модны төгөл ургасан цохиог эзэлсэн болон тэгш талаас өмнө зүгт орших дэнж дээр мөн ялж дийлээд наймдугаар сард гол гатлан, Горицид байрлав. Бидний байрласан

байшингийн хананд улаан өнгийн мөхдөг ургамал асаж өндөр хашаатай цэцэрлэгт нь усан оргилууртай саглагар өтгөн мод элбэгтэй ажээ. Бидний хойгуур гол урсана. Хотыг хялбархан эзэлсэн атал, уулсыг авч дийлсэнгүй. Дайн дуусвал хэзээ нэгэн цагт хотдоо эгэж ирэхийг бодож Австричууд хотыг нураахын тулд бус, журам зохицуулахын тулд өнгөц бөмбөгдсөнд би тун баярлаж билээ. Хотын оршин суугчид хотдоо үлдэж, цэргийн эмнэлэг, кофе гуанзтайн дээр гудамжны булан их буу зоож, нэг нь офицеруудад, нөгөө нь цэрэгт зориулсан хоёр яанхны газартай байв. Зун өнгөрөхийн үес шөнөдөө сэрүүн ороод ойрын ууланд болж буй тулалдаан, бөмбөгөнд хумигдсан гүүрийн төмөр, дайн болж өнгөрсөн голын дэргэдэх эвдэрсэн мэлхий хаалга, талбай тойрсон мод болон талбай орох замын хоёр талаар эгнэсэн мод, түүнчлэн хотод үлдсэн хүүхнүүд, мөн саарал машинаараа дэргэдүүр өнгөрөх ван хааны нүүр, ямааны сахал шиг шодон буурал сахал урт хүзүүтэй бяцхан биеийг эдүгээ сайтах харж болох бөгөөд бөмбөгөнд хана нь нурж гэнэтэд нүцгэрсэн байшингийн дотор тал, шавардлага, цэцэрлэг болон гудамж бүрийд шахуу тогтсон сайр, бас Карсод ажи үйлс сайн яваа зэргээс энэ намар, ноднин бидний тосгонд байсан намраас онцгой ялгарч байлаа. Дайн ч бас өөр болжээ.

Хотын цаад уулын царсан ой сөнөжээ. Биднийг зун хотод ирэх үес тэр ой нов ногоон байсан бол эдүгээ салмарсан иш, хожуул үлдээд, хамагш газар нь урваж, нэгэнтээ намрын сүүлчээр, царсан ой байсан тэр газар уулын чанадаас үүлс гарахыг би харав. Тэр үүлс тун хурдан нүүж нар бүдгэрэн шарлаад, тэнгэр бүрхэн хамаг юм бүүдийн, уул бүрхсэн үүлс төдхөн зуур биднийг нбөмрөн ирж цас орж эхлэв. Салхинд цас ташин орж, нүцгэн газрыг бүрхэн, модны хожуул л цухуйх бөгөөд буу зэвсгийг цас дараад, шуудууны цаадтайх жорлон хүртэл цасан дээгүүр зөрөг зурайна.

Орой нь би хот орж, офицеруудад зориулсан яанхны байшингийн цонхны дэргэд нэг лонх асти хэмээх дарс, хоёр хундага тавьж танилтайгаа ярьж суулаа. Цонхны цаадтай цас лавсан хаялахыг ажиглаад энэ жил ингээд дуусчээ гэж бодогдоно. Глын эхээрх уулсыг авч чадаагүй, голын цаадтайгаас нэг ч уул эзлээгүй учир тэр бүгд ирэх оны ажил болж үлдлээ. Манай хорооы лав, гудамжны шавхай дундуур болгоомжлон алхахыг миний танил хараад анхаарлы нь татах гэж цонхны шил тогшив. Сайхь лам толгойгоо дээш болгож бидний хараад инээвхийлэв. Миний найз хуруугаар даллахад тэр лам толгой сэгсрээд өнгөрч одлоо. Үдэш нь офицеруудын гуанзанд хооллоход хүн бүгд дуугаа хурааж мянтууз яаран идэхдээ, сэрээдэж өргөөд үзүүрийг нь унжуулан үнхэх буюу сэрээдэж өргөнгүүт завсар зайгүй хөхөх бөгөөд дараа нь лангууны төмөр хашлаганаас зүүлттэй сүлжмэл ташмагийн амыг долоовор хуруугаар дарж тонгойлгон, мөн тэр гараараа барьсан аяганд тунгалаг улаан өнгөтэй, исгэлэн үнэртэй аятайхан дарс гоожуулан хийж ууна. Мянтууз идэж дууссаны эцэст сайхь ламыг ахмад өдөж эхлэв.

Тэр лам залуу тул, ичингүйрэн улайх бөгөөд бид бүгдийн адил хувцас өмсдөгийн гадна цэрэг саарал цамцны зүүн энгэрийн халаасны дээд талд хүрэн хилэн загалмай зүүсэн байна.

Ахмад надтай италиар зориуд муухан ярина. Тэгэж л яривал намайг үг гээхгүй ойлгоно гэж тэр бодсон бололтой.

-Ламбугай өнөөдөр нэг охинтой... гэж ахмад хэлээд, лам бид хоёрыг ээлжлэн ажив. Лам инээснээ, царай нь улайж, толгой сэгсрэв. Ахмад тэгэх тусам нь үгээр хатгаж

-Тэгээгүй гэж үү? Өнөөдөр ламбугай тэр охиныд очих уу? гэж ахмад асуув.

-Үгүй гэж лам хэллээ. Бус ад офицерууд ахмадын тийнхүү үгээр хатгахад баясана.

-Ламд охин хэрэггүй гэж ахмад ярьснаа

-Ламд охин хэзээ ч хэрэггүй гэж надад тайлбарлав. Тэгээд тэр миний аягыг

авч, нүд рүү минь үргэлж ширтэн дарс дүүргэхдээ ламыг бас хараанаасаа алдсангүй.

-Лам шөнө болгон ганцаараа унтдаг юм гэхэд бүгд инээлдэж ахмад гараа занган

-Чи ойлгов уу? Лам шөнө болгон ганцаараа унтдаг юм гэж чанга хөхрөв.

Лам түүнийг тоглоом болгон ойлгож байлаа

-Лам ах, дайнд австричууд ялаасай гэж боддог юм. Франц-Иосифт ламтан хайртай. Тэгээд ч Австричуудаас мөнгө авдаг юм. Би шашингүй хүн гэж хошууч хэлэв.

-Чи “Хар гахай” гэдэг ном уншсан уу? гэж дэслэгч асуугаад

-Би чамд олж өгье. Миний итгэлийг хазайлгасан номдоо гэв.

-Тэр бүдүүлэг муухай ном, Тийм номыг та үнэхээр сонирхоогүй байхаа хэмээн лам өгүүлэв.

-Тун хэрэгтэй ном. Лам нарын тухай тэнд бүрэн бий гээд дэслэгч надад хандан:

-Чамд таалагдана гэж хэлэв.

Намайг лам руу харж инээхэд, тэрбээр лааны гэрлийн цаанаас хариу мишээн:

-Битгий тэрнийг уншаарай гэв

-Би чамд олж өгнө гэж дэслэгч хэлэв.

-Сэтгэдэг хүн бүр шашингүйд орно. Гэхдээ би Масоны<sup>1</sup> эвлэлийг үнэлдэггүй гэж хошууч хэлэв.

-Би Масоны эвлэлийг үнэлдэг. Тэр чинь тустай байгууллага гэж дэслэгч хэлэв. Нэг хүн орж ирэхэд, үүдээр цас орж байгаа харагдав.

-Цас унасан болохоор одоо давшихгүй байх гэж хэлэв.

-Тэгэлгүй яахав. Одоо чөлөө авч, Ром, Неаполь, Сифиль... ормоор юм гэж хошууч хэлэв.

-Амальфи яваг л дээ. Амальфид манайхан бий, танаар захиа явуулъя. Тэд таныг хүү шигээ л угтана гэж дэслэгч хэлэв.

-Палермод яваг л дээ.

-Капр очвол бүр ч сайн.

-Та Абруцца очиж Капракоттад байгаа манайханд зочилбол сайнсан гэж лам хэлэв.

-Абруцца рочвол энүүнд тус сайн. Тэнд эндээс илүү цастай. Ямар энд тариачинд дурлаж суултай биш. Соёл, иргэншлийн төвд очиг.

-Сайхан хүүхэнтэй газар оч. Би чамд Наполийн хаяг өгнө. Эхтайгээ суудаг гайхалтай залуу хүүхнүүд бий. Ха, ха, ха!

Ахмад алгаа дэлгэн эрхийгээ гозойлгоод хуруугаа атгаж хятад сүүдэр үзүүлэхэд бэлтгэв. Ханан дээр ахмадын гарын сүүдэр гарав. Тэр италиар дахин эв хавгүй ярьсан нь:

-Та ийм явна гэж эрхийгээ заагаад –Харин тийм болж ирнэ гэж чигчийгээ хөдөлгөхөд цөм инээлдэв.

-Хараарай гээд ахмад, дахин хуруугаа атгахад, лааны гэрэлд гарын нь сүүдэр ханан дээ дахин тусав. Тэрбээр эрхийнээсээ эхлээд таван хуруугаараа дараалан нэрлэж эрхий хуруу, /бага дэслэгч долоовор хуруу /дэслэгч/ дунд хуруу /ахмад/, ядам хуруу /хошууч/ чигчий хуруу /дэд хурандаа/ гээд, та эрхий хуруу шиг /бага дэслэгч яваа чигчий хуруу шиг /дэд хурандаа/ болж ирнэ гэв.

Бүгд инээлдэн, тэр ахмад хятад сүүдэр үзүүлсэн нь их амжилт олов. Тэр ламыг харснаа

---

<sup>1</sup> XIII зууны 1-д үссэн шашин-гйн ухааны нэгэн урсгалын нэр (орчуулагч)

- Лам шөнө болгон ганцаараа унтидаг гэж хашгирахад цөм инээлээ.
- Даруйхан амралтаар яв гэж хошууч хэлэв.
- Би чамтай хамт явж, чамд юм үзүүлж чадахгүй нь харамсалтай байна гэж дэслэгч хэлэв.
- Буцаж ирэхдээ эгшигт хайрцаг авч ирээрэй.
- Дуурийн сайхан дуу авч ирээрэй...
- Карузог авч ирээрэй.
- Карузо хэрэггүй. Тэр ульдаг юм.
- Чи тэгж улиад үз л дээ!
- Тэр ульдаг юм. Ульдаг юм гэж би чамд хэлж байна шүү.
- Та Абруцца очвол сайнсан. Тэнд ан сайтай, хүмүүс нь сайн. Өнөө хүйтэн ч гэсэн хуурай цэлмэг манайханд байж болно. Миний эцэг анд их дуртай гэж лам хэлэв. Бусад нь шуугилдсаар байв.
- За явцгаая. Бид эртхэн дууч эмсийн газар очихгүй бол хаачихна гэж ахмад хэллээ.
- Сайхан унтаарай гэж би ламд хэлэв.
- Сайхан унтаарай гэж тэр хариулав.

[Тор](#)

---

Намайг чөлөөгөө дуусаад ирэхэд манайхан мөн тэр хотдоо байсан бөгөөд тэр орчин улам олон их буутай болоод хавар хэдүйн эхэлжээ. Тал ногоон болж, нахиа гөлөглөж, замын хажуугийн модноос бяцхан навчис цухуйн, тэнгисийн згээс салхи сэвэлзэнэ. Хот толгод, энгэр дээрх хуучин шилтгээн цаад талын бараан уулс энгэр газраа дөнгөж ногоорч буй уулыг би харав. Хотод зэвсэг ихтэй болоод хэд хэдэн шинэ цэргийн эмнэлэг нээж, гудамжинд англи хүн, ялангуяа англи хүүхэн олонтаа дайралдаж бас сум бөмбөгөнд хэдэн байшин гэмтсэн байна. Дулаан болж хаврын үнэр анхилна. Мод суулгасан гудамжаар явж өнгөрөхөд хананд туссан нарны гэрэлд дулаахан байв. Энэ хугацөөнд өөрчлөгдсөн ю м ер үгүй мэт манайхан нөгөө л байшиндаа сууж буйг би мэдэв. Хаалга нь онгорхой агаад наранд зэсэн цэрэг байшингийн дэргэдэх урт сандал дээр сууж, хажуу талын хаалганы дэргэд эмнэлгийн машин зогсож, үүдээр ормогц чулуун шал, эмнэлгийн үнэр амайг угтлаа. Хавар болсноос бус өөрчлөгдсөн юм ер үгүй. Том тасалгаанд шагайхад хошууч үзсэнгүй. Орж илтгэх үү, эсхүл эхлээд дээшээ гарч хувцсаа цэвэрлэх үү гэж би гайхлаа. Тэгээд би дээшээ гарахаар болов.

Дэслэгч Ринальди бид хоёрын суудаг тасалгааны хаалга хашаан дотроос ордог болой. Цонх нь онгорхой агаад миний орыг бүтээлгээр бүтээж, урт төмөр дугтуйтай хорт утааны баг, төмөр малгай зэрэг миний хогшил өнөө л хананы өлгүүрт хэвээрээ байлаа. Орны хөлд миний хайрцаг байна. Хайрцаг дээр гялалзтал тосолсон миний өвлийн гутал байна. Австри маягийн найман талт хар голтой, аялаг сайхан хүрэн самрын өнгө бүхий иштэй винтов буу минь орны хоронд өлгөөтэй байна. Бууныхаа дуранг хараад би хайрцагт хийж цоожилсноо санав. Дэслэгч Ринальди нөгөө орон дээр унтаж байв. Миний хөлийн чимээгээр сэрээд тэр дэрэн дээрээсээ өндийгөөд

-Giao<sup>2</sup> гэж хэлээд тэр-яаж амрав? гэлээ.

-Сайхаан!

Бид гар барилцан мэндлээд тэр миний хүзүүгээр тэврэн үнсэв.

-Ай! гэж би хэлэв.

-Чи муухай байна. Угаах хэрэгтэй.

Хаана байж, юу хийв? Цөмий нь шууд ярь гэж тэр хэллээ.

-Газар бүр очлоо. Милан, Флоренци, Ром, Неаполь, Вилла-Сан-Жованни, Мессин, Таорминд... байлаа.

-Төмөр замын лавлах болоо шив дээ. За тэгээд сонин тохиолдол болов уу?

-Болсоон

-Хаана?

-Mileno, firenze, Roma Napoli

-За, за, чухам хаана хамгийн сайхан байв?

-Миланд

-Анх очоод л тэр биз дээ. Нөгөө хүүхэнтэйгээ хаана уулзав? Ковад уу? Тэгээд хаана очсон бэ? Юу болсон бэ? Цөмий нь хэл! Шөнөөр хоноглососн уу?

-Тэгсээн

-Тэр ч яахав. Одоо манай энд сайхан хүүхнүүд бий. Фронтод анх ирсн шинэхэн хүүхнүүд

-Бас уу?

-Итгэхгүй байна уу? Өнөөдөр явъя, өөрөө үзээрэй. Хотод залуухан сайхан англи хүүхнүүд ирсэн. Би одо Баркли гэдэг хүүхэнд хайртай болсон. Би чамайг танилцуулна. Баркли хүүхэнтэй би лав суух байхаа.

-Би угааж цэвэрлээд даргад илтгэх ёстой. Одоо тжэгээд ажилгүй байгаа юм уу?

-Чамайг явснаас хойш бид, үзүүрээсээ хөлдөх, шарлах, хүйтэнтэх, санаатайгаар эрхтэнээ гэмтээх, уушигны ханиад, хатуу зөөлөн ярыг л мэддэг байлаа. Долоо хоногт нэг маань хадны хэлтэрхийд оногдож байна. Жинхэнэ шархадсан улс хэд бий. Ирэх долоо хоногоос дахин дайн эхэлнэ. Ёстой л дахиж эхэлнэ. Тэгж ярьж байгаа. Тэгээд дайны дараагаар би Баркли хүүхэнтэйгээ гэрлэвэл чамд ямар санагдаж байна?

-Бололгүй яахав гэж хэлээд би түмпэн дүүрэн ус хийв.

-Орой чи надад бүгдий нь яриарай. Би одоо унтлаа. Баркли хүүхэнтэй уулзахад сэргэлэн сайхан байлгүй болохгүй гэж Ринальди хэллээ.

Би гадуур дотуур цамцаа тайлаад түмпэндээ хүйтэн усаар биеэ угааж, алчуураар арчингаа цонхоор эргэн тойрноо харж, нүдээ анин хэвтэж буй Ринальдийг ажиг. Царайлаг агаад надтай үе чацуу, Амальфийд төрсөн, мэс заслын ажилдаа дуртай тэр бид хоёр сайн найз билээ.

Миний харж байгааг мэдээд, тэр нүдээ нээгээд

-Чи мөнгөтэй юу? гэв

-Бий гэсэн

-Надад тавин лир зээлээч гэлээ.

Би гараа арчаад хананд өлгөөтэй гадуур цамцныхаа дотор халааснаас янчаан гаргаж өгөхөд Ринальди хэвтсэн чигээр өмднийхөө халаасанд шургуулаад инээвхийлэв.

-Баркли хүүхэнд би хөрөнгөтэй хүний байдал үзүүлэх хэрэгтэй байн. Чи миний эрхэм найз бөгөөд эдийн засгийн байлдан дагуулагч гэхэд нь

---

\*Итали мэндчилгээ

-Битгий дэмийр гэж би хэлэв.

Орой нь би офицерүүдийн гуанзанд ламтай уулзаж Абруццад очиж чадаагүйгээ хэлсэнд лам ихэд гомдов. Миний тухай тэр лам эцэтээ бичсэн учир намайг очно гэж бэлдсэн байжээ.

Тэр тухайд би ламаас ч илүү харамсаж, яагаа очиж чадаагүй билээ гэж гайхан бодов. Уг нь би очих гэж их хүссэн боловч ажил явдал давхцаад болоогүйн учрыг тайлбарлахад тэр лам учрыг ойлгож итгэх хамаг хэрэг зохицов. Би зөндөөн их дарс уусны дараа кофе цай ууж согтоод хүний хийх гэсэн их юм эхлээд л бүтэхгүй бол яагаад хэзээ ч бүтдэггүй байна гэж шүүн ярилцлаа.

Лам бид хоёрын ярилцах зуур бусад маань марган шуугина. Би Абруццад очих байсан. Гэвч би, төмөр мэт хатуу гөлгөрх зантай, хүйтрэхдээ хуурай цэлмэг агаад туулайн зам татсан цас нь үйрмэг хуурай, ан сайтай тариачид нь малгай аван “Ноёнтон” гэж мэхийдэг тийм газар очсонгүй. Би тийм газар очоогүй мөртөө, шөнийн манарсан Кафе гуанзтай, тасалгаа эргэлдээд байгааг зогсоох гэж хана ширтэхээс өөр аргагүй согтох агаад орондоо согтуу унтахаас өөр мэдэх юмгүй, тэгээд хажуудаа хэн унтаж байгаа мэдэхгүй хачин сэрэх, орчлонгийн юмс хий үзэгдэл шиг санагдаад, жигтэй догдолж, хамаг юмыг ахин эхэлмээр ч болж, шөнөд нь бодох ч, мэдэх ч юмгүй, өөр юу үгүй мэт бодлогогүй хатуу итгэлд автдаг газар очжээ. Тэнд тэгээд гэнэт гүн бодолд орсноо нам унтаж, өглөөгүүр л сэрнэ. Өчигдрийн юм өнгөрч заримдаа өр төлөх тухай маргаан болж ер юм бүгд хурц, тод, нарийн аж. Өглөөний хоол, үдийн хоол гээд дахиад л аятай таатай юм эхэлнэ. Аятай таатай юм үгүй болж, гудамжинд яаран гарахдаа баярлана. Гэвч дараа өдөр, дараа шөнө нь хуучнаа л давтана. Шөнийн тухай, өдөр шөнийн ялгааны тухай зөвхөн өдөр л их хүйтэн тунгалаг байдаг эсэх яагаад шөнө нь илүү болохыг би ярих гэж оролдсон боловч мөн аанай чадсангүй. Хэрэв танд тийм явдал тохиолдсон бол та санаарай Тэр ламд тийм явдал тохиолдоогүй авч миний хэрхэн Абруццад очиж чадаагүй болон очих хүсэлтэй байсныг тэр ойлгосон юм. Тийнхүү бид үнэхээр өөр өөр боловч олон талаар адил нөхөлд хэвээр үлдлээ. Миний мэдээгүй юмыг тэр ямагт мэддэг бөгөөд мэдсэнээ мартаход ч бэлэн хүн билээ. Үүнийг би их л хожуу ухаарсан юм. Энэ завсар өгүүлэхэд бид гуанзанд суусаар л байлаа. Цөм хоол идэж гүйцээд зөвхөн маргалдана. Лам бид хоёыг дуугүй байтал, ахмад хашгиран:

-Лут уйджээ. Охидгүй бол лам уйдна гэв.

-Би уйдаагүй ээ гэж лам хэлэв

-Лам уйджээ. Лам, дайнд австричууд ялаасай гэж боддог юм гэж ахмад хэллээ.

Бусад нь чагнаж, лам толгой сэгсрэн:

-Үгүй гэв

-Биднийг бүү давшаасай гэж лам боддог юм.

Биднийг бүү давшаасай гэж та үнэхээр боддог уу?

-Үгүй. Дайтаж л байгаа хойно бид давших л ёстой гэж санагддаг.

-Давших ёстой бол давшина даа гэхэд лам толгой дохив

-Ламтанг битгий зовоо. Энэ сайн хүн шүү гэж хошууч хэлэв.

-Үнэндээ гэхэд лам яах ч үгүй шүү дээ гэж ахмад хэллээ. Тэгээд бид цөм босож гарав.

[Top](#)

Зэргэлдээ цэцэрлэгт байрласан батарей өглөөгүүр намайг сэрээж, цонхоор нар туссаныг хараад би орноос босов. Цонх руу очиж харахад зам дээр асгасан харга нойтон бөгөөд шүүдэртсэн өвч налмайна. Батарей хоёр удаа буудахад дэлбэрэх адил агаар доргиж цонх дэржигнэн хувцасны минь хормой чичрэгнэв. Буу нь үл үзэгдэх бловч сум нь л бидний толгой дээгүүр ниснэ. Батарей ойр байна гэж бодоход эвгүй боловч тийм ч хүн зэвсэг биш ээ хэмээн сэтгэлээ амраана. Цонхоор шагайх зуур би замаар гарч буй ачааны машины нүргээн сонсов. Тэгээд хувцаслаад доош буун гал зууханд очиж кофе цай уугаад гараашид орлоо.

Урт саравчин доор арван машин эгнэн зогсоно. Эмнэлгийн тэр машинууд мөлгөр хошуутай, модон пин шиг агаад саарал будагтай том тэвштэй аж. Хашаан дотор, мөн тийм нэг машины дэргэд механикчид ажиллана. Бас гурван машин уулан дахь эмнэлгийн салбарт буй.

-Энэ батарей дайсанд ил үү? гэж би нэгэн механикчаас асуулаа.

-Үгүй ээ, Signor tenente<sup>1</sup> Толгойд халхлагдаж байгаа юм гэв.

-Ажил амжиж байна уу? гэсэн

-Зүгээр! Энэ машин л яах ч нөхцөлгүй юм.

Бусды нь засаж болно гээд тэр ажлаа түр орхиж инээмсэглээд” Та чөлөөгөөр явсан уу? гэв.

-Тэгсэн гэхэд тэр цамцандаа гараа арчсанаа инээвхийлж:

-Сайхан байв уу? гэсэн нөхөд нь мөн инээвхийлэв.

-Зүгээр гэж хэлээд би-Энэ машин яагаав? Гэж асуулаа

-Яах ч нөхцөлгүй, юм бүгд нь муу юм гэв.

-Одоо юу нь дутаж байна? гэхэд

-Поршенгийн бүсийг солих хэрэгтэй гэлээ.

Моторы нь сөхөж хамаг юмы нь гишгүүр дээр нь гаргаж өрөө тонуулж муудсан мэт болсон тэр машины дэргэд тэднийг орхиж саравчинд орж бүх машиныг би нэгд нэггүй үзэхэд зарим ы нь саяхан угаасан зарим нь үл мэдэг тоос бүрхэж ер л цэвэрхэн байв. Дугуй нь чулуунд зурагдаж зүсэгдсэн эсэхийг би сайтар харлаа. Хамаг юм ёсоороо байх шиг байна. Миний шалгасан шалгаагүй адил ажээ. Машины байдал болон уулан дахь эмнэлгийн салбараас шархтай өвчтэй хүмүүсийг тасралтгүй, зөөж, төв салбарт авчран тогтоол ёсоор цэргийн эмнэлгүүдэд хүргэх нь ихэвчлэн надаас шалтгаалах мэт санагдав. Чухам үнэндээ гэхэд миний байсан байгаагүй адил аж.

-Сэлбэг дутагдаж байв уу? гэж би ахлах механикчаас асуув.

-Үгүй гэв

-Шатахууны агуулах одоо хаана байгаа вэ? гэхэд<sup>3</sup>

-Хуучиндаа гэлээ.

-Сайн байна гэж хэлээд би байрандаа ирж офицеруудын гуанзанд дахин нэг аяга кофе цай уулаа. Өтгөн сүүгээр сүлсэн тул кофе цай амтлаг агаад цагаан саарал өнгөтэй байв. Гадаа хаврын сайхан өглөө болж, өдөр нь халуу шатахын тэмдэг орон хамар хатна. Тэр өдөр би уулан дахь харуулуудаар яваад үдшээс өмнөхөн хотод буцаж ирлээ.

Намайг явсан хойгуур ажил хэрэг цэгцрээд удхгүй давшилтад бэлтгэн хөдлөх гэж буйг би сонсов. Бидний ажилладаг дивиз голын эхээр давшиж дайрах бөгөөд тэр үед би харуулуудыг хариуцах болсон тухай надад хошууч хэлэв. Давших ангиуд хавцлаас дээгүүр гол гарч

---

<sup>1</sup>ноён дэслэгч гэсэн итали йг

уулын бэлээр гарах ажээ. Машины харуулын байрыг аль болохоор голд ойр сонгон дадалдсан байх хэрэгтэйн гадна, тэр байрыг явган цэрэг олох ёстой бөгөөд төлөвлөгөөг бид боловсруулах болжээ. Энэ бол дайны үйл ажиллагааны илбэ болсон нөхцлийн нэг юм.

Хамаг тоос, шавар шавхайгаа угаахаар би тасалгаандаа ороход Ринальди орон дээрээ, Хюгогийн зохиосон Англи хэлний сурах бичиг үзээд сууж байв. Тэрбээр хар шаахай өмсөж бүрэн хувцасласан агаад үс нь гялалзана. Намайг харангуут тэр:

-Яасан сайн юм бэ. Чи надтай Баркли хүүхнийд очно уу гэв

-Үгүй

-За чи надтай яв л даа, чи ч тэр хүүхэнд аятайхан санагдаж болно

-За, за: Би хувцас хунараа янзлаатахъя

-Цэвэрлэж аваад явъя

Би нүүр гараа угааж, үсээ самнаж явахад бэлтгэв.

-Жаахан хүлээ. Юм уувал яахав гэж хэлээд Ринальди хайрцгаа онгойлгож лонх архи гаргахад

-Стрега хэмээх архи бол хэрэггүй гэж би хэлэв

-Бишээ. Граппа гэв

-Болно гэж зөвшөөрөв.

Тэр хоёр аяганд аягалж, бид тулган уув. Граппа хэмээх тэр архи их хатуу байлаа.

-Дахиад нэг нэг уух уу? гэхэд нь

-Тэгье гэж би хэлэв. Хоёр дахь аяга архиа уугаад Ринальди лонхоо далд хийж гадаа гарав. Хот дундуур явахад халуун боловч нар шингээд таатай балаа. Дайны өмнө нэгэн германы барьсан зуслангийн том байшинд английн цэргийн эмэлэг байдаг бав. Баркли хүүхэн цэцэрлэгт бас нэгэн сувилагчтай байхыг бид модны цаанаас харж, эмнэлгийн цагаан хувцастай тэдний зүг шууд очив. Ринальди мэндлэв. Би арай даруухнаар мөн мэндлэв.

-Сайн байна уу? гээд Баркли хүүхэн та Итали хүн биш биз? гэж асуув

-Бишээ гэв.

Ринальди нөгөө сувилагчтай ярьж инээлдэнэ.

-Тэгээд Италийн армид байдаг хачин юм даа.

-Энэ чинь арми биш шүү дээ. Зүгээр л нэг эмнэлгийн отряд.

-Гэлээ ч гэсэн хачин юм. Та яагаад эн ирсэн юм бэ?

-Сэдэхгүй байна. Тайлбарлаж болохгүй зүйл ч байдаг шүү дээ гэж би хэлэв.

-Тийм үү? Харин тийм зүйл байдаггүй гэж надад сургадаг.

-Таатай л байна.

-Бид ингэж ярьж уулзах ёстой юу?

-Үгүй гэж би хэлэв.

-Бурхан өршөө!

-Энэ чинь юун таяг вэ? гэж би асуув

Баркли хүүхэн нилээд өндөр биетэй, бор нүдтэй, гөлгөр цагаан арьстай юм. Цагаан хувцсы нь хараад би энэрэлт асрагчийн хувцас гэж саналаа. Тэр хүүхэн надад их сайхан санагдав. Тэр хүүхэн, тоглоомын ташуур мэт нарийхан ал модон таяг барина.

-Энэ, ноднин алагдсан нэг офицерын юм.

-Уучлаарай...

-Тун сайн хүн байсан юм. Би тэр хүнтэй суух ёстой байсан юм. Гэтэл Саммад алагдчихсан юм.

-Тэнд ёстой ярганы газар байсан юм.



-Та тэнд байсан уу?  
 -Үгүй  
 -Энд дайн тиймгүй байна гэж хүмүүс надад ярьсан. Энэ таягийг эх нь надад бусад юмтай нь ирүүлсэн юм гэж тэр хүүхэн хэлэв  
 -Та хоёр удаан үерхсэн үү?  
 -Найман жил. Бид хамт өссөн юм.  
 -Та яагаад түүнтэй суугаагүй юм бэ?  
 -Өөрөө ч мээдхгүй байна. Дэндүү тэнэг юм. Сууж ч болох л байсан. Гэхдээ суувал тэрүүнд муу болно гэж би бодсон юм гэж тэр хэлэхэд нь би  
 -Ойлголоо гэлээ.  
 -Та дурлаж явсан уу? гэж асуув  
 -Үгүй гэж би хэллээ.  
 Бид хоёр урт сандал дээр суув. Би тэр хүүхнийг хараад  
 -Та их сайхан үстэй юмаа гэж хэлэв  
 -Танд аятайхан харагдаж байна уу?  
 -Тун аятайхан байна.  
 -Тэ хүнийг нас барахад би үсээ тайръя гэж бодсон юм.  
 -Яаж болох вэ!  
 -Би тэр хүнд ямар нэг юм зориулъя гэж бодсон юм. Тийм юмыг ч би юм гэж боддоггүй шүү. Тэр хүн юу л хүсвэл, цөм л биелэх байсан юм. Тэрний юу хүссэнийг л би мэдвэл тэр бүгд нь биелэх байсан. Би тэрүүнтэй сууж ч болно, байж ч болно. Би одоо тр бүгдийг сайн мэдэж байна. Гэхдээ тэгэхэд тэр дайнд явсан. Яах гэж явсны нь би ер ойлгоогүй гэж ярихад нь би дуугүй л байв.  
 -Би тэгэхэд нь ер нь юу ч ойлгоогүй. Дайнд яваад муу л юм болно доо гэж би бодсон. Дайны хүндийг тэр даахгүй ч байж мэднэ гэж би бодсон. Тэгтэл түүнийг маань алжээ. Ингээд л бүх юм өнгөрлөө.  
 -Яаж мэдэх вэ дээ  
 -Тиймээ, тийм. Ингээд л бүх юм өнгөрлөө гэж тэр хүүхэн хэлэв  
 Нөгөө сувилагчтай ярьж буй Ринальдийн зүг бид эргэж харав  
 -Энэ хүүхнийг хэн гэдэг юм бэ?  
 -Фергюсон. Эллен Фергюсон гэдэг юм. Таны найз чинь эмч үү?  
 -Тиймээ. Тун сайн эмч шүү.  
 -Сайн байна. Фронтын шугаманд сайн эмч цөөхөн дайралддаг шүү. Энэ чинь фронтын шугам мөн биз дээ?  
 -Тэгэлгүй яахав  
 -Дэмий фронт. Гэхдээ энд тун сайхан байна. Давших юм гэв үү? гэж тэр хүүхэн асуув  
 -Тиймээ.  
 -Тэгвэл бид ажилтай болно доо ямар ч ажил алга.  
 -Та сувилагч болоод удсан уу?  
 -Арван таван оны сүүлчээс. Би тэрнээ явахаар л явсан. Миний ажилладаг цэргийн эмнэлэгт тэрнийг ирнэ гэж би дэндүү тэнэг юм бодож явжээ. Сэлэмдүүлж шархдаад толгой нь бололтой юмуу мөрөөрөө буудуулсан ирнэ гэж романтик юм бодож байжээ.  
 -Энд хамгийн романтик фронт байна гэж би хэлэв  
 -Тиймээ. Францын дайн гэдгийг хүмүүс төсөөлөхгүй байна.Хэрвээ хүмүүс төсөөлбөл дайн зогсох болно. Тэр маань сэлэмдүүлж шархадсангүй. Хэдэн хэсэг тасчуулжээ гэж тэр хүүхэн хэлэв  
 Би дуугүй л байлаа.  
 -Үргэлж л ийм бана гэж та бодож байна уу?

-Үгүй  
 -Тэгээд юу болх вэ?  
 -Аль нэг газраараа зад тавина.  
 -Бид задална. Би францад задална.  
 Соммад болсон хэрэг шиг, зад тавихгүй тийм зүйл байж ер болохгүй.  
 -Энд задрахгүй гэж би хэлэв.  
 -Та тэгэж бодож байна уу?  
 -Тиймээ. Ноднин зун хамаг юм их сайн болсон  
 -Задарч ч мэднэ. Хаана ч задарч мэднэ гэж тэр хэлэв.  
 -Германд ч бас магадгүй.  
 -Үгүй байх гэж би бодож байна гэж тэр хүүхэн хэллээ.  
 Тэгээд бид Ринальди Фергюсон хүүхэн хоёрын дэргэд очив  
 -Та италид дуртай юу? гэж Фергюсен хүүхээс Ринальди англиар асуув.  
 -Энд муугүй  
 -Бүү мэд гэж Рианльди толгой сэгсрэв  
 -Abbastanza bene<sup>4</sup> гэж намайг орчуулахад тэр мөн толгой сэгсрэв.  
 -Муу байна. Та Англид дуртай юу?  
 -Онцгүй. Би шотлонд хүүхэн шүү дээ гэхэд нь Ринальди асуусан янзтай намайг харав.  
 -Энэ шотланд хүүхэн болохоор Англиас илүү шотландад дуртай гэнэ гэж би италиар хэлэв.  
 -Шотланд гэдэг минь Англи шүү дээ.. гэсэн  
 Ринальдийн үгийг би Фергюсон хүүхэнд орчуулав  
 -Pas encore<sup>5</sup> гэж Фергюсон хүүхэн хэлэв  
 -Тиймгүй гэнээ?  
 -Хэзээ ч тиймгүй. Бид Англи хүнд дургүй.  
 -Англи хүнд дургүй гэнээ? Баркли хүүхэнд дургүй юу?  
 -Энэ чинь өөр хэрэг. Ингэж махчилан ойлгож болохгүй.  
 Хэсэг зуур байгаад бид салж одов.  
 Харих замдаа Ринальди хэлсэн нь.  
 -Чи Баркли хүүхэнд надаас илүү таалагдлаа. Өдөр шиг ил байна. Тэр нөгөө Шотланд хүүхэн бас л их аятай хүүхэн дээ.  
 -Үнэхээр гэж би хэлээд-Би тэр хүүхнийг сайн ажигласангүй. Чамд таалагдаж байнуу гэв  
 -Үгүй гэж Ринальди хариулав.

[Тор](#)

---

Маргааш нь би Баркли хүүхнийд дахин очив. Тэр хүүхэн цэцэрлэгт байгаагүй учир би эргэж эмнэлгийн машин ирдэг хажуу хаалгаар ороход цэргийн эмнэлгийн ахлах сувилагч тааралдан, Баркли хүүхэн жижүүрлэж байгаа гэж хэлээд  
 -Дайн гэдгийг мэднэ биз дээ гэхэд нь би мэднэ гэж хэллээ.

---

<sup>11</sup> муугий гэсэн итали йг.

<sup>22</sup> тиймгий гэсэн франц йг

-Та италийн армид байгаа америк хүн үү гэж тэр хүүхэн асуув

-Тиймээ

-Яагаад тэр вэ? Та тэгвэл манайд ирэхгүй яасан юм бэ?

Би өөрөө ч мэдэхгүй байна. Одоо би танайд ирж болох уу? гэж би асуув

-Одоо болохгүй биз. Та яагаад италийн армид орсноо яриач?

-Би италид байсан. Италиар ярьдаг гэж тэр хэлэв.

-Ээ, Би итали хэл сурч байгаа. Тун сайхан хэл шүү дээ гэж тэр хүүхэн хэллээ.

-Хоёр долоо хоногт сурч болно гэдэг юм.

-Үгүй ээ, би хоёр долоо хоногт сурахгүй. Би хэдэнсар оролдож байна. Та тэр хүүхэнтэй уулъя гэвэл долоон цагаас хойш ирээрэй. Тэгэхэд ээлж солигдоно. Харин янз бүрийн итали хүн бүү дагуулж ирээрэй.

-Хэлний сайхан нь хамаагүй юу?

-Тийм, Сайхан цол мундир ч хамаагүй

-Баяртай гэж би хэлэв

-A rivederci, tenete<sup>6</sup> гэхэд нь

-A rivederli гэж би хариу талархаад гарав. Италийнхан шиг, төвөггүйгээр гадаадынханд талархал илэрхийлэхэд бэрх аж. Үүгээр үзэхэд талархал илэрхийлэх Итали аргыг гадаадад худалдаалах бололцоогүй юм.

Халуун өдөр болов. Өглөөгүүр би голын эхээр яваад Плав дахь гүүрийн өмнөх бэхлэлтэд очив. Тэндээс давшилт эхлэх ёстой байлаа. Ноднин тэр эргийн дагуу бараг бүтэн миль газар пулемёт болон их бууны галанд ил байсан тул явах аргагүй гагцхүү даваанаас хөвдөг гүүр хүрэх л ганц замтай байсан юм. Түүнээс гадна, давшилтад хэрэгтэй бүх хөсөг унаа тэр нарийнхан эрэгт багтахгүй байсны дээр Австричууд ёстой нэг ярганы газар болгож болох байв. Гэвч Италичууд гол гаталж, голын хоёр эргээр ахин, улмаар австрийн голын эрэгт бүтэн хагас миль зурвас газар эзлэв. Энэ нь аюултай газар боловч Австричуудад бэхжих болоцоо өгөхгүй байлаа. Түүнээс гадна голын адгаар буй гүүрийн өмнөх бэхлэлт австричуудын гарт хэвээр учир хоёр тал харилцан тэсвэрлэж байна гэж би бодно. Австрийн окопууд, италийн байралаж буй газраас хэдхэн ярдын зайтай доор, уулын хажууд байв. Урьд нь тэр эрэг дээр бяцхан суурин байсныг зомгол болтол нь сүйтгэжээ. Түүнээс цаахан төмөр замын өртөөний нурсан балгас, эвдэрхий гүүр байв. Тэр гүүр хамгийн их газар байсан тул засаж хэрэглэх аргагүй аж.

Би нэгэн зөргөөр гол уруудан, толгойн хормой дахь эмнэлгийн салбарт машинаа орхио уулын хошуугаар халхлагдсан хөвдөг гүүрээр гарч эвдэрхий суурин болон уулын хажуугийн окопыг дамжин явахад цэргүүд цөм газар зооринд байв. Тэнд би, их бууны галын хүч нэмэгдүүлэх буюу холбоо тасрахад дохио өгөхөөр бэлдсэн угсармал пуужин үзэв. Намуухан, дулаахан, гагацхүү шавхайтай л байлаа. Төмөр торны завсраар би Австрийн галыг харсан боловч хүн харагдсангүй. Би нэгэн танил ахмадтай газар зооринд архи уугаад гүүрээр гарч буцав.

Уул давсан гүүр рүү буусан энхил тонхил замыг өргөтгөн засаж байлаа. Огцом эргэн ой дундуур явсан тэр замыг засаж дуусмагц давшилт эхлэх ёстой байв. Хоосон машин тээш, шархтан ачсан эмнэлгийн машин, буцах бүр хөсөг хуучин зөрөг замаар явж байсныг өөрчилж, шинэ замаар явах төлөвлөгөөтэй байлаа. Австрийн талын эрэг дээрх толгойн хормодь эмэлгийн салбар байсан тул шархтангуудыг хөвдөг гүүрэн ээгүүр дамнуургаар зөөх ёстой байв. Довтолгооны дараа ч эл зарчмыг журамлах юм. Шинэ замын багахан хэсэг нь рсон сүүлчийн миль газрын налуугаар австрийн их буутай буудалцах ёстой гэж би бодно. Тэнд яаж ч мэдэх байв. Гэвч тэр

---

<sup>11</sup> баяртай дэслэгчээ гэсэн итали иг

эцсийн аюулт замыг өнгөрөн, хөвдөг гүүрээр шархтан авчиртал машин далдлах газрыг би оллоо. Би шинэ замаар явъя гэхэд зам арай л засаж дуусаагүй байлаа. Харьцуулж тохируулсан тэр өргөн замын тохой бүр нь уулын хажуугийн модны завсрын гэрэлд үзэсгэлэн төгс харагдах аж. Тоормос сайтай машин буухад хялбар ч гэсэн тэд доош буухдаа сул явдаг үү дээ. Би зөрөг замаар буцав

Буутай хоёр цагдаа машин зогсоолоо. Урдхан зам дээр сум дэлбэрэн, бидний зогсож байх зуур, дахин гурав дэлбэрэв.э 77 миллиметрийн тэр сум шүнгэнэн исгэрч сонсдоод агшин зуур дэлбэрч, гэрэл цацран, цайвар утаагаар зам бүрхэв. Буутай цагдаа бидэнд явах дохио өгөв. Дэлбэрсэн газартай зэрэгцэн очиж бяцхан нүх тойрон өнгөрөхөд тэсрэх боис, онгилогдсон чулуу шавар шороо шинэхэн тээрэмдсэн хайрганы үнэр үнэртэв. Би Горацид суудаг байшиндаа ирээд жижүүр хийж байсан Баркли хүүхэнтэй уулзахаар явснаа дээр өгүүлсэн билээ.

Би үдийн хоолоо маш түргэн идээд Англи цэргийн эмнэлгийн байшин тийш дахин очлоо. Тэр байшин гоё том агаад үүдээр нь үзэсгэлэнт сайхан мод ургажээ. Баркли хүүхэн Фергюсон хүүхэнтэй хамт цэцэрлэгийн урт сандал дээр сууж байлаа. Намйг очиход тэр баярлаж,, хэсэг зуур байснаа Фергюсон хүүхэн уучлал гуйгаад босов.

-Та хоёр үлд. Надгүйгээр та хоёр тав алдахгүй гэж тэр хүүхэн хэллээ.

-Битгий яв, Эллен гэж Баркли хүүхэн хэлэв

-Би явалгүй болохгүй. Захидал бичих ёстой гэв.

-Тавтай нойрсоорой гэж би хэлэв

-Генри гуай та тавтай нойрсоорой гэж тэ хэллээ.

-Хянагчийг зовоох юм бүү бичээрэй гэхэд

-Зоволтгүй. Ийм сайхан газар бид сууж байна. Италичууд цөм эрэлхэг юм гэж л бич бичнэ:

-Тэгээд байвал та одон авах байх аа.

-Тэгвэл их баярлана.Кэтрин минь тавтай нойрсоорой.

-Би удахгүй очно гэж Баркли хэллээ.

Фергюсон харанхуйд далд орлоо.

-Сайн хүүхэн юм гэж би хэлэв

-Айдаа. Тун сайн хүүхэн шүү. Сувилагч юм.

-Та бас сувилагч биз дээ

-Биш ээ! Би бол V. A. D<sup>7</sup> гэгддэг. Бид ихийг хийдэг. Харин биднийг итгэдэггүй юм.

-Яагаад?

Ажилгүй бол итгэдэггүй. Ажил гарвал итгэдэг юм

-Юунд тэр билээ?

-Сувилагч чнь эмч гэсэн үг. Удаан суралцах хэрэгтэй. V. A. D. бол хамгийн богино түр сургуулиар төгсөнө.

-Мэдлээ.

-Италичууд фронтодэмэгтэй хүн их ойртуулах дургүй болоод бид хаашаа ч гардаггүй ийм их нарийн журамтай юмаа.

-Би ирж байж болно биз дээ?

-Бололгүй яахав. Энэ чинь сүм биш шүү дээ

-За дайны тухай мартацгаая л даа.

-Мартахад хэцүү. Ийм газар дайны тухай мартахад хэцүү.

-Гэвч мартаж орхиё л доо.

---

<sup>11</sup> Voluntary Aid Department байлдаж буй армид ийлчлэх эмэгтэйчүүдийн сайн дурын хэсэг

-За за.

Харанхуйн дунд бид хоёр бие биенээ харан ширтэв. Надад тэр хүүхэн үнэхээр гоё санагдсанд би гараас нь барихад тэр гараа авсангүй. Би түүнийг татаж бэлхүүсээр нь тэврэхэд

-Зүгээр бай гэж хүүхэн хэлсэн боловч би тавилгүй

-Яагаад? гэж асуув

-Зүгээр бай гэв

-Ингэвэл сайхан байна шүү дээ гэж би хэлэв

Харанхуйд би тэр хүүхнийг үнсэх гэж тонгойход ямар нэг юм тэрэнд халуу оргин төөнөв. Тэр хүүхэн миний нүүр рүү алгадав. Нүд дайралдуулж, хамрын уг руу цохисон тул нулимс гоожлоо.

-Намайг уучлаарай гэж тэр хүүхэн хэлэхэд нь би жаахан тайширснаа

-Таны зөв гэв.

-Үгүй дээ, та намайг уучлаарай гэж хэлээд тэр хүүхэн харин амралтын үдэш сувилагч хүн офицертэй ингэж байх тун эвгүй юм боллоо. Би таныг өвтгөх гээгүй юмсан. Өвдөж байна уу? гэв

Харанхуйн дунд тэр хүүхэн амайг харна. Сэтгэл хорсовч би яг шатрын өрөг адил хойшид хэрхэхийг мэдээд итгэл төрлөө.

-Үнэхээр таны зөв. Би ер уурлахгүй гэж хэлсэнд

-Хөөрхий! гэв.

-Би тун хачин амьдарч байгаа биз дээ. Англиар ч ярих газар надад олдохгүй юм. Гэтэл та, ийм гоё хүүхэн дайралдлаа. Гэж хэлээд би тэр хүүхнийг харав

-Та бид хоёр эвлэрч, би танаас уучлал гуйсан шүү дээ. Та битгий тэгэж ярь

-Тиймээ. Бид дайны тухай ярихгүй гэсэн гэж би хэллээ.

Тэр хүүхэн инээв. Түүний хөхрөхийг би анх сонсож, нүүрий нь ажиглан суув.

-Та сайн хүн юм гэж тэрнийг хэлэхэд нь

-Онцгүй ээ гэв

-Тиймээ Та сайн хүн. Би өөрөө таныг үнсэх үү? Гэж хүүхэн хэллээ.

Би нүд рүү нь харснаа дахин бэлхүүсээр нь тэвэрч үнсэв. Би тэр хүүхнийг биедээ наалдуулан тэврээд чанга жимийсэн уруулы нь ярах гэж оролдон, чанга гэгч нь үнсэв.

Биендээ наалдуулан тэврэхдээ би сэтгэл хорссон хэвээр бөгөөтөл тэр хүүхэн гэнэт оцчирхийлэв. Чанга тэврэх тусам зүрхний нь цохилт мэдэгдээд, уруул нь ангайн, гар дээр толгой нь тохогдоод миний мөрийг түшсэн тэр хүүхэн уйлж байна гэдгийг мэдэв.

-Найз минь чи надтай үргэлж сайн байна тиймээ? гэж тэр хүүхэн хэллээ.

“Дэмийрсэн юм” гэж би бодов. Би үсий нь илбэн, дал мөрий нь илэв. Тэр хүүхэн уйлав.

-Нээрээн тийм үү? Бидний амьдрал тун хачин байх байхаа гээд тэр намайг ажиг

Хэсэг зуур болсны дараа би тэр хүүхнийг байшингийн үүдэнд хүргэж өгөөд түүнийг ормогц буцаж харив. Өрөөндөө очиж ороход Ринальди орон дэрээ хэвтэж байв. Намайг үзээд тэр:

-Баркли хүүхэнтэй ажил амжиж байна уу? гэв

-Бид хоёр найзууд болсон

-Чи ч одоо анч нохой шиг л байна.

-Хэнтэй гэнээ? гэж би ойлгоогүй тул асуув

Тэр тайлбарлав

-Энэ чинь та, тэр анч нохойтой адил... гэж би хэлэв

-Больё. Байсхийгээд л та бид хоёр биендээ гомдоох гэж ярих болох нь ээ гэж

хэлээд тэр инээлээ.

-Тавтай нойрсоорой гэж би хэллээ.

-Архичин банзал минь тавтай нойрсоорой гэж тэр хэлэв

Ринальдийн лааг би дэрээр унагаад харанхуйд хэвтэв. Тэрбээр лаагаа авч асаан, номоо үргэлжлүүлэн уншив.

[Тор](#)

---

Хоёр өдөр би харуул эргээд, тун оройтож ирсэн тул маргааш үдэш нь Баркли хүүхэнтэй уулзлаа. Тэр хүүхэн цэцэрлэгт байсангүйд цэргийн эмнэлгийн бичиг хэргийн өөөнд орж, гарч ирэхийг нь хүлээв. Бичиг хэргийн тасалгааны хана дагуу будмал модон тавиуртай олон гантиг цээж баримал тавьжээ. Бичиг хэргийн өрөөний гадна үүдэнд мөн тийм баримал байна. Гантиг баримлууд ерөнхий төлөвөөрөө цөм нэгэн хүний царайтай адил санагдана. Ер алт хүргээгүй учир тэрхүү гантиг цээж баримлууд булшны газар шиг л санагдаад үргэлж уйтгар төрүүлэх аж. Ялдамд өгүүлэх нь: Пизед нэгэн гоё сайхан булшны газар бий. Зэвүүн гантиг хөшөө Генуед л их байдаг юм. Энэ зуслан байр урьд нь германы нэгэн баяных байсан гэх бөгөөд эдгээ цээж барималд лав их мөнгө орсон биз. Чухам хэн үүнийг барьж, хичнээн мөнгө авсан болдоо. Өвөг дээдэс нь юмуу өөр хүн юм уу гэж би ялгах гэсэн боловч тэр бүхэн сонгодог нэгэн байдалтай, тун хараад таахын аргагүй ажээ.

Би саравчтай малгайгаа барьсаар сандал дээр суув. Горишид ч гэсэн бид төмөр малгай өмсөх шаардлагатай авч тэндийн иргэдийг цэрэгжүүлээгүй тул хотод үзүүлэн болж харагдаад тун эвгүй байлаа. Эргүүлд гарахдаа би цэрэг хувцсаа өмсөж, бас английн хорт утаа эсэргүүцэгч хорт утааны баг авч явна. Тэр үед тэгэж нэрлэдэг агаад бидэнд дөнгөж эхэлж тавьж өгөөд байсан билээ. Үнэхээр ч баг шиг л юм байв. Эмнэлгийн салбарын офицер, эмч нар хүртэл бид цөм олон үсэрдэг гар буу бас зүүх шаардлагатай билээ. Сандал налтал гар буу маань нухаж мэдэгдэв. Гар буугаа орхисон хүнийг барих хуультай. Ринальди гар бууныхаа гэрэн дотор бууны нь оронд багс арчих цаас чихчихдэг байв. Би буугаа ёсоор нь зүүж буудталаа л зэвсэгтэй хүн гэж өөрийгөө боддогсон. Тэр нь богино голтой, 7.65 калибрийн “Астра” төрлийн гар буу бөгөөд гохы нь дарахад доргиж чичрээд хараалсан юм ер онох нөхцөлгүй болой. Дасгалын буудлага хийхдээ би, овоо харааг нь ширгээж бариад голы нь доргиохгүйг хичээн оролдсоор хорин алхмаас буудахдаа хараалсан газраас бараг метрээс илүү зөрүүлдэггүй болсон юм. Ингэхлээр гар буу зүүх огт хэрэггүй нь илэрхий болсон билээ. Англи, америк хүнтэй уулзахад ичгүүр төрүүлэхээс цаашгүй тэрхүү ард, бүсэнд зүүттэй гар буугаа би төдөлгүй мартав. Сандал дээр сууж буй намайг бичиг хэргийн жижишүүр үүдээрээ дурамжхан харна. Би Баркли хүүхнийг хүлээж хананы зураг болон тавиуртай гантиг цээж баримал, гантиг шалыг ажиглан байлаа. Хааны зураг тийм муугүйн дээр будаг нь хөдөлж, ховхроод аанай л аятайхан болсон аж.

Кэтрин Барклийн бууж ирэхийг хараад би босов. Өөдөөс минь явахдаа тэр намхавтар бөгөөд их л сайхан харагдав.

-Генри гуай, сайн байна уу? гэж тэр хэлэв.

-Сайн, сайн байна уу? гэж би хэлэв. Бидний үгийг бичиг хэргийн жижишүүр чагнаж байв

-Энд суух уу, цэцэрлэгт гарах уу?

-Гаръя. Цэцэрлэгт сэрүүхэн

Тэр хүүхнийг дагаж хаалга чиглэхэд минь бичиг хэргийн хүн араас харсаар байлаа. Хайрга асгасан зөргөөр явах үед тэр хүүхэн

-Та хаачаад ирэв? гэв

-Би харуул эргээд ирлээ гэж хариулав-Надад зурвас тавиад явах нь яагаав? гэхэд нь:

-Амжиж чапсангүй. Би тэр өдөртөө ирнэ гэж бодсон юм гэж би хэллээ.

-Яалаа ч гэсэн найз минь надад мэдэгдэх л хэрэгтэй байж дээ гэв

Бид засмал замаасаа гарч модон дундуурхи зөргөөр оров. Би тэр хүүхнийг сугадан явж байснаа зогсож үнсэв

-Нэг тийшээ явах уу? гэв

-Болохгүй. Энд л зугаалж болно. Чи ирэхгүй их уджээ гэж тэр хэлэв

-Ирэлгүй гурав хоносон биз. Одо ирлээ шүү дээ гэхэд минь тэр намайг ажиж

-Надад чи хайртай юу? гэж асуув

-Хайрта

-Та надад хайртай гэж үнэн хэлж байа уу?

-Тиймээ. Би чамд хайртай гэж худал хэлж байж. Би урьд нь тэгэж хэлээгүй юм.

Та намайг Кэтрин гэж дуудаж байх уу?

-Тэгнээ.

Бид цааш хэсэг зуур явснаа дахин модны дэргэд зогсов.

-Кэтринд руу би шөнө ирсэн гэж хэл дээ

-Кэтринд руу би шөнө ирсэн

-Хонгор минь, ирсэн чинь үнэн биз дээ?

-Үнэн

-Би чамд их хайртай Тун хэцүү байна.

Дахиад явахгү биздээ?

-Үгүй! би дандаас ирж байх болно.

-Би танд их хайртай. Гараа дахиад энд тавиач.

-За

Тэгээд би тэр хүүхний нүүрийг харах гэж өөр рүүгээ эргүүлэн, үнсэхэд нүдээ ангьсан байв. Би аниастай нүдий нь үнсэв. Яахав, би тэр хүүхнийг жаахан мансууруулах гэж бодсон юм. Гэвч би сүүлдээ яахыг үл мэднэ. Орой олгон офицерүүдийн янхны газар очиж ялдмаа үзүүлэх гэсэн хүүхэнд хүзүүдүүлж дээд давхарт өөр офицертэй гарах зуур нөгөө хүүхэн малгайг минь хөндлөн тавьж явахаас энэ илүү билээ. Кэтрин Барклид би дурлаа ч үгүй, дурлах ч үгүй гэдгээ мэднэ. Хэзрийн оронд үг байгаагаас бус энэ бол мөрийтэй тоглоом юм. Мөрийтэй тоглоом шиг мөнгө юм олох гэж буй дүр үзүүлэх хэрэгтэй Чухам юу олох гэж тоглож буй нь тодорхойгүй байна. Харин би яасан ч яахав гэж бодно. Удтал зогсон янаглаж чаддагүй эрчүүлийн ёсоор би:

-Хаачих вэ? гэв

-Хаачих ч үгүй гээд тэр хүүхэн эргэж газар ширтэв.

-Энд жаахан сууя

-Урт чулуун сандал дээр суугаад Кэтрин Барклийн гарыг атгаа тэврэх гэтэл болсонгүй.

-Та их ядраа юу? гэж тэр асуув

-Үгүй.

Тэр хүүхэн өвс ширтсээр байлаа

-Та бид хоёр дэмий тоглоом эхэлж дээ

-Ямар тоглоом билээ?

-Солиотой юм гэж бодов доо

-Би тэгж бодоогүй

-Та сайн хүн юм. Сайн л тоглох гэж хичээж байх шив. Гэхдээ л дэмий тоглоом доо гэж тэр хүүхэн хэлэв.

-Хүний санааг та дандаа таадаг уу?

-Дандаа ч биш. Гэхдээ таныхыг мэдэж байна. Та надад дурлаж байгаа дүр үзүүлэх гээд яахав. Өнөөдрөөр ингээд шувтаръя. Одоо та юу яримаар байна даа?

-Үнэндээ би чамд хайртай,

-Хэрэггүй дэмий юм яриад юу хийх вэ?

Та тун аятайхан жүжиглэлээ. Одоо боллоо. Би бүр галзуу хүн биш шүү дээ. Галзуу байлаа ч түр зуурын галзуу байх вий... гэхэд нь би тэр хүүхний гарыг чанга атгаад

-Кэтрин минь... гэв

-Одоо "Кэтрин" гэдэг хачин сонсдож байна. Та тун янз янз дуудах хюм. Гэхдээ та тун сайн хүн. Та үнэхээрийн сайн хүн.

-Манай лам бас тэгэж хэлдэг юм

-Тиймээ, та сайн хүн. Та надтай ирж уулзаж байх уу?

-Тэгэлгүй яахав.

Надад хайртай гэж та хэлж байх явдалгүй. Үүгээр одоохондоо шувтаръя. Тавтай нойрсоорой гээд тэр хүүхэн босож, надад гараа өгөхөд би үнсэх гэж оролдов.

-Хэрэггүй. Би жигтэйхэн ядарчээ. гэж тэр хүүхэн хэллээ.

-Тэгвэл намайг үнс л дээ гэж би хэллээ.

-Найз минь, би жигтэйхэн ядарчээ.

-Намайг үнс л дээ

-Үнэхээр- үнсүүлэх гэж тун их хүсэд байна уу?

-Тун их

Бид хоёр үнсэлдэж баөйснаа тэр хүүхэн гэнэтмултран

-Болохгүй. Найз минь тавтай нойрсоорой гэв.

Хоёул үүдэнд хүрээд тэр хүүхний босго алхан ород шатаар өгсөхийг харахад алхаа гишгээ нь надад сайхан санагдав. Тэр хүүхнийг далд ороход би гэрийг зүг буцлаа. Шөнө бүгчим агаад Сан –Габриельд гал манаран дээд талын ууланд чимээ агшин чүл тасарна.

Вилла Россин байшингийн гадаа зогсоход цонх нь хаалттай боловч дотор нь шуугилдаж нэг хүн дуулж сонсдоно. Өрөөндөө орж хувсаа тайлж байтал Ринальди ирэв.

-Ой, үйлс бүтэмжгүй юу. Хүү минь цөхрөө юу? гэж тэр асуув

-Чи хаана очоо вэ? гэсэнд

-Вилла Росса очсон. Хүү минь сэтгэлд таатай юм. Бүх нийтээр дуулсан. Харин чи хаана байв? гэв.

-Англичуудын тэнд очсон гэж би хариулав.

-Бурхан минь, би л англичуудтай холбогдоогүй маань яамай гэж тэр хэлэв.

[Тор](#)

---

Марагааш нь би уулын эхний харуулаас буцаж яваад Smistimento<sup>8</sup> ирж машинаа зогсоов. Тэнд өвчтэй шархтай хүмүүсийн үнэмлэхийг шалган, цэргийн аль эмнэлэгт

---

<sup>11</sup> Хянах салбар гэсэн итали иг



очихы нь үнэмлэх дээр нэтэмдэглэж байв. Би өөрөө машинаа жолоодож явсан тул жолооны ард үлдээд харин жолооч маань тэмдэглүүлх үнэмлэхүүдийг авч одов. Халуун өдөр байв. Тэнгэр цэв цэнхэртээд зам цайран тоосорно. Би монхор найм машины өндө суудал дээр сууж бодох санах ч юмгүй. Гагцхүү хажуу замаар өнгөрч буй хороо цэргийн жагсаалын алхааг ширтэнэ. Хүмүүс ядарч хөлөсөн агаад зарим нь төмөр малгайтай, ихэнх нь төмөр малгайгаа үүргэвчиндээ учсан явна. Олонхийн нь төмөр малгай дэндүү томдоод бараг чихий нь хаана. Офицерүүд цөм төмөр малгайтай бөгөөд яг тааруулэн өмчжээ. Энэ бол Базиликатын бригадын хэсэг юм. Улаан цагаан алагласан петлицээр нь би тэднийг танив. Цэргийн хороо хэдүйн өнгөрсөн боловч ангитайгаа хамт явах чадал үгүй бологсод дэргэдүүр цуварсаар байна. Тэр тарчилж, хөлс тоосонд дарагдаж зарим нь хүнд өвчтэй аж. Хоцрогсдын сүүлч өнгөрөхөд зам дээр нэг цэрэг үлдэв. Тэр цэрэг хазганан явснаа зогсоод, зам дээр суухад нь би машинаас бууж очив.

-Та яагаав? Гэж асуухад минь намайг харж байснаа босож

-Би одоо явлаа гэв

-Юу болоов?

-Дандаа дайн энэ муу хар дайн...

-лХөл чинь яагаав?

-Хөл зүгээр ээ. Би ивэрхийтэй юм.

-Тэгээд яагаад явган явж байна вэ? гэж би асуув

-Хэвтүүлэхгүй байна. Намайг даруулга зориуд хаясан гэж дэслэгч хэлсэн.

-Үзүүлээч!

-Задарчихсан юм

-Аль талдаа?

-Яг энд... гэхэд нь би түүний гэдсийг дарж үзэв.

-Ханиалгаач гэж би хэлэв

-Муудчихгүй байгаа даа. Одоо өглөөнийхөөс хоёр дахин томсоод байгаа гэв

-Машинд суу. Миний авч яваа шархтаны бичиг бэлэн болохоор танай эмнэлгийн салбарт би өөрөө таныг хүргэж өгье гэж би хэлэв.

-Намайг зориуд тэгсэн гэж тэр хэлээ дээ.

-Тэд яаж ч чадахгүй. Энэ чинь шарх биш урьд нь ингэдэг байсан уу? гэж би асуув

-Харин цэргийн эмнэлэгт явуулна

-Tenent би тантай байж болох уу?

-Болохгүй. Таны үнэмлэх надад байхгүй.

Гэтэл бидний зөөж яваа шархтнуудын үнэмлэхийг барьсаар жолооч хаалгаар цухуйв.

-Дөрвийг нь зуун тавд, хоёрыг нь зуун гучин хоёрт гэж тэр хэлэв.Тэр хоёр нь нөгөө эрэгт байдаг цэргийн эмнэлэг юм.

-Тэргээ барь гэж би хэлэв.

Би нөгөө ивэрхий цэргийг түшин дэргэдээ суулгав

-Та англиар ярьдаг уу гэж тэр асуув

-Ярьдаг.

-Энэ хараалын хар дайны тухай та юу гэж бодож байна?

-Новшийн эд дээ.

-Энүүнээс новшийн юм гэж ер байх уу даа.

Ээ, новш гэж

-Та нэгдсэн улсад байсан уу?

-Байсан, Питьсбуошь байсан. Таныг америк хүн гэж би санасан.

-Би италиар муу ярьж байна гэж үү?

-Таныг америк хүн гэж жолооч маань италиар хэлээд ивэрхий цэргийг харав.

-Дэслэгч гуай аа, та намайг заавал хороон дээр хүргэж байна уу?

-Тэгнэ. Ивэрхийг

-Миний ерөнхий эмч мэддэг юм. Тэргүүн шугаманд дахиад явахгүй, бие муудвал муудаг гээд би тэр муу даруулгы нь хаячихсан юм.

-Мэдлээ.

-Намайг та өөр газар аваачихгүй юу?

-Фронтод ойрсон бол аль тааралдсан эмнэлгийн салбарт би таныг өгч олох байна. Гэтэл энэ ар талд үнэмлэхгүй болохгүй.

-Хэрвээ намайг буцаж очвол мэс засал хийгээд л дараа нь цаг үргэлж тэргүүн шугамд явуулах болно.

-Би бодлогошров.

-Та бол цаг үргэлж л тэргүүн шугамд байж байх л дуртай юу? гэж тэр асуухад нь

-Үгүй гэв

-Ээ, чөтгөр гэж! Дайн гэж яасан гамшиг вэ гэж тэр үглэнэ.

-За чи энд машинаас бугаад унаж толгойдоо булдруу гаргаад бай. Буцах замдаа би чамайг авч цэргийн эмнэлэгт хүргэе. Альдо үэнд түр зогсоё гэж би хэлэв.

-Бид замын хажууд гарч зогсоод, тэр цэргийг түшин буулгав.

-Дэслэгч ээ, та эндээс намайг аваарай гэж тэр хэллээ.

-Баяртай гэж би хэлэв. Тэндээс бид замаар нэгэн миль орчим яваад, түрүүчийн хороог гүйцэж, хайлсан цасанд булингартан, гүүрийн багана хоорондуур түргэн жирэлзэн урссан голыг гаран тал дундуурхи замаар явжцэргийн эмнэлэг хүрч шархтан хүмүүсийг тушаагаад буцах замдаа би ханхай машинаа жолоодож сайхь Питтсбургийн цэрэг хүлээж буй зүг яаран давхив. Бүр ч ядраад улам удаан явж буй цэргийн хороо болон замаар цуврагсдыг өнгөрсөн хойно замын дунд эмнэлгийн тэрэг зогсож буйг олж харлаа. Хоёр асрагч тэрхүү ивэрхий цэргийг өргөж байв. Түүнийг авахаар тэд иржээ. Тэр цэрэг намайг хармагцаа толгой сэгсрэв. Төмөр малгай нь унжаад үснийхээ доохино дух нь цустай, хамрын нь арьс зулгарсан агаад шархны цусан дээр тоос наалдаж, үс нь бас шороо тоос болжээ.

-Дэслэгчээ эднийг хараач. Одоо яая гэх вэ. Намайг авах гэж иржээ хэмээн тэр хашгирав.

Байрандаа ирэхэд таван цаг болсон байв. Би усанд орохоор, машин угааж буй газар очив. Дараа нь би тасалгаандаа онгорхой цонхны дэргэд дотуур цамц өмдтэй сууж итгэл бэлтгэв. Нөгөөдөр довтолгоон эхлэх байлаа. Би нэгдсэн улсад захидал бичлгүй уджээ. Бичих ёстой авч хойш тавьсаар өдгөө бололцоо үгүй болсон байна. Бичих ч юм үгүй болжээ. Амархан хүрэхийг нь бодож би “Амьд мэнд байна” гэхээс өөр үггүй Zone di Guerra<sup>9</sup> ил захидал хэдийг илгээв. Америкад тэдгээр ил захидлыг ер бусын нууцгай гэж ихэд таашаах биз. Чухам эл бүсэнд дайн ер бусын нууцгай боловч австричуудтай хийсэн бусад дайнтай зүйрлүүлбэл надад сайтар бэлтгэсэн ширүүн дайн санагддаг юм. Аль нэгэн Наполеоны ялахад Австрийн арми зориулагджээ. Бидэнд Наполеон байсан бол сайнсан. Гэвч бидэнд зөвхөн generale Cadorna хоёрдугаар гэдэг омголон тарган генерал болон Vittorio Emanuele гэдэг ямаан сахалтай туранхай урт хүзүүтэй бяцхан хүн байв. Баруун эргийн зэвсэт хүчнийг толгойлогч гүн Аост их жанжин гэхэд дэндүү гоё агаад жинхэнэ эр хүн шиг харагддаг юм. Чухам тэр хүнийг ван хаан болоосой гэж олон хүн хүсдэг билээ. Харахад тэр ван хаан шиг хүн юм. Тэрвээр ван хааны авгын ёсоор гуравдугаар

---

<sup>11</sup> Дайны бiс гэсэн итали иг

армийг жанжилж бид хоёрдугаар армид багтаж байсан бөгөө гуравь дугаар армид английн хээн батарей байлаа. Тэр ангид байдаг английн хоёр их буучтай би Мали лан хотод танилцсан билээ. Толм биетиэй, даруухан тун аялаг тэр хүн хоёр залуутай би нэгэн үдшийг тавтайяа өнгөрөөсөн юм. Юм бүгд тэр хоёр нэг талаар аягүй, нөгөө талаар таатай байдаг. Английн зэвсэгт хүчинд алба хаавал надад хялбар сайнсан. Тэгвэл би алагдах байхдаа. Эмнэлгийн салбарт боляах бол доо. Эмнэлгийн салбарт ч үхэж болно. Английн эмэлгийн машины хэдэн жолооч алагдсан явдал буй. Гэвч би энэ дайнд алагдахгүй гэдгээ мэдэж байсан юм. Энэ дайн надтай ямар ч холбогдолгүй юм. Хинонд гарч байгаа дайнаас энэ дайн надад арай л аюулгүй билээ. Гэлээ ч гэсэн дайн дуусахыг би хүсэхийн ихээр хүсэж байна. Энэ зундаа дайн дуусах ч магадгүй.

Австричуудыг дарж ч магадгүй. Урьдах дайнуудад тэд дандаа ялагдаж байсан, энэ дайн чухам юугаараа онцгой билээ? Францчууд доройдож гэж хүн болгон ярьж байна. Францын цэрэг босоод Парист цэрэг орсон гэж Риналь ярьсан. Тэгээд юу болсныг асуухад минь “гэхдээ тэднийг зогсоосон” гэж Ринальди хэлсэн. Дайнгүй цагт л би Австрид ирмээр байсан. Шварцвальдад очмоор байсан. Гарцид очсоор байсан. Гарц чухам хаахна байдаг юм бол доо. Одоо Карпатад дайн болж байна. Тийшээ, ямар ч ашигтай байсан би очих дургүй байна. Дайнгүйсэн бол би Испани очихсон. Нар шингэж өдөр өнгөрлөө. Оройн хоолны дараа би Баркли Кэтринтэй уулзана. Тэр хүүхэн андтай энд одоо хамт байгаа ч олоосой. Бид хоёр Миланд цуг байх юмсан. Тэгвэл Ковад орой сайн хооллоод сэнгэнэсэн үдэш Ви Манцониар явж, гүр гараад суваг дагуу эргэж, буудалд Кэтрин Барклтэй орохсон. Тэр хүүхэн очно байх даа. Эсхүл намайг тэр мөнөөхөн Соммед алагдсан офицер шиг бодно биз. Тэгээд бид голын хаалгаар ороход хаалгачин малгайгаа авч мэхийн би буудлын хаалгачны өрөөний үүдэнд зогсож түлхүүр гуйж, Баркли хүүхэн цахилгаан шатны тэнд зогсов. Дараа нь бид цахилгаан шатанд суугаад алгуурха н өгсөж, давхар бүрд зогссор, манай давхарт ирэхэд цахилгаан шатчин хөвүүн үүд онгойлгож эхлээд тэр хүүхэн, дараа нь би гарч гудмаар явлаа. Би хаалга тайлж ороод утас авч утасдан дүүрэн мөстэй мөнгөн хувинд нэг лонх Капри бьянка хэмээх дарс авчирч өгөөч гэж захиалахад, хувинтай мөсний чимээ гудмаар ойртон ойртсоор хөвүүн хаалга цохиход хаалгын тэнд тавьчих гэж би хэлэв. Яагаад гэвэл бид халууцахдаа хамаг хувцсаа тайчаад цонхоо элгэсэн байна. Дээвэр дээгүүр хараацай дүүлэн, харанхуй бүрэнхий болоход цонхоор харвал байшингийн орой моддын дээгүүр өчүүхэн сарьсан багваахай ниснэ. Үүдээ түгжээд бид Капри дарс ууж халууцахдаа дан цагаан даавуу нөмрөн, Малина хотын халуун шөнийн гүнд шөнөжин амраглан янаглана. Иймл байх ёстой. Оройн хоолоо түргэн идээд Баркли Кэтринтэй уулъя байз.

Хол идэхдээ бид тун их ярив. Би дарс уулаа. Хэрвээ би өнөө орой бага зэрэг дарс уугаагүйсэн бол бидний ахан дүүгийн ёсон хазайх байсан. Илэрхий сайн хүн их хамба Айрлэндын хувь заяанд шударга бусаар хандаж, шударга бусаар харьцаж буй тухай би ламтай ярилцав. Америк хүний хувьд би энэ талаар мөн буруутан юм. Тэр тухай би ер мэдэхгүй атугай ч сайн мэддэг дүр үзүлж суулаа. Ер энэ тухай эс мэдвэл муухай юм болно. Хэргийн хамаг нарийн учрыг сайтар тайлбарлуулж байж, учраа ойлголцоогүй хэрэг юм байна гэж мэдлээ. Миннесотын Айрленд, Висконийн Айрленд, Мичиганын Айрленд гэхчилж, үлэмжийн сайхан нэртэй Миннесотын хүн болох тэр их хамбын нэр нь надад тун гоё санагдав. Гэвч хэргийн учир зөвхөн үүд бус гүн гүзгий шүү дээ. Тийм үү, лам ах минь Үнэн байсан ч магадгүй ээ, лам ах минь. Худлаа ч байж болно. Үнэн ч байж болно лам ах минь, та л сайн мэдэх ёстой. Лам хүн сайн атлаа уйтгартай. Офицерууд муу дээрээ бас уйтгартай. Ван хаан сайн боловч мөн уйтгартай Харин дарс муу мөртөө уйтгар тайлна. Дарс уухад шүдний хөгж нүүж тагнайд тогтоно.

-Гурван хувийн хонжворт сугалаа авч явсан гэж амыг барьж хорьсон.

Францад л тэр шүү дээ. Энд бол хэзээ ч барихгүй. Таван хувийнхыг ч огт мэдэхгүй гэж лам өгсөн. Безьедед л ийм хэрэг болж байгаа юм. Би тэнд байхдаа энэ тухай сониноос олж уншаад шоронд очиж, ламтай уулзуулж өгөөч гэж гуйсан юм. Гэтэл лам хонжворт сугалаа хулгайлсан нь үнэнэ байсан гэж Рокка ярив.

-Цөм худлаа гэж Ринальди хэлэхэд

-Юу л гэж бодвол бод. Би өөрийнхөө ламд л ярьж байгаа юм. Их сургаалтай явдал шүү. Манай лам учры нь мэднээ гэж Рокка хэлэв.

-Ярь, ярь би сонсьё гээд лам инээвхийлэв.

-Зарим сугалаа нь олдоогүй, харин гурван хувийн хонжворт нь ламд байж, бас нутгийн нэг банкны хонжворт сугалаа гарсан гэнэ. Тэгээд би шоронд очлоо. Тэнд л хамгийн сонин юм болсон. Тэр ламын өрөөний үүдэнд зогсоод л би залбирал үйлдэх адил “Эцэг минь намайгаа энэрэн өршөө, та нүгэл үйлдсэн буюу” гэсэн гэхэд нь цөм хөхөлдөв.

-Тэгээд тэр юу гэж хариулав хэмээн лам асуулаа

Ламын үгийг Рокка ер анзаарсангүй, харин надад шог ярианы утгыг тайлах гэж оролдон

-Яаж давсалсны нь мэдэж байна уу? гэв. Хэрвэ зөв ойлговол үнэхээр уран хурц шог нь илэрхий байлаа. Надад дахин дарс аягалав. Шүршүүрт орсон англи цэргийн тухай би шог ярив. Дараа нь Чехословак, Унгарын арван нэгэн ахлагчийн тухай хошууч шог ярьж би дахин дарс уугаад нэг зоос олсон хурдан морьтны тухай шог хэлэв. Шөнө унтаж чадахаа больсон хатны тухай Италийн хошин шог бий гэж хошууч ярив. Лам ч явлаа. Умрын хүйтэн салхи үлээсэн өглөөгүүр, таван цагт Марсельд ирсэн панзчины тухай би шог ярив. Намайг архи ууж сурсан гэж сонссоноо хошууч хэлэхэд би эсэргүүцэв. Үнэн болохыг Бакус гэрчилсэн бөгөөд биеэр шалгана гэж хошууч ярилаа. Бакус хамаагүй гэж би хэллээ. Би тэгвэл Басси филиппо Винченцтэй мөрийцаж ууя л даа. Тэгвэл шударга бус юм болно, чамаас би хоёр дахин илүү уусан гэж Басси хэлэв. Бахус ч бай, бус ч бай, Филиппо Винченц Басси ч бай, Басси филиппо Винченц ч бай, энэ бол бузар гүтгэлэг. Энэ хоёр бүхэл оройжингоо дусал ч амсаагүй гэж би хэллээ. Өөрийн нь нэрийг асуусантай аид тэр бас миний нэрийг Энрико Федерико юм уу, Федерико Энрикоо юм уу? гэж лавлав. Бахус дэмий харин хэн ууснаа даасан нь ялна гэж намайг хэлэхэд хошууч бидэнд аяга дүүрэн улаан дарс хийж уралдуулав. Аяганы талд нь ортол уугаад би чадсангүй явах ажлаа бодов.

-Басси дийллээ. Басси илүү юм байна. Би явалгүй болохгүй гэж би хэлэв

-Явах болсон нь үнэн. Болзоотой юм. Би мэднэ гэж Ринальди хллээ.

-Би явалгүй болохгүй гэсэнд

-Чадалтай болж байгаад дахиад үзэлцээрэй. Тэр болтол баяртай гэж Басси хэлээд миний мөрийг алгадав. Ширээн дээр лаа асааж, офицерүүд уем үлэмжхэн баясаж байв.

-Эрхмүүлдээ, тавтай нойрсоорой гэж би хэлэв

Ринальди надтай цуг гарч, үүдэнд зогсоод:

-Чи тийшээ согтуу очоод хэрэггүй байхаа гэв

-Ранин минь би согтоогүй үнэн шүү

-Ядахдаа кофе цайны үр зажилчих

-Шал дэмий

-Найз нь одоохон аваад ирье. Энд түр хүлээж бай гээд явж хуурсан кофе цайны үр ачран

-Май, найзаа, чамайг бурхан өршөөг гэв

-Бахус гэж би хэлэв

-Би чамайг хүргэж өгье гэхэд нь

-Би зүгээр ээ гэв

Хот дундуур биш хоёул явж, би кофе цайны үр зажлан явав. Англичуудын суудаг байшин хүрэх цэцэрлэгт гудамжны эхэн дээр намайг хүргээд тавтай нойрсохыг ерөөж Ринальди салав

-Тавтай нойрсоорой. Чи орохгүй яагаав? Гэж б хэлэв

-Үгүй гэж тэр толгой сэгсрээд

-Би арай энгийн байдалд дуртай гэв

Кофе цайны үр авчирсан чинь баярлалаа гэхэд минь

-Зүгээр, зүгээр найзаа гэв

Цэцэрлэгт гудамжаар явахад хоёр талаар ургасан далдуу мод нарийн тод харлан харагдана.

Эргэж харвал, Ринальди миний араас ширсээр зогсоход нь би гар даллав.

Кэтрин Барклийг хүлээж би үүдний өрөөнд суулаа. Хөлийн чимээгээр босож харван Кэтрин биш, Фергюсен хүүхэн байв

-Сайн уу? Өнөөдөр тантай уулзаж тун чадахгүй нь гэж танд хэлээрэй гэж Кэтрин надаас гуйсан хэмээн тэр хүүхэн хэллээ.

-Харамсалтай байна. Өвдөөгүй биз дээ?

-Бие нь жаахан муу.

-Намайг сэтгэл тавгүй байна гэж хэлээрэй.

-Хэлье

-Би өглөө ирэх үү?

-Ирээрэй.

-Танд их баярлалаа. Тавтай нойрсоорой гэж хэлээд би хүлээх өрөөнөөс гарав.

Түр зуур би гэнэт тавгүй уйтгартай боллоо. Кэтринтэй уулзахаа би хайхралгүй, согтож мартагшаа агаад харин уулзаж чадахгүй болохдоо гиюүрч ганцаардах сэтэл төрөв.

[Top](#)

---

Голын эхээр шөнө дайран довтлох учир бид дөрвөн машинтай тийш явах болсныг маргааш нь мэдэв. Стратегийн мэдлэгээ үзүүлж, хүн бүр ихэд уран цэцэн ярьсан боловч ямар ашиг олохыг хэн ч үл мэднэ. Би эхний машинд сууж англи цэргийн эмнэлгийн үүдээр гарахдаа жолоочоо зогсоов. Бусад машин мөн зогссонд бо гарч, хэрвээ наана гүйцэхгүй бол Кормоны замын агцны тэнд хүлээж бай гээд жолооч нарыг цааш явуулан, цэцэрлэгт гудамжийг яаруу өнгөрч, хүлээх өрөөнд ороод Баркли хүүхнийг дуудаж өгөөч гэж гуйв.

-Жижүүр хийж байгаа гэлээ

-Ганцхан минут уулзаж болохгүй юм болов уу? гэж би асуув

Нэгэн асрагч явж, тэр хүүхнийг дагуулан гарч ирлээ.

-Таны биеийг ямар байгаа бол гэж би ирлээ. Таныг жижүүр хийж байгаа гэхээр дуудуулсан юм.

-Бие сайн. Өчигдөр халуунд жаахан эвгүйрхсэн гэж тэр хүүхэн хэлэв

-Би явах боллоо

-Би тантай хамт түр гаръя

-Бие чинь бүр сайн уу? гэж би гарахдаа асуув

-Сайн найз минь. Та өнөөдөр ирэх үү. Чадахгүй өнөөдөр Плавын найранд очих

гэж явна

-Найр гэнээ?

-Илүү юу л болов аж

-Тэгээд та хэзээ ирэх вэ?

-Маргааш

-Тэгээд тэр хүүхэн ямар нэгэн юм хүзүүнээс тайлж алган дээр минь тавиад

-Энэ ариун сахиус байгаа юм. За маргааш орой ирээрэй гэв

-Та католиг шүтлэгтэй юм уу?

-Үгүй ээ. Гэхдээ ариун сахиус их тустай гэдэг юм.

-Таныг бодож үүнийг чинь нандигнаж явъя. Баяртай

-Баяртай гэх хэрэггүй гэж тэр хүүхэн хэлэв

-Мэдлээ.

-Ухаалаг явж, биеэ болгоомжлоорой. Үгүй, энд үнсэлцэж болохгүй

-Мэдлээ

Эргэж харахад минь тэр хүүхэн шатан дээр зогсоод хойноос далласаар ахуйд би хий үнсэн хариу дохив. Тэр хүүхэн хойноос минь далласаар байлаа. Цэцэрлэгт гудамж өнгөрч би машинд суугаад хөдлөв. Цагаан төмөрлиг ариун сахиусыг жижигхэн гуунд хийжээ. Би гууг нь онгойлгон алган дээрээ сэгсрэв.

-Ариун сахиусуу? гэж жолооч асуулаа

-Тиймээ гэв

-Надад бас бий үз л дээ гээд тэр баруун гараа жолооноос салган товчоо тайлаад өврөөсөө гуутай юм гаргав.

Ариун сахиусаа би гуунд нь хийгээд нарийхан алтан оосор гинжий нь хумхин хажуу халаасандаа хийв.

-Та хүзүүндээ зүүхгүй юм уу?

-Үгүй

-Зүүвэл сайн. Зүүхгүй бол энэ ямар хэрэгтэй юм бэ?

-За гэж хэлээд би алтан оосрын нь товхыг тайлж хүзүүндээ зүүж товчлов.

Ариун сахиус миний цэрэг цамцан дээр зүүлттэй байна. Би энгэрээ тайлж, захаа яран ариун сахиусаа цамцан дотуур хийв. Машинд суухдаа төмөр гуу нь цээж хайрч байсныг нь би мэдэж байв. Төдөлгүй би мартаж, шархадсаныхаа дараа үзэхэд үгүй блсон байв. Бодвол эмнэлгийн салбарт нэг нь намайг боохдоо тайлж авсан буйзаа.

Гүүр гармагц бид хурдлан давхиж төдөлгүй өмнөх зам дээр бусад машины маань тоос харагдав. Гогцоорсон замд нөгөө гурван машин маань өчүүхэн жижиг харагдаж, дугуй дороос нь боссон тоос модны цаагуур суунаглана. Би зэрэгцэн очиж түрүүлэн, уул өөд өгссөн өөр замаар эргэв. Цуваа машины тэргүүнд явахад тун таатай агаад би тавлан сууж, эргэн тойрныг ажиглав. Голын хөвөө уулын хормойгоор явж, зам өгсөхөд умард өндөр оргилын оройг цас дарсан үзэгэв. Эргэж харвал тоосон үүлээр холбогдсон нөгөө гурван машин маань уул өөд өгсөнө. Бид ачаатай луусны урт жин өнгөрөв. Улаан цалмаа өмссөн жинчид луус тууж явна. Тэд цоохор цэргүүд ажээ.

Тэрхүү луусан цуваанаас хойш өөр юу ч тааралдсангүй, бид уул толгой дамжин явсаар голын хөндий рүү орлоо. Тэнд замын хажуугаар мод суулгасан бөгөөд баруун жигүүрийн модны цаана гүехэн тунгалаг түргэн гол урсана. Ус нь татарсан тэр гол элс хайрган дундуур зурвасхан урсаж, хайргатай ёроолдоо ус тогтоод тэнгэр адил цэв цэнхэр аж. Замаас салсан зөрөг гардаг голын чулуун нуман гүүр болон дэнлүү зоосон тариачны чулуун байшин мөн урд хананы нь дагуух лийрийн мод, тал дахь намхан чулуун хашаа харагдана! Хөндийгөөр урт зам туулсны дараа бид эргэж дахин уул өөд өгсөв. Зам огцом өгсөж, туулайн бөөр мдны төгөл дундуур сүлжин явсаар уулах хэц дээр гарав. Моддын хоорондуур хөндий хөрөгдөж,

хоёр армийг тусгаарлан буй голын тохой наранд гялалзана. Хэц нуруу дамнуулан тавьсан цэргийн шинэ чулуун замаар явахад умард талд нарны гэрэлд орой нь цав цагаан мөнх цас хүртэл ногоон бараан хоёр уул нуруу эгнэн байна. Түүнээс дээш өгссөн хойно бас хэрчлээтсэн сонин атриатай, цэрд мэт цагаан, гурав дахь цаст өндөр уул үзэгдэн цаадтай нь мөн уул нуруу дүнхийн хзгаар нь ялгагдахаа болив.

Тэд цөм австрийн уул байлаа. Манайд тийм уулс байхгүй. Урдах зам баруунаа тойройн эргэж, модын чөлөөгөөр огцом доошилсон үзэгднэ. Тэр замаар явган цэрэг, уулын зэр зэвсэг ачсэн луус ачааны машин явна. Бид зам хөвөөлөн уруудахад тэртээ доор гол харагдаж хажуугаар нь толигор зам, замын дэр мод жирийж төмөр замын ухучин гүүр, мөн голын цаана уулын хормойд бидний эзэлбэл зохих хотын нурсан байшин байна.

Бид уруудан бууж, голын эргээр тавьсан төв замаар явахад харуй бүрий болов.

[Тор](#)

---

Замаар хүн хөсөг дүүрээд, хоёр талаар нь сүлжмэл хашаа, сүрлэн сийрс үргэлжилж зам бүрхсэн сийрс нь цирк буюу зэрлэг овогтны суурингийн үүд адил ажээ. Бид тэрхүү сүрлэн мэлхий хаалган дотуур алгуур ахисаар урьд төмөр замын өртөө байсныг цэвэрлэсэн нүцгэн газар гарч ирэв. Түүнээс цааш эргийн даланг ухаж зам засаад тужид нь далдалж, явган цэрэг байрлажээ.

Далан дээгүүр харахад, голын тэртээ уулын оройгоор шингэх нарны туяанаа австрийн ажиглах агаарын бөмбөрцөг харлан байлаа. Тоосгоны үйлдвэрийн балгасны цаадтай бид машинаа тавив. Шатаах зуух болон хэдэн гүн нүхэнд эмнэлгийн салбарын тоног төхөөрөмж хийжээ. Эмч нарын гурав нь миний танил бөгөөд надад ерөнхий эмч хэлэхдээ тулалдаан эхлэхэд манай машин шархтан авч, эргийн далдалсан замаар явж, даваан дээр байгаа харуулын газар өөд машинд шилжүүлнэ. Замд нь л гай бүү дайраасай гэв. Өөр зам байгаагүй тул авсртрийн ил эргээс тийнхүү нуун далдасан байна. Тоосгоны үйлдвэр дээр биднийг пулемёт болон их бууны сумнаас эргийн алан халхалж, ганц муу эвдэрхий гүрээр гол гарахын дээр их буугаар буудаж эхлэхэд бас нэгэн гүүр засаж цэргийн хагас нь голын тохойн гүехэн газраар гатална. Ерөнхий эмч намхан нуруутай, дээш нь мушгисан сахалтай, хошууч цолтой, ливийн дайнд оролцож шархадсаны учир энгэрээ хоёр цоолсон хүн болой. Бүх юм сайнаар өнгөрвөл намайг шагналд дэвшүүлнэ гэж тэр хэлэв. Бүх юм сайнаар өнгөрнө гэж итгэж байгаагаа илэрхийлээд би хариу талархав. Жолооч нарыг байлгах том газар зоорь байна уу гэж намайг асуухад тэр эмч нэгэн цэрэг дуудаж газарчлуулав. Тэр цэргийг дагаж явсаар бид бид тун тохилог газар зооринд төдхөн хүрэв. Жолооч нар дуртайяа тэнд үлдэв. Хоёр офицертой хамт намайг архи ууя гэж их эмч урьсан тул би очиж ром архи уухад нөхдийн хүрээнд байгаадаа сэтгэл таатай санагдав. Бүрэнхий боллоо. Хэдэн цагт довтолгоон эхлэхийг асуухад минь харанхуй болохтой зэрэг эхэлнэ гэж хэлэв. Би жолооч над руу эргэж ирэв. Тэр газар зооринд суун ярилцаж байснаа намайг орохоор намжив. Би тэдэнд нэг нэг “Македони” янжуур өглөө. Сулхан ороосон тул тамхи нь цувраад татахын өмнө нэг үзүүрий нь имрэх хэрэгтэй юм. Маньер асаагуур зурж цөмийн нь тамхийг асаав. Асаагуур нь монхор наймын радиатор маягтай аж. Дуулж мэдсэн бүхнээ би тэдэнд ярилаа.

-Наашаа ирэхдээ бид яагаад харуул олж харсангүй вэ? гэж Пассани асуув.

Бидний эргэсэн тохойд л байсан даа.

-Энэ замаар явахад зүгээр юм гэж Маньер хэлэв.

-Австричууд бид аль алиныхаа аминд орно.

-Амар болноо гайгүй.

-Дэслэгчээ, хоол яах вэ? Нэг л эхэлчихвэл хоолны тухай бодох юмгүй болно

доо.

Одоо явж асууя гэж би хэлэв.

-Бид эндээ сууцгааж байхуу, гарах уу?

-Эндээ сууж байвал дээр.

Тэгээд би ерөнхий эмчид очиход аяны тогоо одоохон ирэхээр жолооч нар ирж хооллог. Өөрсөнд нь аяга байхгүй бол би өгнө гэж тэр хэлэв. Өөрснөө аягатай байх гэж би хэллээ. Би буцаж... очоод хоол авчрахтай зэрэг ирж хэлнэ гэж жолооч нарт яриу. Буудлага эхлэхээс өмнө хоол ачирвал сайнсан гэж Маньер хэллээ. Намайг гартал тэд дуугүй л байлаа. Тэд дөрвүүл механикч бөгөөд дайныг үзэн яддаг юм.

Би гарч машинаа шалган, эргэн тойрон юу болж буйг ажиглаад, жолооч нарын зооринд эргэж оров. Бид цөм хана налан газар дээр сууж тамхи татна. Гадна харанхуй болж байлаа. Зоорины газар бүлээн хуурай агаад би мөрөөрөө хана налаад бүх биеийн булчинг сул тавив.

-Хэн довтолгоод орох вэ? гэж Гавуцци асуув

-Цоохор цэрэг

-Зөвхөн л тэд үү?

-Тийм байлаа

-Жинхэнэ довтолгоонд цэрэг цөөдөж байна.

-Энэ ч зүгээр л үймүүлдэг байх. Жинхэнэ довтолгоон өөр газар болно.

-Довтолгоонд орж байгаа цэрэг энэ учрыг мэдэх үү?

-Мэдэхгүй байх

-Яаж мэдэх юм бэ? Мэдвэл явахгүй шүү дээ гэж Маньер хэлэв.

-Мэдсэн ч энэ тэнэг цэргүүд явна гэж Пассини хэлэв.

-Энэ эрэлхэг цэргүүд их сахилгатай улс шүү гэж би хэллээ.

-Эд нар ханхар цээжтэй чийрэг залуу гэхдээ тэнэг улс юм.

-Торгон цэргүүд цөм их өндөр улс гэж Маньер хэллээ. Энэ нь доогийн үг байсан тул тэд дөртвүүл инээлдэв.

-Дэслэгчээ, таныг байхад торгон цэргүүд явахгүй гэхэд аравдахы нь буудсан юм. гэл үү?

-үгүй

-Тэгсэн юм гэсэн. Цөмий нь жагсаагаад аравдахь хүн бүрийг гаргаж цагдаа нар буудсан юм гэнэ билээ.

-Цагдаа нар гээ гээд Пассини газар нулимж, -Торгон цэргүүд чинь зургаан фут өндөр. Явахгүй гэсэн нь үнэн! Гэв.

-Цөм татгалздаг болоосой. Тэгвэл дайн дуусахсан билээ гэж Маньер хэллээ.

-Гэхдээ торгон цэргүүд ер энэ тухай бодолгүй, зүгээр л айцгаасан. Бүх офицер нь угсаатан байсан гэнэ билээ.

-Зарим офицер нь явсан.

-Явахгүй гэсэн хоёр офицерыг түрүүч буудсан

-Жагсаалын цэргийн зарим нь явсан

-Аравдахь хүний нь гаргахдаа тэр явсан цэргүүдийг жагсаагаагүй юм.

-Манай нутгийн нэг хүнийг тэнд будсан юм. Том биетэй, их өндөр ёстой торгон цэрэг баймаар сайхан залуудаа гэж Пассини хэлэв. Тэгээд тэр: Ромдоо, хүүхэнтэйгээ, цагдаатайгаа мөнхөрчээ гэж инээгээд цааш ярьсан нь: Одоо тэдний гэрийн үүдэнд жадтай манаа зогсож, эцэг эх, эгч дүүстэй нь хүн уулзуулдаггүй, эцгийн



нь иргэний бүх эрхийг хассан, сонгох ч эрх байхгүй, хэн ороод юугий нь аваад гарсан ч хуулиар хамгаалахгүй болсон юм гэв.

-Гэр орны нь тэгэж заналхийлдгээс айхгүй бол хэн ч довтолгоонд орохгүй байхсан.

-Ээ дээ. Альпийн буучид явах вий. Виктор-Эммануилийн хороо явах вий. Бас энэ цоохор цэргүүд явах вий.

-Энэ цоохор цэргүүд чинь зулбасан шүү дээ. Одоо эднүүс тэрнээ мартъя гэж байна уу.

-Дэслэгчээ та биднийг дэмий ийм ярианд орууллаа. Tenente. Evviva Lesercito<sup>10</sup> гэж Пассини санамжлав.

-Би ийм яриа хэдүйн сонссон. Та нар жолоо барихаараа ажлаа хийдэг... гэж би хэлэв.

-Өөр офицерт л дуулдахгүйгээр зөөлхөн ярьцгаа гэж Маньер үгээ дуусгав.

-Бид дайн дуусгах ёстой гэж би бодож байна. Нэг тал нь байлдахаа зогслоо гээд дайн дуусахгүй. Бид байлдахаа зогсвол бүр ч муу болно гэж би хэллээ.

-Муу болохгүй. Дайнаас дор юм байхгүй гэж Пассини онцлов хэлэв.

-Ялагдаа гэдэг бүр ч дор

-Үгүй ч биз. Ялагдана гэдэг юу юм бэ? Гэртээ харина л биз гэж Пассин мөн л онцлон хэлэв.

-Хойноос чинь дайсан очиж, гэр орны чинь, эгч дүүгийн чинь авна.

-Тэгэх ч үү дээ. Тэгвэл айл болгонд очно. Айл болгон тэр орноо хамаагалг. Эгч дүүсээ гаргахгүй байг гэж Пассини хэлэв.

-Чамайг дүүжилнэ. Чамайг барьж дахин байлдуулна. Гэхдээ эмнэлгийн тээвэрт биш, явган цэрэгт оруулна шүү дээ.

-Тэгвэл хүн болгоныг дүүжлэх байлгүй.

-Харин гүрэн өөрийнхөө төлөө байлдуулж чадахгүй. Анхны тулаанд л цөм зугтана гэж Маньер хрэлэв.

-Чехууд шиг

-Ялагдана гэдгийг мэдлэхгүй болохоороо та их амарханд санаж байна.

-Дэслэгчээ, бидний ярихыг та зөвшөөрч байх шиг байна. Та сонс л доо. Дайнаас аймшигтай юм ер байхгүй. Бид эмнэлгийн салбарт байгаа болоод дайны гамшгийг бүрэн мэдэх ч үгүй байна. Дайны аюулыг ойлгосон хүн ийм юманд хутгалдах ч үгүй, хутгалдвал галзуурна. Насандаа ойлгохгүй хүн ч бий. Офицероосоо айдаг хүн ч бий. Тийм хүмүүс л дайн хийдэг юм гэж Пассини хэлэв.

-Дайны аймшгийг би мэднэ. Гэхдээ энэ дайныг бид дуусгах ёстой.

-ДПуусахгүй. Дайнд эцэс гэж байхгүй

-Эцэс гэж хий.

Пассини толгой сэгсрэв.

-Ялснаараа дайнд хожихгүй. Бид Сан Гавриелийг эзэлье. Карсо Монфалькон Триестыг эзэлье гэж бод. Дараа нь яах вэ? Өнөөдөр алсын уулсыг та нар харсан биз дээ? Тэр бүгдийг бид эзэлж болно гэж та бодож байна уу? Австричууд байлдахаа боливол л болно. Нэг тал нь байлдахаа зогсууштай. Бид яагаад больж болохгүй билээ? Хэрвээ тэд итали хүрвэл ядраад буцах болно. Тэдэнд эх орон бий. Ингэхлээр үргэлж дайтах хэрэггүй.

-Та ёстой илтгэгч юмаа

-Бид сэтгэдэг. Бид уншдаг. Бид тариачин биш. Бид механикч. Тариачид ч гэсэн дайнд итгэж байх тэнэгүүд биш хүн болгон энэ дайныг жигшиж байна.

---

<sup>11</sup> Арми мандтугай гэсэн итали иг

-Хэзээ ч , юу ч ойлгодоггүй тэнэг анги улс орныг захирч байна. Үүнээс болж бид дайтаж байна.

-Тэд чинь бас дайнаар хөлждөг юм.

-Хөлждөггүй ч олон бий. Тэд дэндүү тэнэг болоод ийм юмыг энгүүнд үзэж байна. Тэнэгээс л тэр гэж Пассини хэлэв.

Одоо больё. Дэслэгчийг байхад бид дэндүү донгослоо гэж Маньер хэлэв.

-Дэслэгч нийцэж байгаа. Бид дэслэгчээ нэгэн илтгэлтэн болгоно гэж Пассини хэлэв.

-Одоохондоо боллоо гэж Маньер хэлэв.

-Дэслэгч ээ, бидэнд идэх юм өгөх нь үү? гэж Гавуцци асуулаа.

-Одоо би очоод ирье гэж би хэллээ.

Гордини босож надтай гарав.

-Дэслэгчээ, юу хийх хэрэгтэй байна? Би туслах уу? гэж төр дөрвийн хамгийн номхон Гордини хэлэв.

-Тэгвэл, надтай яв л даа. Юу болж байна, үзье гэж би хэллээ.

Хав харахуй болж, уулан дээгүүр шөнийн гэрлийн урт гэрэл зуралзана. Ачааны машин дээр зоосон асар том шөнийн гэрэл манай фронтод ирж шөнийн цагт тэргүүн шугамд тулам явна. Тийм ачааны машин замын хажууд зогсоод, дээр нь суусан офицер гэрэл тавихад цэргүүд сандарна. Үйлдвэрийн хашаагаар бид өнгөрч, эмнэлгийн төв салбарын үүдэнд зогсов. Хаалган дээгүүр саравчлан тавьсан ногоон мөчрийн навчис наранд хатаад шөнийн салхинд сэрчигнээн дотор гэрэл гарна. Ерөнхий эмч хайрцаг сандайлад утсаар ярина. Довтолгоон цагаар хойшилсон гэж надад нэгэн эмч хэлээд коньяк уу гэв. Урт ширээ, гэрэлд гялалзсан багаж, түмпэн, шилэн бөглөөтэй том лонх зэргийг би гүйлгэн харав. Миний ар талд Гордини зогсоно. Ерөнхий эмч утсаар ярьж дуусаад

-Одоо эхэлнэ. Хойшлуулахаа болилоо гэв. Гадагш харахад хав харанхуйд австрийн шөнийн гэрэл бидний арын уулан дээгүүр цайлалзана. Агшин зуур нам гүм байснаа бидний арын бух буу зэвсэг зэрэг гал нээв.

-Савойя гэж ерөнхий эмч хэлэв.

-Хоол яасан бэ? гэж би асуув. Тэр сонссонгүй тул давтан хэлэхэд минь

-Ирээгүй л байна гэв

Том галт бөмбөг дүүлэн ирж үйлдвэрийн хашаан дотор дэлбэрэв. Дахин нэг дэлбэрч тоосгоны хэлтэрхий, бөөн шавар шороо цацагдан бороо адил асгарах нь тодхон сонсогдоно.

-Аманд хийх юм байна уу?

-Жаахан Pasta asciutta<sup>11</sup> байна гэж ерөнхий эмч хэлэв.

-Юу л байвал авъя гэлээ.

Ерөнхий эмч нэгэн асрагчид хандаж үг хэлсэнд тэрвээр байрны доод давхарт орсноо түмпэнтэй хүйтэн гоймон авчирсныг би Гординид өгөв.

Бяслаг байхгүй юу?

Ерөнхий эмч сайхь асрагчид үглэн бас юм хэлсэнд тэрвээр дахин доош орж, цагаан яслалгны дөрөвний нэгэн зүсэм авчрав.

-Баярлалаа гэж би хэлэв

-Одоо та яваадхэрэггүй бие ээ гэлээ. Гадаа үүдэн дээр нэг юм тавих сонсоно. Тэр юм авчирсан асрагчдын нэг нь дотогш шагайн

-Нааш нь оруул. Юу болоов? Бид өөрсдөө гарч авч болох уу? гэж ерөнхий эмч хэлэв.

---

<sup>11</sup> Гоймонгоор хийсэн хоол гэсэн итали иг

Шархтны гар хөлөөс өргөж асрагчид дотогш оруулав.

-Ханцуйг нь огтол гэж ерөнхий эмч хэлэв. Тэр хэсэг самбай дуувуу, хямсаа барьж нөгөө хоёр эмч шинелийг нь тайлна.

-За эхэлье гэж ерөнхий эмч асрагчид хэлэв.

-Дэслэгчээ явъя гэж Гордини хэлэв.

-Буун дуу намжтал хүлээвэл дээр гэж ерөнхий эмч буруу харсан чигээр хэллээ.

-Хүмүүс өлөн байгаа гэж хэлсэнд

-За өөрөө л мэд гэв

Үйлдвэрийн хашаан дотор гараад бид гүйв. Яг эрэг дээр бөмбөг дэлбэрэв. Гэнэт хажууд бөмбөг буухаас урьд бид өөр юу ч сонссонгүй. Бид хоёул нам хэвтэхэд дэлбэрэлтийн нүргээн, бөмбөгний хэлтэрхий исгэрэх тоосго унах сонсдоно. Гордини босон зоорь тийш гүйхэд би тоосгоны гөлгөр өнгийг бүрхсэн тоосонд дарагдаад бяслагаа барьсаар дагаж гүйв. Зоорин дотор гурван жолооч урьдын янзаар хана налан сууж тамхи татна.

-Эх орончид минь үүнийг авцгаа гэж би хэлэв.

-Машин яаж байна? гэж Маньер асуув

-Зүгээр гэж би хэллээ.

-Дэслэгчээ айв уу? гэхэд нь

-Сүнс зайлчих шахлаа гэж би хэлэв.

Би тонгорог гарган тэнийлгээд ирий нь арчиж, бяслаг хальслав. Гавуцци надад гоймонтой түмпэн барьж

-Та эхэл гэв.

-Үгүй. Шалан дээр тавиад цөмөөрөө зэрэг идьэ гэж би хэллээ.

-Сэрээ байхгүй гэхэд нь

-Сэрээгээр яах юм бэ? гэж би англиар хэлэв.

Бяслаг зүсэн гоймон дээр тавиад би

-Идэцгээ гэв. Тэд хөдөлсхийгөөд хүлгэлзэхэд нь би гоймон дунд хуруугаа дүрээд авав. Бөөн гоймон хөврөлдөн ирлээ.

-Дэслэгчээ, сайн өргө гэв

Мөртэйгөө зэрэгцтэл өргөхөд гоймон тасарч, үзүүрий нь би уруулаа тосон үмхэлж зажлаад, мөн зүсэм бяслаг авч, идээд балга дарсаар даруулав. Дарснаас зэв амтагдана. Би Пассинид дашмаг өгөв.

-Новш чинь, дашмагт дэндүү уджээ. Би машинд авч явсан юм гэж би хэллээ.

Тэд дөрвүүл түмпэнд бараг эрүүгээ тулган идэж, "гоймон"-гийн үзүүр сорохдоо толгойгоо гэдийлгэнэ. Би дахин нэг ам дүүрэн үмхэж, бяслаг идээд, дарс уув. Гадаа нэг юм нүргэлж газар доргив

-420 миллиметрийнх үү, эсхүл миномет уу гэж Гавуцци хэлэв.

-Тийм хэмжээний буу ууланд байхгүй гэж би хэллээ.

-Тэдэнд Шкод гэдэг зэвсэг бий. Би сум туссан нүхий нь үзсэн 305 миллиметрийнх

Бид хооллосоор л байв. Галт тэрэг явах гэж байгаа юм шиг уухилж аахилсан чимээ гаргаснаа дахин газар доргитол дэлбэрэв.

-Энэ нимгэн зоорь шүү гэж Пассини хэлэв.

-Энэ лав миномет байна.

-Тийм байна.

Би зүсэм бяслаг идэж, дарс балгав. Үргэлжилсэн чимээн дунд түрчигнээн сонсдож, нүх-чүх-чүх-чүх гэж дуулдан, гэнэт аварга зуухны ам дэлгэх адил гялбаж, нүргэлэн, эхлээд цагаан, дараа нь час улаан өнгө гарч улайрсан шуурга нөмрөв. Амьсгаалах гэтэл амьсгаа гарахгүй, бие минь жингээ алдаад шурганд хийсэх шиг санагдав. Бие мин улам хурдан хийсэж буй нь мэдэгдээд үхсэн юм шиг санагдан

бодох ч хэрэггүй мэт. Би хийд хөвж урагш ахих гэтэл гэдрэг гулсана. Тэгтэл амьсгаа авч ухаан орлоо. Газар хөрвөөд салмарсан модон багана толгой тушаа минь хэвтэнэ. Толгой дүйрнэ. Гэнэ хүн уйлах сон.дов. Тэгснээ хүн чарлах шиг боллоо. Хөдлөх гэтэл хөдөлж болохгүй байна. Голын цаадтай, голын дагууд буун дуу, пулемётны дуу тасралтгүй сонсдоно. Гэнэт буу тасхийж галт сүм дүүлэн тэсэрч, пуужин харвах мэт хамаг юм гэрэлтэнэ. Бөмбөг дэлбэрнэ. Энэ бүхэн ганцхан агшинд л болов. Гэтэл хажууханд минь “Mamma mja! O! Mamma mja<sup>12</sup>” гэх сонсдов. Би зүтгэж цөхөж байж хөлөө сугалж эргээд тэр хүний дэргэд очтол Пассини байв. Биенд нь хүрэхэд тэр чарлав. Хөл нь наашаа харж хэвтэнэ. Гэрэл цайлзах хооронд харахад түүний хоёр хөл өвдөгнөөсөө дээгүүр няцраад, нэг нь бүр тасарч, нөгөө нь шөрмөсөндөө торж уранхай өмдөндөө санжийн байв. Тэр гараа хазлан гиншиж “O mamma mja mamma mja” гэснээ *Djo te Salve Marja*<sup>13</sup>. Инсус бурхан минь, ариун ахай минь, яая даа би. Ээ-э-э гээд санаа алдсанаа “Mama mama mja!” гэв. Тэгээд гараа хазлан дуугүй болоход нь санжсан хөл нь хөдөлсөөр байв.

-Porta Feritj!<sup>14</sup> гэж би гараа амандаа барьж хашгирав. Тэгээд Пассиний дэргэд хүрч хөлий нь янзлах гэсэн боловч би хөдөлж чадсангүй. Ахин оролдсонд хөл маань арай чүү хөдөлж тохойлдон ахив. Пассини чимээгүй л байв. Би дэргэд нь сууж гадуур цамцаа яраад, дотуур цамцныхаа хормойг цуулах гэтэл хүч хүрэх үгүйд шүдээр сэтлэв. Тэр даруйд би Пассиний хөлийн ороолтыг санав. Би ноосон оймстой, тэр ороолттой яадаг билээ. Ер жолооч нар цөм ороолттой. Гэтэл Пассини өрөөсөн хөлтэй болжээ. Ороолтын үзүүрийг олж тайлах зуур ажвал тэр хэдүйн үхсэн тул, боодол хэрэггүй болов. Шалгаж үзвэл тэр үнэхээр үхжээ. Нөгөө гурав нь хэрхсэнийг мэдэх хэрэгтэй байв. Өндийн суутал, толгой эргэж би дайван, хүүхэлдэн нүдний туухай адил юм, нүдэн дотор цохих шиг боллоо. Хөл минь нойт даан бүлээ оргиж, шаахай нойтон бүлээн болов. Шархдаж гэж ухаараад би бөхийж өвдөг дээрээ гар тавих гэтэл өвөг минь алга байв. Гар минь гулгасаар ардаа эргэсэн өвдөгт хүрэв. Гараа цамцандаа арчтал цагаан гэрэл дахин алгуур тусав. Хөлөө хартал хачин аймшиг төрлөө. “Бурхан минь, намайг эндээс гаргаач” гэж би үглэв. Дөрвөн жолооч байсан. Пассини алагдсан. Одоо бас гурван жолооч байх ёстой. Гурав үлдсэн. Гэтэл нэг хүн суганаас барьж, бас нэг хүн хөлий минь өргөв.

-Бас гурав байх ёстой. Нэг нь алагдсан гэж би хэлэв.

-Би Маньер байна. Бид дамнуурганд яваад олсонгүй. Дэслэгчээ, та ямар байна?

-Гордини, Гавуцци хоёр хаана байна? гэсэнд

-Гордини салбарт боолгож байгаа. Гавуцци таны хөлийг өргөж байна. Дэслэгч та миний хүзүүгээр тэвэр. Та их шархдаа юу? гэж Маньер хэлэв.

-Хөлд гэнээ, Гордини яагаав?

Гайгүй ээ. Минометын бөмбөг дэлбэрсэн юм.

-Пассини алагдсан.

-Тиймээ алагдсан

Гэтэл дэргэдхэн бөмбөг дэлбэрч тэр хоёр газар хэвтэхдээ намайг унагав.

-Айхдаа тэглээ

-Та хоёр шархдаагүй биз?

-Бид хоёр хөнгөн шархадсан.

-Гордини машинаа барьж чадах уу?

---

<sup>11</sup> Ээж минь! гэсэн итали иг

<sup>22</sup> Мария чамайг бурхан ершеег гэсэн итали иг

<sup>33</sup> Шархтанг аваач! гэсэн итали иг

-Яах бол доо

Тэгээд салбар хүртэл тэд намайг бас дахин нэг унагав

-Новшнууд гэж би хэлэв

-Уучлаарай, дэслэгчээ! Дахиад унагахгүй гэж Маньер хэллээ.

Эмнэлгийн салбарын гадаа, харанхуйд олон шархтан газар хэвтэх бөгөд сувилагчид дамнуур барин орж гарахад хөшиг сөхөгдөн, доторхи гэрэл надад харагдав. Үхэгсдийг нэг тийш ялган тавьжээ. Мөрөндөө тултал хануй шамласан эмч яргачин адил улаан болжээ. Дамнуур үл хүрэлцэнэ. Шархтны зарим нь ёолох бөгөөд ихэнх нь дуугүй хэвтэнэ. Тогтон дээгүүр унжуулсан мөчрийн навчис салхинд сэржигнэн, шөнө хүйтэн болов. Сувилагчид цаг ямагт дамнуураар хүн зөөсөөр байв. Салбарт хүрсэн даруйд Маньер бага эмч авчирч миний хоёр хөлийг боохдоо, шарханд нь шавар шаалдаад цус бага алдсан байна гэж хэлэв. Жаахан гайгүй болмогц надад мэс засал хийх гэнэ. Эмч нэгэн салбарын байранд оров. Гордини машин барьж чадахгүй нь ээ гэж Маньер хэллээ. Түүний мөр нь няцарч толгой нь хагарчээ. Эхлээд тэр өвдөхөө мэдэхгүй байснаа, мөр нь янгинаж эхэлжээ. Тэр одоо тэнд нэгэн тоосгон хана налан сууна. Маньер, Гавуцци хоёр машиндаа шархтан ачаад одов. Тэдэнд шарх саад болсонгүй. Тус бүр хоёр сувилагч бүхий гурван англи машин ирэв. Царай нь хачин цонхийж муудсан Гордини нэгэн англи жолооч дагуулан ирсэнд, тэр жолооч дээрээс минь тонгойж:

-Та их шархдаа юу? гэж асуулаа. Тэр хүн өндөр нуруутай агаад төмөр саравч зүүжээ.

-Хоёр хөл

-Гайгүй байгаа. Янжуур татах уу?

-Баярлалаа.

-Таныг хоёр жолоочоо алдсан гэж би сонслоо.

-Ти ймээ. Нэг нь алагдсан Нөгөө нь саяын таныг хүргэж ирдэг тэр

-Хэцүүхэн байна. Тэдний машиныг бид авах уу?

-Би яг хэлэх гэж байсан юм.

-Бид ёсоор нь авч яваад буцааж өгнө. Та хоёр зуун зургаагийнх биз дээ?

-Тиймээ.

-Танай тэнд их сайхан газар билээ. Хотод би таныг харсан. Таныг америк хүн гэж надад хэлсэн

-Тиймээ

-Би англи хүн

-Тийм гэж үү?

-Би англи хүн л дээ. Итали гэж та бодоо юу? Манай машиныг авбал тун сайн байна гэж би хэлэв.

-Бид бүрэн бүтэн буцааж өгнө гээд тэр босож,

-Тавтай ярилцаач гэж танай жолооч надаас их гуйсан юм гэж хэлээд тэр Гординийн мөрийг алгадахад Гордини цочин инээвхийлэв. Тэр англи италиар сурмаг түргэн ярьсан нь

-За, бүх юм зохицлоо. Би дэслэгчтэй чинь тохирлоо. Танай хоёр машиныг бид авна. Одоо чамд зовох юмгүй болсоон гэснээ үгээ тасалж, таныг эндээс авч явах арга бодолгүй болохгүй. Би одоо эмч нартай ярьъя. Бид явахдаа таныг авна гээд тэр, шархтны хоорондуур хянуур алхлан үүдэн тийш зүглэв. Үүд рүү унжуулсан бүтээлэг сөхөж ороход нь гэрэл үзэгдэв.

-Энэ хүн танд санаа тавьж байна, дэслэгчээ гэж Гордини хэлэв.

-Бие чинь ямар байна Франко?

-Зүгээр гээд тэр дэргэд минь суув.

Тэр зуур салбарын үүд рүү унжуулсан бүтээлэг сөхөж хоёр сувилагч нэг өндөр

англи хүн гарч намайг чиглэн ирцгээв.

-Америк дэслэгч ирлээ гэж тэр италиар хэлэв.

-Би хүлээж болно. Надаас илүү шархтан энд байна. Би ч бас гайгүй байна гэж би хэлэв.

-За, за баатарлах гээд яахав гэснээ тэр италиар: хөлий нь тун болгоомжтой өргөөрэй, их өвдөж байгаа юм. Энэ чинь ерөхийлөгч Вильсоны төрсөн хүү нь гэв. Тэд намайг дамжилж салбарын байранд оруулахад, ширээ болгон дээр мэс засал үйлдэх бөгөөд намхан ерөнхий эмчбидний зүг дурамжхан эргэж харснаа намайг таниад хямсаагаар занган:

-Ca va bien?<sup>15</sup>

-Ca va<sup>16</sup> гэж би хариулав

-Би авчирлаа. Америкийн элчингийн ганц хүү. Таныг хүлээж энд хэвтэж байг. Тэгээд би хамгийн түрүүнд аваад явна гэж өндөр англи хүн италиар хэлээд над руу бөхийж

-Таны үнэмлэхийг янзалбал, явахад амар болно. Би очоод ирье гэж бөгтийн гарч одов. Ерөнхий эмч хямсаануудаа ялгаж, түмпэнд хаялаа. Би түүний хөдлөх бүрийг ажна. Тэр шархтанг боож байна. Дараа нь нөгөө шархтанг сувилагч нар ширээнээс зөөв.

-Америк дэслэгчийг аваад ир гэж нэг эмч хэлэв

Намайг өргөж ширээн дуур тавилаа. Ширээ нь хатуу агаад гулсамтгай ажгуу. Эргэн тойрон үнэр утаж, эмийн үнэр, цусны таатайхан үнэр ханхална. Өмдий минь тайлаад зөвлөх бага эмчдээ их эмч нь хэлж бичүүлэн ажлаа үргэлжлүүлэв.

-Баруун зүүн гуя, баруун зүүн өвдөг баруун өлмийдөө өнгөц шарх ихтэй. Баруун өвдөг өлмий нь лав шархадсан хуйх нь яварсан шархтай (тэгээд тэр “өвдөж байна уу”, “Ээ, ёо өвдөж байна” гэж туршив) Гавлын яс бага зэрэг доргисон. Байлдааны талбарт шархадсан гээд тэр: Ямар ч гэсэн таныг санаатайгаар эрхтнээ гэмтээсэн гэж цэргийн хээрийн шүүхэд өгөхгүй юм байна. Балга конъяк архи ууна уу? Яагаад ингэчихээ вэ? Амиа хорлож үхмээр санагдаа юу? Татран эсэргүүцэх ийлдэс надад өгөөрэй. Бүртгэлдээ хоёр хөлий нь чагтаар тэмдэглээрэй. За баярлалаа. Одоо би жаахан цэвэрлээд угааж бооно. Таны цус сайхан эргэж байна гэж тэр хэлэв. Зөвлөх нь бүртгэлээ нүд салган:

-Юунд шархадсан бэ? гэж асуув.

-Юунд ингэсэн юм бэ? гэж эмч бас асуув

-Бөмбөгөнд гэж би нүд аниастай хэвээр хэлэв.

Эмч ихэд өвтгөн зүсэж байснаа:

-Үнэн үү? гэв.

Тонгоргоор биеий минь зүсэхэд гэдсээ чангалан байгаагаа мэдрэн тайван хэвтэхийг хичээж

-Тийм байхаа гэв

-Эмч нэг юм олж ихэд сонирхоод:

-Дайсны бөмбөгний хэлтэрхий байна. Дахиад би энэ талаас нь нэг шалгаад үзэх үү дээ. Одоо би энд дарлаа... Төөнөрч байна уу? Зүгээр, энүүнээс илүү юм болно. Өвдөх болоогүй байна. Хундага конъяк авчирч өгөөрэй. Өвдөхөө бага мэдэрнэ. Айгаад байх юм алга өрөвсөхгүй л бол зүгээр. Одоо ч өрөвсөх нь ховор байна. Толгой чинь яаж байна? эгв.

-Ээ, бурхан минь гэж би хэлэв

---

<sup>11</sup> Яаж байна, зигээр ий? гэсэн франц иг.

<sup>22</sup> Зигээр гэсэн франц иг

Тэгвэл конъяк бага увал дээр. Хэрэв тархи хөдөлсөн байвал, өвчин болно. Тэгвэл их муу. За, энд өвдөж байна уу? гэхэд нь миний хөлс асарч:

-Ээ бурхан минь гэв

-Тархи нь жаахан хөдөлсөн шиг байна. Би одоо боож өгье. Толгойгоо битгий хөдөлгөөрэй гэлээ.

Тэгээд тэр боож эхлэхэд, гар нь тун ч түргэн хөдөлж боолт нь нягт бөмбөгөр болов.

-За, сайн яваарай. Vita la trance<sup>17</sup> гэв.

-Америк хүн гэж нөгөө нэг эмч хэлэв.

-Надад тэгэж санагдлаа. Та франц гэсэн биз дээ. Энэ францаар ярьдаг юм. Би урьд нь мэлднэ үүнийг франц хүн л гэж би үргэлж бодож явдаг. Энэ хагас хундага конъяк архи уулаа. За, арай жаахан илүү юм өгөөрэй. Татран эсэргүүцэх ийлдэс бас бэлдээрэй гэж хэлээд тэр над руу гараараа зангав. Намайг өргөж аваад, замдаа нүүрий минь хөшгөөр бүтээв. Намайг аваачиж тавихад Зөвлөх бага эмч дэргэд минь сөхөрч суугаад:

-Овог? Нэр? Нас? Тушаал? Төрсөн газар? Аль анги? Ямар салбар? Гэхчилэн намуухан асууж тьолгойн чинь бүтээлэг эвгүй байна уу, дэслэгчээ? гэхдээ одоо танд арай дээр байгаа биз дээ. Би таныг английн эмнэлгийн машинаар явуулъя гэж тэр хэлэв.

-Би сайн байа. Танд их баярлалаа гэж би хэлэв. Эмчийн хэлснээр өвдөж эхэлсэн бөгөөд эргэж тойрны юм бүхэн утга учраа алдлаа. Хэсэг зуур болоод английн машин ирж, намайг дамнуур дээр тавин, ачааны тэвштэй чацууртал өргөж, дотор нь оруулав. Хажуугийн дамнуур дээр бас хүн хэвтэх бөгөөд нүүрий нь битүү боож зөвхөн хамар нь боолтон дундаас лааны тос адил юм цухуйна. Тэр тун зовж амьсгална. Мөн хоёр дамуур өргөж дээд талын дүүжин хэцэн дээр тавив. Нөгөөх өндөр англи жолооч ирж шагайгаад: Би аяархан явна. Та нарыг зовоохгүйг хичээнэ гэж хэлэв. Мотор асах болон жолооч урд суудалдаа гарч суух, мөн тоормос залгаж хөдлөхийг би мэдэрсээр байв. Бид замдаа орлоо. Би өвдөхийг тэвчээрлэн хөдлөлгүй хэвтсээр билээ.

Өгсүүр газар машины хурд саарч, заримдаа зог тусан заримдаа ухран эргэж сүүлдээ нилээд хурдлах боллоо. Гэтэл надад дээрээс юм урсаж мэдэгдэв. Эхлээд хааяа жигдхэн дусалж байснаа гоожих болов. Жолоочийг дуудсанд машинаа зогсоож цонхоор эргэж:

-Юу болоов? гэж асуув

-Миний дээр байгаа шархтан цус алдаж байна гэсэнд

-Даваа хүртэл тун бага үлдлээ. Би ганцаар дамнуур авч явж дийлэхгүй гээд машин дахин хөдлөв. Юм гоожсоор байв. Брезентний хаагуур нэвтэрч байгааг би харанхуйд харах арга алга. Биеэсээ зайлуулах гэж би хажуу тийш хөндийрөхийг оролдов. Дуссан газар цамцны минь ард бүлээрэн наалдана. Хөл минь янгинаад бие бүр хачин болов Жаахан байтал юм гоожих нь татарч, дахин дуслаар дусах бөгөөд тэр дээр байгаа хүн эвтэйхэн хэвтэх гэж байгаа бололтой дамнуургын брезент хөдлөхийг би сонсож мэдлээ.

-За яаж байна? гэж асуугаад нөгөөх англи хүн эргэж: бид бараг хүрч ирлээ гэв

-Үхчих шиг боллоо гэж би хэлэв.

Дусал улам удаж, нар жаргасны дараа мөснөөс ус дуслах лугаа адил болов. Уулын замаар шөнө явахад машин дотор хүйтэн байлаа. Салбарт ирэхэд сувилагчид дамнуураар хүн солиод бид цааш явлаа.

---

<sup>11</sup> Франц мандтугай! Гэсэн франц иг

Хээрийн цэргийн эмнэлэгт байхад минь, үдийн холны дараа хүн ирнэ гэж надад хэллээ. Халуун өдөр болоод тасалгаанд ялаа элбэг байлаа. Миний туслах цаас зүсэж туужуу мэт модонд уяад даллаж ялаа үргээнэ. Ялаа таазанд суухыг харж баснаа би, үргээхээ болихоор нь унтана. Гэтэл ялаа цөм бууж ирэх бөгөөд би үлээж үргээж байснаа гараар нүүрээ таглан аанай унтчихна. Тун ч халуун байлаа. Сэрэхэд хөл минь загатнана. Би туслахаа сэрээв. Тэрвээр миний боодол дээр рашаан ус хийсэнд ор дэвсгэр чийглэг сэрүүн боловч. Унтаагүй нэг нь тасалгаа алгасан ярьж, үдийн хоолноос хойш хамгийн тайван байлаа. Өглөөгүүр гурван сувилагч, нэг эмч ээлжээр ор болгоны дэргэд очиж хэвтэж буй хүний өргөн боолтын өрөөнд аваачих бөгөөд тэр завсар ор дэвсгэрийн нь засна. Боолтны өрөөнд аялах нь онц таагүй боловч тэр үед би, хэвтэж буй хүний нь өргөлгүй ор дэвсгэрийн нь засаж болох эсэхийг мэдэхгүй байлаа. Туслах маань хамаг усыг юүлсэн тул ор дэвсгэр аятай сэрүүхэн болж, улныхаа загатнааг гаргах гэж би маажих газры нь зааж байтал нэгэн эмч миний тасалгаанд Ринальдийг дагуулан орж ирэв. Тэр тун түргэн орж ирэн орон дээр тонгойгоод намайг үнсэв. Гартаа тэр бээлий хийжээ.

-За, хүү минь яаж байна? Бие чинь ямар байна? үүнийг чамд авчирлаа... гэж тэр лонх конъяк архи барьжээ. Туслах маань сандал авчирсанд тэр сууж: аятайхан сонин сонсоё. Чамайг шагналд дэвшүүлжээ. Мөнгөн медаль авна гэж бодож бай. Гэхдээ хүрэл ч байж магадгүй гэв.

-Яагаад шагнах болоо вэ?

-Чи хүнд шархадсан байна шүү дээ. хэрвээ чи гавъяа багуулсан гэж нотолбол мөнгөн медаль авна гэж ярьцгааж байна. Эсхүл хүрлийг авна. Юу болсны нь над тодорхой яриач: Гавъяа байгуулсан уу?

-Үгүй ээ, бөмбөг дэлбэрэхэд би бяслаг идэж суусан гэж би хэлэв

-Бүү солиор. Тэрнээс өмнө юм уу, хойно чи ямар нэгэн гавъяа байгуулаагүй байж болохгүй. Сайн бодоорой.

Юу ч хийгээгүй.

-Шархтай байхдаа хүн үүрээгүй юу? Хэдэн хүн үүрч зөөсөн гэж чамайг Гордини ярьса. Харин нэгдүгээр салбарын их эмч, тэгэх нөхцөлгүй гэж байна. Шагналын тодорхойлолтонд тэр л гарын үсэг зурах ёстой.

-Би хэнийг ч зөөгөөгүй. Би хөдөлж ч чадахгүй байсан.

-Тэр хамаагүй гэж Ринальди хэлэв

Тэгээд тэр бээлийгээ тайлав

-Гэхдээ бид мөнгөн медаль болгоноо. Чи бусдын өмнүүр орж эмнэлгийн тусламж авахаас татгалзсан байж болохр уу?

-Шууд ч юмгүй.

-Тэр хамаанүй. Шарх чинь ямар вэ?

Чи эрэлхэг зориг гаргасан байна. Би цаг ямагт л тэргүүн шугаманд явъя гэж гуйдаг байсан шүү дээ. Түүнээс гадна мэс засал амжилттай болсон.

-Гол гаталж амжаа юу даа?

-Амжихаар барах уу! Мянга орчим хүн олзолсон. Мэдээлэлд тэгж байсан. Чи үзээгүй юу?

-Үгүй



-Би авчирч өгье. Гайхалтай *cour de main*<sup>18</sup> болсон.

-За та нар ямар байна даа?

-Жигтэйхэн сайхан. Цөм жигтэйхан сайхан. Бүгд л чамайг бахдаж байна. Юу болсноо надад яриач? Чамайг мөнгөн медаль авна гэж би бодож байна. За яриарай. Цөмий нь нарийн яриарай гээд бодлогошрон дуугүй байснаа:

-Чи бас англи медальч авч болох юм шүү. Тэнд чинь англи хүн байсан. Би түүнтэй уулзаж чиний тухай ярих эсэхийг нь асууя. Тэр лав тус болно байх. Их өвдөж байна уу? Уугаарай. Туслахаа, эрэг аваад ирээрэй. Би нэг өвчтөнөөс гурван метр нарийн гэдэс авсныг чи үзсэн ч болоосой. Энэ тухай “Ланцетэд” бичих хэрэгтэй. Чи надад орчуулж өгөөрэй, би “Ланцетэд” явуулъя. Би өдөр болгон дэгжиж байна. Хөөрхий муу хүү минь, тэгээд бие чинь ямар байна даа. Нөгөө хар эрэг нь яачихав аа? Чамайг ийм намуухан тэсвэртэй болохоор би шархтайгий чинь мартаж байна гээд бээлийгээрээ орны ирмэг цохив.

-Эрэг авчилаа, *signor tenente* гэж туслах хэлэв.

-Бөглөөгий нь аваарай. Аяга авчраарай. Хүү минь уугаарай: Толгой чинь яаж байна? Би өвчний түүхий чинь үзсэн. Тархи хөдлөөгүй байна билээ. Тэр нэгдүгээр салбарын эмч чинь ёстой малын эмч. Би бол өдөж мэдэгдэхгүйгээр л юм бүгдийг хийнэ. Надаар эмнүүлсэн хүн өвдлөө гэдэггүй юм. Би тэгж л ажилладаг. Өдрөөс өдөрт би илүү сайн ажиллаж байна. Уучлаарай хүү минь, би дэмий юм их ярилаа. Шарх чинь хүнд байх гэж би их зовлоо. За уугаарай. Сайн конъяк архи шүү. Лонх нь арван таван литрийн үнэтэй. Сайн байх ёстой. Таван таван хошуутай. Эдээс одоо би тэр англи хүнтэй очиж уулзъя. Тэр чамд англи медаль олгохыг бодог.

-Тийм ам ар авч болохгүй байх аа.

-Чи дэндүү даруу байна. Би холбооны офицер явуулъя. Тэр англичуудтай хэлэлцэж чадна.

-Чи Баркли хүүхнийг хараагүй юу?

-Би түүнийг чинь дагуулаадирье. Одоохон очоод би дагуулаад ирье

-Битгий аваач. Горицийн тухай ярьж аль Охидууд яаж байна? гэж би хэлэв.

-Охид байхгүй. Хоёр долоо хоногоор тэднийг сольсонгүй. Би дахиад тийш очихгүй ёстой дэмий.н тэд чинь охид биш, хуучин дайчин нөхөд болсон.

-Ер очихгүй юу?

-Сонин юу байна гэж хааяа шагайдаг. Зүгээр л тэр. Тэд цөм л чамайг асуудаг юм. Ёстой дэмий. Бид нөхөд болбол болохоор удлаа...

-Дахиад фронтод явах хүн гараагүй байх шүү?

-Тэгэх ёсгүй. Хүүхнүүд элбэг бий. Айхавтар байгууллага шүү. Ар талын баатрууд болгох гэж бариад байга юм.

-Ринальди минь дээ. Дайнд гав ганцархнаа, шинэ охид ч ирэхгүй байна даа гэж би хэлэв

Ринальди конъяк архи аягалав.

-Чамд муу юм болохгүй, хүү минь уучих гэв. Би конъяк архи уугаад, бүхэл биеэр халуу оргихыг мэдрэв. Ринальд бам аягалав. Тэр бага зэрэг тайвшраад аягаа авч: Чин гавъяат шархын төлөө! Мөнгөн медалийн төлөө! Хүү минь цаг үргэлж л ийм халуунд хэвтээд байхад цухалдахгүй байна уу гэв.

-Зартим үед л.

-Надад бол бодоход ч хэцүү байна. Би бол галзуурна байх.

-Чи чинь галзуу шүү дээ.

-Чи хурдхан очоосой. Шөнийн зугаалганаас хамт буцах хнгүйдэж байна.

---

<sup>11</sup> Цохилт гэсэн франц иг

Оролдох хүн алга. Мөнгө зээлэх хүн алга. Хамт суудаг ах болох хүн алга. Чи юунд ингэж шархдав даа.

-Ламаар ородохгүй юу?

-Би ер нь тэр ламаар ороддоггүй. Ахмад л ороддог. Тэр лам надад аятай санагддаг юм. Хэрэв чамд лам хэрэгтэй бол манай ламыг аваарай. Тэр чамайг эргэж ирнэ гэж цаг сонгон бэлдэж байгаа шүү.

-Би тэрүүнд их хайртай.

-Би мэднэ. Лам тэр хёр нэг л учиратай шиг надад санагддаг юм. За, чи мэднэ шүү дээ.

-Чамд юу нь санагдах билээ

-Санагддаг гэм

-За, чи явж тонилтугай.

-Тийм бий. Би чиний тэр ариун хүүхний чинь тухай мэддэгээ хэлье л дээ.

Чиний тэр дагины чинь тухай. Ариун хүүхэн, нас гүцсэн авгайхүн хоёрт ганцхан ялгаа байдаг юм.

Тэр босож бээлийгээ хийв.

-Хүү минь, би чамаар ородох тун их дуртай юм. Тэр лам, тэ англи хүүхэн хамаагүй бол, чи сэтгэл санаагаар яг л бидэг шиг шүү дээ.

-Тийм үгүй ээ.

-Яг л тийм дээ. Чи ёстой л итали хүн. Гаднаа гал утаа, дотро хов хоосон. Харин чи Америк хүн гэх л дуртай. Бид чамтай ах дүүс бие биенээ хайрладаг.

-За, тэгвэл чяи одоохондоо миний дуулгаварт хүү бол л доо гэж би хэлэв

-Би чам руу Баркли хүүхнийг явуулгъя. Надгүйгээр та хоёр уулзал сайн. Чи цэвэрхэн ялдамхан хүн

-Чи тонилтугай.

-Би тэр хүүхнийг чинь явуулна. Чиний тэр сайхан, хүйтэн дагины чинь явуулна. Бурхан минь тийм хүүхэнд мэхийхгүй л юм бол өөр яах билээ дээ? Англи хүүхнээр өөр яах ч юм билээ дээ.

-Чи ёстой мунхаг хар хог.

-Хэн тэр вэ?

-Мунхаг жонхуу

-Жонхуу гэнээ. Чи өөрөө жонхуу... хөлдүү царайтан

-Мунхаг, мулгуу гэхэд миньтэр эвгүйсэн тул би цааш нь бүдүүлэг, харанхуй, боловсролгүй мулгуу амьтан гэв.

Хүүхэн хүнийг авахад эмзэг байдаг. Ийм л шүүдээ... гээд бээлийгээрээ орж цохиж:

-Хүүхэн хүндээ тэгээд таалагдаж багаа үгүй г нь хэзээ ч мэдэхгүй гэв.

-Бүү уурла.

-Би уурлаагүй. Чиний тусын тулд л, чамайг илүү юмнаас аврах гэж л би хүү минь энэ үгийг хэлж байна.

-Тэгээд л болоо юу?

-Тэглээ. Гэхдээ чам шиг сая сая тэнэг ч мэдэхгүй.

-Хэлсэн үг чинь тун аятай байна даа.

-Хүү минь хэрэлдэх хэрэггүй. Би чамайг даанч хайрлаж явдаг. Гэхдээ бүү тэнэглээрэй.

-Харин би чам шиг л цэцэн болж үзьец.

-Бүү уурлаарай, хүү минь. Инээгээрэй дахиад уугарай. Би явах боллоо.

-Чи ч сайн хүү л дээ.

-За тэр шүү. Чи яаг л над шиг сэтгэлтэй хүн. Бид дайны ах дүс. Намайг үнсэж үд л дээ.

-Чи муу шүлхий.

-Үгүй ээ. Би блат бэх хүн

Нүүрэнд минь түүний амьсгалмэдэгдлээ.

-Баяртай. Би удахгүй дахиад ирнэ гээд амьсгаа нь холдож, үнсэх дургүй бол хэрэггүй англи хүүхний чинь би явуулна. Баяртай, хүү минь. Конъяк архи орон дор чинь бий. Түргэн эдгээрэй гээд гээд тэр далд оров.

[Тор](#)

---

Ламыг орж иэрэхд бүрэнхий болж байв. Шөл авчирч өгөөд таваа буцааж зөөв. Эгнэсэн ор болон цонхны цаана үдшийн зөөлөн салхинд орой нь найгасан иоддыг би харж хэвтлээ. Цонхоор салхи сэвэлзэж, шөнө ойртох тусам сэрүүн болов. Цахилгаан дэнлүү зүүсэн утас болон дээвэрт ялаа шавжээ. Тасаг дотор юм хийх буюу шөнө шархтан авчирвал л гэрэл асаана. Тэгээд л бүрий орсны дараа харанхуй болж, өглөө болтол харанхуй байх агаад би дахин хүүхэд болсон шиг санагдана. Оройн хоол идмэгц л хучиж унтуулдаг тул үнэхээр ч тийм болой. Орны хоорондуур явсаар туслах маань ирж зогсов. Бас нэг хүн хамт ирсэн нь лам байлаа. Намхан хөх лам, дэргэд минь зовуурилан зогсоно.

-Бие чинь ямар байна? гэж тэр асуугаад орны дэргэд шалан дээр боодолтой юм тавив.

-Сайн байнаал, лам багш минь гэв

Ринальдийн сууж байсан сандал дээр тэр сууж, цонхон тийш зовнингүй харлаа. Царайд нь тун их ядарсан шинж илэрхий.

-Би тун удахгүй. Оройтчихлоо гэж тэр хэлэв.

-Арай оройтоогүй. Ла нар ямар байна? гэж би асуув. Тэр лам инээвхийлэн, урдын адаил намайг тайтгаруулаад, ядарсан дуугаар Бурхны авралаар цөм эсэн мэнд байна. гэв.

-Хамаг юм зүгээр өнгөрсөнд чинь би баярлаж байна. Өвдөх нь гайгүй юу? гэж тэр лам асуув.

Тэр лам тун ядру санагдав. Би ер тийм байхы нь харж дадаагүй юмсан.\_

-Одоо өвдөх юмүй.

-Чамгүйгээр хол идэхэд ч надад их уйтай байн.

-Би ч хурдхан очмоор байна. Тантай ярихад надад үргэлж аятайхан байдаг ч юм.

-Би чамд юм авчирсан гэж хэлээд тэр шалан дээрээс боодолтой юм авч шумуулаас хамгаалдаг тор, лонх вермут хэмээх дарс авчирлаа. Та вермут дарсанд дуртай биз дээ? Бас англи сонин авчирсан гэв.

-За, задлаад аль гэхэд минь тэр байрлан боодлы нь тайлав. Би шумуулаас хамгаалдаг торы нь авлаа. Тэр лам вермут дарсаа өргөн үзүлээд, орны дэргэдэх ширээн дээр тавив. Би нэг сонин авч цонхны бүдэг гэрэл өөд харуулан гарчиглавал "Ньюс оф уорлд" хэмээх сонин байв.

-Бусад нь зурагт хуудас гэж тэр хэлэв.

-Би их сонирхож уншдаг юм. Та хаааас олоо вэ?

-Би Местрид захиж авчруулсан юм. Би бас олноо

-Та их сайн хүн болоод намайг эргэж ирлээ, багш минь. Аяга вермут дарс уугаач?

-Хэрэггүй ээ, чамд авчирсан юм.

Ганц аягыг уучих л даа.

-За, тэгье. Дараа би бас чамд авчирнаа. Туслах хоёр аяга авчирч лонх онгойлгов. Бөглөө нь бацраад хагасы нь дотогш нь түлхэхийг хараад лам гоморхсон авч: за яахав хамаагүй гэж гэж хэллээ.

-Лам багш таны эрүүл мэндийн төлөө!

-Таны эрүүл мэндийн төлөө!

Тэгээд тэр аягаа барьсаар, бид хоёр бие биенээ ширтэлцэв. Бид хоёр элэгсэг яриа дэлгэх гэсэн авч, энэ удаа нэг л ээлж өгөхгүй байлаа.

-Багш минь та яагаа вэ? Та их ядруу харагдаж байна.

-Би ядарчээ. Гэвч ядрах ёсгүй юмсан.

-Халуунд тэр байхаа.

-Үгүй ээ, дөнгөж л хавар болж байна шүү дээ. Сэтгэл зовуурьтай байна.

-Дайнд тэр үү?

-Үгүй ээ. Гэхдээ би дайныг үзэн яддаг.

-Би ч бас дайнд аятай юм харахгүй л байна гэж би хэлэв.

Тэр лам толгой сэгсрээд цонхоод харлаа.

-Дайн чамд саад болохгүй. Дайныг чи үзэх ч үгүй. Уучлаарай, чиний, шархтайг би мэдэж байна.

-Энэ тохиолдол юм даа.

-Чи шархадсан ч дайныг үзэхгүй гэдгийг би мэдэж байна.

Би өөрөө ч дайн үзээгүй байна. Гэхдэ цайныг жаахан мэдэрч байна.

-Намайг яг шархдахад бид дайны тухай ярьж байсан. Пасини ярьж байсан юм.

Лам аягаа тавиад, өөр юм бодов.

-Би тэдэн шиг болохоороо тэднийг мэдэж байна гэж тэр хэлэв.

-Та хахь өөр

-Үнэндээ л би тэдэн шиг л дээ Офицерууд юу ч үзэхгүй

-Цөм адилгүй. Тун сэргэг нь биднээс бүр дор байгаа.

-Тийм нь цөөхөн

-Энд мөнгө, болвсрол хамаагүй. Энд арай л өөр. Пассини шиг мөнгөтэй, боловсролтой, байлаа ч офицер болохыг хүсэхгүй биз. Би бол офицер болохыг хүсэхгүй.

-Зэргэмжээр та адилхан офицер. Би ч офицер шүү дээ.

-Адилгүй ээ. Харин чи итали ч биш гадаадын харъяат. Гэхдээ жагсаалын цэргээс офицерт чи ойр.

-Ямар ялгаатай юм бэ?

-Тайлбарлахад хэцүү байна. Байлдах дуртай хүн гэж байна. Манай оронд тийм хүн олон бий. Байлдах дургүй хүн гэж бас байна.

-Байлдах дуртай нь дургүйгээ албадна.

-Тэгнээ.

-Харин би тэрүүнд тусалж явна

-Та бол гадаадын, эх оронч хүн

-Тэр байдалдах дургүй лс нь дайныг саатуулж чадах уу?

-Мэдэхгүй.

Тэгээд тэр дахин фонхор харав. Би нүүрний нь өнгийг ажиглан байв.

Ер нь тэд тэгээд дайныг саатуулж байсан юм уу?

-Тэд зохион байгуулалтгүй болоод юуг чсаатуулж чадахгүй. Зохион байгуулахаар нь удирдагч нь урвадаг юм.

-Найдваргүй юм шив дээ

-Найдлагагүй юм гэж байхгүй. Гэхдээ найдаж болохгүй тал бас байна. Найдъя

гэвч найдаж болохгүй тал байна.

Ер нь дайн дуусна биз дээ?

-Дууснаа.

-Тэр цагт та яах вэ?

-Болбол. Абруццид харина гээд хөх царай нь баяраар гэрэлтэв.

-Та Абруццид дуртай юу?

-Тун их дуртай

-Тэгвэл тийшээ яв.

-Тэнд сууж, бурхнаа хайрлаж бурханд залбирах дээдийн жаргал даа.

-Бас хүндэтгэл хүлээх ёстой гэж би хэлэв.

-Тиймээ, бас хүндэтгэл хүлээх ёстой. Тэгээд юу гэж?

-Зүгээр. Та хүндэтгэл хүлээх талтай хүн

-Тэр хамаагүй. Миний төрсөн нутаг бол бурхан шүтэх нь шившгийн элэг доог биш жирийн хэрэг.

-Тиймээ, тийм гэхэд минь тэр лам намайг харан инээвхийлэв

-Чи мэдэхийг мэдэг, гэхдээ бурханд хайргүй.

-Тиймээ.

-Бурханд ер хайргүй юу?

-Шөнөд би голцуу бурхнаас айдаг.

-Хайрласан нь л дээр байхаа.

Хайрлах юм ч их л байна.

-Худлаа. Надад ярьсан тэр шөнийн явдал чинь бол хайр биш, зөвхөн тачъяал хурцал юм. Үнэхээр хайр хүрвэл хайрласан шиг хайрламаар байдаг.

-Тэртэй тэргүй би үргэлж жаргалтай байна.

-Энэ ч өөр хэрэг. Биеэр эдлээгүй цагт хайр гэдгийг чи ойлгохгүй.

-Зүйтэй. Хэзээ нэгэн цагт би ойлговол, танд ярина гэж би хэлэв

-Би дэндүү удаан сууж, дэндүү олон үг ярьж байна гэж тэр үнэхээр яарав.

-Жаахан суу л даа. Хүүхэнд дурлах мямар вэ? Би хэрэв үнэхээр нэг хүүхэнд дурлавал бас тийм байх уу?

-Би энүүнийг мэдэхгүй. Би нэг ч хүүхэнд дурлаагүй.

-Эхдээ хайртай юу?

-Эхдээн ч хайртай байсан.

-Бурханд та хэзээнээсээ хайртай байсан уу?

-Хар багаасаа

-Тийм байжээ гэж би хэлэв. Надад өөр хэлэх үг олдсонгүй. Тэгээд би:

-Та залуугаараа байна гэв

-Би залуу. Гэхдээ та намайг багш гэх юм гэж тэр хэлэв

-Энэ чинь ёсорхол гэхэд минь тэр инээвхийлэв

-Би одоо явалгүй болохгүй гэж хэлээд тэр өөр надад захих юм байна уу? гэж итгэлтэйгээ асуулаа.

-Алга. Тантай ярих л сайхан байна.

-Манайханд цөмд нь чиний өмнөс би мэнд хүргэе.

-Бэлэг авчирсанд чинь баялалаа.

-Зүгээр

-Дамжиж ирээрэй!

-Ирнээ. Баяртай гэж тэр гар атгав.

-Баяртай гэж би нутгийн аялгаар хэлэхэд

-Giao гэж тэр давтав.

Тасалгаанд харанхуй бөгөөд цаг үргэлж орны хөлд сууж байсан туслах босож сайхь ламыг үдэв. Тэр лам сэтгэлд тун нийцтэй тул Абруццид эгэж харихыг би

ерөөлөө. Офицеруудын гуанзанд түүний амьдралыг хордуулдаг авч тэрвээр тун ялдам тэвчин өнгөрүүлдэг билээ. Нутагтаа тэр лам ер ямар байдаг бол гэж би бодов. Капракотта хотын дэргэдэх голд тулбага үржүүлдэг гэж тэр ярьж билээ. Шөнийн цагаар либэдэг хориотой гэсэн. Залуус уянгал дуу дуулна. Гагцхүү лимбэдэх л хориотой. Учры нь би асуусан. Шөнийн цагаар лимбэний дуу сонсх нь хүүхнүүдэд эвгүй гэсэн. Тариачин хүн уулзмагц л малгайгаа авч “ноёнто” гэж хүндэлнэ. Тэр ламын эцэг өдөр бүр ан агаж , тариачны овооход орж хооллодог аж. Энэ ёсыг тэнд хүндэтгэл гэдэг байв. Гадаадын хүн ангийн зөвшөөрөл авахдаа ер баригдаж яваагүй гэсэн үнэмлэх үзүүлэх ёстой. Гран Сассо д Италид баавгай үржүүлдэг. Даанч хол юм. Аквил гэж сайхан хот буй. Зуны үдэш сэрүүн агаад, Итали даяар Абриццийнхаас сайхан хаавр гэж ер үгүй. Гэхдээ намар цаг туулайн бөөр модны төгөлд ан агнахаас илүү юм үгүй. Усан үзэм иддэг учир зэрлэг шувуу тун сайн. Хүнс авч явах ер хэрэг үгүй. Тариачдын орж цуг хоол идвэл тэд их дуртай гэсэн гэж бодсор би нам унтжээ.

[Top](#)

---

Эмнэлгийн тасаг урт агаад баруун ханандаа цонхтой, буландаа боолтын өрө рүү орох хаалгатай байлаа. Цонхон тал, ханан гол дагуу хоёр эгнээ ор байх бөгөөд би цонхныэсрэг ханан талд хэвтэж байв. Зүүн талаараа хэвтэхэд минь боолтын өрөөний хаалга харагдана. Бүр цаана бас нэгэн хаалга харагдаж үргэлж хүн орж гарна Эрсхэн муудсан хүний орыг хаалгаар тусгаарлаж, үхэж буйг нь нуух бөгөөд гагацхүү хаалтан доогуур эмч сувилагчдын ороолт шаахай харагдаж эцэстээ ямагт шивнэлдэн зүйл дуусна.

Тэгээд хаалтын цаанаас лам гарч ирэхэд сувилагчид хаалтын цаагуур ахин орж үхдэлийг дамнаж орны хоорондуур явахад толгойг нь бүтээлгээр бүтээсэн байх бөгөөд хүн ирж хаалты нь эвхэж аваачна.

Энэ өглөө тасгийн эмч ирж надаас, маргааш явж чадах уу гэж асуулаа. Би чадна гэж хэлэв. Тэгвэл өглөө эрт явуулна. Дэндүү халуун болоогүй дээр явбал чинь сайн гэж тэр хэллээ.

Боолтын өрөөнд аваачихаар орноос өргөх үед цэцэрлэг дэх шинэ булгийг цонхоор харж болно. Цэцэрлэгт ордог хаалганы тэнд нэг цэрэг суун загалмай хийж цэцэглэгт оршуулсан хүний хорооо, цол нэрийг бичнэ. Тэр цэрэг бас шархтны даалгаврыг биелүүлэх агаад зав чөлөөндөө австри винтовын хонгилоор надад асаагуур хийж өгөв. Эмч нэр нь тун ялдам бөгөөд ихээхэн туршлагатай аж.Тэд намайг Милан хотод явуулахыг эрмэлзэнэ. Бид бүгдийг чөлөөлж, ар талд явуулаад довтолгоон эхлэхэд хамаг ороо сулласан байхыг тэд чармайна.

Миний явахын урьд үдэж хээрийн цэргийн эмнэлгээс Ринальди манай ерөнхий эмчийн хамт ирэв. Милан хотод дөнгөж нээсэн Америкийн цэргийн эмнэлэгт намайг явуулна гэж тэд хэллээ. Америкаас эмнэлгийн хэд хэдэн отряд ирэхийг хүлээсэн бөгөд тэр цэргийн эмнэлэг болон итэлийн армид буй америкчуудад үйлчлэх ажээ. Улаан загалмайд тэд олон билээ. Америкийн Нэгдсэн улс нь австритай бус харин Германтай дайн зарласан болой.

Америкийг австритай дайн зарлана гэж италичууд итгэдэг учир улаан загалмайнхны ч гэсэн америкчуудын л ирэхэд тун их баярлаж байлаа. Ерөнхийлөгч Вильсон австритай дайн зарлах уу гэж надаас асуухад нь би энэ бол шаардлагатай хэрэг гэж хэлэв. Бид австрийн эсрэг үгүйг нь би мэдэхгүй гэвч Германтай нэгэнт дайн

зарласан болохоор Австритай зарлах нь зүйн хэрэг билээ. Турктэй дайн зарлах уу гэж надаас асуулаа. Бид турктэй дайн зарлана байх гэж би хэлэв. Болгартай яах бол? Бид нилээн хэдэн аяга конъяк архи ууж амжсан билээ. Тэгээд би: -за, чөтгөр алгад гэж, Болгартай ч Японтой ч дайн зарлана гэж хэлэв. Яалаа гэж дээ. Япон чинь английн холбоотон шүү дээ гэж тэд хэллээ. Яалаа ч гэсэн энэ хар шулмын англичуудад итгэж болохгүй. Япончууд Гавайн арлыг авах гэж байгаа юм гэж би хэлэв. Тэр Гавайн арал чинь хаана байдаг юм бэ? Номхон дөлгөөн Номхон дөлгөөн гадаад далайд буй. Япончууд яагаад тэр алыг авах гэж буй юм бэ? За ер нь авах гэсэн ч юм биш л дээгэж би хэлэв. Энэ ч зүгээр нэг яриа юм. Япончууд бол зөөлөн дарс, бүжигт их дуртай, жижигхан гайхалтай ард түмэн. Яг л францууд шиг гэж хошууч хэллээ. Францчуудаас бид Ницци, Чавойг авна. Корсик, Адриатын тэнгисийн эргийг авна гэж Ринальди хэлэв. Их Ром италидаа ирнэ гэж хошууч хэллээ. Би Ром италидаа ирнэ гэж хошууч хэллээ. Би Ром италидаа ирнэ гэж хошууч хэллээ. Би ромд дургүй гэж би хэлэв. Тэнд халуун, нохой бөөс ихтэй. Ра ромд дургүй юу? Би Ромд хайртай. Ром бол хүн ардын эх юм. Ромул Тибрийг хөхөж өссөнийг хэзээ ч мартаггүй. Юу гэж? Зүгэжэр. Цөмөөрөө Ром явцгаая. Ром сайхан хот шүү гэж хошууч хэлэв. Хүн ардын эцэг эх гэж би хэллээ. Рома гэж эм хүйсийн үг хэмээн Ринальди хэлэв. Рома эцэг байх ёсгүй. Тэгвэл хэн эцэг нь байх билээ? Ариун бурхан уу? Бурхнаа бүү хараагаарай. Би бурхнаа хараагаагүй, тайлбар хүсэж байна. Хүү минь, чи согтжээ. Хэн намайг уулгав? Би танд хайртай болоод бас америк дайнд оролцсон болохоор би уулгасан юм. Өөр яахав гэж би хэллээ. Хүү минь чи өглөө явна шүү дээ гэж Ринальди хэлэв. Ромд гэж би хэлэв. Миланд явна гэж хошууч хэлэв. Кристаль Паласад, Ковад, бас Кампарид, Биффид, Galleria очно. Азтай юмаа Гран-Итали очно, Жоржаас зээл авна гэж би хэлэв “Ла Скалд” гэж Ринальди хэллээ. Та “Ла Скал” очиж бах уу. Орой болгон гэж би хэлэв. Орой болгон бэл чинь хүрэхгүй гэж хошууч хэллээ. Ороход их үнэтэй. Би өвгөн аавын нэр дээр зээл чек бичнэ гэж би хэлэв Ямар чек гэнээ? Зээл. Эсхүл өвгөн аав төлнө, эсхүл намайг шоронд хийнэ. Эрхэм Кэнипгхэм банкинд намайг аргална. Би зээл чекээр амьдарна. Италийг аврах гэж амь дүйж яваа эх оронч ач хүүгээ өвгөн аав нь шоронд оруулна гэж үү дээ. Америкийн Гарабильди мандтугай гэж Ринальди хэлэв. Зээл чек мандтугай гэж би хэллээ. Битгий шуугилд гэж хошууч хэлэв. Биднийг бүү шуугилдаач гэж хэдэнээ гуйсан билээ. Федерико та тэгээд маргааш явах үнэн үү? Америкийн цэргийн эмнэлэгт очно гэж би танд хэлсэн шүү дээ гэж Ринальди хэлэв. Гоёхон асрагчдад очно. Хээрийн цэргийн эмнэлги йн сахалт сахиул биш болноо. Энэ үнэхээр америкийн цэргийн эмнэлэгт очих юм гэж хошууч хэллээ. Сахал тавих хсэлтэй байвал рүүл эсэн болтугай. Signor maggiore, та сахал тавихгүй яасан юм бэ? Хорт утааны баг торохгүй орно. Би хорт утааны баг өмсч үзсэн. Анд минь намуухан ярь гэж Ринальди хэллээ. Фронтод байсны чинь бид цөм мэднэ. Ээ, хөөрхий анд минь чамайг явчихаар би яах билээ? Явцгаая гэж хошууч хэлэв. Одоо ер дэндүү уярах нь байна. Би чамд нэг чихэр шиг үг хэлье Нөгөө англи хүүхнээ санаж байна уу? Нөгөө орой болгон английн цэргийн эмнэлэгт очиж уулздаг хүүхэн үү? Тэр хүүхэн бас Миланд очно. Тэр хүүхэн бас нэг сувилагч хүүхнтэй хамт америкийн цэргийн эмнэлэгт очиж ажиллана. Америкаас сувилагчид ирж амжаагүй байна. Би өнөөдөр тэдний partito<sup>19</sup> даргатай ярьсан. Энэ фронтод тэдний дэндүү олон хүүхэн бий гэнэ. Тэгээд хагасы нь ар тийш явуулахаар шийдсэн гэнэ. Хүү минь чамд ямар санагдаж байна? Зүгээр үү? Ямар вэ? Том хотод сууж англи хүүхэнтэйгээ амраглана. Би шархдах нь яав аа? Шархдана гайгүй гэж би хэллээ. Явцгаая гэж хошууч хэлэв. Бид

---

<sup>11</sup> отряд гэсэн итали иг

архидаж, шуугиж, Федериког тав алдуулж байна. Жаахан сууцгаа. Бид явцгаах боллоо. Баяртай Сайн яваарай. Тавтай байгаарай. Giaou Giaou Giaou Анд минь хурдан эргэж ирээрэй. Ринальди намайг үнсэв. Чамаас эм үнэртэж байна. Баяртай анд минь Баяртай. Тавтай болтугай. Хошууч миний мөрийг алгадав. Тэд сэмхэн гарцгаав. Би их согтжээ. Тэгээд би нам унтжээ.

Маргааш өглөө нь бид Милан хотын зүг хөдөлж, яг хоёр хоногийн дараа хүрсэн билээ. Замд тун уйтгартай байлаа. Местре хүрэлгүй бид бэлтгэл зам дээр удтал зогсов. Хүүхдүүд ирж цонхоор шагайна. Лонх конъяк архи авчирч өгөөч гэж би нэг хөвүүнийг гуйж, тэ хөвүүн зөвхөн Граппа хэмээх дарс байна гэж буцаж ирсэн бөгөөд би Граппа дарс авчир хэмээн явуулж, нэг лонх дарс авчрахад нь хариулты нь чи ав гэж би хэллээ. Цуг яваа хүнтэйгээ би согттол уугаад Виченц хүртэл нам унтаж сэрэхдээ шалан дээр унав. Надтай цуг яваа хүн урьд нь хэдэнтээ шалан дээр унасан тул энэ ч онцгой бус болой. Сүүлд нь тэгээд би цангаж үхэх дөхөв. Вероны буудал дээр галт тэрэгний дэргэдүүр хойш урагш явж буй нэг цэргийг би дуудаж уч авчруулав. Надтай цаг архи уусан хөрш Жоржеттийг би сэрээж ус өгсөнд тэрвээр толгой руу асгачих гээ дахин унтав. Ус авчирсан цэрэгт би мөнгө өгөхөд тэр авсангүй. Харин надад том зүрж авчирч өгөв. Би зүрж сорж хальсыг нь тургиад, зэргэлдээ зам дээрх ачааны галт тэрэгний дэргэдүүр хойш урагш холхиж яваа цэргийг харж бөгөөтөл, галт тэрэг замдаа хөдлөв.

[Тор](#)

---

### ХIII

Тиран хотод өглөө эрт биднийг ирэхэд эмнэлгийн машинаар ачааны буудлаас зөөж америкийн цэргийн эмнэлэгт аваачив. Машин дотор дамжуурга дээр хэвтэхэд аль гудамжаар яваа нь үл мэдэгдэх бөгөөд дамнуурга буулгах үед би зах зээлийн талбай болон зоогийн газрын онгорхой үүдээр хог шүүрдэж буй хүүхэн олж харлаа. Гудамж услаад өглөө эртийн үнэр ханхална. Асрагч дамнуургийг минь газар тавьж байшинд ороод хаалгачин дагуулан гарч ирлээ. Буурал сахалтай хаалгачин нь хавчаартай малгайтай энгийн хувцастай аж. Цахилгаан шатан дотор дамнуурга эс багтсан учир, нэг бол намайг дамнуурганаас авч цахилгаан шатаар зөөх, эсхүл дамнуурган дээр өргөж шатаар аваачих хоёрын аль нь хялбар болохыг ярилцан тэр маргалдахад би чагнан хэвтэв. Тэгээд тэд цахилгаан шатаар аваачих болж намайг дамнуурган дээрээс авахад:

-Аяар, аяар гэж би хэлэв

Цахилгаан шатан дотор давчуу агаад хөлий минь атийлгахад их л өвдөнө.

-Хөлий минь тэнийлгээч гэжэж би хэлэв

-Болохгүй, Signor tenente Зайгүй байна гэж хэлсэн хүн нэг гараараа намайг тулж, би хүзүүгээр нътэврэхэд амьсгал нь мэдэгэн улаан дарс болоод саримсны хатуу үнэр ханхийн утав.

-Чи дуугүй бай гэж нэгэн асрагч хэллээ.

-Би дуугүйдээ яасан юм бэ? гэхэд

Чамайг дуугүй бай гэж байна хэмээн миний хөлийг өргөж байсан нөгөө нэг нь датав.

Төмөр тор болоод цахилгаан шатны хаалга хааж, хаалгачин дөрөвдүгээр давхрын товч дарав. Хаалгачин хичээсэн төлөвтэй байна. Цахилгаан шат алгуур



өгсөв. Нөгөөх сармис ханхлуулсан хүнээ би:

-Хүнд байна уу? гэж асуулаа.

-Зүгээр гэж тэр хэлэв. Гэвч түүний нүүрэнд хөлс үзэгдэж тэвдээ. Цахилгаан шат өгсөн өгссөн зогсов. Миний хөлийг өргөж байсан хүн хаалга онгойлгож түрүүлэн бид талбарт гарахад зэс бариултай хэдэн хаалга байх бөгөөд хөлий минь өргөж байсан хүн товч дарж, хаалганы цаана хонх жингэнэв. Хариу үгүйд хаалгачин шатаар өгсөв.

-Эд хаана байна вэ? гэж асрагчид асуув.

-Мэдэхгүй. Тэд доор унтдаг юм гэж хаалгачин хэллээ.

-Хэн нэгий нь дуудаач гв.

Тэгээд хаалгачин хонх дарснаа тогшиж ядаад онгойлгон орж, саравч зүүсэн нэгэн ахимаг авгай дагуулан гарч ирлээ. Тэр авгайн ус нь сэгсийгээд, гоёл нь задарч харин сувилагчийн хувцас өмссөн байлаа.

-Би италиар ойлгодоггүй гэж тэр авгай хэлэв.

Би англиар ярьдаг. Намайг нэг тийш нь оруулж өгөөч гэж би хэллээ.

-Нэгч бэлэн өрөө байхгүй. Хүн ирнэ гэж бид бэлдээгүй хэмээн тэ авгай үсээ янзлахыг оролдон, хараа муутай нүдээрээ намайг харж ядна.

-Миний хэвтэх газрыг зааж өгөөч гэсэнд

-Мэдэхгүй байна. Хүн ирнэ гэж бид бэлдээгүй. Би таныг аль таарсан газар хэвтүүлж чадахгүй гэж тэр авгай хэлэв.

-Хаана ч яахав гээд бид хаалгачинд хандаж италиар Сул өрөө олооч гэв

-Цөмөөрөө сул. Та энд анхны шархтан гээд тэр малгайгаа барьж ахимаг сувилагчийг ширтэн харав.

-Намайг та нэг газар хэвтүүлээд өгч үзээч дээ гэж би хэлэв. Атийсан хөлний өвчин ихдэж ясандаа янгинан. Буурал сувилагчтай цуг хаалганы цаагуур далд орсноо хаалгачин төдхөн эргэн ирж намайг дагаад яв гэв. Урт гудмаар намайг дамжлан явж, буулгадаг хөшигтэй өрөөнд оруулахад шинэхэн модон эдлэлийн үнэр ханхална. Хананы дэргэд ортой, буландаа толин шүүгээтэй аж. Намайг орон дээр хэвтүүлэв.

-Би цагаан даавуу өгч чадахгүй. Цөс цоожтой байна гэж нөгөө авгай хэллээ.

Би тэр авгайтай ярихыг болив.

-Миний тэр товчтой халаасанд мөнгө бий гэж би хаалгачинд хэлэв

Хаалгачин мөнгө гаргаж рэв. Хоёр асрагч малгайгаа барьсаар орны дэргэд зогсоно

-Энэ хоёрт тав таван лир өгнөөд өөрөө бас тавар лир аваарай. Миний үнэмлэх бичиг нөгөө халаасанд нь байгаа. Түүнийг сувиалагчид өгнө үү гэж намайг хэлэхэд асрагч нар ёслоод баярлалаа гэв.

-Баяртай. Би та нарт бас их баярлалаа гэж намайг хэлэхэд тэд дахин ёслоод гарч одов.

-За энэ миний бичиг, өвчний түүх гэж би сувилагчид хэлэв

Тэр авгай бичгүүдийг авч саравчаараа харлаа. Эвхээстэй гурван бичиг байсан юм.

-Би яахаа ч мэдэхгүй байна. италиар би уншиж чаддагүй. Эмчийн заалтгүйгээр би яаж ч чадахгүй гээд тэр авгай уйлагнан нөгөөх бичгийг өвөр халаасандаа хийж

-Та америк хүн үү гэж асуув

-Тиймээ. Тэр бичгүүдээ орны дэргэдэх ширээн дээр орхино уу гэж би хэлэв

Тасалгаан дотор бүрэнхий, сэрүүхэн бөгөөд орон дээрээс шүүгээний том толь харагдах авч юу тусаж буй нь үл үзэгдэнэ. Орны хөлд хаалгачин зогсоно. Сайхан царайтай тэр хүнийг би сайн хүн гэж бодов. Тэгээд би түүнд:

-Та яв даа гээд сувилагчид хандан –Та ч бас яв даа. Таны нэр хэн билээ?

гэсэнд

-Уокер авгай гэдэг гэв

-Уокер авгай та яв даа. Би унтах гэж үзье гэв

Тасалгаандаа би ганцаар үлдэхэд сэрүүн бөгөөд эмийн үнэр үл ханхална. Дэсгэр нь төвгөр аятайхран тул би бараг амьсгалах ч үнүй хөдлөх ч үгүй хэвтэж, өвчин намдахад баярлан хэсг зуур болоод ам цангасанд орны толгой тушаа хонхны товч олж хонхдоход хэн ч ирсэнгүй. Тэгээд би нам унтжээ.

Сэрээд ажиглавал: цонхны хаалтан завсраар нарны гэрэл тусаж том өлгүүр болон нүцгэн хана, хоёр сандал харагдан. Хөлний болт хиртээд, орон дээр мод шиг юм байв. Би хөлөө хөдөлгөхгүйг хичээв. Ам цангаад байхаар нь нөгөө хонхны товчийг дарлаа. Хаалга онгойлгох сонсдон өчигдрийнхөөс өөр нэгэн сувилагч, залуухан аявтайхан хүүхэн орж ирлээ.

-Сайн байна уу? гэж би хэлэв

-Сайн, сайн байна уу? гээд тэр хүүхэн орны дэргэд ирж: Бид эмч дуудаж амжсангүй. Коно орохоор эмч явчихсан. Өнөөдөр хүн авчирна гэж бид мэдээгүй. Та яасан юм бэ? гэж асуулаа.

-Би шархадсан. Хоёр өвдөг өлмий, бас толгой бэртсэн гэв.

-Таны нэр хэн бэ?

-Генри Фредрик Генри

-Би одоо таныг угааж өгье. Харин боолты чинь бид эмч иртэл хэвээр нь байлгана

-Баркли хүүхэн гэж энд бий юу?

-Манай энд тийм хүн байхгүй

-Намайг авчрахад уйлсан хүүхэн чинь юун хүн бэ? гэхэд тэр сувилагч инээгээд:

-Уокер авгай гэдэг юм. Тэр шөнө жижүүрлээд унтчихсан юм. Хүн авчирна гэж тэр бодоогүй гэнэ гэж ярингуута миний боолтноос бусды нь тайчиж аваад тун сурмаг хөнгөн угаахад би ихэд сэргэлээ. Толгой минь боолттой боловч боолт тойруулан бүгдий нь тэр угаалаа.

-Та хаана шархдаа вэ?

-Изонцод Плаваасхойш байдг юм

-Энэ чинь хаана байдаг м бэ?

-Горицийгаас хойш байдаг юм гэсэн боловч тэр хүүхэн аль ч нэрний учрыг ойлгосонгүй.

-Их өвдөж байна уу? гээд тэр хүүхэн миний аманд халууны шил хийлээ.

-Италичууд суганд хийдэг юм гэж би хэлэв

-Битгий яриарай гэв

Тэгээд тэр хүүхэн халууны шил авч хараад сэгсрэв

-Халуунтай байна уу?

-Танд хэлэх хэрэггүй

-Ямар байна хэлээч дэ

-Бараг хэвэндээ байна.

-Би ер халуурдаггүй юм. Гэхдээ харин хөлөнд минь хуучин төмөр орчихсон юм шүү дээ

-Яаж тэр вэ?

-Бөмбөгний хэлтэрхий, хуучин хадаас, пурш элдэв юм бий гэхэлд минь тэр хүүхэн толгой сэгсрэн инээвхийлээд:

-Хэрэв хөлөнд чинь ямар нэг юм байвал хөндүүрлэж халуурах ёстой гэв

-Мэс засал хийхээр юу гарч ирэхий нь үзье л дээ гэж би хэллээ.

Тэр хүүхэн гараад нөгөө шөнө жижүүрлэсэн ахимаг сувилагчийг дагуулан ирж, тэр хоёр намайг босголгүй, цагаан даавуу дэвсэх нь надад шинэ сонин өгөөд тун

эвлэгхэн ажээ.

- Эмнэлгийн дарга хэн бэ?
- Ван Кампен гэдэг авгай.
- Хэдэн сувилагчтай вэ?-Ердөө л бид хоёр
- Өөр хүн ирэхгүй юу?
- Ирэх ёстой
- Хэзээ вэ?
- Мэдэхгүй. Өвчтөн хүн ийм сониуч байх хэрэггүй.
- Би өвчтөн биш шархтай хүн гэж би хэлэв.

Тэр ор засаж дуусаад, би шинэхэн цэвэрхэн даавуу дэвсэн нөмрөн хэвтлээ. Уокер авгай гарч дотуур хувцас барьж ирэн хоёул надад өмсгөөд, би тун цэвэрхэн хувцастай болов.

- Та нар их аятайхан улс юм гэж би хэллээ.
- Гэйж хүүхэн гэдэг сувилагч нь инээвхийлэв
- Нэг аяга ус олоход бол уу? гэсэнд-
- Олдохгүй яахав. Тэгээд өглөөний хоолоо идээрэй гэв
- Би юм идэхгүй. Цонхны хаалт сөхвөл болох уу? гэж би хэлэв

Тасалгаанд харанхуй байснаа, цонхны хаалт сөхмөгц нарны хурц гэрэл дүүрч, тагт болон цаана нь вааран дээвэр, утааны яндан харагдав. Вааран дээгүүр харвал цагаан үүлс цэв цэнхэр тэнгэр үзэгдлээ.

- Бусад сувилагч хэзээ ирэхий нь та мэдэхгүй юу?
- Яах нь вэ? Бид муу сувилаад байна уу?
- Та нар их аятайхан байна
- Таныг түших үү
- За

-Тэд намайг өргөж түшсэн боловч тус болсонгүй. Тэгээд би хэвтэж, онгорхоя хаалгаар тагт ширтлээ.

- Эмч хэзээ үзэх вэ?
- Ирмэгц л үзнэ. Эмчийг ир гэж Комо руу бид утасдсан.
- Өөр эмч байдаггүй юм уу?
- Тэр манай эмнэлгийн эмч

Гэйж хүүхэн шилтэй ус, аяга авчирч би гурван аяга ус уугад тэр хоёрыг явсны дараа нэг хэсэг цонхоор харж байснаа унтчихжээ. Өглөөний хоёрдугаар хоол идсэн дараа эмнэлгийн дарга Ван Кампен авгай орж ирсэн бөгөөд би ч түүнд таалагдсангүй тэр ч надад таалагдсангүй. Тэр авгай намхан нуруутай агаад их зангаар дүүрсэн, муу санааны бирд байлаа. Надаас тэр олон юм асуухдаа италийн зэвсэгт хүчинд алба хаахыг бараг гутамшиг гэж үзэж байгаа бололтой.

- Үдийн холон дээр дарс авч болох уу? гэж асуув.
- Эмчийн зөвшөөрөлтэй бол болно гэв
- Эмч иртэл болохгүй юу?
- Хэрхэвч болохгүй
- Эмчийг ирнэ гэж та бодож байна уу?

-Утасдсан л юмсан гээд түүнийг явмагц. Гэйу хүүхэн тасалгаанд эгэж ирээд хамаг юм тэр даруй янзалж дуусаад:

- Ван Кампен авгай юунд уурлав гэж асуулаа.
- Би уурлахгүй гэж бодсон юм. Гэтэл тэр авгай чинь дэндүү хамраа сөхөөд байна
- Таныг их юм шаарддаг, бүдүүлэг хүн байна гэж тэр хүүхэн хэлсэн
- Тийм ч үгүй байхаа. Гэхдээ ер нь эмчгүй эмнэлэг гэж байх уу?
- Ирэх ёстой. Комо руу утасдсан
- Тэр эмч чинь тэнд юу хийж байгаа юм бэ?

-Нууран сэлж байгаа юм уу?

-Үгүй ээ. Тэнд бас тэр эмчилгээтэй юм

-Өөр эмч авахгүй яасан юм бэ?

-Шш... Шш... Дуулгавартай байж үз. Эмч удахгүйирнэ гэхэд нь би хаалгачинг дуудаж өгөөч гэж гуйж,хаалгачинг ирэхэд дарсны мухлагт очоод нэг лонх чинцано хэмээхр дарс нэг ташмаг нь янти хэмээх дарс, оройн сонин худалдаж авчирч өгөөч гэж италиар хэлэв. Тэр явж сонинд боосон дарс авчраад онгойлгож орон дор тавив. Өөр хэн ч орж ирсэнгүй, би орондоо хэвтэн сонин уншиж фронтын мэдээ, алагдсан офицерын жагсаалт, тэдний авсан шагнал зэргийг үзээд гараар тэмтрэн лонх чинцано дарс аваад хүйтэн ёролоор нь гэдсэн дээрээ тавьж, балган тавин гэдсэн дээрээ дугуй хээ гарган хотын дээгүүр харуй бүрий болохыг ажиглан балаа. Дээвэр дээгүүр хараацай, шөнийн харцага хисэхийг харан Чинцано дарс ууж байтал Гэйж хүүхэн аягатай шарөндөг барьсаар рж ирэхэд би лонхтойгоо орны араар нуув.

-Ван Кампен авгай энүүнд жаахан Херес дарс нэм гэж хэлсэн юм. Тэр авгайд уурлах хэрэггүй. Залуу нас нь өнгөрөөд эмнэлэг удирдаж их хариуцлагатай яваа хүн юм. Уокер авгай дэндүү өтөлсөн болоод дэвтэй тус хүргэж чадахгүй байна гэж тэр хүүхэн хэлэв.

-Тэр авгай гайхалтай эмэгтэй. Намайг баярлаж байна гэж хэлээрэй гэж би хэллээ.

-Би одоо танд оройн хоол авчиръя

-Хэрэггүй. Би өлсөөгүй байна гэж би хэллээ.

Тэгээд тэр хүүхэн, тавиуртай хоол авчирч орны дэргэдэх ширээн дээр тавихад би талархаж бага зэрэг идэв. Төдөлгүй бүр харанхуй болж, шөнийн гэрэл тэнгэрт солбилцохыг харж хэвтсэнээ би унтчихжээ. Тун бөх унтаж байснаа би айж хамаг бие хөлөрч сэрээд дахин тэгэж зүүдлэхгүйг хичээн унтав. Тэгээд би үүр цайхаас нилээд урьд ахин. Сэрж тахиан дуу чагнан сэрүүн хэвтэж үүр цайхыг хүлээхэд ядаргаатай байв. Бүүр гэрэл орсон хойно би дахин унтжээ.

[Тор](#)

---

Сэрэхэд минь тасалгаан дотор нар хурц гэрэлтэн, би дахиад фронтод очсон мэт санагдан орондоо суниав. Тэгтэл хөл минь өвдөж, хиртсэн боолты нь харахдаа би хаана байгаагаа саналаа. Хонхны твчийг дартал гудамж хонх хонхдож сонсдон, бөмбөгөн ултай гуталтай хүн өөлөн гишгэж өнгөрсөн нь Гэйж хүүхэн байж, нарны хурц гэрэлд хөгшивтөр агаад тийм ч сайхан бус харагдав.

-Сайн унтавуу? гэж тэр хүүхэн хэллээ.

-Сайн нутлаа. Үсчин дуудаж өгөхгүй юу гэж би хэлэв.

-Намайг ороход та энүүнийг барьчихсан унтаж байсан гээд тэр хүүхэн шүүгээ онгойлгож чинцано дарсны хоосорсон лонх харуулаад

-Орон дороос чинь би бас өөр лонх авч энд хийсэн. Та аяга гуйхгүй яасан юм бэ? гэж тэр хүүхэн хэллээ.

-Уулгахгүй байх гэж би айсан юм.

-Би хамт уух байсан

-Тэгвэл ч сайн байнаа

-Ганцаар уухад чингь муу. Дахиад битгий тэгээрэй гэж тэр хүүхэн хэлэв.

-Дахиад тэгэхгүй.

-Баркли хүүхэн чинь ирсэн гэж тэр хэллээ.

-Үнэн үү?

-Үнэн. Надад тэр хүүхэн тааруухан санагдлаа.

-Сайхан санагдах болно доо. Тун сайн хүүхэн шүү гэхэд минь тэр хүүхэн толгой сэгсрээд

-Гайхамшигтай амьтан гэхэд эргэлзэх юм алга. Жаахан ийшээ болж чадах уу? За боллоо, Өглөөний хоол идэхэд чинь би бэлдэж өгье. Гараа өргөөрэй. За боллоо гэж бүлээн ус, алчуур, саван хэрэглэн тэр хүүхэн нүүр гары минь угааж өгөв.

-Өглөөний хоолноос өмнө үсчин илрүүлж болохгүй юу?

-Хаалгачинд одоо хэлье гээд гарснаа төдхөн эргэж ирээд үсчинд хаалгачин явлаа гэж алчуураа түмпэнтэй усанд хийлээ.

Хаалгачинтай хамт үсчин ирлээ. Тэр хүн тавь эргэм настай дээш мушгисан сахалтай аж. Гэйж хүүхэн ажлаа дуусаад гарахад үсчин хацры минь савандаж, сахал хусахдаа ихээхэн сүртэй агаа үг үл дуугарна.

-Та юунд дуугүй байна. Шинэ сонин яриач гэж би хэллээ.

-Ямар шинэ сонин бэ?

-Ямар ч яахав. Хотоор юу дуулдана?

-Одоо дайны үе, гадны хүний чих урт болсон цаг гэж тэр хэлэхэд би эргэн харлаа.

-Толгойгоо битгий хөдөлгө. Би юм ярихгүй гээд тэр сахал хуссар байлаа.

-Та юу болоов? гэж би асуув

-Би Итали хүн. Гадны хүнтэй ярианд оролцохгүй гэв

Тэгээд би албадсан ч үгүй, хэрвээ тэр галзуу бол бушуухан надаас тонгорог салгаж үзээсэй. Нэг удаа би түүнийг харах гэтэл. Болгоомжтой бай, тонгорог хурц шүү гэв

Сахал хусаж дуусахад нь би зохих үний нь өгч хагас лир нэмэн шагнахад мөнгий минь тэр буцааж өгөв.

-Би авахгүй. Би фронтод байгаа биш. Би итали хүн шүү гэхэд нь би.

-Тонил! Гэв.

-Таны тааллаар явъя гэж хэлээд тэр тонгоргоо сонинд боож гарахдаа, орны дэргэдэх ширээн дээр таван зэс зоос орхив. Хонхдоход минь Гэйж хүүхэн орж ирлээ.

-Хаалгачинг дуудаж өгвөл сайн байна гэсэнд

-Тэгье ээ гэлээ.

Хаалгачин инээдээ барьж ядсаар орж ирлээ.

-Тэр үсчин чинь галзуу юм уу?

-Үгүй ээ, signorino. Миний үгийг буруу сонсоод таныг австрийн офицер юм гэж эндүүрчээ.

-Ээ, бурхан минь- гэж би хэлэв

-Ха-ха-ха гэж хаалгачин инээгээд хөгтэй юм. "Тэрнийг хөдөлтөл л би яг..." ингэнэ гэсэн гэж хуруугаараа хацар дээгүүрээ зурж мөн л ха-ха-ха гэж инээдээ барьж чадахгүй хөхөрсөөр –Тэгээд би таныг австри хүн биш гэж хэлсэн... Ха ха-ха гэв.

-Ха-ха-ха гэнэ шүү гэж би уурлан хэлээд хэрэвтэр хоолойг минь огтолсон бол ч бүр хөгтэй юм болно. Ха-ха-ха гэв

-Хаанаас даа signorino минь яав ч үгүй. Тэр чинь австри хүнээс бүх хэтлээ айдаг юм. Ха-ха-ха.

-Ха-ха-ха гэнэ шүү. Тонил! Гэж би хэлэв. Тэгээд тэр гарч хаалганы цаана мөн хөхөрсөөр амой. Гэтэл нэг хүн гудмаар явах сонсдож, үүд рүү харвал Кэтрин Баркли байлаа.

Тэр хүүхэн өрөөнд минь орны дэргэд ирэв.

-Сайн байна уу, найзаа? Гэж тэр хүүхэн хэлэв. Тэр хүүхний царай нь өнгө

ороод залуухан, тун сайхан тул тийм үзэсгэлэнтэй царай хэзээ ч үзээгүй мэт санагдлаа.

-Сайн. Сайн байна уу? гэж би хэллээ. Тэр хүүхнийг харсан даруйдаа хамаг бие минь хувьсаж түүнд дурласнаа ухаарав. Тэр үүд рүү хараад, хэн ч үгүйд, орны ирмэг дээр сууж бөхийн намайг үнслээ. Би мөн түүнийг тэврэн үнсэхдээ зүрний нь цохилтыг мэдрэв.

-Хайрт минь чи ирдэг тун сайн юм боллоо гэж би хэлэв.

-Тэр ч яахав. Эндээ байх нь л хэцүү байна.

-Чи энд байх хэрэгтэй. Чи жавхлантай. Би галзуу юм шиг л байлаа гэж намайг хэлэхэд: Тэр хүүхэн дэргэд минь суугаад үнэхээр итгэж ядан, чанга тэврэв.

-Хэрэггүй. Чи сайн эдгээгүй байна шүү дээ гэж тэр хүүхэн хэлэв.

-Би эрүүл. Ир л дээ

-Үгүй. Чи тамир миуутай байна.

-Тамир муугүй. Ир л дээ.

-Чи надад хайртай юу?

-Би их хайртай. Ухаан балартаж бана. Ир л дээ чи.

-Зүрхний цохилт сонсож байна уу?

-Зүрх ч яахав. Чамайг л ир гэж байна. Улхаан балартах нь байна шүү.

-Чи үнэхээр надад хайртай юу?

-Битгий тийм юм асуу. Наашаа ир. Мэдэв үү?

Кэтрин минь ир л дээ.

-За яахав, ганцхан минут шүү.

-За . Үүдээ хаачих гэж би хэлэв

-Болохгүй. Одоо болохгүй

-Битгий дэмий ярь. Наашаа л хүрээд ирэ.

Орны дэргэдэх зөөлөн сандал дээр Кэтрин сууна. үүд онгорхой бөгөөд ухаан балартах явдал өнгөрч, амьралд ер урьд өмнө үзээгүйгээр бие минь талбиун байлаа.

-Одоо чи миний хайрыг ойлгов уу? гэж тэр хүүхэн асуулаа

-Хайрт минь, чи эндээ байна. Чамайг хааш нь ч явуулахгүй. Чамд дурласандаа би ухаан балатрах нь байна гэж би хэллээ.

-Бид тун болгоомжлохгүй бол болохгүй. Дэндүү тэнэг юм боллоо. Ингэж болохгүй.

-Шөнө бол болно

-Бид тун болгоожмллохгүй бол болохгүй. Гадны хүнээс чи их болгоомжлох хэрэгтэй.

-Би болгомжтой байя.

-Чи тун бодолтой байгаарай. Чи их сайн. Чи надад хайртай, тиймээ?

-Ийм юм бүү ярь. Эсхүл би чамайг явуулагүй.

-За дагаад ярихгүй. Намайг харин явуулаарай. Би одоо явах боллоо шүү дээ хө.

-Одоохон ирээрэй:.

-Зав гарахаар л ирнэ.

-Баяртай

-Баяртай, хонгор минь гээд тэр хүүхэн гарлаа. Бурхан минь, би энэ хүүхэнд дурлахгүй гэж бодсон юмсан. Би ер нь хүүхэнд дурлахгүй гэж бодсон юмсан. Гэтэл би дурлачихаад, Милан хотын цэргийн эмнэлгийн орон дээр хэвтэхдээ толгойд синь түмэн бодол эргэлдэж, сэтгэл тун таатай байна. Гэнэт Гэйж хүүхэн орж ирээд

- Эмч иронэ. Комоос утасдсан гэж хэлэв
- Хэзээ ирэх вэ? гэхэд
- Үдэш ирнэ гэлээ.

[Top](#)

---

Үдэш болтол хэвийн байлаа. Эмч нь чухамхүү дайнаар гарч ирсэн гэмээр өдлгөөн туранхай хүн миний гуянаа хэдэн жижиг гангийн хэлтэрхий ухаж төнхөн гаргахдаа тэр хэсэгт нь мэдээ алдуулах,% өөрийн хэлдгээр “хөлдөөх” арга хэрэглэж, эсий нь хатууруулан, хөлдөөсөн хэс гээс цааш гүйн хайя, хямсаа орохгүй бол өвдөхгүй болгов\_ Хөлдөөсөн хэсгийн захыг нарийн тодорхойлж болох билээ. Гэтэл эмчийн хүчин дутагдаж, гэрэлд харуулах нь зүйтэй, туршилтаар сайн мэдэгдэхгүй байна гэх болов.

Гэрлийн тасаг нь Ospedale Maggiore<sup>20</sup> –д байх агаад гэрэлд харсан эмч нь хөгжүүн шалмаг, яриа хөөрөөтэйхүн байлаа. Биедээ орсон юмыг гэрэлд хараг гэж намайг эмч араас минь түшнэ. Зургий нь сүүлд явуулна гэлээ. Мч намайг тэмдэглэлийхээ дэвтэрт нэр, хороо болон дурсгал бич гэв. Тэгээд тэр, харийнхан цөм адгийн хог новш гэж өгүлэв. Австричуудыг нохойн үр сад гээд надаас хичнээнийг алсан бэ? гэж асуулаа. Би нэгийг ч алаагүй боловч тэр эмчид аятай үг хэлэхсэн гэхдээ үй түмэн австричуудыг алсан гэж хэллээ. Гэйж хүүхэн надтай очсон бөгөөд эмч бэлхүүсээр нь тэвэрч түүний Клеопатраас сайхан хүүхэн гэж магтлаа. Клеопатр гэж эртний египетийн хатан хаан байсныг тэр хүүхэн мэдэх бол уу даа? Тэр хүүхэн бурхан, мэт сайхан ажгуу. Эмнэлгийн машинаар манай цэргийн эмнэлэгт эгүүлэн зөөж нэг дамнуургаас нөгөөд дамжуулан тавьсаар дээш гаргаж, би орон дээрээ ирлээ. Үдийн холны дараа зураг ирж, эмч хоолны дараа бэлэн болгоно гэсэндээ бурхан мэтхүрчээ. Тэр зургийг надад Кэтрин Баркли үзүүлэв. Улаан дугтуйнаас Баркли зураг гаргаж бид хоёр гэрэлд харлаа.

-Энэ баруун хөл нь гээд тэр хүүхэн зургийг дугтуйд нь хийж энэ зүүн нь гэв.

-Нэг газар тавьчихаад ир гэж би хэлэв.-

Болохгүй. Би чамд зураг үзүүлэх гэж түр ирсэн юм гэж тэр хэллээ.

-Тэгээд тэр хүүхэн явж би ганцаар үлдэв. Халуун өдөр болохор хэвтэхэд тун залхуутай учир би хаалгачинг гуйж, олдсон сонин бүгдийг худалдаж аваад ирээч гэв.

Түүнээс хүлээж хэвтэх зуур гурван эмч орж ирлээ. Туршлага багатай эмч нар нэгнээсээ тусламж зөвлөгөө эрдгийг би хэдүйн мэдэх билээ. Мухар олгой авч чадахгүй эмч нь холгойны мах авч чадахгүй эмчдээ өвчтөнг үзүүлдэг. Энэ гурав чухам тэдний өрөөсөн аж.

-За, энэ залуу даа гэж цэргийн эмнэлгийн эмч, нөгөөх намбархуу хүндээ хэллээ.

-Сайн байна уу? гэж тэр сахалтай, өндөр, туранхай эмч хэлэв. Улаан дугтуйтай гэрлийн зураг барьсан эмч үг дуугарсангүй.

-Боодлы нь тайлах уу даа гэж сахалтай эмч асуусан янзтай өгүүлэв.

-Зүйтэй сувилагчаа, боддлы нь тайлаарай гэж Гэйж хүүхэнд цэргийн эмнэлгийн эмч хэлэв. Гэйж хүүхэн боодлы нь тайлав. Би хөлөө харлаа. Хээрийн цэргийн

---

<sup>11</sup> Цэргийн төв эмнэлэг гэсэн итали иг

эмнэлэгт хэвтэж байхад хөл минь татсан мах хатаасан адил байж билээ. Эдүгээ харин хөрсжиж, өвдөг бэлцийн цайраад, булчин зөөлрөөд ер идээлээгүй байна.

-тун цэвэрхэн, их сайн байна гэж цэргийн эмнэлгийн эмч хэлэв.

-хайм гэж сахалтай эмч хоолой засан Гурав дахь эмч нь цэргийн эмнэлгийн эмчийн мөрөн дээгүүр харна.

-Өвдгөө нугал гэж сахалтай эмч хэллээ.

-Болохгүй байна гэв

-Үеий нь үзэх үү дээ гэж сахалтай эмч асуусан янктай өгүүлэв. Тэр эмчийн ханцуйн дээр гурван таван хошуунаас гадна бас нэг зураас буй нь эмнэлгийн албаны ахмадын цолын тэмдэг ажээ.

-Зүйтэй гэж цэргийн эмнэлгийн эмч хэлэв. Тэгээд тэр хоёр баруун хөлий минь хянуур өргөж, тахийлгахыг оролдов.

-Өвдөж байна гэж би хэллээ.

-Ухай даа. Эмчээ% Бас жаахан

-Боллоо, илүү тахийхгүй гэж би хэллээ.

-Үе нь сайн хөдлөхгүй байна гэж сахалтай эмч хэлээд биеэ эгцлэн-эмчээ, дахиад зургий нь үзье гэхэд гурав дахь эмч зураг өгөхөд-бишээ, зүүн хөлийнх нь аль гэв.

-эмчээ, энэ чинь зүүн хөлийнх

-Өө, тийм байна. Би баруун талаас нь харж гээд тэр буцааж өгөв. Нөгөө зургий нь мэдэн мминут харж байснаа Эмчээ, харж бана уу? гээд гэрэлд тов тодорхой харагдаж буй шигдсэн нэгшэн зүйлийг заав. Тэд цөм нөгөө зургийг мэдэн минут ажлаа.

Тэгээд ахмад цолтой, сахалтай эмч хэлсэн нь:

-Миний бодоход, гурван сар юм уу, хагас жил хэрэгтэй гэв

-Зүйтэй. Шар ус дахиж тогтох хэрэгтэй шүү дээ.

-Зүйтэй: Хугацаа хэрэгтэй. Хэлтэрхийд нь гэр тогтохоос нааш би л бол ийм тахимны үеийн хагалгаа хийхгүй.

-Таны саналтай бүрэн нийлж байна.

-Яагаад хагаж жил гэж? хэмээн би асуув

-Хэлтэрхийд нь гэр тогтоож, өвдөгний үеий чинь хагалахад осолгүй болгох гэж хагас жил болно.

-Би итгэхгүй байна гэж би хэлэв

-Та залуу хүн байж хөлтэй бая гэж санаж байна уу? гэхэд нь

-Үгүй гэж би хэлэв

-Юу? гэв

-Хөлий минь дэгээ хийж болохоор тайрч аль гэж би хэллээ.

-Юу гэнээ? Дэгээ гэнээ.

-Тоглож байгаа мю. Хөлтэйгээ байя гэж бодож байгаа юм. Энэ тун эрэлхг залуу шүү. Эрэлхэг болоод мөнгөн медаль шагнуулах гэж байгаа юм хэмиээн цэргийн эмнэлгийн эмч хэлээд тун ёсорхуугаар мөрий минь алгадав

-Чин сэтгэлээсээ талархъя гэж ахмад цолтой эмч хэлэв. Тэгээд тэр гары минь атгаж

-Миний бодоход, Ийм танхимыг хагалахад юуны өмнө осолгүй болгохын тулд наад зах нь хагас жил хүлээххэрэгтэй. Өөр юм хэлээд байх явдалгүй гэв

-Баярлалаа. Таны санал, надад их таатай байна гэж би хэлэв

-Ахмад цолтой эмч цагаа хараад:

-Бид явах боллоо. Сайн сайхныг хүсье гэв.

-Танд бас сайн сайхныг хүсье. Их барлалаа гэж би хэлэв. Гуравдахь эмчийн гарыг атгаж би Capitano Varini-tenente Enry” гэв. Тэр гурван эмч гарч одов.



-Гйж хүүхээн гэж дуудахад минь тэ орж ирлээ.  
 -Цэргийн эмнэлгийн эмчийг түр дуудаж өгөөч гэв.  
 -Тэр эмч малгайгаа барьсар ирж орны дэргэд зогсоод:  
 -Надтай уулзах гээ юу? гэв.  
 -Тиймээ. Би хагас жилээр мэс засал хүлээж чадахгүй. Бурхан минь, эмч та хагас жилээр хэвтэрт байж үзсэн бол уу?  
 -Цаг үргэлж л чи хэвтэж байхгүй. Эхлээд шархаа наранд ээх хэрэгэти болно.  
 Дараа нь таягтай явж эхэлнэ  
 -Хагас жил болоод мэс засал хийх үү?  
 -Тэгвэл осол багатай. Шигдсэн юмны гадуур гэр тогтоож, шар ус хуралдтал хүлээх хэрэгтэй болно. Тэгвэл өвдөгний үеийг хагалахад осолгүй болно.  
 -Тэгэж удаан хүлээх хэрэгтэй гэж та бодож байна уу?  
 -Тэгвэл осол багатай  
 -Ахмад цолтой хүн юун эмч вэ?  
 -Милан хотын сайн мэс засалч  
 -Ахмад цолтой байсан биз дээ?  
 -Тиймээ. Харин ту сайн мэс засалч даа  
 -Ямар нэг ахмад хөлий минь төнхөхөд би дургүй байна. Хэрвээ тэр ондоосон бол хошууч байхсан биз. Эмч минь ахмад гэгчийг би мэднэ.  
 -Тэр тун сайн мэс засалч. Би тэрний саналыг бусдаас илүүд үздэг юм.  
 Миний хөлийг өөр мэс засалчид үзүүлж болох уу?  
 -Болноо. Таны дурны хэрэг. Гэхдээ би бол хувьдаа Варелл эмчийн саналыг дагана.  
 -Та өөр нэг мэс засалч ирүүлж өгөөч?  
 -Би Валентинийг ирүүлье  
 -Юун хүн бэ?  
 -Ospedale Maggiore-гийн мэс засалч  
 Тэгээч . Тэгвэл би танд их талархана. Эмч минь% хагас жилээр би хэвтэрт байж чадахгүй байна шүү дээ.  
 -Үргэлж л чи хэвтэж байхгүй. Эхлээд наранд шүарна. Дараа нь хөнгөн дасгалд орно. Тэгээд гэр тогтохоор нь бид мэс засал хийнэ.  
 -Би хагас жил хүлээж ер чадахгүй. Барьж байгаа малгайгаа эмч ёсорхуу илбээд инээвхи йлэн:  
 -Фронтдоо очих гээд тэсэхгүй байна уу?  
 -үгүй гэх үү дээ?  
 -Сайхан байна. Сайн залуу байна гээд бөхийж духан дээр минь ёсорхуу үнсэж  
 -Валентинад би хүн явуулъя. Битгий уурлаж сандар. Ухаалаг бай гэв  
 -Эчмээ, аяга дарс уугаач? Гэж би гуйв  
 -Уухгүй, би уудаггүй. Баярлалаа.  
 -Ганцхан аяга шүү дээ гээд би аяга авчруулах гэж хаалгачийг дуудаж хонхдов  
 -Үгшүй , үгүй. Намайг хүн хүлээж байга. Баярлалаа.  
 -Баяртай гэж би хэлэв  
 -Баяртай гэлээ

Хоёр цагийн дараа Валентина эмч орж ирлээ. Тэр ихэд яарч, сахлы нь үзүүр дээшээ сэрвийнэ. Тэр эмч хошууч цолтой, борлосон нүүртэй бөгөөд цаг ямагшт мишээнэ.

-Чамайг айлгаа юу? гээд тэр үглэн: Алив зүрхий нь үзүүл. За. За. Ийм байжээ. Чи ч эрүүл, ёстой бух шиг, лут амьтан юмаа. Энэ аятайхан хүүхэн юусан билээ? Амраг чин ь үү? Би тэгэж бодсон юм. Энэ муу хар дайныг дээ? Энд өвдөж байна уу?

Сайн байна. Эв эрүүл болгоно доо. Энэ эмч нар их өвтгөх дуртай улс аа даа. Юугаар эмнэж байв даа? Энэ хүүхэн италиар ярьдаг уу? Сургах хэрэгтэй. Гайхамшигтай хүүхэ. Би бол ч хичээл заана. Би өөрөө энэ эмнэлэгт хэвтэнэ. Би энэ хүүхнийг төрөх болгонд нь үнэ төлбөргүй эх барьж авна. М иний яриаг энэ хүүхэн ойлгож байна уу? ЭНэ хүүхэн чамд сайхан хүү төрүүлж өгнө дөө. Өөр шигээ хүү төрүүлнэ. Их сайн. Тун сайн. Гайхамшигтай хүүхэн. Надтай хамт оройн хоол идэхгүй юм бол уу, асуугаач. Болъёе доо. Чамаас салгаад яахав дээ. Баярлалаа. Хүүхэн гуайд их баярлалаа. За боллоо. Мэдэх гэснээ мэдлээ. За боллоо. Боолты нь ороох хэрэггүй гээд миөрий минь алгадаг.

-Валентин эмчээ, аяга дарс уугаая?

-Дарс гэнээ? Уулгүй яахав. Арван аяга ч болно. Хаана байна?

-Шүүгээнд бий. Баркли хүүхэн авчирна

-Таны эрүүл мэндийн төлөө.н Хүүхэн гуай таны эрүүл мэндийн төлөө. Гайхамшигтай хүүхэн. Энүүнээс сайхан дарс би авчирч өгнө гээд тэр сахлаа арчив.

-Таны бодоход хэзээ мэс засал хийж болмоор байна?

-Маргааш өглөө болно. Түүнээс нааш болохгүй, гэдсээ суллах хэрэгтэй. Хамаг юмы чинь цэвэрлэнэ. Би доорхи эмгэнийд орж бэлтгэе. Баяртай. Маргааш уулзъя. Энүүнээс сайхан дарс би авчирч өгнө.Энд чинь сайхан газар шүү. Маргааш болтол баяртай. Сайн унтаарай. Би эрт ирнээ гэв. Тэгээд тэр босгон дээрээс даллаж, сахал шорвойгоод хүрэн царай нь мишилзэнэ. Тэр хошууч цолтой утл ханцуйн дээрх таван хиошуу нь эмжээртэй ажээ.

[Тор](#)

---

Хотын дээвэр дээгүүр шөнө харагдаж буй онгорхой тагтаар тасалгаан дотор тэр шөнө сарьсан багваахай орж ирээд тэнгэрт нисэж буй мэт тасалгаан дотуур айхгүй ниснэ. Тасалгаан дотор харанхуй бөгөөд хотын дээгүүрх шөнө тагтны хаалгыг бүдэг гэрэлтүүлнэ. Бид сарьсан багваахайг харж хэвтлээ. Бид тун чимээгүй хэвтэцгээсэн учир сарьсан багваахай биднийг мэдээгүй биз. Сарьсан багваахайг гарч нисэх үед, шөнийн гэрэл тусаж зурвас гэрэл тэнгэрээр цайлалзаад арилж дахиж харанхуй боллоо. Гэрэл тэнгэрээр цайлалзаад арилж дахиаж харанхуй боллоо. Шөнө дунд салхи хөдөлж, зэргэлдээ дээвэр дээрх, агаарын их буучдын дуу сондоно. Сэрүүн байсан тул тэд цув өмсжээ. Хүн орж ирэв үү яав гэж шөнө дунд намайг сандрахад цөм унтаж байгаа гэж Кэтрин хэлэв. Шөнө дунд бид нэг удаа унтаад намайг сэрэхэд Кэтрин тасалгаанд байсангүй, харин гудмаар хөлий нь чимээ сонсон, хаалга онгойлгож орны хажууд ирээд, ямар ч аюулгүй гэв. Доош ороход нь тэнд бүгд унтаж байжээ. Тэгээд тэр Ван Кампен авгайн үүдэнд очиж чагнахад унтаж байгаа амьсгаа нь дуулджээ. Дараа нь хуурай боов авчирч бид хоёул идээд, Вермут дарс уув. Бид тун өлссөн байлаа. Өглөө надаас тэр бүгдийг цэвэрлэх тухай хүүхэн ярив. Үүр тэмдэгрэхийн үеэр би дахин унтаад, ёэрэхэд Кэтрин мөн тасалгаанд үгүй байв. Тэр хүүхэн сайхан, цэвэрлэх тухай хүүхэн ярив. Үүр тэмдэгрэхийн үеэр би дахин унтаанд, сэрэхэд Кэтрин мөн тасалгаан үгүй байв. Тэр хүүхэн сайхан, цэвэрхэн орж ирэд, орон дээр сууж, намайг амандаа халууны шилтэй хэвтэх хооронд нар гарч, дээвэр дээрх шүүдэр үнэртэн дараа нь зэргэлдээ дээвэр дээрх шүүдэр үнэртэн дараа нь зэргэлдээ дээвэр дээрх их буучдын кофе цайны ааг ханхлав

-Одоо агдуур явахсан. Түшлэгтэй суудал байвал би чамайг зөөхсөн гэж Кэтрин

хэлэв.

-Би яаж суух билээ?

-Яаж ийгээд л

-Цэцэрлэгт очиж, гадаа цайлахсан гээд би онгорхой хаалга руу харлаа

-Одоо бидэнд өөр ажил байна. Чиний танил эмч валентина ирнэ. Биеий чинь бэлдэлгүй болохгүй гэж тэр хэлэв.

-Гайхалтай эмч шүү, тийм биз?

-Надад ч тийм сайхан санагдаагүй ээ. Ер нь сайн эмч байх шүү.

-Кэтрин минь нааш ирээв. Дуулав уу? гэж би хэлэв

-Болохгүй. Шөнө яасан сайхан байваа!

-Өнөө шөнөө чи бас жижиүүрлэж болохгүй юу?

-Би жижүүрлэх байхаа. Гэхдээ чи намайг гэх тэнхэлгүй болно.

-Чамайг л гэнэ.

-Гэхгүй. Чи ямар мэс засал хийлгэж үзсэн биш. Чи ямар байдалтай болохоо мэдэхгүй байна.

-Мэдэж байна. Сайн болно

-Бие чинь өвдөөд, намайг гэх тэнхэлгүй болно.

-Тэгвэл, одоо ир л дээ.

-Үгүй. Найз минь, халууны чинь тэмдэглэж, янзалж, бэлдэн гэж тэр хэлэв.

-Чи ирэхдүргүй болохоор надад хайргүй юм шив дээ.

-Чи ямар тэнэг юм бэ? гэж тэр намайг үнсэд,

-За засаж бэлдье. Халуун чинь үргэлж хэвийн байна. Чиний хралуун ийм их сайн байна гэв.

-Чи бас үргэлж сайхан байх юм.

-Үгүй, үгүй. Харин чиний халуун ийм сайн байна. Чиний халуун ийм сайн болохоор би бахтай байна.

-Лав манай хүүхдүүд цам ийм сайн халуунтай болно биз.

-Манай хүүхдүүд тогтворгүй халуунтай болохоос би айж байна.

-Валентинаг ирэхэд би юу бэлдэх хэрэгтэй билээ?

-Амархаан. Харин энэ чинь л эвгүй байна.

-Чи энүүнд оролцох нь л харамсалтай байна.

-Надад бол тиймгүй. Харин өөр хүн битгий чамд хүрээсэй гэж би бодож байна.

Би тэнэг л дээ. Хэрвээ өөр хүн чамд хүрвэл би солиорно.

-Фергюсон ч гэсэн үү?

-Ялангуяа Фергюсон, Гэйж, бас энэ хэнсэн билээ?

-Уокер үү?

-тийм, тийм. Энд дэндүү олон сувилагч байна. Хэрэв өөр шархтан ирэхгүй бол, биднийг шилжүүлнэ. Одоо энд дөрвөн сувилагч байна.

-Өөр ирэх байлгүй. Энэ том эмнэлэгт дөрвөн сувилагч ч тийм олон биш.

-Хүн ирнэ байгаа. Хэрэв чамайг өөр тийш шилжүүлнэ гэвэл би яах билээ?

Хэрэв шархтан ирэхгүй бол тэгэх л болно доо.

-Тэгвэл би бас явна.

-Дэмий бүү ярь. Чи хаашаа ч явах бологүй, харин чи минь хурдан эдгэвэл, бид хаашаа ч явж болно.

-Тэгээд яахав.

-Дайн дуусна биз. Үргэлж л байлдаад байхгүй юм байгаа биз дээ.

-Би эдгэнэ. Валетина амайг эмчилнэ гэж би хэлэв.

-Бас тэр нэг хачин сахалтай амьтан уу! Найз минь харин эфир үнэртүүлэхүүд нь л хоёр биенийхээ тухай биш, өөр юм бодоорой: Тэгэхгүй бол ухаан алдуулсан хойно дэмий юм их ярьдаг шүү дээ.

-Би тэгээд юу бодох билээ?  
 -Юу ч хамаагүй. Хоёр биенийхээ л тухай биш бол юу ч хамаагүй. Төрөл төгсөгсдийнхөө тухай. Эсхүл өөр нэг хүүхний тухай бод. Үгүй  
 -За тэгвэл маани уншаарай. Тэгвэл их аятайхан юм болно.  
 -Би дэмий юм ярихгүй ч байж болно шүү дээ  
 -Болноо. Хүн бүгд ч дэмий ярьдаггүй шүү.  
 -Би бас дэмий ярихгүй.  
 -найз минь бүү онгир. Би онгироорй. Чи ийм сайн байж онгирох тун хэрггүй.  
 -Би ганц ч үг дуугарахгүй.  
 -Найз минь, дахиад л чи онгирлоо. Чамд онгирох юм ер байхгүй. Зүгээр л сайн амьсгал гэхээр нь маани эсхүл, шлэг, эсхүл өөр юм унш. Тэгвэл тун сайн. Би чамайг бахархдаг. Чиний халуун чинь их сайн. Чи хү?үхэд шиг унтахаа, амайг гэж бодож дэрээ тэвэрдэг. Харин би биш, өөр хүүхэн гэж боддог уу? Ямар нэгэн итали дагина гэж боддог уу?  
 -үгүй ээ, чм  
 -и байлгүй яахав дээ. Би чамд тун хайртай. Валентина хөлий чинь янзалж зүгээр болгоно. Үүнд оролцохгүй байх нь надад сайн байна.  
 -Чи шөнө жижүүрлэх үү?  
 -Тэгнэ. Гэхдээ чамд ялгаагүй шүү дээ.  
 -Үзье дээ.  
 -За найз минь гүйцлээ. Чи одоо дотор гаднагүй бүр цэвэр болсон. За чи амьдралдаа хичнээн хүүхэнд дурлаж явснаа надад хэл дээ?  
 -Нэгд ч үгүй.  
 -Надад үгүй юу?  
 -Чамд тиймээ.  
 -Өөр хэдэд вэ?  
 -Нэгд ч үгүй.  
 -Хэдэд гэж, юу ч гэх юм бэ дээ%? Хэдийг таньдаг байсан бэ?  
 -Нэгийг ч үгүй.  
 -Чи хулаа хэлж байна.  
 -Тийм ээ.  
 -Зүйтэй. Чи надад үргэлж худал ярь. Би тэгэхэд дурьтай. Тэр сахйан хүүхнүүд байсан уу?  
 -Би нэгийг ч таньдаггүй байсан.  
 -Зөв даа. Тэд тун ялдамхан хүүхнүүд байсан уу?  
 -Хэлэх юм алга  
 -Чи зөвхөн л минийх. Чи өө хэнийх ч байгаагүй нь үнэнтэй. Тиймгүй ч гэсэн надад хамаагүй. Би тэднээс айхгүй. Харин чи тэднийхээ тухай надад бүү яриарай. Эмэгтэй хүн, эр хүнд элдвийн юмсаа яривал ямар байдаг вэ дээ?  
 -Бүү мэд.  
 -Аргагүй, чи мэдэхгүй биз. Хүүхэн нь эрдээ хайртай гэж хэлдэг үү?  
 Яриач.Мэдэх юмсан.  
 -Хэрвээ эр нь тэгж хэлүүлэхийг хүсвэл хэлнээ  
 -бас эр нь эмдээ хайртай гэж хэлдэг үү?. Яриач. Их сонин байна.  
 -Хэлүүлье гэвэл хэлнээ.  
 -Чи хэзээ ч хэлээгүй юү? Үнэн үү?  
 -Үгүй гэж би худал хэлэв  
 -Чи хэлээгүй. Чамайг тэгж хэлээгүй гэж би бодсон. Чи сайхан. Бичамд тун их хайртай гэж тэр хүүхэн хэлэв  
 -Дээвэр дээгүүр наран өндөр мандаад, сүмийн ганжир нарны гэрэлд

гялалзана. Гадна талдаа би цэвэрхэн болоод дотроо эмч ирэхийг хүлээнэ.

-Тийм байдаг уу? Эрийн хүссэн бүхнийг эм нь ярьдаг уу гэж Кэтрин хэлэв.

-дандаа ч тиймгүй ээ.

-Би дандаа тэгнэ. Чиний хүссэн бүгдийг би үргэлж ярина. Чиний хүссэн бүгдийг би үргэлж хийнэ. Харин ч өөр хүүхэн хөөцөлдөхгүй, тийм үү гээд баясгалантайяа намайг харснаа. Чиний хүссэнийг би хийнэ. Чиний хүссэнийг би хэлнэ. Тэгвэл сайн сайхан байна Тийм үү? Гэв.

-Тиймээ

-За чи одоо мэс засал хийлгэхэд бэлэн боллоо. Харин одоо юу хүсэж байгаагаа хэлж болно.

-Наашаа ир

-Зүйтэй. Очъёо.

-Чи миний бүр дээдийн дээд жаргал гэж би хэлэв

-Би чиний хүссэн бүхнийг ингэж л хийнэ. Одо мэдэв үү гэж тэр хүүхэн хэлэв

-Чи миний ухаантай хүүхэн

-Би чамд бүрэн сайхан санагдахгүй байх болбуу гэж би их айх юм

-Чи ухаантай хүүхэн

-Чиний хүссэнийг би хүснэ. Өөр юу ч хэрэггүй. Чиний хүссэнийг хүснэ

-Хонгор минь

-Баярлаж байна уу? Үнэхээр чи баярлаж байна уу? Өөр хүүхэн хүсэхгүй биз?

-Үгүй

-Чи баяртай байна. Хүссэн бүгдийг чинь би хийнэ

[Тор](#)

---

Мэс заслын дараа сэрэхдээ юу болсныг би мэдэхтэй байлаа. Арай ч ухаан балартчихаагүй, гагцхүү амьсгаа давхацсан болой. Энэ нь үхэхтэй адилгүй. Юм үнэртүүлж унтуулахад зөвхөн мэдрэхээ байж, их согтсон хүн шиг болоод, ганцхан л гашуун юмаар оргиул дээрдэж өгөхгүй байв. Орны хөлд гөлтгөнөөс унжсан гогцоонд тохсон шуудайтай элс байв. Тэгээд би жаахан байзнаад Гэйж хүүхнийг олж харлаа.

-Тэр

-Яаж бана? Гэж асуув

-Гайгүй гэж би хэлэв

-Өвдгий чинь мөн ч бузгай сайн болгосон шүү.

-Удсан уу?

-Хоёр цаг хагас болсон

-Би шал дэмий юм яриагүй биз?

-Үгүй, үгүй. Ярилгүй тайван хэвт гэлээ.

Бие эзгүйрхэж, Кэтриний хэлсэн үнэн болов. Энэ шөнө хэн ч жижүүрлэсэн надад адилхан аж.

Цэргийн эмнэлэгт эдүгээ надаас гадна гурван хү буйн нэг нь Жоржийн нутгаас ирсэн туранхай хөвгүүн, улаан загалмайн ажилтан, хумхаа өвчтөн: нөгөө нь Нью-Йоркаас ирсэн аанай туранхай, хумхаа шар өвчнөөр өвдсөн сайн хөвүүн, гурав дахь: австрийн холын тусгалт бөмбөгний хоолойн таглааг эрэгдэж дурсгал болгон авах гэсэн ялдамхан хөвүүн болно. Тэр нь австричууд ууланд хэрэглэж байсан холбн тусгалт их бууны тэслэх бөмбөг бөгөөд тийм бөмбөг хувь дахин хүчтэй билээ.

Кэтрин Баркли шөнө бүхэн жижүүрлэх дуртай тул сувилагчид түүнийг эрхэмлэн дээдэлнэ. Хумхаа өвчтөнд асрамж бага орох бөгөөд сайхь тэслэх бөмбөгний таглаа мултлагч хэдүйнээ бидэнтэй нөхөр бололцоод шөнийн цагт чухал хэрэгцээ гарвал л утасдах учир тэр хүүхэн завтай цагтаа надтай цуг байдаг байв. Би тэр хүүхнийг тун их хайрлаж, тэр ч надад хайртай болов. Өдөр нь би унтаж, хэрэв сэрүүн бол бид хоёр зурвас ичилцэн Фергюсоноор зөөлгөнө. Фергюсон тун сайн хүүхэн билээ. Нэг ахр нь тавин хоёрдугаар дивизид нөгөө нь Месополтамид байдгийн дээр Кэтрин Барклитай онцын холбоотой гэхээс түүний тухай өөр зүйл би мэдэхгүй.

-Фержи чи бидний хуриманд очно биз? гэж би яагаад ч юм бэ? түүнээс асуучихлаа

-Та хоёр хэзээ ч гэрлэхгүй

-Гэлэнэ

-Гэрлэхгүй

-Яагаад?

-хуримнаасаа өмнө эвдрэлцэнэ

-Хэзээ ч бид эвдрэлцэхгүй

-Амжнаа

-Хэзээ ч ер бид эвдрэлцэхгүй

-Тэгвэл үхнэ. Эсхүл эвдрэлцэнэ. Эсхүл үхнэ. Данда тэгдэг юм. Хэн ч гэрлэхгүй гэхэд нь би гараа хүргэх гэв

-Надад бүү хүр! Би уялъя гэж бодоогүй. Танд ч зүгээр л байдаг юм биз. Харин цадахад чинь явдал ургавал юу болно. Хэрэв танаас болж, цаадахад чинь явдал ургавал% би таныг ална шүү гэж тэр хүүхэн хэлэв

-Ямар ч явдал тэрүүнд ургахгүй

-Сайхан мэдээрэй. Би ч таныг болно бүтнэ гэж итгэдэг. Одоо сайн биз дээ?

-Одоо бидэнд сайхан байна.

-Тэгээд л, эвдрэлцэхгүй цаадахдаа явдал ургуулахгүй байж үз.

-Тэгнээ.

-Болгоомжлоорой. Дайны цагт тэр маань хүүхэд тэвэрч бүү үлдээсэй л гэж би бодож байна.

-Фержи, чи тун сайн хүүхэн юм даа.

-Сайнсах юмгүй. Над руу бүү ор. Хөл чинь яаж байсна.

-Сайн байна.

-Толгой чинь яаж байна гээд орой дээр нь хуруугаа хрүргэхэд өвдсөн хөлд минь л ингэж бүү хүрээсэй гэж санагдав.

-Толгойгоо ер тайвшруулахгүй байна.

-Тийм юмнаас амархан маанаг болж болно шүү. Их өвдөж байна уу?

-Үгүй

-Аз болж дээ. Зурвас бэлэн үү? Би одоо буулаа.

-Май гэж би хэлэв

-Шөнийн жижүүрээс түр амар гэж чи цаадахаа хэлэлгүй болохгүй шүү. Бие чинь тун ядарч байна.

-Тэгье. Би тэгье

-Би шөнө жижүүрлэе гэж бодсон юм. Гэтэл цаадах чинь болдоггүй. Бусад маань ч ээлжиндээ жижүүрлэхэд баяртай л байна. Цаадахаа жаахан амраах хэрэгтэй

-Тэгье

-Таныг дандаа өдөр дунд хүртэл л унтах юм гэж Ван Кампен авгай рьж байна лээ.

-Тэгэх байсан юмаа.

-Цаадахаа хэдэн шөнө жижүүр хийлгэхгшүй байлгавал сайн сайн

-Би ч тэгж бодож байна  
 -Та ч тэгж бодоогүй байх аа. Харин цаадахыгаа та ятгавал би таныг хүндэлнэ  
 -Би ятганаа  
 -Итгэхгүй л байна гээд тэр хүүхэн зурвас авч гаргав. Намайг хонх дармагц  
 Гэйж хүүхэн орж ирээд  
 -Яав? Гэв  
 -Чамтай яримаар санагдлаа. Баркли хүүхэн шөнийн жижүүрээс жаахан амрах болоогүй юм уу? Чи юу гэж бодож байна. Тэр хүн ядарсан харагдах юм. Тэр хүүхэн яагаад тэгж шөнийн ээлжинд дандаа ядаг юм бэ? ?гэхэдэ минь Гэйж хүүхэн намайг ширтэж,  
 -Би таны найз, надтай ингэж ярих хэрггүй гэж трэ хүхэн хэлэв  
 -Юу гэсэн үг вэ?  
 -Бүү тэнэгэрх. өөр юмгүй юу?  
 -Хоёулаа Вермут дарс ууя  
 -Тэгьеэ. Гэхдээ би уулцчихаад л явна шүү гээд тэр шүүгээнээсээ лонхтой дарс гаргаж, ширээн дээр аяга тавив.  
 -Чи аягаар уу, би шилээр нь ууна гэж би хэлэв  
 -Таны эрүүл мэндийн төлөө гэж Гэйж хүүхэн хэлэв  
 -Намайг өглөөд их унтдаг талаар цаана чинь Ван Канпен юу гэж ярьж байна?  
 -Яриа тасрахаа байсан. Таныг тэр “Манай тархтан” гэдэг юм  
 -Тэр муу новш!  
 -Муу ч хүн биш шүү. Нас ахисан, зөрүүд л хүн. Таныг харин уулзсаар таашаагаагүй.  
 -Тиймээ.  
 -Харин та надад таалагдсан. Би таны найз. Битгий мартаарай.  
 -Чи ховор сайн хүүхэн юм  
 -Боль доо. Сайн гэдэг үгий чинь мэдэж байна. Хөл чинь ямар байна?  
 -Сайн байна.  
 -Би хүйтэн рашаан авчирч, жаахан нэмж өгье. Гөлтгөнө шохойдуулчихаар өвддөг байх аа.  
 -Өнөөдөр халуун байна.  
 -Чи сайн хүүхэн  
 -Их өвдөж байна уу?  
 -үгүй. Тун сайн байна.  
 -Элстэй шуудайг засъя гээд тэр бөхийж –Би таны найз шүү гэв  
 -Би мэдлээ гэсэн  
 -Худлаа. Та мэдэхгүй. Гэвч мэдэх болно гэлээ.  
 Кэтрин Баркли гурван шөнө жижүүр хийлгүй байгаад ирэхэд бидний хэн хэн нь алс аянд удтал яваад эргэж уулзалдсан мэт байлаа.

[Тор](#)

---

Тэр зун бид тун аятайхан байлаа. Намайг босч болно гэснээс хойш бид цэцэрлэгт зугаалах гэж унаагаар очдог болов. Алгуур алхлах миорь, тэрэг, урдтай суугаа хөтөч, түүни маажиндсан өндөр бүрх, зэрэгцэн суугаа Кэтрин Баркли, энэ бүхнийг би санаж байна. Бид хоёрын гар нэг нэгэндээ дөнгөж хүрмэгц л хоёулангшийн маань дотоор

догдолдогсон. Тэгээд би суга таяг тулах болсноос хойш, бид Биффи болон Гран-Итали гуанзанд очиж үдийн хол идэхдээ. Гадаа Galleria-гийн талд ширэ засуулдагсан. Хоол зөөгч орж гарч, зорчигчид дэргэдүүр өнгөрөн, бүтээлэгтэй ширээн дээр бүрхүүлтэй дэн байдагсан. Төдөлгүй Гран-Итали гуанз бидний уртай очдог газар болж, ахлах зөөгч Жорж ямагт ширээ зэхсэн байдагсан. Тэр ахлах зөөгч тун аятай хүн тул өөрөө л ямар хол өгөхөө мэд гэж даатгаад бид Galleria-гийн бүрэнхүйд замхрах зорчигчид болон бие биесээ ширтэн суудаг байв. Хувинтай мөсөнд суулгасан хуурай цагаан Капри дарс уухаас гадна бид Фреза, Барбера, амтат цагаан дарс зэрэг олон дарсны амтыг үзсэн билээ. Дайнаас болж гуанзанд архины тусга зөөгч байсангүй. Фреза мэтийн дарс сураглахад Жорж дурамжхан мушилздаг байв

-Зэтгэнэ шиг амттай дарс хийдэг улсынх тухай юу ч гэх билээ гэж тэр хэллээ.

-Юу нь муу юм бэ? Надад харин аятайхан гэж Кэтрин асуун өгүүлэв

-Бүсгүй минь, аятай бол амсаарай. Харин tenente-д нэг лонх марго дарс авчрах уу? гэж Жорж хэлэв

-Жоржоо, би бас үзье

-Эрхэм минь би бол дургүй л байна. Зэтгэнийн амт ч тэр дарсанд бахгүй.

-Гэтэл тун аятайхан санагдвал яах вэ? гэж Кэтрин хэлэв-Би авчирч өгье. Бүсгүй гуайн сэтгэл ханахаар би зкөөж авъя гэж Жорж хэлэв

-Үнэхээр сулхан дарс бөгөөд Жоржийнх зөв болж, зэтгэнийн амт ч үгшүй байлаа. Тэгээд бид Капри дарс уув. Нэг удаа би мөнгө дутаж, Жорж зуун ли зээлүүлж билээ.

-Зүгээр зүгээр. Tenente янз бүрийн юм тохиолддог. Би мэднэ. Танд юм уу танай авгайд мөнгө хэрэгтэй болбол би үргэлж тусалж байна гэж тэр хэлэв

-Үдийн хоолны дара бид Galleria-гаар явж, өөр гуанз болон буулгадаг төмөр хөшигтэй дэлгүүрүүд өнгөрөөд зираа болон гахайн махтай сэндвич, мөн долоовор хуруунаас уртгүй жижиг ягаан талхан дээр май жараахайтай сэндвич зардаг мухлагийн үүдэнд зогсож, шөнө өлсөхдөө идэхээр тэр бүгдээс авлаа. Тэгээд бид сүмийн эсрэг Galleria-гийн амнаас задгай морин тэргэнд сууж цэргийн эмнэлэгтээ ирэв. Эмнэлгийн үүдэнд хаалгачин гарч ирээд таяг тулахад минь түшив. Хөтчид би мөнгө төлөөд бид цахилгаан шатаар өгслөө. Сувилагчид суудаг давхарт Кэтрин бууж, би дээш гарад гудмаар таягтай явж өрөөндөө орлоо. Заримдаа би тайчиж хэвтдэг агаад, заримдаа тагтнаа суун хөлөө сандал дээр твьж, дээвэр дээгүүр нисэж яваа хараацай ажиглан Кэтринг хүлээнэ. Түүний өгсөж ирэх нь алс аянаас эгэж ирсэнтэй адил бөгөөд би таягтайгаа гудмаар хамт түмпэн зөөж, өвчтөн нь хэрэв бидний найз бол бид хоёр хамт орж, биш бол би үүдэнд нь хүлээж тэр маань хамаг ажлаа дууссан хойно хоёул миний өрөөний тагтан дээр сууна. Тэгээд би орондоо хэвтэж, цөм унтсан хойно, одоо ч дуудах хүнгүйдээ гэхдээ тэр хүүхэн ирнэ. Би түүний үсийг задгайлах дуртай билээ. Тэр хүүхэн хөдлөлгүй орон дээр сууж, ямагт гэнэт гэнэт бөхий н намайг үнсэнэ. Би хаваары нь авлаа. Дэвсгэр дээр тавилахад үсний нь үзүүр ар шилэндээ тогтож ядаад сүүлчийн хоёр хавсаар авмагц бү задран унаж тэр хүүхэн толгойгоо бөхийлгөхөд үс нь бид хоёрыг бүрхэж, майхан дотор буюу хүрхрээний цаана буймэт болно.

Тэр хүүхэн үлэмжийн сайхан үстэй тул онгорхой хаалгаар, тусах гэрэлд эргүүлж янзлахы нь би хэвтэнгээ ямагт ширтдэг байв. Шөнийн цагт ч үс нь үүрийн үнэгэн харанхуйд ус гялтганах адил гялалзана. Тэр хүүхэн үзэсгэлэнт царайтай, гоолиг биетэй, мяндсан гөлгөр арьстай билээ. Тэр бид хоёр зэрэгцэн хэвтээд хацар, дух, доод зовхи, эрүү хүзүүнд нь би хурууны үзүүр хүргэж: “Яг л төгөлдөр хуурын даралт шиг” гэж хэлэхэд миний эрүүг хуруугаараа илбэж “Төгөлдөр хуурын даралтан дээгүүр явуулбал яг л гуранз шиг” гэж тэр хэлэв



-Хатгаж байна уу ?гэсэнд

-Үгүй ээ, найз минь. Чамайг л өдсөн юм гэв.

Тэр шөнө тун аятай байлаа. Хэрэв бид шүргэх төдий учралдсансан бол жаргалд тоолно. Учралын гол бөаяраас гадна хайраа илэрхийлсэн олон жижиг тохиол бидэнд буй. Саланги байхдаа бид хоёр бие биенийхээ сэтгэлд орох гэдэг байв. Заримдаа тэр нь биелсэн юм шиг байдаг нь үнэндээ бид хоёр нэг л адилхан юм боддогтоон байсан биз. Цэргийн эмнэлэгт Барклийн ирсэн өдрийг бид гэрлэсэн өдрөө гэж ярилцаад тэр өдрөөс эхлэн сар тоолов. Үнэхээр гэрлэе гэж би хүсдэг байлаа. Харин Кэтрин хэлэхдээ: Тэгвэл би явна. Эсхүл биднийг бүртгүүлэх хооронд намайг мөрдөж хагацаана гэнэ. Тэгвэл италийн гэр бүлийн хуулиар гэрлэх хэрэгтэй. Бүртгэл гэдэг нь тун ярвигтай. Ялангуяа хүүхдийн тухай бодол намайг зовоож үнэхээр гэрлэе гэж би хүсдэг байлаа. Харин бид өөрсдийгөө гэрлэсэн тоолдог. Түүндээ тайвширна. Гэтэл хэрэг дээрээ гэрлээгүй байдаг нь надад таатай. Чухам энэ тухайн нэгэн шөнө бид хоёр ярьснаа санааж байна. Кэтрин хэлэхдээ:

-Тэгээд, найз минь би эндээс гэнэт явах болбол яана

-Явахгүй ч байж болно.

-Явах л болно. Намайг буцааж, дайн дуустал чи бид хоёр уулзахгүйд хүрнэ.

-Би чөлөөгөө очно.

-Чөлөөний хугацаанд Шотланд ороод буцаж ирж амжихгүй. Бас би чамаас холдохгүй. Одоо бидэнд заавал гэрлэх хэрэг юу байна? Бид гэрлэсэн л байна. Энүүнээс илүүгээр гэрлэнэ гэж байхгүй.

-Би чамайг л гэж ингэж байгаа юм

-“Чамайг” гэж бүү ярь. Би гэдэг чинь “Чамайг” гэж бүү тусгаарлаж үзээрэй.

-Хүүхнүүд дандаа л эрд гарах бодолтой байдаг байх гэж би санадаг.

-Тийм л дээ. Гэхдээ найз минь би нөхөртэй. Чи миний эр нөхөр. Би муу эхнэр гэж үү?

-Чи тун сайхан эхнэр

-Найз минь, би бас нэг удаа эрд гарах гэж хүлээж үзсэнийг чи мэднэ шүү дээ

-Би энэ тухай сонсох ч дургүй байна.

-Ганцхан би л чамд хайртай болохоор өөр хэнч надад дурлаж байна, хамаагүй биш үү.

-Тиймээ

-Бас тэр үхсэн. Чи намайг эзэгнэсэн. Хардаад байх юу байна?

-Тийм байлаа чби тэр тухай сонсох дургүй.

-Хөөрхий минь? Чи янз бүрийн хүүхнүүдтэй байсныг би мэдэхээс өөр яах ч үгүй.

-Хоёлухнаа нууцаар гэрлэвэл арга нь олдох уу? Гэнэт би яадаг ч юм бэ?, эсхүл чи хүүхэдтэй ч болж болно.

-Иргэний, сүмийн гэж л хоёрхон янзын гэрлэх ёс байдаг. Нууцаар гэвэл бид гэрлэчихсэн. Найз минь, би хэрэв бишрэлтэйсэн б ол энэ чинь надад их л чухал байхсан. Гэтэл миний бишрэлтийг чи мэднэ

-Чи надад ариун сахиус өгсөн.

-Тэр чинь ерөөлийн юм. Надад ч бас өгсөн.

-Тэгвэл чамд зовох юмгүй юу?

-Ганцхан бид хагацах бий дээ л гэж бодох юм. Чи миний бишрэл, ертөнц дээр чи л байвал наддаа боллоо.

-Зүйтэй. Чамайг хүсмэгц л би чамтай гэрлэнэ.

-Хонгор минь, ч намайг журамт бүсгүй болгох л чиний үүрэг юм шиг ярих юм. Би журамт бүсгүй шүү. Жаргал, бахархал болно гэвэл өөр хэрэгл дээ. Чи жаргаагүй байна гэж үү?

-Чи надаас өөр хүнд хэзээ ч очихгүй шүү дээ.

-Үгүй ээ, найз минь. Би чамаас салаад өөр хэнд ч хэзээ ч очихгүй. Харин бидэнд нэг л их аюул тохиолдмоор юм шиг надад санагдаад байна. Гэхдээ энэ тухай зовох хэрэггүй.

-Би зовоогүй. Би чамд хязгааргүй хайртай. Гэтэл чи надас өмнө өөр хүнд дурласан.

-Тэгээд яасан бэ?

-Тэр үхсэн

-Тиймээ. Хэрвээ тэгээгүй бол би чамтай уулзахгүй л байх байсан. Найз минь, чи намайг тогтворгүй гэж болохгүй. Надад олон муу тал бий. Гэхдээ би даанч тогтвортойдоо. Тэр ч байтугай миний тогтвор чамд залхуутай байгаа байхаа.

-Би удахгүй фронтдоо буцаж очих ёстой.

-Чамайг энд байгаа цагт тэр тухай бодохоо больё. Найз минь, ба жаргалтай, бид хоёр сайхан байна. Би жаргал эдлэлгүй тун уджээ. Анх чи бид хоёрыг уулзахад би бараг солиотой байсан. Бүр солиорсон байсан биз. Гэтэл одоо бид жаргалтай, бие биендээ хайртай. Сайхан жаргалтай л байя л даа. Чи жагалтай шүү дээ, тий үү? Чамд аятай харагдах гэж би яах вэ? Аан? Би үсээ унжуулах уу? Тэгэх үү?

-Тэг. Тэгээд дараа нь энд хэвт

-За. Харин эхлээд өвчтөнөө эргэе.

[Тор](#)

---

Тийнхүү зун өнгөрлөө. Зуны өдрүүд ихээхэн халуун байсан, сонинууд ялалтын мэдэгээр дүүрэн байсан гэхээс өөр мэдэх юм алга. Бие минь эрүүлжиж, шарх түргэн аниад, суга таягтай босох болсноос хойш төдөлгү йби гар таягтай явдаг боллоо. Тэгээд би Ospeda le Maggiore очиж өвдөгний үе мөчний эмчилгээ хийлгэх болж механик эмчилгээ хийлгэж хөх ягаан гэрлээр шаруулж үе мөчөө бариулж угаалга хийлгэж эхлэв. Үдийн хоолны дараа би тэнд оод буцах замдаа, Кафе гуанзанд орж шар айраг уун сонин уншина. Би хотоор тэнэдэггүй, Факе гуанзангаас шууд эмнэлэгтээ ямагт эгэж ирнэ. Кэтринтэй уулзах л гол х үсэл минь байлаа. Бусад цагийг яаж ийж өнгөрөөнө. Ихэвчлэн би өглөөгүүр унтаж, үдийн хоолны дараа ямагт морин уралдаан үзэж, дараа нь механик эмчилгээ хийлгэхээр очно. Англи-Америкийн клубт би дандпаа орж, цонхны дэргэдэх том ширэн сандалд суугаад сонин ушинэ. Намайг суга таягаа орхисноос хойш, үзтэл тусламж хэрггүй нэгэн өвчтөнтэй, сувиллагч хүн зугаалж явах нь эвгү йгээд бид хоёрын хамт гарахыг хэдүйн хориглосон тул өдрийн цагт цуг байх маань ховордоо. Хэрэв Фергюсон хамт байвал хотын нэгэнтээ цугтаа үдийн хоол идэж болдог ч байлаа. Кэтрин бид хоёрыг найзууд гэхэд Ван Канпен авгай зөвшөөрсөн учир гэвэл түүний ажилд нь Зэтрин ихээхэн тусалдаг байлаа. Онцын сайн гэр бүлээс Кэтринийг гарсан гэж тэр үздэг нь бидэнд ч маш ашигтай болов. Ван Канпен авгай гарал үүслийг ихээхэн чухалд тооцдог бөгөөд өөрөө язгууртан гаралтай хүн юм. Түүнээс гадна эмнэлэгт олон ажил явдал байдаг болохоор тэр зан муутай. Зунхалуун байлаа. Милан хотод би олон танилтай боловч бүрэнхий болохтой зэрэг эмнэлэгтээ ирэх гэж яардаг байлаа. Фронт Карсо тийш урагшилж, Плавын нөгөө эрэг дэх Кукийг хэдүүн эзлээд, өдгөө Баинзиццын тал хүрчээ. Баруун фронтод муухан байв. Дайн тул их удах шинжтэй боллоо. Өдгөө бид бас дайнд оржээ. Гэхдэ хүрэлцэхүйц цэрэг илгээх, тулалдаанд бэлтгэхэд жилээс

илүү хугацаа хэрэгтэй гэж би бодож байв. Ирэх жил сайн муу алин болох нь мэдэгдэхгүй байлаа. Италийн цэрэг үлэмжхэн хохирчээ. Яаж ингэж үргэлжлэх юм бол доо. Монте Сан-Габриел болон Баинзиццын талыг бүрэн эзэллээ ч гэсэн австричуудад бас их олон уул бий. Би тэр уулсыг харсан. Цаашлах тусмаа хамаг өндөр уулс бий. Карсод давшиж амжсан боловч доошлоод далайн хөвөөгөөр намаг шавартай. Австричуудыг Наполеон бол хөндийд бут цохино. Тэдэнтэй тэр ууланд ер тулалдахгүй йбуйзаа. Тэднийг тэр зам тавьж буулгаад Вероны тэнд л бут цохисон юм одоохондоо алга. Өдгөө дайн ялалтаар дуусахгүй байж магадгүй. Дайн ер дуусахгүй байж ч магадгүй. Энэ ер нь шинэ зуун жилийн дайн байж ч магадгүй. Уншиж байсан сонин би байранд нь тавиад клубээс гарлаа. Шатаар би аяархан бууж, Виа Монционигоор явлаа. Гранд-Отел буудлын өмнө Мейерс өвгөн гэргийн хамт, жууз тэрэгнээс бууж харагдав. Тэд морин уралдаанаас эгэн иржээ. Эхнэр нь том хөхтэй гялалзсан хар торгон хувцастай, нөхөр нь буурал сахалтай, жи жигхэн биетэй, ул татанхай өвчтэй болоод таяг тулж явдаг өвгөн аж.

-Сайн сууж байна уу? Бие чинь сайн уу? гэж тэр хүүхэн гар барив.

-Баяр хүргэе гэж Мейерс хэлэв

-Уралдаан яав?

-Үлэмжийн сайхан боллоо. Би гурван удаа хожлоо.

-Та яасан бэ? гэж би Мейерсээс асуув.

-Зүгээр, би нэг удаа хожсон

-Энүүний ажлдыг би ер мэддэгүй. Энэ надад ер ярьдаггүй юи гэж Мейерсын авгай хэллээ.

-Миний ажил сайн гэж Мейерс хэлэв Тэр дотно байхыг хичэж: Чи яаж ийж морин уралдааны тэнд очих хэрэгтэй гэж ярихдаа, ярьж буй хүн рүүгээ хараагүй, эсхүл хүн андуурсан сэтгэл төрүүлнэ

-Яриангүй гэж би хэлэв

-Цэргийн эмнэлэгт чоиж би чамайг эргэнэ. Хүүхдүүддээ өгөх юм бий. Та нар цөм л миний үрс шүү дээ. Та нар цөм миний хонгор үрс гэж Мейерсийн авгай хэлэв

-Таныг очиход тэд их баярлана

-Ёстой, хонгор үрс. Чи ч ялгалгүй. Чи миний нэг хүү

-Би явах боллоо гэж би хэлэ

-Миний хонгор үрст цөмд нь мэнд хүргээрэй. Би амттайхан юм ихийг аваачиж өгнө. Би сайн марсал дарс печень боов хадгалсан.

-Баяртай. Танд цөмөөрөө жигтэйхэн баярлана гэж би хэлэв

-Баяртай. Galleria очоорой. Миний ширээг мэднэ биз дээ. Билд тэнд өдөр болгон байдаг гэж Мейерс хэлэв. Би гудамжаар цааш явав. Би Кова орж Кэтринд юм авах гэсэн юмсан. Кова орж хайрцаг шоколад шилж аваад худалдагч эмэгтэй боодоллох хооронд би архины лангууд очлоо. Тэнд хоёр англи хүн, хэдэн нисгэгч сууна. Би мартины дарс уугаад хэнтэй ч ярилцалгүй үний нь төлөөд чихрийн лангуунаас хайрцаг шоколадаа авч цэргийн эмнэлэгтээ очив. Архи ны жижиг гуанзангийн үүдэнд "Ла-Скала" очдог гудамжнаа хэдэн танил зогсох нь: дэд элчин-консул, дуу заалгаж буй хоёр залуу, италийн зэвсэгт хүчинд алба хааж буй Сан-Францискийн итали Эттор Моретти нар аж. Би тэдэнтэй архи уухаар оров. Дуучны нэгийг Ральф Симмонс гэдэг бөгөө тэр Энрико дель Кредо гэдэг нэрээр дуулдаг. Хэрхэн дуулдгийг нь би төсөөлөх ч үгүй авч тэр дандаа их их үйл явдлын босгон дээр байдаг. Тэр тарган агаад хамар амы гнь тойрон хээрийн хадиадных нь шиг арьс хогжруутжээ. Тэр саяхан Пьяченцад дуулаад эгэж ирсэн ажээ. Тэр "Тоске" орж дуулж бүхнээ гайхагджээ.

-Чи ер миний дуулахыг сонсоогүй шүү дээ гэж тэр хэлэв

-Энд хэзээ дуулах вэ?

-“Ла-Скала”-д намар дуулна

-Энүүн рүү сандлаар шидэх хүн оллоо. Моденд энүүн рүү сандлаар шидснийг чи сонссон уу? гэж Эттор хэлэв

-Худлаа гэсэнп-Энүүнийг сандлаар шидэхэд би байсан. Би өөрөө зургаан сандал шидсэн гэж Эттор хэллээ.

-Чи ёстой Фрискийн адгийн жонхуу.

-Энэ итали дуудлага муутай, хаан ч дуулсан сандлаар шиднэ гэж Эттор хэлэв

-Бүх умард Италид Пьяченцаас муу театр байхгүй. Ёстой хогийн театр шуухан юм гэж өөр нэгэн баргил хоолойтон хэлэв. Тэр баргил хоолойтонг Эдгар Саундерс гэдэг бөгөөд Эдуардо Жованни гэдэг нэрээр дуулдаг аж.

-Би тэнд очиж, сандлаар шидүүлэхий чинь хараагүй нь харамсалтай. Та чинь италиар дуулж чаддаггүй шүү дээ гэж Эттор хэлэв.

-Энэ сандлаар шидэхээс илүү юм олж чадахгүй итэнэг гэж Эдгар Саундерс хэлэв

-Чамайг дуулахад тэрнээс илүү юм үзэгчид олж чадахгүй. Тэгээ ч Америкт буцаж очоод “Ла-Скал”-д дуулснаа ярина. “Ла-Скал”-аа чамайг дуу гарахтай чинь зэрэг л хөөхсөн бий.

-Би “Ла-Скала”д дуулна. Арван сард “Тоске”-д дуулна гэж Симмонс хэлэв.

-Махаа, очих болж байна. Эднийг хамгаалах хэрэг гарах байх гэж Эттор дэд элчин-консулд хэлэв

-Америкийн зэвсэгт хүчин эдэнд хамгаалалт болж болох юм гэж дэд элчин-консул хэлэд-Симмонс оо, дахиад нэг аяга уух уу? Саундерс бас нэг аяга ууна уу? гэв

-Алив гэж Саундерс хэллээ

-Таныг мөнгөн медаль авна гэж ярьцгаах юм. Яаж тодорхойлсон бэ? Ямар гавьюя байгуулсан бэ? гэж надад Эттор хэллээ.

-Мэдэхгүй. Ер нь аваах ч юм уу, мэдэхгүй л байна гэв

-Авна, ээ харл а гэж дээ, Кова-гийн хүүхнүүд юу гэх бол доо! Тэд бодохдоо, таныг ганцаархнаа хоёр зуун асвтричуудыг алсан, эсхүл бүтэн окоп эзэлсэн гэнэ. Б өөрийнхөө үүрэг гавъяа шударга гүйцэтгэсэн.

-Эттор оо, чамд хэд бий вэ? гэж дэд элчин-консул асуулаа.

-Одон бүгд бий. Энхэ хүний тулд л дайн хийж байгаа юм гэж Симмонс хэлэв.

-Би хоёр удаа хүрэл, гурван удаа мөнгөн медаль авахаар тодорхойлогдсон. Тэгээд ганцыг авсан гэж Эттор яриу.

-Бусад нь яасан бэ? гэж Симмонс асуулаа.

-Мэс засал муу болсон. Хэрэв мэс засал муу болбол медаль өгдөггүй гэж Эттор хэлэв.

Эттор чи, хэдэн удаа шархадсан бэ?

-Гурван удаа хүнд шархадсан. Би шархны гурван тэмдэгтэй харцгаа гээд цжмбэн ханцуйгаа харуулав. Хар суурьтай зэрэгцмэл мөнгөн зурвас тэмдэг, мөрнөөс доош долоон дюйм зайтай байлаа.

-Танд бас нэг бий шүү дээ. Тэмдэгтэй байх тун сайн хэрэг бие дээ. Би үүнийг медалиас илүү хүндэлдэг. Нөхөд минь, гурван ийм юм чинь учиртай шүү. Адаглаад нэгийг олоход гурван сар цэргийн эмнэлэгт хэвтэх хэрэгтэй болно гэж Эттор наздад хэлэв

-Хаана шархадсан бэ, Эттор оо? Гэж дэд элчин консул асуулаа. Эттор ханцуйгаа шамлаж, Энд хэмээн урт улаан гөлгөр сорви үзүүлэхэд, бас хөлд бий. Хөлийн уланд ороолтон дотор болохоор би үзүүлж чадахгүй байна. Хөлийн хэсэгхэняс мэдрэлгүй болчихоо муухай үнэр гардаг болсон, Өглөө болгон би тэндээс хэлтэрхий авч хаядаг. Харин үнэр нь арилахгүй юм гэ.

-Юуны шарх вэ? гэж Симмонс асуулаа.

-Гар бөмбөгнийх. Төмсний үрлэгч шиг л юм. Тэгээд хөлийн минь нэг талыг зулгаачихсан юм. Тэр бөмбөгийг мэдэх үү гэж миний зүг харав.

-Мэднээ.

-Тэр хортны бөмбөг шидэдэх нь би харсан. Би ч уналаа. Ингээд л дуусах гэж бодлоо. Гэвч тэр бөмбөггэй барцад багатай юм. Би тэр хортонг винтовоор буудсан. Офицер гэдгээ нууж би үргэлж винтов үүрдэг байсан юм гэж Эттор хэллээ.

-Ямар янзын хүн байсан бэ? гэж Симмонс асуулаа. Тэр хортон ганцхан л бөмбөгтэй байж. Тэрнээ яах гэж шидсэний нь бүү мэд. Лавтэр бөмбөг шидэж үзье гэж бодож явсан байх. Жинхэнэ тулалдаан огт үзэгү йбайж таарна. Би тэр хортонг тэнд нь хэвтүүлсэн гэж Эттор хэлэв

-Буудахад тэр ямар янзтай байв? гэж Симмонс асуулаа.

-Би яаж мэдэх юм бэ? Би гэдэс рүү нь буудсан. |Толгой руу нь буудъя гэтэл алдчих байх гэж айсан гэж Эттор хэлэв

-Эттор та офицер болоод удсан уу? гэж би асуув.

-Хоёр жил, би удахгүй ахмад болно та дэслэгч болоод удаж байна уу?

-Гурван жил болж байна.

-Та итали хэл муу мэддэг болохоор ахмад байж таарахгүй. Та яьж чаддаг боловч бичих уншихдаа муу. Ахмад болоход боловсрол хэрэгтэй. Та америкийн армид шилжихээ яасан юм бэ? гэж Эттор хэлэв

-Шилжих ч болно.

-Би ч бас дургүйцэхгүй л байна. Америкийн ахмад ямар цалинтай вэ? Мак аа?

-Тодорхой мэдэхгүй. Хоёр зуун тавин доллар орчим болов уу даа.

-Чөтгөр гэж! Хоёр зуун тавин доллараар юу ч хийж болно. Фред та түргэхэн америкийн армид шилжмээр юм даа. Тэгвэл би ч орж болно.

-Болноо

-Би италиар салбар удирдаж чадна. Надад англиар суога гшэхийн хэрэг алга

-Та генерал болно гэж Симмонс хэлэв

-Генерал болоход миний мэдлэг дутна. Алив юмны үхэл мөхлийг генерал мэддэг байх ёстой. Дайн гэж дэмий юм гэдгийг танаас бусад залуус ойлгоно. Танд ахлагчийн ч чадвар дутна

-Тэр чин ч нада хэрэггүй гэж Симмонс хэлэв

-Хэрэг болох ч цаг ирнэ. Ийм залхуучуудыг цөмийг цэрэгт татахсан... Та хоёр, тэгээд миний цэрэг болж таардаг ч болоосонй. Мак ч ялгалгүй, Сак , чамаар би мэдээчнээ хийхсэн

-Эттор чи сайн хөвүүн. Гэхдээ түрэмгийлэгч байх гэж айж байна гэж Мак хэллэ.

-Дайн дуусахаас өмнө би хурандаа болно гэж Эттор хэллээ.

-Урьд нь чи алагдчихгүй л болбол,

-Алагдахгүй гээд тэр захан дээрх таван хошуугаа эрхий долоовор хоёр хуругаар дарж

-Би яаж байна харав уу? Данд үхэх тухай яриа гарахад таван хошуугаа ямагт дарах хэрэгтэй гэв

-За Сим ээ явъя гэж Саундерс босонгуутаа хэлэв

-Явцгаая.

-Баяртай. Би ч явъя Giaou, Эттор гэж би хэлэв. Гуанзангийн цаг зургаад арван таван минут дутуу байлаа.

-Giaou ферд гэж Эттор хэлээд, Чи мөнгөн меаль авах сайхан байна гэв

-Авах эсэхийг бүү мэд

-Лавтай авна, Фредээ! Чамайг лав авна гэж би сонссон

-За баяртай. Эттор минь зовлонд унав даа гэж би хэллээ.

-Надад бүү зшв. Би архидаж тэнэдэггүй. Авгай хөөж дэмийрдэггүй. Сайн мууг би ялгана.

-Баяртай. Ахмад болоход чинь би баярлана гэж би хэлэв

-Би өөр юм хийхгүй дайчин гавъяагаараа ахмад болно. Дээрээ титэмтэй зөрүүлдсэн сэлэмтэй гурван таван хошууг чи мэднэ биз дээ. Тэр чинь би байна.

-Санасанчлан болтугай.

-Санасанчлан болтугай. Ч фронтдоо хэзээ буцах вэ?

-Одоо удахгүй

-Дараа уулзъя

-Баяртай

-Баяртай. Бүү гуйваарай.

Цэргийн эмнэлэгт араас нь орж болох булангаар би тойров. Эттор хорин гуравтай. Сан францискод авгындаа өссөн бөгөөд дайн зарлах үецэр Туринд эцэг эхдээ айлчлан иржээ. Америк авгындаа хамт өссөн эгч нь энэ жил сурган хүмүүжүүлэх сургууль төгсөх ёстой. Тэр хүн бүгдийн залхуу хүргэдэг хэвшмэл баатруудын нэг билээ. Түүний яриаг Кэтрин тэсвэрлэж чадсангүй.

-Манайд бас баатрууд бий. Гэхдээ тэд арай даруухан шүү дээ гэж Баркли хэлэв.

-Надад тэр саад болоогшүй.

-Надад ч адилхан. Гэхдээ тэр дэндүү эрхэмсэг, тэгээд бас ёстой уйтгарын тулам

-Надад ч бас уйтгартай.

-Найз минь чи надад л гэж тэгж ярьж байна. Тэрхамаагүй. Фронт дээр тэр лав үүргээ биелүүлдэг байх гэж бодож болно. Гэхдээ л би тийм хүүхдүүдэд дургүй

-Тэрүүнд сүйдп болоод байх хэрэггүй шүү дээ.

-Дахиад л чи надад гэж ярьж байна уу? Тэрүүнд бүү зэвүүцээсэй л гэж байна уу. Гэхдээ тэр чинь ёстой өөдгүй хүүхэд шүү.

-Өнөөдөр тэр ахмад болно гэж ярьсан

-Сайн байна. Тэр бахтай байгаа байх гэж Кэтрин хэллээ.

-Намайг өндөр цолтой байгаасай гэж чи боддог уу?

-Үгүй ээ, найз минь. Сайн риесторанд бид рж болох л цол чамд байвал боллоо.

-Тэрүүнд ч би ахдахуйц өндөр цолтой.

-Чи сайхан цолтой. Чамайг би илүү өндөр цолтой болоосой гэж ер хүсэхгүй. Тэгвэл чиний тлгой эргэж болно. Найз минь бичамайгаа эрхэмсэг зангүйд нь баярлах юм. Чамайг эрхэмсэг зантай байсан ч би чамтай суух л байсан. Гэхдээ эр нөхөр минь эрхэмсэг зангүйд тайван сайхан байх юм.

Бид тагтан дээр сууж намуухан ярилцана. Сар гарах болсон боловч хотын дээгүүр маантаад, хэсэг зуур байтал бороо шивэрчя, бид тасалгаанд орлоо. Манан нь бороо боло н орж байснаа аадар цутгаж, дээвэр бөмбөрдөв. Тасалгаанд ус орж буй эсэхийг үзэхийг би босож тагтны хаалга руу очоод зүгээр тул онгорхой орхв.

-Өөр хэнтэй уулзав гэж Кэтрин асуув

-Мейерс гуай эхнэртэйгээ тааралдсан

-Хачин хоёр шүү.

-Эх орондоо тэр шоронд байсан гэлцдэг. Чөлөөтэй яваад үхэг гэж сулласан юм гэнэ.

-Түүнээс хойш тэр Миланд жаргаж байгаа юм уу?

-Жаргалтай эсэхийг мэдэхгүй

-Шоронгоос гарсан хойно жаргалтай байх ёстой.

-Тэд бэлэгтэй ирэх гэж байна.

-Тэр авхай гоё бэлэг авчирна. Чи бас хонгор үр ньбиз дээ?  
 -Тэгэлгүй яахав  
 -Та нар цөм хонгор үрс нь  
 -Хонгр үрсдээ тэр тун хайртай. Бороог сонсож байна уу гэж Кэтрин хэлэв  
 -Ширүүн бороо  
 -Чи намайг хаяхгүй биз  
 -Үгүй  
 Бороо хамаагүй юу?  
 -Хамаагүй  
 -Яасан сайхан юм бэ? Би борооноос айдаг.  
 -Яагаад? Миний нойр хүрч, цонхны цаадтай бороо улам асгарна.  
 -Бүү мэд, найз минь. Би дандаа борооноос айдаг  
 -Би бороонд дуртай.  
 -Би бороотойд зугаалах дуртай. Хайрын хувьд гэвэл муу зуршил биз.  
 -Би чамайгаа үүрд хайрлаа.  
 -Бороотой ч, цастай ч, мөндөртэй ч өөр юутай ч байсан би чамайгаа харлана.  
 -Бүү мэд. Нойр хүрээд байна.  
 -Найз минь унт. Ямар ч гэсэн би чамайгаа хайрлана  
 -Нээрээ чиборооноос айдаг уу?  
 -Чамтай бол айхгүй  
 -Яагаад чи тэгж айдаг юм бэ?  
 -Мэдэхгүй  
 -Хэл л дээ  
 -Бүү албадаарай  
 -Хэл л дээ  
 -Үгүй  
 -Хэл л дээ  
 -За хэлье. Яагаад гэвэл би бороотойд л үхэх байх гэж дандаа боддог юм.  
 -Яалаа гэж%  
 -Чамайг үхчих байх л гэж би дандаа бодох юм  
 -Тэгвэл энэ арай үнэн байж болно  
 -Найз минь ер тэгэхгүй. Яагаад гэвэл би чамайг асарч чадна. Чадахаа би мэднэ. Өөрийгөө бол яаж ч чадахгүй.  
 -Больж үз дээ. Өнөөдөр би Шотландын галуу солиорол сонсох дургүй байна. Бидний хамт байх хугацаа бага үлджээ.  
 -Би Шотланд хүүхэн болоод галзуу бол яая гэхэв. Би больё. Ер нь дэмий юм боллоо.  
 -Тиймээ ер нь дэмий юм  
 -Ер нь дэмий м. Ерөөсөө л дэмий юм. Би борооноос айдаггүй. Би борооноос айдаггүй, Ээ бурхан минь гэж дээ. Хэрэв би айдаггүйсэн бол доо? гээд тэр хүүхэн уйлав. Намайг аргадахад тэр уйлахаа зогсов. Бороо орсор л байлаа.

[Тор](#)

---

Үдийн хоолны дараахан бид морин уралдаан үзэхээр явав. Бид хоёрын хамтФергюсон миён нөгөөх холын тусгалт их бууны бөмбөг дэлбэрэхэд нүд нь

шархадсан Кроуэл Рожерс явлаа. Хүүхнүүд хувцаслатал Рожерс бид хоёр орон дээр сууж, түрүүлэх болзлтын нэрс, сүүлчийн уралдааны дүн бичсэн биеийн тамирын хуудас үзэж байв. ТОлгой нь битүү боолттой Кроуэл морин уралдааныг тун бага сонирхдог боловч өөр хийх юмгүй тул бүх морьдыг мэдэж биеийн тамирын хуудас байнга уншдаг болй. Энэ морьд цөм адгийн адсага, олигтой юм ер байхгүй гэж тэр ярина. Мейерс өвгөн талархаж зааж зөвлөнө. Мейерс үрглж хожно. Гэхд зааж хэлэх дургүй. Учир юун гэвэл орлого нь багасах болно. Морин уралдаанд булхай их балаа. Дэлхийн бүх морин уралдааны гшазраас хөөгдсөн уралдаачид Италид цугласан байв. Мейерсын зааж хэлэх нь ямагт оновчтой авч би түүнээс юм асуух дургүй. Яагаад гэвэл тэр ихэвчлэн үл хариулах агаад хариулавч тун дурамжхан билээ. Гэхдээ тэрвээр өөрийгөө бидэнд зааж хэлэх учирта гэж үзэх бөгөөд Кроуэлд бусдаас арай л илүү харагдана. Кроуэлын нүд нь гэмтсэн ялангуяа өрөөсөн нүд нь айхавтар гэмтсэний гадна Мейерсийн нүд ч бас муу тул тийнхүү илүү ханддаг буйзаа. Аль морийг түрүүлнэ гэж бэнчин тавихаа Мейерс гэргийдээ үл хэлнэ. Гэргий нь хожих алдахыг хослон, голдуу л алдаж, цаг ямагт дэмий ярина.

-Сан-Сиро очихоор бид дөрвүүд задгай жууз тэргээр явлаа. Сайхан өдөр байсан бөгөөд бид цэцэрлэгээр өнгөрөн трамвайн зам дагуу яваад хотоод гарч тоостойхонх замд оров. Зуслангийн төмөр хайстай байшин, өтгөн цэцэрлэг, усан суваг, ургамал нь тоосорсон ногоны газартай гүвээ хоёр талаар үргэлжилнэ. Талын тэртээд тариачдын байшин зохиомол усалгааны суваг бүхий ногоо тариалангийн өргөн газар харагдаж умар зүг уулс сүндэрлэнэ. Морин уралдааны газар очих замаар жууз тэрэг олноор явах бөгөөд бид цэргийн хувцастай тул шалгаг билет үгүйгээр руулав. Бид жуузнаас бууж, хөтөлбөр худалдан аваад тойргийг зүсэж, шалдсан гөлгөр зөргөөр үзэгдчийн байр тийш явав. Хуучирсан модон инэр дороо касстай, мөн м орины саравчны дэргэд олон касс байна. Хашааны тэнд цэргүүд шахцалдана. Үзэгчдийн барнаа үлэмж олонхү нбайв. Их индрийн арын хаалганы тэнд агтчид морьд авчирна. Таньдаг хүн тааралдаж, Фергюсон, Кэтрин хоёрт сандал олж өгөөд бид морьд үзэв

Агтчид цулбуур барьж, морьд толгой духайн тойрно. Нэгэн улаан хээр морийг Кроуэл хараад будмал юм гэв. Тэгээд бид сайтар ажигласанд үнэхээр будмал ажээ. Тэр морийг гагцхүү эмээллэх дохио өгөхийн өмнөхөд авчирчэ. Агтчингийн ханцуй дээрх дугаараар хөөж тэр морийг хөтөлбөрт үзвэл Япалак гэдэг улаан хээр гэжээ. Мянган ливр зоосноос илүү шан авч ер үзээгүй морьд уралдах гэж байлаа. Морьдын зүсийг буджээ гэдэг Кэтрин бат итгэж байв. Худлаа гэж Фергюсон хэлэв. Би ч бас эргэлзэж байлаа. Бид цөм тэр морийг түрүүлнэ гэж зуун лирээр мөрий тавив. Тэр моринд гучин тав дахин их шагнал өгнө гэж тооцооны хуудсанд дурьджээ. Кроуэл билет худалдан авахаар явлаа. Бид үлдэж, морь уралдагч дахин нэг удаа мод тойроод зөргөөр орж, тойрог замаар алгуур шогшуулан уралдааны байр тийш очихыг харан байлаа.

Мрь уралдахыг харах гэж бид индэр дээр гарлаа. Тэр үед Сен-Сиролд резинэн тууз байгаагүй учир уралдуулагч бүх морьдыг жагсаахад алс зөрөг зам дээр жирийн жижигхэн юм шиг харагдаж, урт шилбүүрээр шилбүүрдэн уралдаан эхлэв. Бидний өмнүүр морьд өнгөрөхөд нөгөөх улаан хээр морь түрүүлэн давхиж, зам тойрохдоо хол цойлон гарав. Дурангаар харахад минь, бусад морьд хойноос нь бараадаж, түрүүчийн тэр морийг унасан хүн, амы нь татах гээд хүч хүэхгүй бусад морьд зам тойрон гарах үед сайхь улаан хээр арван тавны газар түрүүлж, шон өнгөрөөд дахин хагас тойрог хурдлав

-Ямар сайхан бэ? бид гурван мянга илүү лир авах нь ээ. Гайхалтай морь юм даа гэж Кэтрин хэлэв

-Болно байх. Мөнгө автал будаг нь тогтоно гэж Кроуэл хэлэв



-Үнэхээр гайхалтай морь юм даа Мейерс гуай энэ морийг яасан бол доо гэж Кэтрин хэллээ.

-Хжив уу гэж би Мейерст хашгиран хэлэхэд тэр толгой сэгсрэв.

-Би хожсонгүй. Харин хүүхдүүд минь та нар аль морийг авсан бэ? гэж Мейерсын гэргий хэллээ.

-Япадакийг авсан

-Яах нь вэ? Тэр чинь гучин тавынх шүү дээ

Зүс нь бидэнд атайхан санагдсан

-Надад бол үгүй. Харин надад өрөвдөлтэй санагдсан. Тэр моринд мөрий тавих хэрэггүй гэж ярилцсан

-Хонжвор нь бага юм гэж Мейер хэлэв

-Тооцоо ёсоор гучин тав гэж би хэллээ.

-Хонжвор нь бага юм. Барианы үед нь хүн хожсон гэж Мейерс хэлэв.

-Хэн бэ?

-Кэмптон хүүхдүүдтэйгээ хожсон. Тэгээд хоёр хувь шан хүртээвэл сайн л биз

-Өө, тэгвэл бид гурван мянган лир авахгүй нь шив дээ? Ийм уралдаан дэмий байна. Ёстой булхай гэж Кэтрин хэлэв.

-Бид хоёр зуун лир авна.

-Тэр дэмий. Бидэнд тэр хамаагүй. Бид гурван мянгыг авна гэж би бодсон юм.

-Адгийн булгай гэж Фергюсон хэлэв

-Хэрэв ингэж булхайцдаггүй бол бид тэр моринд мөрий тавихгүй байсан байх даа. Гэхдээ гурван мянган лир авна гэхэд аятай л байсан гэж Кэтрин хэлэв

-Доошоо бууж, юм ууя. Ямар шан өгөхийг мэдье гэж Кроуэл хэлэв

-Би доош бууж, түрүүлэгчдийн дугаар өлгөсөн самбар үзэх үед шан олгох дохио дуугарч Япалакийн өмнө талд “арван найм тавьжжж” гэсэн тоо гарав. Тэр нь хоёр дахинаас бага шантайн гэрч юм.

-Тэндээс бид уруудан их индрийн доорхи архины мухрлагт орж нэг нэг аяга Виски архи содтой уулаа. Тэнд бид, танил хоёр итали болон Мак Адамс, дэд элчин-консултай тулгарч хамтдаа ээш гарав. Италичууд их л баяр ёслолын байдалтай явцгаана. Кэтринтэй МакАдамс яриа дэлгэнэ. Бид мөрий тавихаар доош буув. Нэгэн кассны дэргэд Мейерс гуай зогсож байв.

-Ямар моринд мөрий тавихы гнь хасуу гэж би Кроуэлд хэлэв.

-Мейерс хөтөлбөр гаргаж тав дугаарыг харандаагаар заав.

-Бид тантай адилхан тавибал та дургүйцэхгүй биз гэж Кроуэд асуулаа.

-Тэгцгээ, тэгцгээ. Харин намайг хэлсэн гэж манай эхнэр бүү дуулгаарай гэв

-Юм ууцгаая гэж би хэлэв

-Баярлалаа. Би ер уудаггүй гэлээ.

Тэгээд би тав дугаарт мөрийний зуун лир, хоёр хувйн зуун лир тавиад, ахин нэг нэг аяга виски архи содтой уулаа. Миний сэтгэл ихэд сэргэж бид дахин хоёр итали хүнтэй уулзан тус бүртэй нь тулгаж уугааддээш эргэн гарав. Тэр хоёр итали бас их ёсорхуу агаадтэ талаараа бидний уулзсан түрүүчийн хоёроос ер дор орохгүй байв. Тэдний ёсорхуугаас болж хэн ч байрандаа суусангүй. Би билетийг Кэтринд өгөв

-Ямар морь вэ?

-Мэдэхгүй. Мейерс гуай шилсэн юм.

-Чи нэрий нь ч мэдэхгүй юу?

-Мээхгүй-Хөтөлбөрт үзье. Тав дугаар морь,

-Чиний итгэмтгий чинь баярлууштай юм гэж тэр хүүхэн хэлэв

Тавдугаар морь түрүүлсэн боловч шан нь даанч өчүүхэн байлаа.

Мейерс гуай уурлав.

-Хорин лир авах гэж хоёр зууг тавих болж байна. Аравт арван хоёр лир болно.

Ажлын гарз. Манай авгай хорин лир хожиж гэж тэр ярив.

-Би та нартай доошоо бууя гэж Кэтрин асуув

-Зүгээр байна.

-Уг нь тэнд аятай л байна. Гэхдээ, найз минь, ийм олон таньдаг хүн байгаад хэцүү байна гэж тэр хүүхэн хэллээ.

-Тийм ч олонгүй шүү.

-Тиймээ. Гэхдээ энэ Мейерсынхэн, ба энэ авгай, охидтойгоо яваа банкны хүн...

-Тэр миний чекээр төлнө гэж би хэлэв

-Харин энэ биш өөр хүн төлбөл таарна. Бас энэ сүүлчийн дөрвөн итали ерөөсөө өөдгүй улс.

-Тэгвэл эндээ байж, дараачийн уралдааныгхарах уу даа.

-Тэгвэл сайхан байна. Тэгвэл найз минь бид ерөөсөө мэдэхгүй. Мейерс гуайн мөрий тавихгүй мори йг олж хоёулаа мөрий тавья.

-Тэгье.

Тэгээд бид “Хүүхэн хараа” гэдэг моринд мөрий тавьж, тэр морь таван морины дөрөвдүгээр ирэв. Бид хашаа тохойлдож, туурай нь тачигнан хажуугар давхилдах морьдыг ажиглан, алсын уулс болон модод, талын цаадтайх Милан хотыг харж зогсов.

-Энд надад цэвэр тунгалаг санагдаж байна гэж Кэтрин хэлэв

Хөлөрч уурч манаруулсан морьд хаалгаар эгэн орно. Уралдагчид морьдоо амраан, модны дэргэд очиж байлаа.

-Юм ууя: Эндээ морь харж юм ууя гэв

-Одоохон авчиръя гэж би хэлсэнд

-Хүүхдээр авчруулъя гэж Кэтрин хэлээд гара өргөхөд жүчээний дэргэдэх “Пагода” мухлагаас хүүхэд гүйж ирэв. Би дугариг төмөр ширээ тойрон суулаа.

-Бид тусдаа л байвал, илүү сайхан юм тийм үү? Гэхэд нь

-Тийм ээ гэж би хэлэв

-Энэ хүмүүс цөм бидэнтэй байхад би хичнээн ганцаардаж байваа гэв

-Эд тун сайхан байна гэж би хэлэв

-Тиймээ. Уралдааны газар гайхалтай сайхан юм.

-Муугүй ээ.

-Найз минь, би чинийхээ сэтгэлийг хиртээхгүй юмсан. Дээшээ харахыг хүсмгч чинь л би тэр даруй гарна шүү

-Үгүй ээ. Эндээ байж, юм ууя. Тэгээд явж саадтай уралдааны устай нүхний дэргэд очье гэж би хэлэв

-Чи надад ийм л сайн шүү гэж тэр хэлэв. Бид хоёул тийнхүү байсны эцэст, нөгөөдүүлтэйгээ дахин уулзахад мөн таатай байлаа. Тэр өрийг бид сайхан өнгөрүүлэв

[Тор](#)

---

Есдүгээр сард шөнөдөө хүйт орж тэгсээр өдөртөө хүйтэрдэг болж, цэцэрлэгийн модны навчис шарлаж эхлээд зун өнгөрсний тэмдэг мэдэгдэв. Фронтын үйлс тун муу бөгөөд Сан-Габриелийг эзлэн авч дийлдсэнгүй. Баинзиццийн ууланд тулалдахыг хэдүйн больж, мөн сарын дундуур Сан-Габриелыг аанай авч дийлсэнгүй өнгөрлөө. Эттор фронтонд явса. Морьдыг Ромд аваачсанаас хойш ураодаан болсонгүй.

Кроуэл мөн Ромд явсан бөгөөд тэндээсээ халагдаж Америк очих ёстой. Милан хотод дайн эсэргүүцсэн үймээн хёр чудаа дэгдэж Туринд мөн тиймэрхүү самуун гарсан байна. Нэгэн англи хошууч клубт дайралдаж наад хэлэхдээ Сан-Габриелийн дэргэд болон Баинзеццийн ууланд италичууд зуун тавин мянган хүнээ алдсан гэв. Түүнээс гадна тэд Карсод дөчин мянгн хүнэ бас алдсан гэж тэр хэлэв. Бид хоёр архи ууж, тэр ярьсаар байв. Энэ жил тулалдаан ер болоохгүй. Италичууд залгиж баршгүй их юм үнхсэн гэж тэр хэлэв. Фландрид довтлоод муугаа үзсэн гэж тэр хэлэв. Хэрэв цаашид энэ намрынх шиг хүмүүсээ хайрлахгүй байх юм бол холбоотнууд жилийн дараа амьсгал хураагаад байна. гэвч бид тэрнээ м мэдэхгүй яваад л байвал яахав болно гэж тэр хэлэв. Бид цөм амьгал хураагсан. Тэрнээ мэдээгүйдээ л учир нь оршино. Амьсга хурааснаа аль хожуу мэдсэн улс нь л дайнд ялна. Бид дахин архи уув. Намайг штабаас ирсэн үү ? гэж асуулаа. Үгүй Тэр өөрөө штабаас ирсэн гэнэ. Цөм дэмий юм. Клубийн нэгэн том зөөлөн ширэн сандал дээр бид хоёулхнаа налан сууж байв. Тэр өмсөж яваа бүдүүн ширэн гутлаа сайтар өнгөлжээ. Тийм гутал ч ховорхондоо. Цөм дэмий гэж хэлэв. Хүн бүхний боддог нь дивиз агаад нэмэлт хүч болжээ. Дивизийн төлөө уралдаж байж дивизтэй болонгуутаа булшилж эхэллээ. Цөм амьсгаа хураажэ. Ялдаг нь л герман болжээ. Эн цэргүүдийг юу гэхэв дээ. Эртний хүн нар бол ёстой цэрэг дээ. Гэвч тэд бас амьсгаа хураасан. Бид цөм амьсгаа хураажээ. Оросуудын тухай би асуулаа. Тэд бас л амьсгаа хураасан гэж тэр хэлэв. Тэдний амьсгаа хураасан эсэхийг би удахгүй үзнэ. Бас Амвстричууд амьсгаа хураасан. Харин тэд хүн нарын хэдэн дивизтэй болбол сэргэж чадна. Энэ намрын довтолгоонд тэд ирж орох уу? гэж чи надаас асуу л даа. Ирнэ. Орно, Италичууд амьсгаа хураасан. Тэдний амьсгаа хураасныгхэн бүхэн мэднэ. Эрттний хүн нар Грентаногоор араад Биченцын төмөр замын харилцааг тасалж орхивол ианай италиууд яахад чбэлхэн болно. Арвун зургаан онд Австричууд тэгэж үзсэн шүүү дээ гэж би хэлэв. Гэхдээ Германчууд байгаагүй. Тиймээ гэж би хэлэв. Тэд чухам яах бол доо гэж тэр хэлэв. Амархан шүү дээ. Тэд ч нэг л их төвөгтэй юм төлөвлөөд, бүрмөсөн амьсгаа хураана биз. Бид явъя. Цэргийн эмнэлэгэтэ очих цаг боллоо гэж би хэлэв

-Баяртай гэснээ тэр нэмэн: сайн сайхан болтугай гэв. Тэр хүний итгэл тасрах бодол, хөгжүүн ааш хоёр нь даанч зөрүүтэй юм.

Би үсчинд орж сахлаа хусуулаад цэргийн мнэлэгтээ очихоор явла. Тэр үед хөл минь нилээд сайжраад бараг зүгээр болж байсан билээ. Гурав хоногийн өмнө би эмч нарын зөвлөлгөөнөөр орж Ospedale Maggiore-д эмчилгээ дуусгахад хэдхэн арга засал үлдсэн бөгөөд булан тойрхдоо доголохгүйг хичээж явав. Саравчин доор нэг өвгөн хар дүрс хайчилж буйг хархаар би зогсов. Өмнөө зогсож буй хоёр хүүхнийг байн байн харж толгой гилжийлгэн хайчаа түргэн түргэн хөдөлгөн хар дүрсий нь цугт нь гарган хайчилна. Хоёр хүүхэн инээдээ барьж ядна. Хар дүрсийг цагаан цаасан дээр нааж, хүүхнүүдэд өгөхийн өмнө надад тэр өвгөн үзүүлэв.

-Адилхан байгаа биз ээ? Tenente танд хэрэггүй юу? гэж өвгөн хэлэв

-Хар дүрсээ харан инээсээр хүүхнүүд явав. Нэг хүүхэн нь цэргийн эмнэлгийн өөдөөс харсан зуушны газар ажилладаг билээ.

-За гэж би хэлэв

-Малгайгаа аваарай гэв

-Малгайтай бая гэсэн

-Малгайтай муу болно гэснээ өвгөний царай нь гэрэлтэн нээрээ ч эрлхэг харагдана гэж хэлэв

Тэр өвгөн хар цаас барьж, хайчаа мурилзуулснаа хоёр хэсэг болгоон хажуугаас нь харсан хоёр хар дүрсийг хатуу цаасан дээр нааж надад өгөв.

-Ямар үнэтэй вэ? гэхэд

-Яахав, яахав. Чамд зүгээр хайчилж өгсөн юм гэж тэр гараа затав.

-Май. Сэтгэлий минь баясгаж үз гэж би хэдэн мөнгө гаргав.

-Хэрэггүй. Харин би өөрөө баясах гэж хийсэн юм. Хонгортоо бэлэглээрэй гэв.

-Баярлалаа. Баяртай

-Дараа уулзъя.

Цэргийн эмнэлэгт ирэхэд минь, бибиг хэрэгт надад ирсэн нэг албан захидал, хэдэн энгийн захидал байлаа. Биеэ тэнхрүүл гэж гурван долоо хоногийн чөлөө надад олгожээ. Тэгээд дараа нь би фронтод очиж ажээ. Дахин сайтар уншиж үзвэл гарцаагүй тийм байна. эмчилгээний хугацаа дууссанаас хойш арван сарын дөрөвнөөс чөлөө эхлэх болжээ. Гурван долоо хорин нэг хоног гэдэг чинь арван сарын хорин таванд дуусна. Гдуур бас жаахан яваад ирье гэж хэлээд би “Керьере делла сера” хэмээн сонин болон шуудангийн хайрцагт захиа хараад оройн хоол идэхээр цэргийн эмнэлгээс хэдэн байшингийн цаана байдаг гуанзанд орохоор явлаа. Авгаас минь ирсэн нэг захидалд гэр орны сонин болоод эх оронч сургаал бичиж, хоёр зуун долларын чек, мөн сонины хэдэн хайчилбар хийжээ. Бас манай ламаас ирсэн уйтгартай захидал байв. Фрацын нисэх хүчинд ажилладаг нэгэн танил нисгэгч захидал бичихдээ хөгжүүн нөхдийн хүрээнд орсноо дурьджээ. Ринальдаас ирсэн зурвасыг үзвэл: ямар сонинтойг лавлаад Миланд удаан суух эсэхийг минь асуужээ. Тгээд тэр, захидалд нэр заасан пянзыг авчраач гэж хүссэн байв. Оройн хоолондоо би нэг лонх къянта дарс захиж, кофе цай конъяк архитай уугаад, сонин уншиж дуусган бүх захидлыг халаасандаа хийж, сониноо шан мөнгөний хамт ширээн дээр орхиж гарав. Цэргийн эмнэлэг дэх тасалгаандаа ирээд би жагсаал хувцсаа тайлж, гэрийн хувцас өмсөж, тагтны хаалганы хөгийг буулган орондоо хажуулаа Мейерсийн авгай хүүхдүүддээ авчирсан сониноос Бостоны сонинг уншиж эхлэв. Чикаго-Уайт-Соксын баг Америкийн холбооны шагнал авч, үндэсний холбоонд Нью-Йорк-Жайэнтсын бага түрүүлж яваа гэнэ. Бэйб Рут энэ удаа Бостоны багт орж тогложээ. Тэр сонинууд уншихад уйтгартай бөгөөд фронтын мэдээ нь хуучирсан, шинэ мэдээ нь орон нутгийн чанартай дулимагхан байв. Америкийн шинэ мэдээнд гагцхүү хөдөлмөр сургуулийн тухай өгүүлсэн байна. Хөдөлмөр сургуульд ороогүйдээ би баярлав. Биеийн тамирын мэдээнээс өөр уншиж болмоор юм алга. Харин тэр мэдээг ихэд с онирохов. Олон сонин зэрэг уншихад амтархан унших нөхцөл байдаггүй билээ. Сонинууд нилээд хуучирсан боловч би уншив. Хэрэв Америк дайнд бүрэн орвол биеийн тамирын холбоонууд хаагдах болов уу гэж би бодлоо. Хаагдахгүй л байх ёстой. Дайн өрнөж байсан ч Мтиланд урьдын ёсоор морь уралдаж байлаа. Харин францад морь уралдахаа больжээ. Тэгээд манай Япалаккийг тэндээс авчирсан билээ. Кэтрин гагцхүү есөн цагаас жижүүрт гарна. Жтижүүрт ирхэд нь би гудмаар явахы нь сонсож, онгорхой халгаар нэг удаа үзэв. Тэр хүүхэн хэдэн тасгаар ороод миний өрөөнд орж ирэв

-Найз минь би өнөөдөр оройтлоо. Ажил ихтэй. Чи ямар байна.? гэж тэр хэлэв.

Би тэр хүүхэнд сонинууд болоод чөлөөнийхөө тухай яриу.

-Сайхан байна. Чи хаашаа явъя гэж бодож байна гэж тэр хүүхэнхэлэв

-Хаашаа ч үгүй. Эндээ бая гэлээ.

-Шал дэмий. Аятайхан газар чи сонго. Би бас цуг явъя.

-Чи яаж явах юм бэ?

-Мэдэхгүй. Яаж ийгээд болно

-Чи ёстой сайхан

-Үгүй байхаа. Гэвч амьдралд алдах юм нь бага бол олох юм нь зовлонгүй

-Чи тэгээд юу гэх гээ вэ?

-Юу ч гэх гээгүй. Давшгүй санагдсан саад одоо юу ч биш байна гэж л бодогдлоо.

-Миний бодоход хэцүү л байх байхдаа

-Гүйгүй ээ, найз минь. Болдоггүй юмаа гэхэд би орхиод л явна. Гэхдээ тиймд хүрэхгүй биз.

-Хаашаа явах вэ?

-Хаашаа ч яахав.: Таних хүнгүй болохоор дуртай тийшээ л очъё.

-Чамд үнэхээр хаашаа ч явсан адил уу?

-Тиймээ. Явбал л барав.

Тэр хүүхэн машид шимтэж, зовсон янзтай байв.

-Кэтрин чи яагаа вэ?

-Яагаа ч үгүй

-Худлаа

-Үнэн. Юу ч болоогүй

-Худлаа гэдгийг би мэдэж байна. Хэл л дээ хө. Чи надад хэлэх ёстой.

-Яагаа ч үгүй

-Хэл л дээ

-Хэлэх дургүй байна. Чамайг юм санаж, тэвдэх байх гэж би зовж байна.

-Чи л юм санаагүйгээс хойш надад бас адилхан

-Би ярих дургүй байна

-Хэл л дээ

-Хэлэх хэргтэй юу?

-Хэрэгтэй

-Найз минь би бие давхар болсон. Бараг гурван сар болж байна. Харин чи юм санахгүй биз үнэн үү? Хэрэггүй. Бүү юм санаарай.

-Үгүй үгүй

-Үнэн үү?

-Үнэн

-Би элдвээр үзэж, аргаллаа, ер болсонгүй.

-Би юм санах ёсгүй.

-Нэгэнт ийм болсон болохоор надад санах юм алга, найз минь. Чи ч бүү юм санаж, бүү сандраарай.

-Би ганцхан чамайг л бодож байна.

-Тэгэх л ёстой. Тэгэх ч хэрэггүй. Хүн болгонд хүүхэд төрдөг. Заримаас нь цаг ямагт төрдөг. Байгалийн жам шүү дээ.

-Чи ёстой сайхан

Үгүй байх аа. Найз минь энэ тухай битгий юм бодоорой. Би чамайг сандаргахгүйг хичээнэ. Одоо би чамайг сандаргалаа. Харин би өдий болтол хадгалж явсан шүү. Тий үү? Чиний санаанд ер ороогүй биз?

-Тиймээ.

-Цаашдаа ч тийм байна. Чи ер юм бодох хэрэггүй. Чи юм боджээ. Боль доо найз минь, боль доо. Юм уумаар байна уу? Юм уух хэрэгтэй. Тэгвэл сэргэж баясана.

-Үгүй ээ. Би баясгалантай хэвээр чи ёстой сайхан хэвээр байна.

-Үгүй байхаа. Харин би бүх юмыг зохицуулна. Хоёулаа цуг явъя. Харин чи очих газраа сонгож ол. Аравдугаар сар лав сайхан болох байх. Найз минь хоёулаа тэр цагийг сайханөнгөрөөнө. Тэгээд чамайг фронтод очихоор чинь би өдөр бүр захиад бичнэ.

-Чи хаана байх вэ?

-Мэдэхгүй л байна. Лав л хамгийн сайхан газар байх болно. Би тэр бүгдийг аргална.

Бид хоёрын яриа зогсож дуугүй болов. Кэтрин орон дээр сээж, би түүнийг ширтэх авч бие биендээ үл хүрнэ. Тасалгаанд гадны хүн орж ирэхэд цөм гэнэтэлд соноржиж% хүн бүр биеэ барихад л ийм байдагсан.

Тэр хүүхэн гараа хөдөлгөж миний гар дээр тавин  
 -Найз минь чи уурлаагүй биз, хэл л дээ  
 -Үгүй ээ  
 -Чи өөрийгөө торонд орлоо гэж бодоогүй юм биз дээ?  
 -Жаахан байхад ч байна. Гэхдээ чамаа болоогүй шүү  
 -Надаас болсон гэж би бодоогүй байна. Бүү дэмий юм ярь. Гэхдээ л торонд орсон гэж би хэлмээр байна  
 -Бие цогцос ч хэзээд тор л доо  
 Гэтэл тэр хүүхэн, гараа татаагүй, хөдлөөгүй ч гэсэн надаас ихэд хол хөндийрлөө  
 -Хэзээд гэдэг ч муу үг шүү. Уучлаарай  
 -Тэр хамаагүй ээ. Харин би ерөөс хүүхэдтэй болж байгаагүй, ерөөс хүнд дурлаж яваагүй гэдгийг чи мэднэ. Гэхдээ би чиний хүссэнээр байя л гэж бодсон. Тэгтэл чи гэнэт л “хэзээд” гэж хэллээ.  
 -Тэгвэл би хэлээ огтольё гэж би санал гаргав.  
 -Найз минь гээд тэр надаас хол хөндийрөхөө больж::  
 -Юм бодох хэрэггүй. Чи бид хоёр нэг болохоор дэмий юмаар хөөцөлдөх хэрэггүй, тийм биз дээ гэв. Бид дахин хамт болж соноржих байдал ярилав.  
 -Хэрэггүй ээ.  
 -Байдаг л юм. Хүн нэг нэгэндээ хайртай байснаа дэмий юмаар хөөцөлдөж, хэрэлдэж тэгээд нэг байхаа гэнэт больдог.  
 -Бид хэрэлдэхгүй.  
 -Хэрэлдэх ч хэрэггүй. Яагаад гэвэл: Чи бид хоёр хоёулхнаа орчлонгийн бусад бүх юмны эсрэг байгаа шүү дээ. Хэрвээ бидний хооронд ямар нэгэн хэрэг гарвал бид эвдэрч, биднийг тэд олзолно.  
 -Тэд бидэнд хүрэхгүй. яагаад гэвэл чи их эрэлхэг. Эрэлхэг хүнд зовлон учирдаггүй юм гэж би хэлэв  
 -Эрэлхэг хүн ч ялгаагүй үхдэг.  
 -Гэхдээ ганцхан удаа  
 -Тийм үү? Хэн хэлсэн юм бэ?  
 -Аймхай хүн мянга үхдэг, эрэлхэг хүн гац үхдэг үү?  
 -Зүйтэй. Хэн хэлсэн юм бэ?  
 -Мэдэхгүй  
 -Өөрөө аймхай байсан биз гэж тэр хүүхэн хэлээд-аймхай хүн аймхайг ойлгоно. Эрэлхэг гэдгийг ойлгохгүй хүн хэрэв ухаанат болбол хоёр мянган удаа чүхэж болно. Гагцхүү тэр тухайгаа л ярьдаггүй биз.  
 -Бүү мэд. Эрэлхэг хүний ухаанд хүрэх хэцүү.  
 -Тиймээ. Тэр үүгээрээ л хүчирхэг  
 -Чи мэдэж ярьж байна.  
 -Найз минь чиний зөв. Энэ удаад чинийх зөв.  
 -Чи өөрөө эрэлхэг  
 -Үгүй ээ. Гэхдээ би эрэлхэг байхыг хүсдэг гэж тэр хүүхэн хэллээ.  
 -Би эрэлхэг бишээ. Би хир хэмжээгээ мэднэ. Надад мэдэх цаг бүрэн байсан. Би бол улиралд хорин хоёр бөмбөг цохихоос илүү чадалгүй бейсболчин яг мөн гэж би хэллээ.  
 -“Улиралд хорин хоёр цфохино” гэдэг чинь юу гэсэн үг бэ? Тун онцгой сонсдож байна.  
 -Онцгой бишээ. Бейсбол бөмбөгний багийн дайралтад ёстой дунд зэргийн бөмбөгчин гэсэн үг  
 -Тэгвэл хайралтын бөмбөгчин гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэж намайг тэр хүүхэн

өдөв.

-Чи бид хоёр нэгэн нэгнээ шалгаагаад яахав биш үү дээ. Чи эрэлхэг болохыг боддог

-Бид хоёул эрэлхэг. Би архиа уухаараа тун эрэлхэг гшэж би хэлэв

-Бид сайхан улс гэж Кэтрин хэлэв

Тэгээд тэр шүүгээ рүү очиж онгойлгон конъяк архи, аяга авав.

-Найз минь уучих, Энэ чиний занг засна гэж тэр хүүхэн хэллээ.

-Би уух дургүй байна.

-Уучих, уучих.

-За тэгье гээд би аягаы баганх конъяк архи хийж уув.

-Конъяк гэдэг архи баатарын ундаан гэдгийг би мэднэ. Гэхдэ орох хэрэггүй гэж тэр хүүхэн хэллээ.

-Дайны дараа бид хаана амьдрах билээ?

-Хуучиндаа л биз дээ гэж тэр хэлээд:

Зулын хорин тавны үеэр дайн дууссан байна гэж гурван жил би их гэнэн юм бодож байжээ. Одо бол хүү маань дэслэгч болсон цагт дайн дуусна гэж итгэж байна.

-Генерал ч болж болно.

-Хэрэв энэ зуун жилийн дайн бол генерал болох зай байх байлгүй.

-Чи уухгүй юу?

-Үгүй. Найз минь чи конъяк архи уухаараа сэргэдэг бол миний толгой эргэх юм.

-Чи ер нь конъяк архи ууж байгаагүй юу?

-Үгүй. Найз минь. Би чинь их хуучин янзын авгай шүү.

Би лонх авч өөртөө конъяк архи аягалав

-Чи заавал явах гээд байна уу?

-Одоо явахгүй бол сүүлээр явна

-Одоо нь дээр

-Одоохон би ирнэ.

-Би сониноо уншчихаадб айна гэж би хэлэв.

[Тор](#)

---

Шөнө хүйтэрч, маргааш нь бороо оров. Ospedale Maggiore очоод буцаж ирэхэд бороулам ширүүсэж би нэвт норов. Тасалгааны минь тагт руу бороо цутгаж, салхинд гуйвран тагтны хаалганы шил рүү асгарна. Би хувцсаа солиод конъяк архи уухад амт нь муухай санагдлаа. Шөнө нь би эвгүйрхэж өглөөгүүр цай уусны дараа бүр чмуудав

-Тодорхой байна. Хүүхээн чи, нүдний нь цагааныг хар даа гэж цэргийн эмнэлгийн эмч хэлэв

Гэйж хүүхэн харлаа. Намайг бас хар гэж толь өгөв. Нүдний цагаан шар блж, шарлах өвчин тусчээ. Би хоёр долоо хоног хэвтэв. Хоёулхамт явах гэж байсан чөлөө маань ингээд өнгөрлөө. Бид Палланцын Лаго Мажор очих гэж байсан билээ. Навч шарлаж эхлэх намрын цаг тэнд зугаалах сайхан газартай, мөн тулбага агнах нууртай. Палланцад хүн цөөн тул Стрезээс дээр буйзаа. Харин таньдаг хүн олонтаа учир Милланаас Стрез явахад хүн олонтаа учир Милланаас Стрез явахад таатай юм. Палланцын орчинд онцын сайхан тосгод буй. Мөн тэндээс сэлдэг завиар загагсдын аралд хүрч болох агаад хамгийн том арал дээр ресторантай билээ. Гэвч бидний явах өнгөрчээ.

Шарлаад өвчтэй хэвтэж байхад нэгэн удаа Вэн Кампен авгай тасалгаанд минь орж ирээд шүүгээний хаалга дэлгэж хоосон лонхнуудыг харчихав. Дөнгөж саяхан би хаалгачинд өчнөөн олон лонх өгч явуулсныг бодвол тэр хүүхэн хараад үлдсэн эсэхийг үзэхээр орж ирсэн байна. Вермут дарсны ллонх марсал дарсны лонх, капри дарсны лонх, къянти дарсны хоосон дашмаг хамгийн олон байсан бөгөөд конъяк архины лонх хэд хэд байв. Къянти дарсны сүлжмэл сүрлэн гэртэй дашмаг, вермутын лонх зэрэг хамгийн том лонхнуудыг хаалгачин аваад конъяк архины лонхыг дараа нь аваачихаад үлдээсэн байжээ. Ван Кампен авгайн олж харсан лонхнууд гэвэл: конъяк архины лонхыг дараа нь аваачихаар үлдээсэн байжээ. Ван кампен авгайн олж харсан лонхнууд гэвэл: конъяк архиных бөгөөд кюммел дарсны нэгэн баавгайтай лонх байв. Ялангуяа тэр баавгайтай лонх Ван Кампен авгайн дургүйг ихэд хүргэжээ. Түүнийг тэр авгай авч үзлээ. Урд хоёр хөлөө өргөж хойт хоёр хэл дээрээ суусан баавгайн шилэн толгой нь бөглөөтэй ёсроолд нь шилэн талст гялалзана. Би инээд алдчихлаа

Коммел дарс байсан юм. Хамгийн сайн коммел дарсыг ийм баавгай лонхтой зардаг юм. Оросоос авчирдаг юм гэж би хэлэв

-Энэ лонхнууд чинь цөм конъяк архиных биз дээ гэж Ван Кампен авгай асуулаа

-Эндээс надад цөм харагдахгүй байна. Гэхдээ тийм байхаа гэж хэлэв

-Ингэсээс урдаж байна уу?

-Би худалдаж авчирсан юм. Итали офицерууд намайг дандаа эргэж ирдэг болохоор би дайлдаг юм гэж би хэлэв

-Өөрөө уудаггүй байсан гэж үү?

-Өөрөө бас уудаг

-Конъяк архи! Конъякны арван нэгэн хоосон лонх, бас эм баавгайн ус гэж тэр авгай хэлэв

-Кюммел дарс.

-Би одоо хүн явуулж авахуулья өөр хоосон лонх бий юу?

-Одоохондоо алга

-Шарлаж өвдөхөд чинь би бас зовж байсан. Зовох ч хэрэггүй юм байж дээ.

-Баярлалаа.

-Таныг фронтод эргэж очих дургүй юм байна гэж би одлоо. Гэхдээ та албаар архи ууж шарлаж өвдөж байснаас арай дээр арга бодож олсон бол илүү байж дээ.

-Юу гэнээ?

-Архи ууж гэж байна. Миний хэлснийг та тун сайн сонссон гэв. Би дуугүй байв.

Тэгээхд тэр цааш:

-Та дахиад өөр юм бодож олж байхгүй бол шар өвчин чинь арилахтай зэрэг фронтод явуулна байх гэж айж байна. Албаар шарлаж өвдсөн хүнд биеэ сайжруулах чөлөө олдохгүй байх гэж бодож байна гэв

-Та тэгэж бодож байна уу?

-Тэгж бодож байна.

-Ван Кампен авгай та ер нь шар өвчнөөр өвдөж байсан уу?

-Үгүй гэхдээ энэ өвчнийг олон харсан

-Өвдсөн хүдээ аятай байдаг болов уу та ажсан уу?

-Лав л, фронтод явснаас дээр байх.

-Ван Кхипен гуай, цэргийн албан хаахаас зайлах гээд өөрийнхөө төмсгийг өшиглөчихдөг байсан хүнийг та ер үзсэн үү? Гэж би хэлэв

Ван Кампен авгай миний асуултыг чихнийхээ хажуугаар өнгөрөөв. Тэр авгай нэг бол чихнийхээ хажуугаар өнгөрөөх, нэг бол таалгаанаас минь гарах ёстой юм. Гарах дургүй байжээ. Яагаад гэвэл тэр авгай намайг хэдүйнээс үзэж чаддагүй бөгөөд эдүгээ тооцоо хийх цаг нь болжээ.



-Эррхтнээ зориуд гэмтээж фронтоос биеэ авардаг хүнийг би олон үзсэн  
-Гол нь тэр биш. Эрхтнээ зориуд гэмтээхийг би ч харсан. Цэргийн албан хаахаас зайлах гээд төмсгөө өшиглөчихдөг хүнийг та ер үзсэн үү гэж би асууж байна. Яагаад гэвэл: энэ шар өвчинтэй ойролцоо юм. Үүнийг хүүхнүүд дэвтэй мэдэхгүй гэж би бодож байна. Тэгээд л би, Ван Кампен гуай та шарлаж цр үзсэн үү гэж би асуусан м. Яагаад гэвэл...

Ван Кампен авгай гарч одов. Төөлгүй Гэйж хүүхэн орж ирэв.  
-Ван Кампенд чи юун хэрэггүй юм хэлчихэв. Учиргүй уурлаж байна.  
-Бид янз бүрийн л юм харьцуулж ярьсан. Түүнийг ер төрж үзээгүй байх гэж би бодож хэлсэн юм...  
-Бүү дэмийр. Амьдаар чинь арьсы чинь хуулахад тэр бэлэн байна гэж Гэйж хэлэв.  
-Хуулдгаа хуулсан. Миний чөлөөг хасаад, до бас намайг хээрийн шүүхэд өгөх гэнэ. Болох нь тэр дээ.  
-Ер нь тэр чамд дургүй шүү дээ. Юунаас болж хэрэлдээ вэ? гэж Гэйж асуув.  
-Фронтод очихгүй гээд албаар шарлатлаа архи уусан гэж намайг хэлж байна.  
-Түий, Чамайг ер дусалч амандаа хүргээгүй гэж би тангаргална. Чамайг ер дусал л амандаа хүргээгүй гэж цөм тангараглана гэж Гэйж хэлэв.  
-Тэр лонхнуудыг олчихсон  
-Энэ лонхнуудыг зайлуулахыг чамд би зуун удаа хэлсэн шүү дээ. Одоо тэгээд хаана?  
-Хувцасны өлгүүр дотор  
-Танд чемодан бий юу?  
-Байхгүй. Энэ үүргэвчинд хий. Гэйу хүүхэн үүргэвчинд лонх чихэв.  
-Хаалгачинд аваачиж өгье гэж үүд рүү явахдаа тэр хэлэв.  
-Жаахан азна. Энэ лонхнуудыг би авна гэж Ван Кампен авгнай хэллээ.

Хаалгачин түүнтэй цуг иржээ.  
-Эднүүсийг ав. Би эмчид үзүүлж учры нь хэлнэ гэж тэр авгай хэллээ.  
Тэгээд тэр авгай гудмаар явж, хаалгачин үүргэвчийг аваачив. Дотор нь юу буйг тэр мэднэ.  
Хэрэг төвөг ч болсонгүй. Гагцхүү чөлөө минь олдсонгүй.

[Тор](#)

---

Шөнө хүйтэрч, маргааш нь бороо оров. Ospedale Maggiore очоод буцаж ирэхэд бороулам ширүүсэж би нэвт норов. Тасалгааны минь тагт руу бороо цутгаж, салхинд гуйвран тагтны хаалганы шил рүү асгарна. Би хувцсаа солиод коньяк архи уухад амт нь муухай санагдлаа. Шөнө нь би эвгүйрхэж өглөөгүүр цай уусны дараа бүр чмуудав  
-Тодорхой байна. Хүүхээн чи, нүдний нь цагааныг хар даа гэж цэргийн эмнэлгийн эмч хэлэв  
Гэйж хүүхэн харлаа. Намайг бас хар гэж толь өгөв. Нүдний цагаан шар блж, шарлах өвчин тусчээ. Би хоёр долоо хоног хэвтэв. Хоёулхамт явах гэж байсан чөлөө маань ингээд өнгөрлөө. Бид Палланцын Лаго Мажор очих гэж байсан билээ. Навч шарлаж эхлэх намрын цаг тэнд зугаалах сайхан газартай, мөн тулбага агнах нууртай. Палланцад хүн цөөн тул Стрезээс дээр буйзаа. Харин таньдаг хүн олонтаа учир Милланаас Стрез явахад хүн олонтаа учир Милланаас Стрез явахад таатай юм.

Палланцын орчинд онцын сайхан тосгод буй. Мөн тэндээс сэлдэг завиар загагсдын аралд хүрч болох агаад хамгийн том арал дээр ресторантай билээ. Гэвч бидний явах өнгөрчээ.

Шарлаад өвчтэй хэвтэж байхад нэгэн удаа Вэн Кампен авгай тасалгаанд минь орж ирээд шүүгээний хаалга дэлгэж хоосон лонхнуудыг харчихав. Дөнгөж саяхан би хаалгачинд өчнөөн олон лонх өгч явуулсныг бодвол тэр хүүхэн хараад үлдсэн эсэхийг үзэхээр орж ирсэн байна. Вермут дарсны ллонх марсал дарсны лонх, капри дарсны лонх, къянти дарсны хоосон дашмаг хамгийн олон байсан бөгөөд конъяк архины лонх хэд хэд байв. Къянти дарсны сүлжмэл сүрлэн гэртэй дашмаг, вермутын лонх зэрэг хамгийн том лонхнуудыг хаалгачин аваад конъяк архины лонхыг дараа нь аваачихаад үлдээсэн байжээ. Ван Кампен авгайн олж харсан лонхнууд гэвэл: конъяк архины лонхыг дараа нь аваачихаар үлдээсэн байжээ. Ван кампен авгайн олж харсан лонхнууд гэвэл: конъяк архиных бөгөөд кюммел дарсны нэгэн баавгайтай лонх байв. Ялангуяа тэр баавгайтай лонх Ван Кампен авгайн дургүйг ихэд хүргэжээ. Түүнийг тэр авгай авч үзлээ. Урд хоёр хөлөө өргөж хойт хоёр хэл дээрээ суусан баавгайн шилэн толгой нь бөглөөтэй ёсроолд нь шилэн талст гялалзана. Би инээд алдчихлаа

Коммел дарс байсан юм. Хамгийн сайн коммел дарсыг ийм баавгай лонхтой зардаг юм. Оросоос авчирдаг юм гэж би хэлэв

-Энэ лонхнууд чинь цөм конъяк архиных биз дээ гэж Ван Кампен авгай асуулаа

-Эндээс надад цөм харагдахгүй байна. Гэхдээ тийм байхаа гэж хэлэв

-Ингэсээс урдаж байна уу?

-Би худалдаж авчирсан юм. Итали офицерууд намайг дандаа эргэж ирдэг болохоор би дайлдаг юм гэж би хэлэв

-Өөрөө уудаггүй байсан гэж үү?

-Өөрөө бас уудаг

-Конъяк архи! Конъякны арван нэгэн хоосон лонх, бас эм баавгайн ус гэж тэр авгай хэлэв

-Кюммел дарс.

-Би одоо хүн явуулж авахуулъя өөр хоосон лонх бий юу?

-Одоохондоо алга

-Шарлаж өвдөхөд чинь би бас зовж байсан. Зовох ч хэрэггүй юм байж дээ.

-Баярлалаа.

-Таныг фронтод эргэж очих дургүй юм байна гэж би одлоо. Гэхдээ та албаар архи ууж шарлаж өвдөж байснаас арай дээр арга бодож олсон бол илүү байж дээ.

-Юу гэнээ?

-Архи ууж гэж байна. Миний хэлснийг та тун сайн сонссон гэв. Би дуугүй байв.

Тэгээхд тэр цааш:

-Та дахиад өөр юм бодож олж байхгүй бол шар өвчин чинь арилахтай зэрэг фронтод явуулна байх гэж айж байна. Албаар шарлаж өвдсөн хүнд биеэ сайжруулах чөлөө олдохгүй байх гэж бодож байна гэв

-Та тэгэж бодож байна уу?

-Тэгж бодож байна.

-Ван Кампен авгай та ер нь шар өвчнөөр өвдөж байсан уу?

-Үгүй гэхдээ энэ өвчнийг олон харсан

-Өвдсөн хүдээ аятай байдаг болов уу та ажсан уу?

-Лав л, фронтод явснаас дээр байх.

-Ван Кхипен гуай, цэргийн албан хаахаас зайлах гээд өөрийнхөө төмсгийг өшиглөчихдөг байсан хүнийг та ер үзсэн үү? Гэж би хэлэв

Ван Кампен авгай миний асуултыг чихнийхээ хажуугаар өнгөрөөв. Тэр авгай

нэг бол чихнийхээ хажуугаар өнгөрөөх, нэг бол таалгаанаас минь гарах ёстой юм. Гарах дургүй байжээ. Яагаад гэвэл тэр авгай намайг хэдүйнээс үзэж чаддагүй бөгөөд эдүгээ тооцоо хийх цаг нь болжээ.

-Эррхтнээ зориуд гэмтээж фронтоос биеэ авардаг хүнийг би олон үзсэн

-Гол нь тэр биш. Эрхтнээ зориуд гэмтээхийг би ч харсан. Цэргийн албан хаахаас зайлах гээд төмсгөө өшиглөчихдөг хүнийг та ер үзсэн үү гэж би асууж байна. Яагаад гэвэл: энэ шар өвчинтэй ойролцоо юм. Үүнийг хүүхнүүд дэвтэй мэдэхгүй гэж би бодож байна. Тэгээд л би, Ван Кампен гуай та шарлаж цр үзсэн үү гэж би асуусан м. Яагаад гэвэл...

Ван Кампен авгай гарч одов. Төөлгүй Гэйж хүүхэн орж ирэв.

-Ван Кампенд чи юун хэрэггүй юм хэлчихэв. Учиргүй уурлаж байна.

-Бид янз бүрийн л юм харьцуулж ярьсан. Түүнийг ер төрж үзээгүй байх гэж би бодож хэлсэн юм...

-Бүү дэмийр. Амьдаар чинь арьсы чинь хуулахад тэр бэлэн байна гэж Гэйж хэлэв.

-Хуулдгаа хуулсан. Миний чөлөөг хасаад, до бас намайг хээрийн шүүхэд өгөх гэнэ. Болох нь тэр дээ.

-Ер нь тэр чамд дургүй шүү дээ. Юунаас болж хэрэлдээ вэ? гэж Гэйж асуув.

-Фронтод очихгүй гээд албаар шарлатлаа архи уусан гэж намайгхэлж байна.

-Түий, Чамайг ер дусалч амандаа хүргээгүй гэж би тангаргална. Чамайг ер дусал л амандаа хүргээгүй гэж цөм тангараглана гэж Гэйж хэлэв.

-Тэр лонхнуудыг олчихсон

-Энэ лонхнуудыг зайлуулахыг чамд би зуун удаа хэлсэн шүү дээ. Одоо тэгээд хаана?

-Хувцасны өлгүүр дотор

-Танд чемодан бий юу?

-Байхгүй. Энэ үүргэвчинд хий. Гэйу хүүхэн үүргэвчинд лонх чихэв.

-Хаалгачинд аваачиж өгье гэж үүд рүү явахдаа тэр хэлэв.

-Жаахан азна. Энэ лонхнуудыг би авна гэж Ван Кампен авгнай хэллээ.

Хаалгачин түүнтэй цуг иржээ.

-Эднүүсийг ав. Би эмчид үзүүлж учры нь хэлнэ гэж тэр авгай хэллээ.

Тэгээд тэр авгай гудмаар явж, хаалгачин үүргэвчийг аваачив. Дотор нь юу буйг тэр мэднэ.

Хэрэг төвөг ч болсонгүй. Гагцхүү чөлөө минь олдсонгүй.

[Тор](#)

---

Фронтод явах болсон тэр орой буудалд очиж, Туриээс галт тэрэг ирмэгц суудал аваад байгаач гэж хаалгачинг би явуулав. Галт тэрэг шөнө дунд явлаа. Туринээс гарсан тэр галт тэрэг, арван цаг хагасын үед Миланд ирж яван явтлаа зогсов. Суудал олж авахын тул галт тэрэг ирэхээс өмнө буудалд очих хэрэгтэй байлаа. Чөлөөнийхээ хугацаанд хувцасны газар ажиллаж байсан пулемётчин нөхрөө хаалгачин дагуул явсан учир хоёул надад суудал авч чадна гэдэгт би итгэлтэй байлаа. Би тэдэнд мөнгө өгөөд ачааг минь аваад яв гэжв. Надад аяны хоёр цүнх болоодтом үүргэвч байлаа.

Таван цагийн үед би цэргийн эмнэлэгт салахын ёс гүйцэтгээд гарав. Миний

ачааг хаалгачин хэдүйн байрандаа авчирчээ. Буулдалд шөнө дундаас өмнөхөн очно гэж би хэлэв. Намайг хаалгачны авгай 3Sigorino” гээд уйлав. Тэгээд нүдээ арчсанаа гары минь сэгсрээд дахин уйлав. Тэр хүүхэн эелдэг царайтай буурал үстэй намхан пагдгар биетэй болой. Тэр авгай надад дандаа оймс нөхөж өгдөг байв. Уйлахад нь нүүр нь урсчих шиг санагдана. Булангийн нэгэн гуанзанд ороод би цонхоор харан хүлээв. Гудамжинд харанхуй, манантай хүйтэн байв. Грапп дарстай аяга кофе цайны мөнгөн төлөөд би цонхны зурвас гэрэлд, дэргэдүүр өнгөрөх хүмүүсийг харан суув. Кэтринг хараад би цонх тогшив. Тэр хүүхэн намайг харж иээвхийлэхэд би угтан гарав. Тэр хүүхэн хар хөх цув, нарийн эсгий малгай өмсжээ. Бид хоёр явган хүний замаар орж, дарсны мухлагуудын дэргэдүүр өнгөрөн, зээлийн талбайг гатлаад гудамжаар гулдан хаалгаар орж, сүмийн талбай хүрэв. Түүгээр трамвайны замтай цаана нь сүм байна. Тэр сүм манан дунд цайрч чийглэг харагдана. Бид зам төмөр дээгүүр алхав. Бидний баруун талд байгаа цонхны үзмэр нь гэрэлтэй дэлгүүр өнгөрөн Galleria орно. Талбайн дээгүүр манан өтгөрч, ойрын сүм том харагдаад хананы чулуу нь нойтон аж.

-Орох уу? гэсэн

-Үгүй гэж Кэтрин хэлэв

Тэгээд бид цааш явлаа. Байшингийн чулуун доголд сүүдэр дотор цэрэг хүүхэн хоёр зогсож байв. Бид хоёр дэргэдүүр нь өнгөрөв. Тэр хоёр хананд наалдан зогсоод эрэгтэй нь эмэгтэйдээ цуваар хулджээ.

-Бидэн шиг хоёр байна гэж би хэлэв

-Хэн ч бидэнтэй адилгүй гэж Кэтрин хэлэв

Баяр баясгалангийн тухай Кэтрин бодоогүй байжээ.

-Тэдэнд явах газар алга

Ингэж байх нь ч сайхан байж болно.

-Бүү мэд. Гэхдээ хүн болгон явах газартай байх хэрэгтэй.

-Эдэнд сүм байна гэж Кэтрин хэлэв.

Бид цааш өнгөрөн талбайн зах хүрээд сүм өөд харав: Манан дотор гоёхон харагдана. Ширэн эдлэлийн дэлгүүрийн үүдэнд бид зогсов. Морь унахад өмсдөг савхин гутал үүргэвч цанын ээтэн гутал цонхны үзмэрт нь байв. Энэ бүхнийг аятайхан тараан: дунд нь үүргэвч, нэг голд нь савхин гутал, нөгөө талд нь цанын гутал тавьсан байна. Шир нь гөлгөр хар бөгөөд дөрөөний суранд үрэгдсэн мэт гялалзаж, бүдэг гялгар ширээн дээр цахилгаан гэрэл урт цайвартана.

-Хоёулаа цанаар гулгах юмсан гэхэд

-Хоёр сарын дара Мюрренд цаны улирал эхэлнэ гэж Кэтрин хэлэв

-Тэгвэл тэнд очъё гэсэнд

-Тэгье гэж тэр хүүхэн хэлэв. Өөр цонхны дэргэдүүр бид өнгөрөөд булан тойров.

-Би энд нэг ч ирээгүй гэв.

-Энэ замаар би дандаа Ospedale Maggiore очдог юм гэж би хэлэв

Гудамж нарийн тул бид баруун талы нь дагав. Өтгөн манан дунд олон хүн зөрнө. Бидний дэргэдүүр нь өнгөрсөн бүх мухлагийн цонх гэрэлтэй байв. Нэгэн цонхоор бид овоолсон бяслаг харав. Тэгээд зэвсгийн мухлагийн үүдэнд зогслоо.

-Түргэхэн оръё. Би юм авах хэрэгтэй

-Юу вэ?

-Гар буу

Бид орж би бүсээ тайлан хоосон гэрийн хамт лангуун дээр тавив. Лангууны ард хоёр хүүхэн зогсож байлаа. Тэр хоёр наад хэд хэдэн гар буу үзүүлэв.

-Хэмжээ нь таарвал сайнсан гэж би гэрийн нь нээнгүүтээ хэлэв. Тэрхүү саарал ширэн гэрийг би хотод зүүж явах гэж авсан билээ.

-Энэ сайн буунууд уу? гэж Кэтрин асуув.

-Бараг л адилхан. Энэ бууг шалгаж болох уу? гэж би хүүхнүүдээс асуулаа.

-Одоо манай энд буудах газар байхгүй. Гэхдээ тун сайн буу. Зовох юмгүй гэж нэг нь хэлэв.

Би гохы нь дарж, зам агт нь татав. Пүрш нь тун чанга болоод сайн ажиллаж байна. Шагайж үзээд би дахин гохы нь дарав.

-Хуучин буу. Тэргүүн зэргийн буучин нэг офицерын юм гэж нэг эмэгтэй нь хэлэв.

-Танай эндээс худалдаж авсан уу?

-Тиймээ

-Дахиад яаж энд ирээв?

-Тэр офицерын мэдээчнээс авсан юм.

-Миний буу ч бас танайд байж магадгүй юм даа. Ямар үнэтэй вэ? гэж би хэлэв

-Тавин лир. Хямдхан шүү.

-Сайн байна. Наад бас хоёр илүү хавчаар хайрцаг сум өгөөрэй.

Лангуун дороос тэр хүүхэн сум өвч өгөв.

-Танд сэлэм хэрэгтэй юу? Надад эдэлж явсан сэлэм бий. Хямдхан шүү гэж тэр хүүхэн асуув.

-Би фронтод явж байна.

-Тэгвэл танд сэлэм хэрэггүй гэж тэр хүүхэн хэлэв.

Сум бууны мөнгийг төлөөд би хавчаартаа сум хийж шургуулан гар буугаа гэрэнд нь хийж, дараа нь гэрний шизэрн халаасанд далдлаад бүсээ бүслэв. Бууны хүндэд бүс дарагдана. Яалаа ч гэсэн жагсал маягийн зэвсэг дээр гэж би бодов. Сум авахад хялбар болно.

-Одоо бид бүрэн зэвсэглэжээ. Явахаас өмнө миний хийх гол зүйл энэ байсан юм. Намайг цэргийн эмнэлэгт явуулхад нэг нь миний хуучин бууг авчихсан байна билээ гэж би хэлэв.

-Сайн л буу байгаасай гэж Кэтрин хэлэв

-Өөр юу хэрэгтэй вэ? гэж тэр хүүхэн асуув.

-Үгүй байхаа.

-Оосортой гар буу байна гэж тэр хүүхэн хэлэв.

-Би үзсэн

Тэр хүүхэн бас өөр юм худалдах дуртай байлаа.

-Шүгэл хэрэгтэй биш үү?

-Үгүй байхаа.

Тэр хүүхэн "баяртай" гэж, бид гудамжнаа гарлаа. Кэтринг цонхоор шагайхад нөгөө хүүхэн мөн харж, бидэнд мэхийв.

-Энэ модон жаазтай юун жижиг толь вэ?

-Шувуу барьдаг юм. Энэ толийг хээр тавьж тусгаад болжмор ирж суухад нь италиуд алдаг юм.

-Уран аргатай улс юм. Танай тэнд америкийн болжмор буудаггүй гэж үнэн үү найзаа? хэмээн Кэтрин асуулаа.

-Тэгэлгүй яахав

Бид гудамж хөндлөн гарч нөгөө талаар нь явав.

-Одоо надад аятай байна. Гарч ирэхэд наад их аягүй байсан гэж Кэтрин хэлэв.

-Бид хоёр хамт бол дандаа сайн байдаг

-Бид дандаа хамт байх болно.

-Өнөө шөнө дунд миний явахыг эс тоолбол, тиймээ

-Найз минь, тэрнээ март

Бид гудамжаар явсаар л байв. Манан дотор гэрэл шаргалтана.

-Чи ядарч байна уу? гэж Кэтрин асуув  
-Чи яаж байна?  
-Ядраагүй. Ингэж тэнэх аятайхан байна.  
Харин их удаан тэнэх хэрэггүй  
-Зүйтэй.

Бид булан хүрээд эргэж, дэнлүүгүй нарийн гудамжаар орохдоо би зогсож Кэтринг үнсэв. Үнсэхдээ би Кэтриний гар мөрөнд минь хүрэхийг мэдрэв. Миний цувьг тэр бие рүүгээ татаж, хоёр биенээ хулдах гэж буй шиг байна. Өндөр хананы дэргэдүрх явган хүний зам дээр бид зогсоно.

-Нэг тийшээ явъя гэж би хэлэв.

-Тэгье гэж Кэтрин хэлэв. Сувгийн арай өргөн гудамжинд ортол бид тэр нарийн гудамжаар явахад нөгөө талд тоосгон байшин байх бөгөөд гудамжны адагт гарахад гүүрээр трамвай явж харагдлаа.

-Гүүрний тэндээс унаа олъя гэж би хэллээ. Унаа хүлээж гүүрэн дээр бид хоёр манан дунд зогсоно. Гэртээ яарсан хүмүүс пиг дүүрсэн трамвай хэд хэд өнгөрлөө. Тэгтэл сүйх тэрэг ирлээ. Гэвч хүнтэй аж. Бороо ч шивэрч эхлэв.

-Явган явъя, эсхүл трамвайд сууя гэж Кэтрин хэлэв.

-Тэрэг олно. Эд элбэг байдаг юм гэж би хэллэ.

-Энд яг ирлээ гэж Кэтрин хэлэв

Хөтөч морио зогсоон, тооцооны төмөр тэмдгээ буулгав. Тэрэгний бүхээгий нь татсан агаад хөтчийн цуван дээр бороон дусал тогтоод, маажиндсан өндөр бүх нь усанд цайлалзана. Арын суудалд бид хоёр хамт суухан бүхээгэн дор болоод харанхуй байв.

-Хаашаа яв гэж хэлсэн бэ? гэхэд нь

-Галт тэрэгний буудал тийш. Түүний нөгөө талд зочид буудал бий. Тэнд орё гэв.

-Зочид буудалд ингэж ачаа тээштэй орж болдог юм уу?

-Болно гэж би хэлээ.

-Бороотойд нарийн гудамж тойрон галт тэрэгний буудал тийш бид удаан явав.

-Бид оройн хиоол идэхгүй юм уу? Өлсөж байх шиг байна гэж Кэтрин асуув

-Өрөөндөө идэв

-Би ер хувцсаа тайлахгүй. Би шөнө өмсдөг цамцаа ч аваагүй.

-Тэгвэл худалдаж авна гэж хэлээд би хөтчид: Био Манционигоор яваарай гэж хашгирав

Хөтөч маань толгой дохиж, дарачийн булан тойрохдоо баруун тийшээ эргэв. Төв гудамжинд ороод Кэтрин хоршоо хайлаа.

-Энд байна гэхэд нь би хөтчийг зогсоож Кэтрин буун явган хүний зам гараад дотогш далд оров. Тэргэн дотор налж суугаад хүлээхэд бороо орсоор, нойтон гудамжны үнэр үнэртэж бороонд норсон морины хондлойноос уур савсана. Кэтрин боодолтой юм авч гарч ирээд ууж бид цааш одов.

-Найз минь би хачин үрлэгчин шүү. Гэхдээ даанч гоёхон цамц байна гэж Кэтрин хэлэв

Зочид буудлын дэргэд би Кэтринг тэргэндээ хүлээж бай гээд өөрөө орж даргатай нь ярилцахад сул өрөө зөндөөн тул би эгэж хөтөчид хөлсий нь төлөөд Кэтринтай хамт дотогш оров. Гялалзсан товчтой хөвүүн боодолтой юм барьж, дарга нь биднийг цахилгаан шат өөд мэхийн урив. Цахилгаан шатныхаа дотрыг брнзоор алтдаж, улаан хилэнгээр бүржээ. Дарга нь бидэнтэй хамт өгсөв.

-Monsieur, madame та хоёр өрөөндөө хооллох уу? гэж асуув.

-Тэгнээ. Жагсаалт явуулаарай гэж би хэлэв.

-Тусад нь захих юм бий юу? Зэрлэг шувууны мах авах уу, хөнгөн зууж авах уу?

Лифт давхар бүрт чахарсаар гурван давхар өнгөрөөд мөн ч чахран зогсов.

-Танайд ямар зэрлэг шувуу байна?

-Гургууль, ойн цууцлын мах бэлдэж болно.

-Цууцал гэж би хэлэв. Бид гудмаар явахад хивс нь халцархай бөгөөд хоёр талаар олон хаалга байлаа. Сайхь дарга зогсож нэгэн хаалга түлхүрээр онгойлгож дэлгээд:

-За орцгоо тун аятайхан тасалгаа шүү гэв. Гялалзсан товчтой хөвүүн боодолтой юмаа тасалгааны дундах ширээн дээр тавив. Дарга очиж цонхны хөшгийг засаад:

-Өнөөдөр манантай байна гэв. Тасалгаанд улаан өнгийн ямаан хилэн бүрээстэй модон эдлэл тавьж, олон толь, хоёр зөөлөн сандал, торгон бүтээлэгтэй өргөн ор байна. Халуун ус нь тусдаа хаалгатай юм.

Одоо жагсаалт авчруульъя гээд дарга мэхийн ёслоод гарлаа.

Би цонхион ти йш очиж гудамж руу хараад зузаан ямаан хилэн хөшигний оосрос нь татахад алгуур хаагдаж, Кэтрин орон дээр суун лааны болор суурийг ширтэнэ. Тэр хүүхэн малгайгаа авахад үс нь гэрэлд гялталзаж, нэг толинд харад үсэндээ гараа хүргэхий нь би өөр гурван толинд харж байв. Тэр хүүхэн гунигтай харагдах бөгөөд цуваа орон дээр хаяв.

-Чи яагаа вэ хө? гэсэнд

-Би өөрийгөө авгай болсон гэж огт бодохгүй байна гэж тэр хэллээ. Би цонхон тийш очиж хөшиг яран гудамж руу харлаа. Тэгэж хэлнэ гэж би ер санасангүй.

-Чи авгай болоогүй.

-Найз минь, би мэдэж байна. Гэхдээ тийм гэж бодоход аягүй байна гэхэд холой нь бүрэн хөндий дуугарав.

Цонхор харахад талбайн нөгөө талд галт тэрэгний буудлын гэрэл гийгэж дэргэдүүр нь морь тэрэг сүлжилдэн, цэцэрлэгийн модод харагдаад, зочид буудлын гэрэл нойтон гүүрнээ тусна. “Ээ, харлаа гэж, ингээд одоо хэрэлдэх гэж үү” хэмээн би бодлоо.

-Нааш ир. Нааш ир. Би эрххэн охин гэж Кэтрин хэлэхэд нөгөөх хөндий дуу нь арилсан байв.

-Орон тийш эргэж харваас Кэтрин мишээнэ. Би дэргэд нь очиж орон дээр суугаа үнсэв.

-Чи миний эрххэн охин гэхэд

-Чинийх байлгүй яахав гэж тэр хэллээ.

Оройн холны дараа тайвширч бүр ч сайхан болоод төдөлгүй тэр тасалгаа бидний гэр мэт санагдав. Урьд нь цэргийн эмнэлэгдэх мий тасалгаа бидний гэр болж байсан шиг зочид буудлын энэ өрөө бидний гэр боллоо.

Кэтрин миний цэрэг цамцыг нөмөрч сууна. Бид их өлсжээ. Хоол нь сайн юм. Бид нэг лонх капри дарс, нэг лонх сент-эстефа дарс ув. Ихэнхий нь би уусан бөгөөд Кэтрин жаахан ууж тун сайхан сэргэв. Бидэнд төмстэй ойн цууцлын мах, хөнгөн зууш туулайн бөөрний нухууш шанцай амтлаг шүлт өгөв.

-Сайхан тасалгаа байна. Ёстой гоё тасалгаа байна. Бид урьд энд сууя гэж санах нь яав даа гэж Кэтрин хэлэв

-Алаг цоог юм. Гэхдээ сайхан

-Садар самуун гэдэг гайхалтай ззүйл.

Тэрүүгээр хөөцөлддөг хүн үүнийг тохируулж хийдэг байхдаа энэ улаан өнгийг ямаан хилэн онцгой юм. Ийм л байх хэрэгтэй. Энэ толь ч гэсэн чимэг бус уу? гэж Кэтрин хэлэв

-Хонгор минь.

-ийм тасалгаанд өглөө сэрэхэд ямар байхыг бүү мэд. Харин энэ гол тасалгаа

юм.

Би дахин нэг аяга сент- эстефа аягалав.

-Нүглийг ёсоор нь үйлдмээр байна.

Бидний хийж байгаа бүхэн энгийн гэмгүй юм.

Бид тэнэг юм үйлдээгүй гэж б бодож байна гэж Кэтрин хэллээ.

-Чи ер бусын хүн юм

-Би өлсөж байна. Би жигтэйхэн өлсжээ.

-Чи энгийн бөгөөд хворхон хүн юм.

-Намайг энгийн гэж чамаас урьд нь хэн ч мэдээгүй

-Чамтай танилцсан даруйдаа би, өдөрчин яаж хоёулаа Кавур буудалд очих билээ. Тэгвэл л бүх юм бүтлээ гэж боддогсон

-Чиний хувьд тэр чинь бүдүүлэг юм. Гэхдээ энэ Кавур биш шүү дээ тийм үү?

-Бишээ. Тийш нь биднийг бол оруулахгүй.

-Оруулах л болно. За найз минь ингээд л чи бид хоёр ялгаатай байна. Би бол хэзээ ч юу ч бодож байсангүй.

-Хэзээ ч үгүй юу?

-Жаахан бодсоон гэж тэр хүүхэн хэлэв.

-Найз минь, найз минь.

Би дахин дарс аягалав.

-Би ёстой энгийн шүү гэж Кэтрин хэллээ.

-Эхлээд би өөрөөр босон. Чи галзуу юм шиг санагддаг байсан.

-Би ч жаахан галзуу байсаана. Гэхдээ онцын галзуу биш ээ. Найз минь тэгэхэд би сэтгэлд чинь юм хийгээгүй биз?

-Дарс гэдэг хосгүй зүйл. Муу бүхнийг мартана гэж би хэллээ.

-Гайхамшигтай зүйл. Харин эцэг минь үүнээс болж хэрх өвчинд тун их нэрвэгдсэн юм гэж Кэтрин хэлэв

-Эцэг чинь бий юм уу?

-Би, хэрэх өвчинтэй. Чи түүнтэй уулзах хэрэг ер гарахгүй. Чиний эцэг чинь байхгүй юм уу? гэж Кэтрин хэллээ.

-Байхгүй. Хойт эцэгтэй гэж би хэлэв

-Уулзвал ямар байх бол доо? Чи түүнтэй уулзах хэрэг ер гарахгүй.

-Чамтайгаа л байвал сайхан байна. Өөр сонирхох юм надад алга. Би их жаргалтай эхнэр юм гэж Кэтрин хэлэв.

Зөөгч ирж аяга таваг хураав. Хэсэг зуур болоод бидний чимээ намдахад бороо орох сонсдоно. Доор талбайд машин бүрээднэ.

Цаг гэдэг жигүүрт морь

Цаашлан давхихыг сонсоном

гэж би хэллээ.

-Би энэ шүлгийг мэднэ. Марвеллийн шүлэг. Нөхөртэйгээ цуг байхгүй гэсэн хүүхний тухай юм шүү дээ гэж Кэтрин хэлэв.

Толгой минь онцын сайхан сэргээд амьдралын асуудал яримаар санагдав

-Чи хаан хөнгөрөх вэ? гэж би асуув

-Мэдэхгүй. Аль л сайн газар төрнө

-Яаж болгох вэ?

-Хамгийн сайн аргаар бүтээнэ. Найз минь бүү зов. Дайн дуустал бид бас олон хүүхэдтэй ч болж болно.

-Уахгүй явах цаг болох нь ээ.

-Би мэдэж байна. Хүсээд байгаа бол цаг болж гэж болно

-Үгүй ээ

-Тэгвэл найз минь бүү уурла! Цаг ямагт чи сайн байсан атлаа одоо юунд



уурлаж эхлэв

- Уурлахгүй. Чи надад дандаа захидал бичиж байх уу?
- Өдөр бүр бичнэ. Та нарын захиаг шалгадаг уу?
- Тэнд англи хэл бараг мэддэггүй болохоор ер хамаагүй.
- Би ихээхэн ээдрээтэй бичнэ гэж Кэтрин хэлэв
- Дэндүү ээдрээтэй хэрэггүй
- Ялихгүй ээдрээтэй бичнэ
- Тэгээрэй, явах уу даа
- Тэгье найз минь
- Энэ таатайхан гэрээсээ явмааргүй л байна.
- Надад бас тийм байна
- Явах хэрэгтэй
- За, бид ер нь нэг байшинд удаансуудаггүй шүү дээ
- Суух болно.
- Чамайг эргэж ирэхээр чинь би аятайхан байшин бэлдээд байна.
- Би тун удахгүй ирж чмэднэ
- Гэнэт хөл чинь өчүүхэн шарх олбол
- Эсхүл чихний ходоодондоо
- Үгүй ээ. Чих чинь энэ хэвээр байхыг би хүсэж байна.
- Хөл хэрэггүй гэж үү?
- Хөлдөө чи шарх олсон
- За хө явах боллоо
- За чи эхлээд гар.

[Top](#)

---

Бид цахилгаан шат дуудсангүй, зүгээ шатаар буув. Шатны нь хивс халцархай юм. Хоол авчрах үед би мөгий нь төлсөн бөгөөд тэр зөөгч үүдэнд сууж байснаа босон харайж мэхийн ёслов. Би түүнтэй хамт конторт орж байры мөнгө төллөө. Анх ирэхэд минь дарга нь нөхрийн адил угтсан бөгөд миөнгө урьдчилж аваагүй атлаа намайг гарахдаа мөнгө төлөлгүй зугтах байх гэж үүдэнд тэр зөөгчийг суулгасан ажээ. Үзвээс, тийм явдал нөхдийн нь дотроос ч гарсан бололтой. Дайны үед ч тийм л нөхөд байна даа. Сүүх тэрэг олж ирээч гэж зөөгчөөс гуйсанд тэ надаас Кэтрины ваадантай юмыг авч шүхэр дэлгээд гарч бороон дундуур гудамжаар гарахыг нь бид цонхоор харав. Бид конторт зогсон цонхоор ширтсээр байв.

- Кэтрин, чи яамаар байна?
- Унтмаар л байна
- Би уйдаад, хоол идмээр байна
- Чи идэх юм авсан уу?
- Авсаан. Аяны цшнхэнд бий.

Сүүх тэрэг ирж харагдав. Хөтөч жолоогоо татахад морь нь бороонд духуйн зогсоод сайхь зөөгч шүхэ дэлгэн буж буудал тийш ирэхэд бид үүдэнд, тосож уулзаад шүхрээ барьж явган хүний нойтон замаар гарч сүүх тийш очиход урсгалын сувгаар ус цутгана.

-Таны ваадантай юм суудал дээр бий шүү гэж зөөгч хэлэв. Бидний сууж амжтал тэр шүхэр барин зогсож, би шан өгөв

-Баярлала. Сайн яваарай гэж тэр хэлэв. Хөтөч жолоо дугтрахад тэрэг хөдлөв. Сайхь зөөгч шүхрээ барьсаар эргэж буудалдаа орлоо. Бараг бороо дуусахгүй нэгэн дэнлүүний хажууд хоёр цагдаа зогсож малгай нь дэнлүүний гэрэлд гялалзана. Ачаа зөөгч саравчин дороос гарч борооноос толгойгоо халхлан захандаа шургасаарирэв.

-Баярлалаа. Хэрэггүй гэж би хэллээ.

Тэр эгэж саравчин дороо оров. Би эргэж Ктринг харвал, нүүр нь дээрээсээ сүүдэртэ нбайна.

-За салах ёс гүйцэтгэх үү дээ?

-Би орно.

-Хэрэггүй

-Кэтрин минь баяртай-Цэргийн эмнэлгийн хаягийг цаадахдаа хэлж өгөөрэй.

-За

Очих газры нь би хөтөчид зааж өгсөнд тэр хөтөч толгой дохив.

-Баяртай. Биеэ гамаарай. Бяцхан Кэтринг гамнаарай гэж би хэлэв

-Баяртай, найз минь гэхэд нь

-Баятай гэж би хэлэв

Намайг бороон дунд гарахад хөтөч явлаа. Кэтрин цээжэ түрэн цухуйж мишээгээд гараа даллахад нүүр нь дэнлүүний гэрэлд үзэгдэнэ. Сүүх тэрэг гудамжаар давхив. Саравчин тийш Кэтрин хуруугаар зангахад эргэж харвал: гагцхүү саравч, хоёр цагдаа байх бөгөөд тэнд борооноос хоргод гэсэн үг гэж би ухаарлаа. Би саравчин дор орж зогсоод сүүх тэрэг булан тойрохыг ажив. Тэгээд би галт тэрэгний буудал дундуур өнгөрөн галт тэргэн тийш очлоо.

Тавцан дээр намайг хаалгачин хүлээж байжээ. Би дагаж галт тэргэнд ороод олонтаа шахцалдан явсаар хаалга онгойлгож, дүүрэн хүнтэй тасалгаанд чихцэлдэхэд буланд нь пулемётчин сууж толгой дээгүүр нь буй ачааны торонд миний үүргэвч, аяны цүнх байлаа. Гудамд олон хүн зогсох бөгөөд тасалгаанд сусан хүмүүс биднийг ороход харцгаав

Галт тэргэнд суудал хүрэлцээгүй учир цөм бие биедээ дайсагналцана. Пулемётчин босож надад суудал тавив. Нэг хүн мөрөн дээр алгадахад эргэж харвал, их бууы тун өндөр, туранхай агаад хацар дээрээ улаан сорвитой ахмад аж. Шилэн хаалгаар тэр, биднийг хараад намайг дагаж иржээ.

-Яагаав? Гэж асуугаад би өөдөөс нь халз харан эргэв. Тэр хүн надаас өндөр, мөн Би дагаж галт тэргэнд ороод олонтаа шахцалдан явсаар хаалга онгойлгож, дүүрэн хүнтэй тасалгаанд чихцэлдэхэд буланд нь пулемётчин сууж толгой дээгүүр нь буй ачааны торонд миний үүргэвч, аяны цүнх байлаа. Гудамд олон хүн зогсох бөгөөд тасалгаанд сусан хүмүүс биднийг ороход харцгаав

Галт тэргэнд суудал хүрэлцээгүй учир цөм бие биедээ дайсагналцана. Пулемётчин босож надад суудал тавив. Нэг хүн мөрөн дээр алгадахад эргэж харвал, их бууы тун өндөр, туранхай агаад хацар дээрээ улаан сорвитой ахмад аж. Шилэн хаалгаар тэр, биднийг хараад намайг дагаж иржээ.

-Яагаав? Гэж асуугаад би өөдөөс нь халз харан эргэв. Тэр хүн надаас өндөр, мөн Би дагаж галт тэргэнд ороод олонтаа шахцалдан явсаар хаалга онгойлгож, дүүрэн хүнтэй тасалгаанд чихцэлдэхэд буланд нь пулемётчин сууж толгой дээгүүр нь буй ачааны торонд миний үүргэвч, аяны цүнх байлаа. Гудамд олон хүн зогсох бөгөөд тасалгаанд сусан хүмүүс биднийг ороход харцгаав

Галт тэргэнд суудал хүрэлцээгүй учир цөм бие биедээ дайсагналцана. Пулемётчин босож надад суудал тавив. Нэг хүн мөрөн дээр алгадахад эргэж харвал, их бууы тун өндөр, туранхай агаад хацар дээрээ улаан сорвитой ахмад аж. Шилэн хаалгаар тэр, биднийг хараад намайг дагаж иржээ.

-Яагаав? Гэж асуугаад би өөдөөс нь халз харан эргэв. Тэр хүн надаас өндөр,









буй ачааны торонд миний үүргэвч, аяны цүнх байлаа. Гудамд олон хүн зогсох бөгөөд тасалгаанд сусан хүмүүс биднийг ороход харцгаав

Галт тэргэнд суудал хүрэлцээгүй учир цөм бие биедээ дайсагналцана. Пулемётчин босож надад суудал тавив. Нэг хүн мөрөн дээр алгадахад эргэж харвал, их бууы тун өндөр, туранхай агаад хацар дээрээ улаан сорвитой ахмад аж. Шилэн хаалгаар тэр, биднийг хараад намайг дагаж иржээ.

-Яагаав? Гэж асуугаад би өөдөөс нь халз харан эргэв. Тэр хүн надаас өндөр, мөн Би дагаж галт тэргэнд ороод олонтаа шахцалдан явсаар хаалга онгойлгож, дүүрэн хүнтэй тасалгаанд чихцэлдэхэд буланд нь пулемётчин сууж толгой дээгүүр нь буй ачааны торонд миний үүргэвч, аяны цүнх байлаа. Гудамд олон хүн зогсох бөгөөд тасалгаанд сусан хүмүүс биднийг ороход харцгаав

Галт тэргэнд суудал хүрэлцээгүй учир цөм бие биедээ дайсагналцана. Пулемётчин босож надад суудал тавив. Нэг хүн мөрөн дээр алгадахад эргэж харвал, их бууы тун өндөр, туранхай агаад хацар дээрээ улаан сорвитой ахмад аж. Шилэн хаалгаар тэр, биднийг хараад намайг дагаж иржээ.

-Яагаав? Гэж асуугаад би өөдөөс нь халз харан эргэв. Тэр хүн надаас өндөр, мөн малгайны нь саравчны сүүдэрт нүүр нь тун туранхай юм шиг агаад шарх нь шинэхэн гялгар аж.

Тэнд байсан хүмүүс намайг харлаа.

-Ингэдэггүй юм. Суудал авах гэж эртнээс цэрэг явуулж болохгүй гэж тэр хэлэв.

-Би тэгсэн юм гэж би хариулав.

Тэр хүн хий залгиж төвөнх нь дээш доош болно. Сул суудлын хажууд пулемётчин зогсож, гудамжны шилэн хашлагын цаанаас хүмүүс харж, цөм дуугүй байв.

-Би чамаас хоёр цагийн өмнө энд ирсэн

Чи ингэж болохгүй гэхэд нь би

-Та гээ вэ? гэв

-Сууна гэлээ

-Би ч бас сууна гэж би хэлэв

Би түүний царай өөдхарвал, эргэн тйрон цөм миний эсрэгнь илэрхий. Би эсэргүүцсэнгүй. Тэрний зөв байжээ. Би ч бас суумаар байв.Эргэн тойрон урьдын адил дуугүй

“Новш гэж” хэмээн би бодов

-Суугтун, signor capitano гэж би хэлэв. Пулемётчин зай тавьж өндөр ахмад суув. Тэгээд тэр намайг ширтэх нь уурласан байртай. Суул тэрнийх боллоо.

-Миний юмыг ав гэж пулемётчинд хэлэв. Бид гудманд гарлаа. Галт тэрэг пиг дүүрээд, суудлын тухай ярихын ч хэрэггй боллоо. Хаалгачин пулемётчин хоёрт би аравн арван лиг өгсөнд тэд галт тэрэгнээс гарч тоцонг тууш явж цонхоор харавч суудал байсангүй.

-Брешийд буух хүн байж магадгүй гэж хаалгачин хэллээ.

-Брешийд бас хүн сууна гэж пулемётчин хэллээ. Би салах ёс гүйцэтгэж гар барьж тэд явлаа.Тэд хоёул харамсжээ. Галт тэрэг хөдлөхөд суудалгүй үлдсэн бид бүгд гудамд зогсов. Замын хажуугаар өнгөрөх сум, дэнлүүг би цонхоор ширтэж, бороо орон орсоор, төдөлгүй цонх нойтон болж юу ч харагдахгүй болов. Оройхон би гудамны шалан дээр унтахаар хэвтэхдэ, мөнгөтэй түрийвч үнэмлэхээ цамцан дотуур гэдсэн дороо шургуулсан учи гуя өмд хоёрын завсар оржээ. Би шөнөжин унтлаа. Гагцхүү шинээр суугчид галт тэргэнд орж ирэх үе Брешин Вероны зогсоолд сэрээд тэр даруйдаа бас унтжээ. Аяны нэг цүнхээ би дэрлэж, нөгөөг нь тэвэрч над дээр гишгэлгүйгээр дээгүүр минь хүн алхалж гарч болохоор хэвтэв. Гудам дүүрэн, шалан дээр хүмүүс унтана. Зарим нь хаалга налах буюу цонхы бариулаас барьж

зогсоно. Энэ галт тэрэг дандаа дүүрэн хүнтэй явлаа.

[Top](#)

---

Хэдүйнээ намар болоод хамаг мод нүцгэрч, зам бүхэн шавхайд хучигдана. Би Удинээс Гориций орохоор ачааны машинаар явж байлаа. Зам зуур ачааны машинууд дайралдан. Би ийш тийшээ харж явлаа. Ялмаа мод нүцгэрээд тал газар бараантана. Эгнэсэн нүцгэн м одны хоорондуур зам дээр унасан навчис нойтон хэвтэнэ. Замын хажуугаархи модны ёроолд хураасан хайрганаас ажилчид зөөн замын хонхорхойд асгана. Хот харагдаж, цаадтайх уулын нь орройг мана бүсэлжээ. Гол гарахад ус үерлэсэн байв. ууланд бороо орно. Бид хотод рж үйлдвэрүүд өнгөрөөд сууц байшингийн дэргэдүүр явахад намайг байхгүй хоронд улам олон байшин бөмбөгөнд эвдэрсэн үзэгдэнэ. Нарийн гудамжинд Английн улаан загалмайн машин тааралдав. Туранхай нүүртэй, наранд түлэгдсэн жолооч нь эрүү малгай өмсжээ. Би тэр жолоочийг танихгүй юм. Захиргааны өмнөх том талбайд намайг машинаас буухад жолооч үүргэвчийг минь авч өгөв. Би үүргэвчээ үүрч хоёр цүнхээ мөрөвчлөөд байшин тийшээ явав. Үүнийг гэртээ харьж ирсэнтэй хэрхэн зүйрлэж болох билээ.

Өнгө алдсан моддын цаадтайх сууцыг харан өргөн гудамжны нойтон хайрган дээгүүр алхлан явав. Хамаг цонхоо хааж хаалга дэлгэцгээжээ. Өрөөнд ороход хошууч ширээний цаана сууж байлаа. Ар талын нь нүцгэн хананд гагцхүү машиндсан хуудас газрын зураг өлгөөтэй байв.

-Сайн ирэв үү? Бие чинь сайн уу? гэж хэлэхэд нь үзэхүл өвгөрч хатангирсан харагадана.

-Зүгээр! Ажил ямар байна? гэж би асуув

-Ажил дууссан. үүргэвч юмсаа тайлаад суу гэж тэр хэлэв

Би үүргэвч болоод хоёр цүнхээ шалан дээр тавьж, үргэвчин дээр малгайгаа тавиад, хананы дэргэдээс сандал авч ширээнд ойртож суулаа.

-Энд муухан зуншсан. Чи сайн эдгэв үү гэж хошууч хэллээ.

-Эдгэсэн

-Шагналаа авав уу?

-Авсан. Хамаг хэрэг бүтсэн. Танд баярлалаа.

-Үзүүлээч хө

Хоёр лентээ харуулах гэж би цуваа ярав

-Жинхэнэ медалы нь авав уу?

-Үгүй ээ. Зөвхөн үнэмлэх авсан

-Медалиуд нь дараа ирнэ. Нилээд хугацаа болно

-Одоо та намайг хааш нь явуулах вэ?

-Машинууд цөм замд гарсан. Зургаа нь хойшоогоо Капоретто явсан. Чи Капореттог мэдэх үү?

-Мэднэ гэж үби хэлэв. Хөндийд байсан гунхтай бяцхан цагаан хот надад санагдав. Тэр хот цэвэрхэн агаад талбайдаа сайхан оргилууртай билээ.

-Одоо дайн дуусаад, тэнд олон өвчтөн бий.

-Бусад нь хаана яваа вэ?

-Хоёр нь ууланд, дөрөв нь Баинзицид рэвээр бий. Нөгөө хоёр эмнэлгийн салбар гуравдугаар армитай цуг Карсод бий.

-Та намайг хааш нь явуулах вэ?



-Явъя гэвэл, Баинзиццэд байгаа дөрвөн машиныг авч болно. Жино аль хэдүйн тэнд очсон. Түүний халааг ав. Тэр чинь чиний дараахантай болсон хэрэг байх аа даа?

-Тиймээ

-Муухай хэрэг болсон юм. Бид гурван машинаа алдсан

Би дуулсаан

-Ринальди чамд бичсэн юм

-Ринальди хаана вэ?

-Энд, цэргийн эмнэлэгт бий. Зун намар ч хэцүүхэн байсан дээ.

-Тийм байхаа.

-Үнэхээр муухай байсан. Ямар муухай байсныг чи арай л мэдэхгүй биз. Чамайг эхэн үед шархадсан нь нож гэж би дандаа боддог байсан.

-Би ч тэгж боддог

-Одоо ууланд бороотойд довтолгоон эхэлнэ гэж бодохгүй байна. Уахгүй цас оррно. Таны орныхон юу болж байгаа вэ? Танаас өөр америк хүн ирэх үү?

-Арван саятны арми бэлдэж байгаа.

-Хэсэгхэн нь ч наашаа ирвэл сайнсан.

Гэхдээ францчууд цөмий нь авчихна. Энд нэг ч хүн ирэхгүй. За,яая гэхэв. Чи өнөөдөр эндээ унтаад, углөөгүүр жижиг тэргээр явж, Жиногийн халаа ав. Би зам мэддэг хүн өгнө. Жино чамд цөмий нь ярина. Биз. Тэнд хааяа бууддаг юм. Гэхдээ, ер нь дууссан. Баинзицци очвол чамд сонин байх биз.

-Тэнд очих надад тун сайхан байна.

Тавтай дахин уулзсан минь тун сайхан байна.

-Та ялдамхан байна. Энэ дайнд би ядарлаа. Хэрэв би явсансан бол эргэж ирмээр санагдахгүй байх гэж би бодож байна хэмээн тэр инээвхийлэв

-Тийм айхавтар муухай юу?

-Адгийн муухай юм. Явж нүүр гараа угаагаад Ринальди найзаа хайдаа.

-Би юмаа авч шатаар дээш гарахд Ринальди өрөөндөө үгүй, харин юмс нь хэвэндээ байв. Би орон дээр сууж ороолтоо тайлаад өвдөж буй баруун хөлийнхөө шаахайг сугалан хэвтэв. Би ядарчээ, орон дээр өрөөсөн шаахайтай хэвтэх эвгүй тул би босож суугаад нөгөө хөлийнхөө шаахайг тайлж шалан дээр хаяад эргэж бүтээлэх дээр хэвтэв. Цонх хаалттай учир тасалгаанд бөгчим боловч босож онгойлгох тэнхэл надад байсангүй. Миний бүх юмыг тасалгааны нэгэн буланд хураажээ. Бүрий болэ эхлэв. Би орон дээр хэвтээд Кэтриний тухай бодож Ринальдийг хүлээнэ. Кэтриний туха би зөвхөн үдэш унтахын өмнө бодно гэж шийдсэн билээ. Гэвч би ядраад хийх зүйлгүй тул хэвтэж тэр хүүхний тухай бодож байна. Ринальдийг орж ирэхэд ч би тэр хүүхний тухай бодож байлаа. Ринальди ер хувирсангүй, гагцхүү жаахан тураа юу даа.

-За, өвгөөн гэж тэр хэлэв

-Намайг өндийтөл тэр дэргэд ир суугаад тэврэв

-Хөөрхий, миний муу өвгөн гээд тэр араар минь тэврэхэд би мөрөөр нь тэврэв.

-Хөөрхий миний өвгөн, алив өвдгөө үзүүлээч гэж тэр хэллээ.

-Өмдөө тайлах болно

-Өмдөө тайл, өвгөн минь. Энд гадны хүн алга. Яаж янзалсы нь би үзмээр байна.

Би босож өмдөө шувтлаад өвдөгнийхөө боолтыг тайлахад Ринальди шалан дээр сууж хөлий минь тахийлгэж тэнийлгэж үзээд сорвий нь илбэснээ үөвдөгний нүдэн дээр хоёр эрхийгээ нийлүүлж бусад хуруугаараа доогуур нь зөөлхөн дарлаж.

-Илүү нураарахгүй байна уу? гэв

-Үгүй

-Ийм хүнийг эмнэлгээс гаргасан нь ялт хэрэг болно. Үеий нь тэд бүрэн эдгээр ёстой байсан байна.

-Үүнээс доор байсан юм. Хөл гэж мод шиг л байлаа.

Ринальди дахин шалгаж үзэв. Би гары нь дагуулан харна. Тэрний гар нь эвлэгхэн мэс засалч болохоо илэрхийлнэ. Би түүний толгойг ажиглахад гөлчийтөл хагалж самнасан үс нь гялалзана. Хөлий миньтэр дэндүү чанга тахийлгахад би

-Ай! Гэж дуун алдав

-Бас л нилээд бариулах хэрэгтэй байж дээ гэж ринальди хэлэв

-Урьд нь энүүнээс доор байсан юм.

-Өвгөн минь, би мэднэ. Ийм юмыг би чамаас илүү ойлгоно. Уг мэс засал нь сайн болжээ гээд тэр босож орон дээр суугаад миний өвдөгний тухай яриа дуусаж,

-Одоо явснаа ярь гэв

-Ярих юм алга даа. Амгалан тавтай л байлаа гэж би хэллээ.

-Чамайг гэрлэсэн гэж бодож явж болох уу? Яриач гэж тэр хэлэв

-Харин чи яриач гэж би хэлэв

-Дайн намайг сүйтгэлээ. Би бүр сүйрчээ гэж хэлээд Ринальди өвдгөө салаавчлав

-Өө! Гэж би дуун алдлаа.

-Яагаав? Надад хүнлэг сэтгэл байж бөөлөхгүй гэж үү?

-Хаанаас даа. Чи зун аятайхан өнгөрөөсөн шиг байна, яриач

-Зунжин, намажин би мэс засал хийлээ. Амрах загүй би ганцаархнаа ажиллаж байна. хамгийн хүнд юм ч тааралдлаа. Үнэнээ хэлэхэд, өвгөн минь би тэргүүн мэс засалч болж байна.

-Энэ чинь л аятай сонсдож байна.

-Надад юм бодох зав байхгүй. Үнэнээ хэлэд, юм ч бодох завгүй, мэс засал л хийгээд байна.

-Зүйтэй

-Гэхдээ өвгөн минь доо юм өөр болсон. Одоо мэс засал хийгээд байх юм байхгүй. Сэтгэл минь зэвүүн муухай байна. Өвгөн минь энэ айшигт дайн шүү. Миний үгэнд итгэ. Одоо чи намайг жаахан баясууж өгөөч.

Пянз авчирсан уу?

-Авчирсаан.

Миний үүргэвчин дотор цаасан боодолтой хайрцагт пянзнууд буй бөгөөд гаргая гэтэл би тун ядарчээ.

-Өвгөн минь, сэтгэл чинь сэргэлэн байна гэж үү?

-Зэвүүн байна.

-Энэ аймшигт дайн шүү. За яая гэхэв. Хоёулаа согтож сэтгэлээ сэргээе. Гунигаа хийсгэе. Сайн сайхан болно гэж Ринальди хэлэв

-Би шарлаж өвдсөн, согтож болохгүй гэж би хэллээ.

-ээ, өвгөн минь. Чи чинь ямар янзтай болж ирэв дээ. Өвдсөн элэгтэй, бодотгой болж иржээ дээ. Үнэндээ дайнд холбогдов доо.

-За жаахан ууя. Би согтохгүй. Гэхдээ ууж болно.

Ринальди нөгөө ханын угаагуур тийш очиж хоёр аяга, нэг лонх коньяк архи авчрав

-Энэ долоон таван хошуутай Австри коньяк энэ дээ гэж Ринальди хэлэв

-Чи тэнд очо юу?

-Очоогүй. Би хаашаа ч яваагүй. Би дандаа энд байж мэс засал хийсэн. Хараач, өвгөн чинь, энэ чиний шүд зайлдаг хуучин аяга шүү дээ. Чамайг санагдуулж байг гэж би үүний чинь дандаа гамнаж байсан юм.

-Эсхүл шүдээ цэвэрлэхэд хэрэгтэй байв уу?

-Надад өөрийн аяга бий. Вилла Россад орсноо өглөөгүүр чи цэвэрлэх гэж яаж сандарч, уурлаж, халууны эм залгиж, хүүхнүүдийг зүхэж байсны чинь санагдуулж байг гэж бүүний чинь дандаа гамнаж байсан юм. Энэ аягыг харах бүрдээ би чамайг санаж ариун сэтгэлээ чи хэрхэн шүдний сойзоор цэвэрлэж гэж сандардгий чинь дурсдаг юм гээд орны дэргэд ирж: за намайг үнс, тэгээд бодомтгой зангаа мартсан гэж хэл гэв

-Би чамайг үндсэх дургүй. Чи сармагчин.

-За за. Би мэдэж байна. Чи англи саксон гарлын сайн хөвүүн би мэдэж байна. Ариун сэтгэл чамайг цөлмөсөн. Би мэдэж байна. Миний англи саксон гарлын хөвүүн дахиад биенээсээ янхны гарыг шүдний сойзоор цэвэрлэж эхлэхийг би хүлээж байна.

-Архи аягалаач

Бид тулгаж уув. Ринальд намайг дооглоно.

-Чамайг сайн уулгаад, элгий чинь аваад, сайн итали элэг суулгаад дахин хүн болгоно.

Дахин конъяд архи хийлгэх гэж би аягаа Ринальд барив. Бүр харанхуй блжээ. Аягаа барьсаар би цонхон тийш очиж цонх онгойлгов. Бороо арилжээ. Хүйтэн болж, моддын мчрийг манан бүрхжээ.

-Цонхоор архи бүү асга. Ууж чадахгүй бол надад аль гэж Ринальди хэлэв.

Юу болж байгаагаа чи мэдэж байна уу? гэж би хэлэв. Ринальдитай дахин уулзахдаа би баярласан билээ. Хоёр жилийн турш тэр намайг өдөөж сураад би үргэлж хайрладаг болжээ. Бие биенээ бид тун сайн мэддэг юм.

-Чи гэрлэсэн үү? Гэж тэр орон дээр суусаар асууу.

-Үгүй гэв.

-Чи дурласан уу?

-Тиймээ

-Тэр англи хүүхэнд үү?

-Тиймээ

-Хөөрхий муу өвгөн минь. Тэр хүүхэн бас чамд дурласан уу?

-Тиймээ

-Тэгээд тэр чинь хэрэг дээр нь үзүүлсэн үү ?

-Дуугаа тат

-Дуртайяа больё. Онцын журамт хүн болохы минь чи мэднээ гайгүй. Тэр хүүхэн чинь тэгээд...

-Ри минь дуугаа татаж үз. Хэрв нөхөд хэвээр баяцгаая гэвэл дуугаа тат гэж би хэлэв

-Өвгөн минь, бид найз байгаасай гэж хүсээд байх юм надад алга даа. Бид ерөөсөө нөхөд шүү дээ.

-Тэгвэл дуугаа тат.

-Мэдлээ

-Би орон тийш очиж Ринальдийн дэргэд суув. Тэр аягаа барьсаар шал ширтэнэ.

-Ри минь одоо мэдэв үү?

-Мэдлээ, мэдлээ. Амьдралынхаа туршид би сонин хачин юм үзэж л явлаа. чи бид хоёр танилцаад удсан ч биш дээ. Би чамайг мэдэхгүй юм. Бодвол чиний амьдралд ч тийм юм байдаг л биз гэж хэлээд Ринальди шал харав.

-Өөр сонин юм чиний амьдралд байхгүй юу?

-Байхгүй

-Ямар ч байхгүй юу?

-Ямар ч байхгүй.

-Эхийнхээ тухай юм уу, эгчийнхээ тухай яривал дээр байсан юм биш үү дээ.

-Эгчийнхээ тухай гэдэг чинь ядахдаа болно гэж Ринальди сэргэн хэлэв. Тэгээд бид хоёул инээв

-Ёстой онцгой хүн юм даа чи гэж би хэллээ.

-Би атаархаж байгаа хэрэг үү гэж Ринальди хэллээ.

-Үгүй тэгэх ёсгүй.

-Чи буруу ойлгож байна. Чиний нөхдөд эхнэртэй хүн бий юу?

-Бий гэж би хэлэв.

-Миний нөхдөд бахгүй. Эхнэртэйгээ эрх жаргалаараа байгаа хүн бахгүй гэж Ринальди хэлэв

-Яагаад?

-Тэд надад дургүй.

-Яагаад?

-Яагаад гэвэл би далдыг таагч юм.

-Та андуурч байна. Далдыг мэдэгч гэж байх ёстой.

-Таагч таагч гэж тэр хөгжүүхэн хэлэв:

-Дэндүү бодомтгой болоод чи эвдэрч байна гэж би хэллээ.

-Өвгөн минь би чамд хайртай. Намайг Италийн их сэтгэгч болохоор ч туршаад үзээрэй. Учирлан гаргаж чадахгүй олон юм би мэдэж байна. Би чамаас илүү юм мэднэ гэж тэр хэлэв.

-Тэр ч үнээн.

-Харин чи бол сэтгэл амгалан амьдарна. Хувь заяа чинь хазгай ч амгалан явах болно.

-Үгүй байхаа.

-Тэгнэ, тэгнэ. Тийм байаг юм. Одо надад бол ажиллаж бахад л таатай байдаг гээд тэр дахин шал ширтэв

-Гайгүй болно биз.

-Үгүй. Миний дуртай хоёр зүйл бас байдаг юм. Нэг нь миний ажилыг үрдэг. Нөгөө нь хагас цаг буюу арван таван минут эзэлдэг. Ихэнхдээ бага цагч эзэлдэг

-Ер нь тун бага гээч

-Өвгөн минь би амжилт олсон ч байж болох юм. Чи мэдэхгүй шүү дээ. Гэхдээ би тэр хоёр зүйлээс бас өөрийнхөө ажлыг мэднээ.

-Өөр ч юм мэдэж болно.

-Үгүй. Бид хэцээ ч өөр юм мэдэхгүй. Бид энэ байгаа биеэрээ л төрдөг. Илүү юу ч мэдэж чаддаггүй. ид шинэ юм мэднэ гэж хэзээ ч ер байдаггүй. Бид нэгэнт тодорхой замаар ордог. Чи литин биш гэдэгтээ л баярлаж яв.

-Латин хүн гэж ерөөсөө байхгүй. Харин чи ллатин байж мэдэхнээ. Чи энэ алдаандаа бахархвал таарна гэхэд минь Ринальди дээш болж, чангаар инээв.

-За за больё өвгөн минь, би ядарч байна. Удахгүй үдийн хоол болно. Чамайг ирсэнд би баярлаж байна. Чи миний шилдэг нөхөр зэвсэг нэгтэй ах дүү гэж Ринальди хэлэв. Тэр орж ирэхийнхээ л ядарсан харагдаж билээ.

-Зэвсэг нэгтэй ах дүүс хэзээ хоолоо идэх вэ гэж би асуув

-Одоохон. Чиний элгийг эдгээсэй гэж бас нэг ууцгаая.

-Павелын сургаалаар тэр үү?

-Яг ч тийш биш. Тэнд дарс ходоод хоёрын тухай гардаг. Ходоодныхоо ашгийг бодож дарс тогтооё.

-Юу ч гэсэняахав гэж би хэллээ.

-Хонгорын чинь төлөө гэж хэлээд ринальди аяга өргөв

-Болноо.

-Би тэр хүүхний чинь тухай дахиад нэг ч муу үг хэлэхгүй.

-Биеэ, бүү хавч.

Ринальди коньяк архийг дуустал уув.

-Би ариун сэтгэлтэй. Өвгөн минь чи бид хоёр ер ялгаагүй. Би бас англи хүүхэнтэй танилцана. Үнэндээ гэхэд, танай тэр хүүхэнтэй чинь би эхэлж танилцсан, хартин тэр хүүхэн чинь надад дэндүү өндөрдөөд байсан. Ер нь өнөр хүүхнүүд ч сувилагч болдог юм гэж тэр мэдэмхийрэв.

-Чи өөрөө ариухан биз гэж би хэлэв

-Худлаа гэх үү? Тэгээд ч намайг цэвэрхэн Ринальди гэдэг юм.

-Гахайхан Ринальди

-За, за явъя өвгөн митнь, цэвэрхэн байгаа дээрээ хоолоо идье

Би нүүр гараа угааж, үсээ янзлаад, бид хоёр дахин дош буув. Ринальди бага зэрэг согтжэ. Гуанзанд ороход хоол арай болоогүй байв

-Явж коньяк архи авчиръя гэж Ринальди хэлээд дээш гарав. Би ширэнд сууж байв. Ринальди лолнхтой коньяк архи авчраад, хоёр аяганд дундуур аягалав.

-Дэндүү их байна гэж хэлээд би аягаа авч ши рээний дунд буй дэнлүүний гэрэлд харав.

-Хоосон ходоодонд ихдэхгүй. Сайхан эд шүү. Дотор талыг нэлэнхүйд нь төөнөнө. Энүүнээс адгийн юм олдохгүй.

-яахав дээ.

-Биеэ тогтмол хөнөөх гэж үүнийг хэлдэх юм. Ходоод гэмтэж, гар салгалдаг болно. Мэс засалчин хүнд ёстой тохирсон зүйл дээ гэж Ринальди хэлэв

-Намайг уу гэж байгаа юм уу?

-Тэгэлгүй яахав. Өөр юм хэрэглэхгүй.

Өвгөн минь, наадахаа балгачихаад, туйвганахаа бод

-Би хагасы нь уув. "Шөл бэлэн боллоо! Гэж мэдээчин гудамд хашгирах сонсдов.

Хошууч орж ирж бидэнд толгой дохиод суув. Ширээний ард тэр дэндүү жижигхэн харагдана.

-Өөр хүн алга уу? гэж тэр асуув. Мэээчин өмнө нь шөл тавихад тэр шууд таван дүүрэг хийж авав.

-Өөр хүн алга. Гагцхүү лам л ирэх болох нээ. Хэрэв тэр Федерико ирсэн гэж мэдвэл заавал ирнэ гэж Ринальди хэлэв.

-Лам хаана байгаа вэ? гэж би асуулаа

-Гурван зуун долоод гэж хошууч хэлэв. Тэр хоол идээд завгүй аж. Тэгээд амаа арчиж, дээш нь мушгисан буурал сахлаа сайтар шувтраад:

-Ирэх байхаа. Би тэнд очиж, чамайг ирсэн гэж зурвас орхисон гэж трэ хэлэв.

-Урьд нь гуанзанд шуугиантай байдагсан гэж би хэлэв

-Тиймээ. Одоо ч намуухан болж дээ гэж хошууч хэллээ.

-Одоо би шуугия гэж Ринальди хэлэв

-Энрикээ, дарс уугаач гэж хошууч хэлэв. Тэгээд тэр миний аягыг дүүргэв. Мянтууз авчрахад бид цөм идэв. Мнтууз идэж дуусмагц лам орж ирлээ. Тэр мөнөөхөн хөхөвтөр, жижигхэн, цэмцгэр хэвээр ажээ. Би бодсож, бид хоёр гар барьж ёслоод, мөрөн дээр минь, тэр гараа тавьж:

-Чамайг ирсэн гэж сонсоод л ирлээ гэв

-За суу. Та хожимдчихжээ гэж хошууч хэлэв

-Лам бугайн амрыг эрье гэж Ринальди хэлэв

-Ринальдийн амрыг эрье гэж лам хариулав. Мэдээчин шөл авчирч өгсөнд тэр мянтууз эхэлжиднэ гэв

-Бие чинь сайн уу? гэж надаас тэр асуув

-Сайхаан. Юу дуулдана даа? гэж би хэлэв.

-Лам бугай, дарс уу. Ходоодныхоо ашгийг бодож дарс тогтоо. Павелын

сургаалд тэгж байдаг биз дээ гэж Ринальди хэллээ.

-Тийм ээ, тийм гэж лам идэвхийлэн хэлэв.

Ламын аягыг Ринальди дүүргэв

-Энэ Павелын сургаал уу, юм бүрийн шалтгаан болж байна эгж Ринальди хэллээ. Лам над руу харж инээвхийлэв. Үгээр хатгахад тэр дасал болсон нь илэрхий байна.

-Тэр Павелын сургаалтан уу, тэр чинь өөрөө орооны нохой, шар сэмжилсэн этгээд байгаад тэнхил нь хүрэхээ болихоороо тийм юмыг нүгэл гэж зарласан юм. Өөрөө юу ч чадахаа байж, тэгээд чаддаг хүнийг сургамжлах болсон юм. Федерико, тийм биз дээ? гэж Ринальди хэлэв

Хошууч инээвхийлэв. Тэр үе бид халуун хоол идэж байлаа.

-Нар жаргаснаас хойш би хувраг хүнийг ер муулахгүй гэж би хэлэв. Лам тавагаас нүдээ салган намайг харж мишээв.

-За ингээд л энэ одоо ламын талд орчихлоо. Нөгөө үг өддөг хуучин сайн нөхөд байх нь яав даа. Кавальканта байхгүй. Брунди байхгүй. Чезар байхгүй. Энэ муу хөөрхий ламыг би л ганцаар үгээр хатгаж байх болж байна уу даа? гэж Ринальди хэлэв.

-Энэ сайн лам шүү гэж хошууча хэллээ.

-Энэ сайн лам. Гэхдээ л лам шүү дээ. Гуанзанд урьдын адил байгаасай л гэж би бодож байна. Би Федерикогийн шавайг хангах гэсэн юм. Энэ лам тонилох болтугай гэж Ринальди хэлэв.

Ринальдийг согтуу байна гэж хошууч мэдчихэв бололтой. Ринальдийн туранхай царай цав цагаан духан дээрээ үс нь хав харлана.

-Ринальди минь зүгээ, зүгээр гэж лам хэлэв

-Чи тонилтугай. Ер нь юм бүхэн тонилох болтугай гээд Ринальди сандлынхаа түшлэгийг налав.

-Энэ их ажиллаад ядарсан байна гэж надад хандан хошууч хэллээ. Ринальди мах идэж дуусаад, таваг дээрх шүлтийг талхаар хамав. Тэгээд тэр нийтэд хандаж:

-Та нарыг би нулимаадпөнгөрнө. Ер нь хамаг юм бүхэн тонилох болтугай гээд уриалангуй янзаар эргэн тойрноо харахад нүд нь гөлрөн, нүүр нь цайрчээ.

-За яахав, хамаг юм бүхэн тонилох болтугай гэж би хэлэв.

-Үгүй ээ, тэгж болохгүй ээ. Тэгж болохгүй ээ. Чамд би тэгж болохгүй гэж байна шүү. Харанхуй хоосон хоёроос өөр юу ч алга. Өөр юу ч алга гэж байна шүү. Хов хосон. Үүнийг би ажил хийхгүй байхда мэддэг юм гэж Ринальди хэлэв

-Лам толгой сэгсэрч, мэдээчин халуун хоол харууна.

-Та яагаад мах идэж байна. Өнөөдөр баасан гэдгийг та мартлаа гэж үү? Хэмээн Ринальди эргэж ламаас асуув.

-Өнөөдөр Пүрэв гэж лам хэлэв

-Худлаа. Өнөөдөр баасан. Чи аврагчийнхаа махыг идэж байна. Энэ чинь ариун мах. Би мэднэ. Энэ чинь үхсэн австрийнх. Юу идэж байгаагаа мэдээ биз.

-Цагаан мах бол офицерийнх гэж би хуучны хошин үгийг санаж хэлэв.

Ринальди инээж аягаа дүүргээд:

-Миний үгийг бүү анхаар. Би жаахан дэмийрлээ гэв.

-Чи чөлөө авч явбал таарна гэж лам хэллээ. Хошууч дургүйцэн толгой сэгсрэв. Ринальди ламыг харна.

-Таны бодлоор бол би чөлөөгөөр явах хэрэгэти байна уу?

-Дураараа болооорой. Дургүй бол хэрэггүй гэж лам хэлэв.

-Чи тонилтугай.! Эд надаас хөндийрөх гэж хичээж байна. Орой болгон л эд надаас хөндийрөх гэж хичээж байна. Би зайлаад өгч болно. Хэрвээ би торгон өмд өмссөн байлаа гээд яагаав? Тогон өмд чинь хүн өүгдэд л байдаг зүйл. Дэлхий

дахинд байдаг зүйл гээд Ринальди цааш илтгэгчийн буурьтай ярьсан нь: эхлээд жижигхэн гүвдрүү гарна. Дараа нь цээж бэржрүүтнэ. Тэгээд л мэдэгдэх юмгүй болно. Хамаг найдвар мөнгөн усан дээр тохогдоно.

-Сальварсан ч байж болно гэж хошууч үгий нь таслан тайван өгүүлэв.

-Мөнгөн усны уусмал гээд Ринальди дуугаа ихэд өргөж ярьсан нь: Би арай илүүтэй мэднэ. Эрхэм сайн ламтан та хэзээ ч торгон өмд өмсөхгүй. Харин миний муу өвгөн өмснөө. Энэ бол үйлдвэрлэлийн оёол юм. Ердөө л үйлдвэрлэлийн осол гэсэн үг гэв.

Мэдээчин кофе цай болоод жимс өгөв. Жимс нь өтгөн юм. Дэнлүү тогтогтож хар тортог шилнээ сууна.

-Нааш нь лаа өгөөд дэнлүүгээ ав гэж хошууч хэллээ.

Мэдээчин, дийзэнд суулгасан хоёр лаа авчирч дэнлүүг авч яван үлээв. Ринальди тайвширч ухаан орсон мэт болж, бид цөм ярилцан суусаар кофе цай уугаад дотор үүдэнд гарав.

-За, би хот явлаа, баяртай лам бугай гэж Ринальди хэлэв.

-Баяртай Ринальди гэж лам хэлэв.

-Фредээ, дараа уулзъя гэж Ринальди хэлэв.

-За эртхэн ирээрэй гэж би хэлэв

Тэр царайгаа хачин болгоод гарч одов.

Хошууч бидэнтэй зэрэгцэж зогсоно.

-Энэ ядраад бас солиорчээ. Тэгээд бас өөрийгөө тэмбүүрсэн гэж бодоод байна. Би итгэхгүй байна. Гэвч байж болно. Тэгвэл тэмбүүгээ эмчилнэ биз. За Энрико баяртай . Чи үүрээр явах уу? гэж хошууч хэлэв.

-Тэгнэ.

-За тэгвэл баяртай. Сайн яваарай! Педуцци чамайг сэрээж хамт явна гэж тэр хэлэв.

-Баяртай.

-Баяртай. Австричууд довтлохоор бэлдэж байна гэсэн. Гэвч би итгэхгүй байна. Бодох ч дургүй байна. Тэглээ ч гэсэн эндээс хол. Жино чамд цөмий чинь ярина. Одоо утсан харилцаатай блсон.

-Би үргэлж утасдаж байна.

-Тэгээрэй, баяртай. Ринальдид архи бага уулгаарай.

-Хичээнээ.

-Баяртай лам гуай

-Баяртай.

Тэгээд тэрэрөөндөө оров.

[Тор](#)

---

Би хаалганы тэнд очиж гудамж руу харав. Бороо зогссон авч их манантай байлаа.

-Манай өрөөнд жаахан суух уу? гэж би ламд өгүүлэв

-Би тун удалгүй явах ёстой шүү.

-За яахав оръё

Бид шатаар өгсөн миний өрөнд оров. Би Ринальдийн орон дээр хэвтэв. Мэдээчний надад зассан орон дээр лам суув. Тасалгаанд харанхуй байлаа.

-Ер нь тэгээд бие чинь ямар байна даа гэж тэр асуув.

-Сайн. Өнөөдөр жаахан ядарлаа.  
-Би ч гэсэн зүгээр байж байгаад л ядарчихлаа.  
-Дайн юу болж байна?  
-Миний бодоход дайн удахгүй дуусна.  
Ер нь л нэг тэгэж санагдаад байх юм.  
-Яагаад тэр билээ?  
-Манай хошуучийн хувирсныг та анзаара уу? Номхорсон байна. Одоо ихэнх нь тийм болжээ.  
-би ч бас тийм гэж би хэлэв  
-Зун аягүй байсан гэж лам хэлэв. Тэр ламд урьд нь байгаагүй ер бусын итгэл буй болжээ. Тэгээд тэр ярьсан нь: юу болсныг чи төсөөлөх ч үгүй. Зөвхөн тэнд байсан хүн л төсөөлж мэднэ. Дайн гэдгийг энэ зун олон хүн ойлгосон. Ойлгох чадваргүй офицерууд ч одоо ойлгосон гэв  
-Одоо юу болох бол? гэж би алгаараа бүтээлэг илбэв.  
-Мэдэхгүй. Гэхдээ удтал ингэж үргэлжилж боломгүй санагдана.  
-Юу болох бол?  
-Дайтахаа болино  
-Хэн нь  
-Хэн хэн нь  
-Итгэж сууя гэж би хэлэв  
-Чи итгэхгүй байна уу?  
-Хэн хэн нь дайтахаа шууд зогсоно гэдэгт би итгэхгүй байна.  
-Тэгэлгүй аргагүй. Тэгвэл дэндүү амар юм болно. Гэхдээ хүмүүс юу болж байгааг харахаар л надад, удтал тэгэж боломгүй санагддаг.  
-Зун тэгээд хэн нь хожсон бэ?  
-Хэн ч хожоогүй.  
-Австричууд хожсон. Италичуудад тэд Сан-Сабриелийг алдаагй. Тэд хожсон болохоор дайтахаа зогсохгүй гэж би хэлэв  
-Хэрэв тэд бидэн шиг л байдалтай болсон бол болно. Тэд бас энэ бүхнийг туулсан шүү дээ.  
-Дайнд хожиж байгаа тал нь дайтахаа хэзээ ч болихгүй  
-Чи намайг төөрөлдүүлж байна.  
Би бодсоноо л ярьж байна.  
-Тэгвэл чи дайн зогсохгүй гэж бодож байгаа хэрэг үү?  
-Мэдэхгүй. Харин авчтричууд ялсан болохоор дайтахаа болих гэж бодож байна. Бидний христостонг тэд дийлж байна.  
-Бас австричууд чинь христостон шүү дээ. Барлагуу д нь л орохгүй.  
-Би христосын шашны тухай яриагүй. Христосын сүнсний тухайд ярьж байна гэхэд минь тэр дургүй байв.  
-Дийлдэл хүлээгээд бид цөм номхорчээ.  
-Хэрвээ Гефсиманы цэцэрлэгт Петрит аврагдсан бл христос бурхан ямар байхыг хэн мэдэх билээ?  
-Ийм л байна.  
-Итгэхгүй байна гэж би хэлэв  
-Чи намайг төөрөлдүүлж байна. Ямар нэгэн өөрчлөлт гарах ёстой. Тэгээд ч залбирдаг. Тэгэж байгаа нь мэдэгдэж байна гэж тэр давтав.  
-Ямар нэгшэн өөрчлөлт гарч болно. Харин зөвхөн бидэнд л гарна. Хэрэв тэдний байал бидэн шиг бол өөр хэрэг. Гэтэл тэд биднийг цхисон. Тэдний байдал өөр байна гэж би хэлэв  
-Манай цэргүүд ч үргэлж л тийм байсан. Одоо тэд цохигдсон гээдп өөр



болчихоогүй байна.

-Тэд эхлэхээс цохигдсон. Тэднийг газар тариалангаас нь салгаад цэрэг хувцас өмсгөхөөс эхлээд л тэд цохигдсон. Тариачид эхлээд ялагдсан болохоор цэцэн байгаа юм. Тэдэнд засгийн эрх өгөөд үз! Тэд жинхэнэ цэргүүд болох нь харагдана.

Лам ер хариу хэлэхгүй, бодлого болно.

-Миний ч сэтгэл бас хүнд байна. Тэгээд ч би ийм юмны тухай бодохоос зайлдаг юм. Энэ тухай би боддоггүй, гэвч яриа эхлэх болохоор аяндаа толгойд ороод ирэх юм гэж би хэлэв.

-Би ч ямар нэгэн юманд итгэлтэй явдаг шүү дээ.

-Ялагдалд уу?

-Үгүй ээ, өөр л их юманд

-Их юм гэж байхгүй. Яаад л байх хэрэг үү. Тэгвэл бүр чдор байж мэднэ.

-Ялна гэдэгт би ихээхэн итгэж явсан.

-Би ч адилхан

-Одо мэдэх ч юм алга

-Ялах ялагдах хоёрын нэг нь байх ёстой.

-Ялна гэдэгт одо би итгэхгүй.

-Би ч бас итгэхгүй. Гэхдээ ялагдана гэдэгт бас итгэхгүй байна. Илүүтэй ч байсан адилха.

-Тэгээд чи юунд итгэж байна?

-Нойрондоо гэж намайг хэлэхэд тэр босож

-Уучлаарай, цагийг чинь их үрчих шиг боллоо. Би чамтай ингэж ярихдаа дуртай гэв.

-Би ч тантай ярихдаа бас дуртай. Би нойрны тухайд л тоглоом болгож зүгээр тэгэж хэлсэн юм гээд би босож, бид харанхуйд гар барилцан салах ёс үйлдэв.

-Би одо гучин долоод унтаж байгаа гэж тэрхэллээ.

-Маргааш өглөөгүүр и харуулд очно.

-Ирэхээр чинь уулзана.

-Тэгээд ярьж зугаалъя гэж би түүнийг үүд хүртэл үдэв.

-Буугаад яах вэ. Өөрт чинь тусгүй ч гэсэн эргэж ирсэн чинь таатай байна гэж хэлээд тэр гараа мөрөн дээр минь тавив.

-Наадд ч зүгээр ээ, За баяртай гэж би хэлэв.

-Баяртай Giaou!

-Giaou! гэж би хэлэв. Нойр минь хүрэх гэж жигтэйхэн

[Top](#)

---

Ринальдийг ирэхэд би сэрсэн боби сэрсэн болловчовчовч т тэр үг дуугарсангүй тул би дахин уэр үг дуугарсангүй тул би дахин унтжээ. Үүр цайхаас өмнө би босож хувцаслаад явав. Намайг өрөөнөөс гарахад Ринальди сэрсэнгүй.

-Би урьд нь Байинзиццийг үзээгүй билэнтжээ. Үүр цайхаас өмнө би босож хувцаслаад явав. Намайг өрөөнөөс гарахад Ринальди сэрсэнгүй.

-Би урьд нь Байинзиццийг үзээгүй билээ. Мөнөөхөн өөрийн шархадсан эрэг дагуу явж, хавар австрийнхан эзлэн байсан налуугаар өгсөхөд хачин санагдав. Тэнд огцомхон шинэ зам зассан бөгөөд ачааны олон машин цувна. Сэрвэн даваад хажуу руу ороход ой болон манатай шовгор толгод харагдав. Тэр ойг түргэн эзэлсэн учир шатааж амжаагүй үлдээжээ. Толгод өнгөрөөд зам нь ил тул хоёр хажуу болон

дээгүүр нь сийсээр халх тавьжээ. Тэр зам эвдэрсэн тосгон хүрэх бөгөөд тэндээс байлдааны газар эхэлж, эргэн тойронд олон их буу зоожээ. Байшингууд нь хагас дутуу нурсан авч юм бүгдийг аятай тохируулан засаж, газар бүрий сум заасан самбар зүүжээ. Бид Жиноог хайж олов. Тэр биднийг кофе цайгаар дайлаад цугтаа гарч хүмүүстэй уулзан харуулуудыг эргэв. Английн машинууд түүнээс цааш Равнагийн тэнд ажиллаж байгаа гэж Жино хэлэв. Тэр тэгээд англичуудыгхэд магтав. Зарим заримдаа бас бууддаг. Гэхдээ шархтан бага гэж тэр хэлэв. Одоо бороо орохоор өвчтөн олширно. Австричууд довтолоход бэлтгэж байна гэж ярилцдаг боловч тэр итгэдэггүй гэнэ. Бид бас довтолгоонд бэлтгэж байна гэлцэх авч хүчин бэлдсэн явдал ер үгүй учир аанай итгэхэд хэцүү аж. Хүнсээр муу гэнэ. Тэгээд тэр Горициид хооллоход их дуртай байв. Өчигдөр ямар хол идсэн бэ? гэж тэр надаас асуулаа. Миний ярьсныг тэр ихэд таашаав. Ялангуяа жимслэгийн зүйл түүний санаанд онц нийцэв. Би тодорхой хэлэлгүй зүгээр л жимслэг гэсэн учир өчигдрийн миний хувьтаас илүү сайхан зүйлийг тэр төсөөлөн бодсон бололтой.

Өөрийгөө хааш нь явуулах бол? гэж тэр надаас асуув. Би мэдээгүй гээд ер нь ихэнх машин Капореттод буй гэлээ. Тийшээ тэр дуртайяа явах ажээ. Тэр тун сайхан хот агаад эргэн тойрны өндөр уулс нь түүнд таатай санагддаг аж. Тэр Жино хүн бүгдийн хайрыг татсан сайн хөвүүн билээ. Тэр хэлэхдээ: Ломыг авч гэж довтолоод муугаа үзсэн, Сан-Сабриелийн тэн ёстой том гэгч байсан гэв. Бидний ар болоод дээд талаар Герновын нурууны ой туждаа австрийн их буу дүүрэн байгаа бөгөөд шөнө турш зам руу бууддаг гэж тэр ярив. Тэдэнд тэнгисийн зэвсгийн батарей байдаг бөгөөд тэр нь түүний зүрхэнд оржосн гэнэ. Сум нь доогуур нисдэг тул танихад хялбар гэнэ. Буун дуу сонсогдмогц л сум нь исгэрч хоёр буугаар тасралтгүй ээлжлэн буудах агаад сум нь дэлбэрэхдээ том том хэлтэрхий үсчдэг гэнэ. Нэгэн фут урт бөгөөд шөвөг шиг үзүүр гарсан хэлтэрхийг нь наад тэр үзүүлэв. Тэр төмөрлөг нь цагаан тугалгатай төстэй юм.

-Тэд нэг их амжилт олно ч гэж би бодохгүй байнха. Гэхдээ аймшигтай юм. Сум нь яг л дээрээс буучих гэж байгаа юм шиг дуутай. Эхлээд дуу гарна. Тэр дороо л исгэрээд дэлбэрнэ. Айж үхсэнд орвол шархадсан нь дээр биз гэж Жино хэлэв. Бидний эсрэг одоо Кроат, Мажар нарын хороо буй гэж тэр хэлэв. Манай цэрэг аанай довтолгооны журмаар байдаг гэнэ. Хэрэв австричууд довтолон ирвэл ухрах газар үгүй. Харин нурууны арын намхан уулс хамгаалалтанд тохирох сайхан газартай боловч бэлтгэсэн юм ер үгүй гэнэ. Тэгээд Баинзиццэд надад ямар санагдсаныг тэр асуулаа.

-Энэ газар нуруу шиг ч уул шигч юм гэж би бодов. Би энэ газрыг ийнхүү таслагдсан гэж мэдээгүй билээ.

-Alto piano<sup>21</sup> болохоос piano<sup>22</sup> биш гэж Жино хэлэв.

-Тэгээд бид Жииногийн суудаг байрны зооринд ногийн суудаг байрны зооринд оров. Хэрэв уулын хэц нь тэгшхэн бол дээрээ олон хонхортой байж таарна. Тэгвэл жижиг уулсын салбараас хамгаалатанд хялбар бөгөөд ашигтай гэж би хэлэв. Тэгш газар орвол, ууланд довтолгоон арай хөнгөн гэж би ятгав.

-Уулын байдлаас б-Уулын байдлаас болно. Сан-Сабриелийг л бод л доо гэж тэр хэллээ.

-Тиймээ гэхдээ орой нь тэгшхэн хажуу налууухан болоод оройд нь гарахад зүйрлэшгүй хялбар гэж би хэлэв

-Тийм ч амаргүй шүү гэж тэр хэллээ.

---

<sup>11</sup> Уул нуруу гэсэн итали иг

<sup>22</sup> Тэгш тал гэсэн итали иг

-Тийм нь ч тиймээ. Гэхдээ тэр чинь онцгой тохиолдол шүү. Яагаад гэвэл тэр чинь уул биш цайз гэсэн үг. Австричууд олон жил тэнд бэхлэлт хийсэн гэж би хэлэв.

Дайн тулааны хөдөлгөөнтэй үед, уулсын салбарыг фронтын шугам болгох ньутгагүй юм. Уулс газрыг эзлэхэд хялбархан байдаг гэж би хэлбээр санагдлаа. Дээд зэргийн маневр хэрэгтэй болбол уулан маневр хийх хэцүү. Тэгээд бас дээрээс доош нь буудахад үргэлж дэгсэлдэг. Жигүүр тасрах хэрэг гарвал шилдэг хүч нь хамгийн өнгөж би хэлэв.

Дайн тулааны хөдөлгөөнтэй үед, уулсын салбарыг фронтын шугам болгох ньутгагүй юм. Уулс газрыг эзлэхэд хялбархан байдаг гэж би хэлбээр санагдлаа. Дээд зэргийн маневр хэрэгтэй болбол уулан маневр хийх хэцүү. Тэгээд бас дээрээс доош нь буудахад үргэлж дэгсэлдэг. Жигүүр тасрах хэрэг гарвал шилдэг хүч нь хамгийн өндөрлөг дээр үлддэг. Уулын дайнд би итгэл муутай. Би энэ тухай их бодсон гэж би ярив. Бид нэг уулан дээр байрлана. Тэд нэг уулан дээр байрлана. Тэгээд ёстой дайн эхэлвэл, хэн хэн нь уруугаа буух болно.

-Хэрэв уулан дээгүүр хил тогтвүлддэг. Уулын дайнд би итгэл муутай. Би энэ тухай их бодсон гэж би ярив. Бид нэг уулан дээр байрлана. Тэд нэг уулан дээр байрлана. Тэгээд ёстой дайн эхэлвэл, хэн хэн нь уруугаа буух болно.

-Хэрэв уулан дээгүүр хил тогтвол яах билээ? гэж тэр асуув

Түүнийг би арай бодож тогтоогоогүй гэж би хэлэв. Тэгээд бид хоёр инээлдэв

-Гэхдээ урьдын цагт австричуудыг Ёроны цайзны дөрвөн буланд үргэлж цохидог байсан. Тэднийг тэгш талд буулгаж ирээд цохидог байсан гэж би хэлэв.

-Тиймээ. Тэр чинь францчууд шүү дээ. Харин нутаг дэвсгэр дээр дайн хийхэд стратегийн асуудлыг шийдэхэд ямагт хялбархан байдаг юм гэж Жино хэллээ.

-Тиймээ. Өөрийн нутаг оронд энэ асуудлыг жинхэнэ шинжлэх ухааны ёсоор үзэх блолцоо байхгүй гэж би зөвшөөрөв.

-Наполеоныг торонд оруулах гэж оросууд чадсан юм.

-Гэхдээ оросын нутаг их шүү дээ. Италид Наполеоныг торонд оруулах гэж ухраад үз л дээ. Агшин зуурын адраа л чи Бриндизид хүрчихсэн байх буй.

-Зэвүүн хот шүү. Чи тэнд ер очсон уу? гэж Жино хэлэв.

-Зөвхөн явуутаар өнгөрсөн.

-Би эх оронч хүн. Гэхдээ Бириндизи, Таранто хоёрт би дургүй гэж Жино хэлэв

-Баинзицид чи дуртай юу гэж би асуув

-Энэ ариун газар. Харин энд төмс их тариасай гэж би хүсдэг. Биднийг ирэхэд энд Австричуудын суулгасан төмсний талбай байсан юм.

-Энд хүнсээр үнэхээр тийм муу юу? гэж би асуув.

-Би хувьдаа ер цадтал идсэнгүй. Би хоолонд сайн л даа. Гэхдээ өлсөөгүй. Офицерын хоол тааруухан. Тэргүүн барйанд онцгой хоолтой харин энэ шугаманд дэмжлэг муутай. Ямар нэг юмаар доголдоно. Хнс хүрэлцээтэй байх ёстой.

-Зувчуулагчид нэг тийш нь худалддаг биз.

-Тиймээ. Тэргүүн эгнээнд байгаа батальонд аль болох юм бүгдээ өгдөг. Ар талд ойр хэсэг

-Тиймээ. Өөрийн нутаг оронд энэ асуудлыг жинхэнэ шинжлэх ухааны ёсоор үзэх блолцоо байхгүй гэж би зөвшөөрөв.

-Наполеоныг торонд оруулах гэж оросууд чадсан юм.

-Гэхдээ оросын нутаг их шүү дээ. Италид Наполеоныг торонд оруулах гэж ухраад үз л дээ. Агшин зуурын адраа л чи Бриндизид хүрчихсэн байх буй.

-Зэвүүн хот шүү. Чи тэнд ер очсон уу? гэж Жино хэлэв.

-Зөвхөн явуутаар өнгөрсөн.

-Би эх оронч хүн. Гэхдээ Бириндизи, Таранто хоёрт би дургүй гэж Жино хэлэв

-Баинзицид чи дуртай юу гэж би асуув

-Энэ ариун газар. Харин энд төмс их тариасай гэж би хүсдэг. Биднийг ирэхэд энд Австричуудын суулгасан төмсний талбай байсан юм.

-Энд хүнсээр үнэхээр тийм муу юу? гэж би асуув.

-Би хувьдаа ер цадтал идсэнгүй. Би хоолонд сайн л даа. Гэхдээ өлсөөгүй. Офицерын хоол тааруухан. Тэргүүн барйанд онцгой хоолтой харин энэ шугаманд дэмжлэг муутай. Ямар нэг юмаар доголдоно. Хнс хүрэлцээтэй байх ёстой.

-Зувчуулагчид нэг тийш нь худалддаг биз.

-Тиймээ. Тэргүүн эгнээнд байгаа батальонд аль болох юм бүгдээ өгдөг. Ар талд ойр хэсэг нь л нь л хххэцүүхэн байна. Австрийэцүүхэн байна. Австрийн бүх төмсийг идэж дуусаад орчиндоо байгаа тиуулайн бөөр модн бүх төмсийг идэж дуусаад орчиндоо байгаа тиуулайн бөөр модны хамаг төглийг бас дууссан. Сайн хооллох хэрэгтэй. Бид бүгд л холонд сайн улс. Хүнс хны хамаг төглийг бас дууссан. Сайн хооллох хэрэгтэй. Бид бүгд л холонд сайн улс. Хүнс хүрэлцээтйүрэлцээтй б болно гэж би итгэж байна. Цэргийн хнс хүрэлцэхгүй тул муу байна. Хүмүүсийн сэтгэлд яаж нөлөөлдөг гэж та бодож байна?

-Тиймээ. Тэр чинь ч ялах бус ялагдахад түлхэц болно гэж би хэлэв.

-Ялагдлын тухай ярихаа больё. Ялагдлын тухай хангалттай ярилаа. Энэ зуны гүйцэлдсэн бүхэн дэмий ч биш байхаа. Би дуугарсангүй. “Ариун, алдарт, өргөл” гэх буюу “гүйцэлдсэн” гэдэг үгс дандаа миний дургүйг хүргэдэг юм. Бороод зогсох бүрдээ хашгирах дуу сонсдох газраас, бид тийм үгсийг сонсох буюу нэг зурагт хуудсан дээр нөгөөг нааж байхад нь бид тийм үгсийг уншдаг. Гэвч би ариун юмы нь үзээгүй. Алдартай гэсэн юм нь алдар лж чаддаггүй. Үхэл нь чикагийн ярганы газрыг тун их санагдуулах бөгөөд гагцхүү махыг энд зөвхөн газарт булна. Сонсоход дургүй хүрмээр үг зөндөө байдаг. Гагцхүү газар усны нэр л хэрэгтэй хэвээр үлджээ. Зарим дугаар, зарим он сар үлдсэн боловч газар усны нэрээ тэр бүрийн ач холбогдл тодорно “Алдар гавъяа, ялалт” “шүтээн” мэтийн хийсвэр үгс нь тосгоны нэр, замын дугаар, голын нэр хороны дугаар, он сар мэт оноосон нэртэй зэрэгцүүлэхэд өчүүхэн юм. Жино эх оронч хүн тул ярих болгондоо амлана. Тэр сайн хөвүүн бөгөөд түүний эх оронч үзлийг би мэднэ. Үзэлтэйгээ тэр хамт төрсөн юм. Грицин орохоор Жино Пуруццийн хамт машинд суув.

-Өдөржин шуурга тавив. Салхинд ус туугдаж, газар бүг тогтоол, шавхай болоод нурсан хананы шавардлага норж сааралтана. Үдэш болохын өмнөхөн бороо намдав. Хоёр дугаар харуулын тэндээс харахад намрын нүцгэн газар нойтрон, толгодын оройгоор үүлс нүүж зам дээр хэвтээ нойтон сүрлэн сийрснээс ус урсана. Нар шингэхийнхээ урдхантай нэгэн удаа үзэгдэж уулын хэцийн тэртээх нүцгэн ойг гийгүүлэв. Тэр хэсийн ой дотор австрийн олон бууч байсан авч хагас нь буудсангүй. Хажуугаар нь фронт байрлаж буй фермийн балгасны дээр тэнгэрт гэнэт их буугийн дэлбэлэх сумын өтгөн утаа манараад дунд нь цайвар шар юм эхлээд зуралзаж, нүргээн сонсдон, утааны хүрээ задран салхинд сарнив. Олон ти йм сум балгасан дунд, мөн харуул буй нурсан байшингийн дэргэдэх зам дээр унах бөгөөд энэ орой харуул буудалцсангүй. Бид хоёр машинд ачиж аваад, нарны сүүлчийн гэрэл завсраар нь туссан нойтон сийрсээр далдалсан замаар явав. Биднийг ил замд гарахад нар хэдүйн шингэжээ. Тэгээд бид эл замаар явж тохой тойроод, дөрвөлжин оройтой мэлхий хаалгаар орж явахад дахин бороо оров

Шөнө салхи ширүүжсэж, өглөөний гурван цагийн үед зүс борооноор дайсан буудаж Кроатууд уулын нуга гатлан манай байр руу шууд ирэв. Харанхуй борооноор тэд тулалдаж хоёрдугаар шугамын окопоос цэргүүдийг зоригжуулан эсрэг довтолгонд гаргаснаа ухраав. Бөмбөг дэлбэрч борооноор пуужин харван фронтын бүх шугам дагуу пулемёт, бууны гал үргэлжлэв. Тэд дахин ойртохыг оролдсонгүй, эргэн тойрон нам гүм болоод салхи борооны намдах завсарт тэртээхөйт зүгт шуурган гал

тасралтгүй сонсдоно.

Харуулын байранд шархтан ирцгээнэ. Заримы нь дамнуургаар зөөж, зарим нь өөрснөө ирж, зарим нь тулалдааны талбараас буцаж яваа нөхөд нь үүрэн авчирна. Тэд тасам бортлоо нороод айсандаа хий үзэгдэл шиг явна. Харуулын байрны зоринд хэвтэж байсан хүн шархтанг бид хоёр машин дүүрэн ачиж сүүлчийн машины хаалга хааж түгжихэд нүүрэн дээр минь цасан ширхэг унав. Бороо цас хутгалдан шавна.

Үүр цайхад шуурга намаагүй хэвээр, харин цас зогссон байлаа. Нойтон газар унасан цас хайлжээ. Дахиад л бороо орж эхлэв. Үүрээр биднийг дахин дайрсан боловч амжилт олсонгүй. Дахиад довтолох болбуу гэж бид өдөржин хүлээсэн боловч нар жаргатаг нам тайван байлаа. Харин өмнө зүгт, австрийн их бууны төв болсон ойтой уулын урт хэцийн тэнд буудаж эхлэв. Биднийг буудах болов уу гэтэл буудсангүй. Харанхуй боллоо. Манай зэвсэг тосгоны хойт талд байсан бөгөөд сумны исгэрэх дуунд сэтгэл амсхийнэ.

Дорно зүгийн довтолгоон амжилтгүй болсныг бид сонсов. Тэр шөнийн довтолгоон онцгүй боловч хойт талын фронт сэтэрчээ. Биднийг ухрахад бэлтгэж гэж шөнө мэдэгдэв. Энэ тухай ахмад надад хэлэв. Тэр бригадын штабт очиж утсаармэдээ авахаар яваад төдөлгүй цөм худал байна гэжхэлж ирэв. Баинзиццийн байрыг яасан ч алдаж болохгүй гэж штабт тушаал иржээ. Сэтэрхийний тухай намайг асуухад Капореттогийн чиглэлээр хорин долдугаар армийн корпусын фронтыг австриууд сэтэлсэн байх гэж штаб ярьж байна... Хойт зүгт өчигдөр өдөржингээ ширүүн тулалдсан гэнэ гэж тэр хэлэв.

-Хэрэв энэ гөлгүд тэднийг оруулчихвал бид торонд рно гэж тэр хэлэв.

-Энэ германууд довтолж байгаа гэж нэг эмч хэлэв. "Герман" гэдэг үг айдас хүргэнэ. Бид германуудтай үзэлцэх ер дургүй.

-Тэн германыарван таван дивиз бий. Тэд сэтэлсэн. Бид ингээд таслагджээ гэж эмч хэлэв.

-Энэ байрыг бид огт алдаж болохгүй гэж бригадыын штабт ярьж байна.

-Сэтэрхий онц бус, харин бид одоо Монте Мажороос нааш уул дагуух фронтын шагамыг авах болж гэж ярьж байна.

-Энэ мэдээг тэд хаанаас аваа вэ?

-Дивизийн штабаас

-Ухрахад бэлдэх хэрэгэй гэсэн мэдээг бас дивизи йн штабаас авсан.-

-Бидний захиргаа бол армийн штаб. Харин энд миний захиргаа бол та юм.

Хэрэв та намайг яв гэвэл би явна.

Ямар тушаалтайг тодорхой хэлж өгөөч гэж би хэлэв.

-Бид эндээ байх тушаалтай. Та бол шархтанг хуваарилах салбарт зөөх үүрэгтэй.

-Хуваарилах салбараас хээрийн цэргийн эмэлэгт зөөх явдал бидэнд ямагт тохиолддог. Харин ухрахыг би ер үзээгүй юм. Хэрэв ухарвал бүх шархтанг яаж зөөдгийг надад хэлж өгөөч гэж би хэллээ.

-Бүгдийг авахгүй. Чадлынхаа хирээр авна. Бусды нь орхино.

-Би машиндаа юу ачих билээ.?

-Эмнэлгийн төхөөрөмж

-Мэдлээ гэж би хэлэв

Маргааш шөнө нь ухарч эхлэв. Хойт зүгт герман австричууд фронт сэтлээд уулын хавцгайгаар Чивидал, Удин тийш яваа нь илэрхий болов. Бороон дундуур зохион байгуулалттай, намуухан, бүргэр ухарцгаав. Тахирласан замаар шөнийн борооноор цэрэг, зэвсэг алгуурхан өнгөрч морь, луус хөллөсөн тэрэ, ачааны машин цөм фронтоос холдон явах нь харагдана. Урагш давшихаас арай журамтай аж.

Тэр шөнө бид уулын тосгонд байрласан цэргийн хээрийн эмнэлгийг буулгаж

ачихад туслан, шархтанг Плав тийш зөөж, маргааш нь өдөр туж Плавын хуваарилах салбар, цэргийн эмнэлгийг татв. Бороо цутгана. Арван сарын борооноор Баинзиццын арми уулаас бууж энэ оны хавар ахны их ялалт хийсэн газраараа гол гатлав. Маргааш нь үд дунд бид Горицийд ирлээ. Бороо намжаад хот бараг эзгүйчээ. Гудамжаар яваж байтал цэргийн янхны газрын хүүхнүүдийг тэсэн ачааны машин харагдав. Тэр долоон хүүхэн бүрх малгай, пальто өмсөж жижигхэн хайрцаг барьж, хочр нь уйлах агаад нэг нь биднийг харж инээн, хэлээ гаргаж годгонуулна. Тэр хүүхэн хөөнгө зузаан ураалтай, хар нүдтэй юм.

Би машинаа зогсоож гараад эзэгтэйтэй нь ярив. Офицерын газрын хүүхнүүд өглөө эрт гарсан гэж тэр хэлэв. Хаашаа явж буйг нь би асуув. Коньеляно орно гэж тэрхэлэв. Тэр ачааны машин хөдлөхөд сайхь зузаан уруулт дахин бидэнд хэлээ гаргав. Эзэгтэй гараар даллаж байна. Хоёр хүүхэн нь уйлсаар бусад нь хот сонирхон харна. Би машиндаа суув.

-Эдэнтэй цуг явахсан. Хөгжүүн аян болно доо гэж Бонелло хэлэв

-Манай энэ аян ч хөгжүүн болноо гэж би хэллээ.

-Адгийн болно

-Би чгадарлаж байна гэж би хэлэв

Манай байшин тийш очдог өргөн гудамжаар бид явлаа.

-Энэ үнхэлцгүүд байрандаа бууж ажлаа хэлхээр нь очих юмсан.

-Эднийг шууд л ажлаа эхэлнэ гэж та бодож байна уу?

-Бас уу? Энэ эзэгтэйг хоёрдугаар армид хэн эс мэдэхсэн билээ. Бид байрныхаа үүдэнд ирэв.

-Тэр эзэгтэйг ширээт ээж гэдэг юм. Түүнийг хүн бүгд мэднэ. Хүүхнүүд нь шинэ юм. Тэднийг лав, ухрахын өмнөхөн авчирсан биз ээ гэж Бонелло хэлэв.

-Одоо ажиллацгаанаа

-Ажиллацгаанаа гэж би хэлж байна шүү дээ. Тэдэнтэй би үнэгүй зугаалахсан даа. Гэхдээ тэд тэнд байшинд нохойтдог улс маань биднийгээ шулж байна.

-Машинаа аваач. Механикч үзэг. Масло сольж, дифференциалы нь шалган үзэж янзлаад жаахан унтаж болно гэж би хэлэв.

-Мэдлээ гэлээ.

Байшин эзгүйрчээ. Ринальди цэргийн эмнэлэгтэй цуг яваад, хошууч штабын машинаар эмнэлгийнхнийг аваачжээ. Отор үүдэнд хураасан төхөөрөмжийг ачаад Порденти тийш дагаарай гэж надад цонхон дээр зувас орхисон байв. Механикчид хэдүйн явжээ. Би гарашид ирлээ. Тэндээс намайг байшин тийш явахад нөгөө хоёр миашин ирээд жолооч нар нь хашаан дотор зогсоно. Бороо дахин шиврэв.

-Плаваас ирэх замдаа би нойр хүрээд гурван удаа унтчихжээ. Дэслэгч минь одоо юу хийх вэ? гэж Пиани хэлэв

-Масло сольж тосолллж янзлаад гол үүдэнд ирж бидэн үлдээсэн эрдэнэсийг ачна

-Тэгээд шууд явах уу?

-Гурван цаг унтана.

-Унтах сайхаан. Тэгэхгүй бол би жолооны ард унтчи байх гэж Бонелло хэлэв.

-Машин чинь ямар байна, Аймо гэж би асуу

-Зүгээр

-Надад савхин дээл аль, би чамд тусалъя.

-Хэрэггүй ээ, дэслэгчээ. Ялихгүй юм. Та явж юмаа бэлд гэж Аймо хэллээ.

-Миний юм бэлхэн. Би явж тэдний үлдээсэн тэр бүх новшийг зөөе. Засангуутаа машинаа аваачаарай гэж би хэлэв.

Тэд машинаа байшингийн гол хаалганд авчирч, дотор үүдэнд хураасан эмнэлгийн юмсыг бид ачив. Төдөлгүй ачиж гүйцээд машинууд, цэцэрлэгт гудамжны

моддын дагуу бороонд зэрэгцэн зогсов. Бид байшинд орлоо.

-Гал зуухны өрөөнд гал түлээдхувцсаа хатаа гэж би хэллээ.

-Нойтон ч байсан яахав. Унтмаар л байна гэж Пиани хэлэв.

-Би хошуучийн орон дээр хэвтье гэж Бонелло хэлэв.

-Надад унтах газар алга гэж Пиани хэлэв.

-Тэнд хоёр ор байна гэж би хаалга онгойлгов.

-Би энэ тасалгаанд ер орж үзээгүй гэж Бонелло хэлэв.

-Энэ чинь хөгжих бахын тасалгаа гэж Пиани хэллээ.

-Тэнд хоёулаа хэвт. Би сэрээнэ гэж би хэллээ.

-Дэслэгч ээ, уучлаарай. Австричууд ч биднийг сэрээж болдох юм гэж Бонелло хэлэв.

-Унтчихгүй ээ. Аймо хаана байна? гэж би хэлэв

-Галын зуухны өрөөнд орсон.

-Хэвтэж унтацгаа гэж би хэлэв.

-Хэтлээ. Би өдөржин суугаар унтсан. Духасхийгээд л байсан гэж Пиани хэллээ.

-Гутлаа тайл. Энэ бахын ор уу? гэж Бонелло хэлэв

-Бахыг би нулимаад өнгөрнө.

Пиани орон дээр хэвтэж шавхайтай гутлаа жийж гараа дэрлэв. Би галын өрөөнд орло. Аймо гал түлээд тогоотой ус тавьжээ.

-Жаалхан мянтууз бэлдье. Сэрээд юм идмээр санагдана гэж тэр хэлэв.

-Баортоломео чи унтахгүй юм уу?

-Яахав ээ. Ус буцлахаар би явна. Гал аяндаа унтарна из.

-Йунтсан чинь дээр биз. Лаазтай мах бялаг идэхэд болно гэж би хэллээ.

-Энэ нь дээр байхаа. Цаад хоёр замбараагүйг чинь таваг халуун юмаар тэтгэе.

Харин та унтаж хэвт гэж тэр хэлэв.

-Хошуучийн өрөөнд ор бий.

-Та тэнд хэвт

-Би хуучин өрөөндөө орно. Бартоломео чи архи ууна уу

-Дэслэгч ээ, явахдаа л ууя. Одоо надад хэрэггүй.

-Хэрэв гурван цагийн дараа сэрэхэд чинь би унтаж байвал сэрээгээрэй.

-Надад цаг байхгүй.

-Хошуучийн өрөөнд хананы цаг бий.

-За.

Би гуанз болон дотор үүдний өрөөгөөр өнгөрч, гантиг шатаар өгсөөд Ринальди бид хоёрын сууж байсан өрөөнд оров. Бороо орж байлаа. Би очиж цонхоор харав. Бүрэлзэх харанхуйд миодны доор цувран зогссон гурван машин ялгаран модноос ус гожиж, хүйтэнд мөчрөөс дусал бөнжийнө. Би Ринальдийн орон дээр хэвтмэгц нам унтав.

Явахынхаа өмнө бид гал тогооны өрөөнд орж холлов. Аймо сонгинотой мянтууз бэлдээд лаазалсан мах задалж шөл хийжээ. Бид ширээ тйрон сууж, байшингийн зооринд нөөцлөн үлдээсэн дарснаас хоёр лонхийг уув. Хэдүйн нь хав харанхуй болоод бороо орсоор байна. Пиани ширээний дэргэд бүр үүргэлэн сууна.

-Надад довтлохоос ухрах нь аятай байна. Ухрах үедээ бид барбера дарс ууж байна гэж Бонелло хэллээ.

-Одоо л бид тэгэж байна. Маргааш бид борооны ус уух болно гэж Аймо хэлэв.

-Маргааш бид Удинд очно. Бид шампан дарс ууна. Тэнд хамаг залхуучууд бий.

-Пиани минь сэрээрэй! Маргааш бид Удинд шампан дарс ууна.

-Би унтаагүй байна гэж Пиани хэлэв. Тэгээд тэр тавгандаа мянтууз, мах хийж хэлсэн нь: Барто, улаан лоолийн шүлт байхгүй байна гэв.

-Олдсонгүй гэж Аймо хэлэв.









- Удин хүртэл л тамд залгиулалгүй амар мэнд яваасай гэж Пиани хэлэв.
- Дэслэгч, та цадав уу гэж Аимо асуулаа.
- Цадсан. Бартоломео, лонхоо нааш явуул.
- Надад бас аваад явах нэг ллонх юм бий гэж Аимо хэлэв.
- Чи ер унтаагүй юу?
- Би их унтах дургүй. Жаахан унтсаан.
- Маргааш бид хатан хааны орон дээр унтана гэж Бонелло хэлэв. Тэр тус их сэргэжээ.
- Маргааш бид тамд ч унтаж мэднэ гэж Пингаи хэллээ.
- Би хатан хаанта унтана гэж Бонелло хэлээд шог яриагий нь намайг юу гэж бодсон бол гэсэн язтай эргэж над өөд харав.
- Чи эрлэгтэй цуг унтана гэж Пиани үүрлэж өгүүлэв
- Дэслэгч ээ, энэ чинь улсаас уравсан хэрэг. Энхэ чинь уравсан хэрэг мөн биз дээ гэж Бонелло хэллээ.
- Дуугүй байцгнаа. Дусал дарсанд дэндүү дийлдэж байна шүү гэж б хэлэв. Бороо улам ширүүсэв. Цагаа харвал есөн цаг хагас болж байна.
- Явах боллоо гээд би босов.
- tenente та хэнтэй нь явах вэ? гэж Бонелло асуув
- Аймотой. Дараа нь чамтай. Тэгээд Пианитэй явна. Замдаа Кормонсоор орно.
- Би унтчих байх гэж айж байна хэмээн Пинаи хэлэв.
- Тэгвэл би чамтай явъя. Дараа Бонеллотой , тэгээд Аймотой явъя.
- Энэ л зүйтэй байна. Тэгэхгүй бол би бүр унтчихна гэж Пиани хэллээ.
- Би машины чинь жолоодъё. Чи жаахан унт даа.
- Тэгэхгүй ээ. Хэрэв унтвал сэрээх хүнтйгээс хойш би өөрөө жолоодож чадна.
- Би чамайг сэрээнээ. Барто гэрлээ унтраа.
- Асаж л байг. Бид дахиад энд ирэх биш гэж Бонелло хэлэв.
- Миний өрөөнд жижиг хайрцаг бий. Пиани чи авчралцаж өгөөч гэж би хэлэв.
- Альдо хоёулаа яваад аваад ирье гэж Пиани хэлээд Бонеллош,тйн хамт гарч шатаар өгсөх нь сонсдоно.
- Энэ сайхан хот шүү гэж Бартоломео Аимо хэлээд даалитндаа хоёр лонх дарс, тал дугуй бяслаг хийж:
- Өөр ийм хотыг бид дахиад олохгүй, дэслэгч ээ, бид хаашаа ухрах юм бэ? гэж асуув
- Тальяментогоос цааш гэж дуулдсан. Цэргийн эмнэлэг, штаб хоёр Порденонд байрлана.
- Тэнд Порденорноос илүү.
- Би Порденорноос илүү.
- Би Порденонд байгаагүй. Дэргэдүүр нь л өнгөрсөн эгж би хэлэв.
- Тааруухан хотын нэг дээ гэж Аимо хэллээ.

[Тор](#)

---

Биднийг Горицийгоос гарахад бороо орж хотод харанхуй агаад эзгүй. Гагцхүү төв гуамжаар цэрэг зэвсгийн цуваа өнгөрнө. Бусад олон ачааны машин, тэрэг өөд гудмаар ярьж засмал дээр нийлнэ. Элдүүрчний байшинг өнгөрч, бид, цэрэг, зэвсэг, ачааны машин, даачаа тэрэг нэгэн өргөн цуваа болж алгуур явж бүхий засмал зам

дээм гарав. Дээрээ ачаа ачиж нойтон брезентээр бүтээсэнг ачааны машины араас радиатораараа бараг тулан алдаж борон дундуур бид алгуур боловч зогсолтгүй явна. Ачааны машин гэнэт зогсход бүх цуваа зогсоно. Цуваа дахин хөдөлж, бид хэсэгхэн явснаа бас л зогсов. Би бууж, ачааны машин даачаа тэрэгний хоорондуур, морьдын нойтон хошуун доогуур зайчлан урагш гарав. Тэртээ урд л саатал гарсан бололтой. Би замаасаа эргэж банзан гүүртэй сувгаар гараад сувгийн хөвөөнөөс цааших талаар явлаа. Замаас холдон явахад боронд зогссон цуваа модны хоорондуур харагдсаар л байлаа. Өи нэг бээр орчим явлаа. Цуваа зогссоор л байна. Үл хөдлөх хөсөгний цаагуур цэргүүд цувна. Би машиндаа эргэж ирлээ. Бүр Удинд тулж ирээд ч саатал гарсан байж болох юм. Пиани жолоогоо түшээд унтаж байна. Би дэгэд нь сууж бас унтав. Хэдэн цагийн дара урд талын ачааны машиныг асааж буй чимээг би сонсов.

Би Пианийг сэрээгээд бид хөдөллөө. Урагш хэдхэн ярд яваад дахин зогсож дахин хөдөлнө. Бороо орсоор л байна.

Шөнө нь цуваа аанай л нам зогсов. Би бууж Бонелло Аймо нартай уулзахаар хойш явав. Бонеллогийн машинд инженерийн ангийн хоёр түрүүч суужээ. Намайг очиход тэр хоёр хулгасхийв.

-Эднийг гүр зас гэж үлдээсэн юм байна. Тэгээд ангиа олохгүй байгаа юм байна. Би хүргэж өгье гэж суулгасан юм гэж Бонеллоо хэлэв.

-Ноён дэслэгч зөвшөөрнө үү гэхэд нь

-Болноо гэж би хэлэв.

-Манай дэслэгч америк хүн болохоороо дуртай хүнээ суулгадаг юм гэж Бонелло хэлэв.

Нэг түрүүч нь инээв. Нөгөө нь намайг өмнөд америкийн итули уу, хойт америкийн итали уу гэж Бонеллоос асууж байна.

-Энэ итали биш. Хойт америкийн анги хүн гэв.

-Тэр хоёр анхааран сонсовч үл шнэмшинэ. Би цааш Аймо руу явав. Аймо тамрхи татн булан налж, дэргэд нь хоёр хүүхэн суужээ.

-Барто Барто! Гэж намайг хэлэхд тэр инээмсэлэв.

-Дэслэгч ээ, эдэнтэй яриач! Би хэл нэвтрэлцэхгүй юм гээд тэр: хүүш гэж нэг хүүхний н гуян дээр гараа тавьж дотночлон базна. Толгойгоо алчуураар ороож хулдсан тэр хүүхэн гары нь түлхэв. Тэгээд

-Хүүш! гэснээ тэр: Дэслэгч та нар хэн гээг, юу хийдэг вэ? гэж асуугаач гэв.

-Тэр хүүхэн намайг сонирхон харав. Нөгөө хүүхэн нь хөдлөлгүй сууна. Намайг харсан хүүхэн нутгийн аялгаар юм хэлсэн авч би нэг ч үг ойлгосонгүй. Тэр хүүхэн бор царайтай, арван зургаа орчим насны бололтой.

-Sorella<sup>23</sup> гэж хүүхнийг зааж асуухад тэр толгой дохин инээмсэглэв.

-За гээд би тэр хүүхний өвдгий нь нь илбэв. Биед нь хүрэхэд тэр хүүхэн биеэ хураав. Тэр хүүхэн доошоо харсаар байв. Нөгөөдөхөөсөө нэг насаар дүү болов уугэлтэй. Аймо том хүүхний нь гуян дээр ахин гараа тавьсанд гары нь түлхэв. Тэгээд Аймо инээн өөрийгөө зааж.

-Би сайн хүн шүү гээд намайг зааж:

Энэ хүнээс айх хэрэггүй гэв.

Хүүхнүүд Аймо тийш хялайнхарахад тэр хоёр зэрлэг шувуу мэт байв.

-Хэрэв надад л дургүй байгаа юм бол яах гэж энэ надтай явсан юм бэ? гэж асуугаад Аймо ярьсан нь: намайг затмагц л эд машинд авчирсан гээдхүүхнүүд рүү эргэж:

---

<sup>11</sup> Сувилагч гэсэн итали

-Битгий ай. Хэн ч чамайг ... хаана ч яах ч үгүй... гэж эвгүй үг хэлээд –Энэ хүүхэн үг ойлгох шиг л болсон. Өөр яагаач үгүй гэв. Аймаг харж байснаа тэр хүүхний нүдэнд айдас тодроод алчууртаа толгой нь бүр шургав.

-Дүүрэн машин байхад, хэн чамайг... хаан ч ... яах ч үгүй гэж Аymo хэллээ. Тэр үгийг хэлх бүр хүүхнүүд биеэ хураана. Биеэ хураан хураасаарширтэж байснаа тэр хүүхэн уйлж, уруул нь таталдан, дугариг хацар дээгүүр нь нулимс бөмбөрөв. Сувилагч хүүхэн доош харсан хэвээр нөгөөгийнхөө гараас барьж шахан суув. Урьд нь тийм догшин байсан том нь эхэр татан уйлав.

-Айж шүү. Айлгах гэж бодоогүй юмсан гэж Аymo хэлэв.

Тэгээд тэр даалингаа авч хоёр зүсэм бяслаг зүсээд:

-Май, бүү уйл гэв.

Том хүүхэн нь толгой сэгсэрч уйлсаар харин бага нь бяслаг авч идэж эхлэв. Тэгээдтэр хэсэг байснаа нөгөөхдөө бяслаг өгч хоёул дуугүй иднэ. Том хүүхэн мөн хааяа эхэр татсаар байлаа.

-Зүгээр зүгээр тайтгарна гэж аymo хэлэв. Тэгээлд түүнд нэг бодол төрсөн бололтой.

-Чи хүүхэн үү? Гэж дэргэдээ суугаагаас асуув. Тэр хүүхэн толгой дохиж байна.

-Чи бас хүхэн үү? Гэж томыг нь зааж мөн асуув. Хоёул толгой дохиод том нь нутгийн аялгаар юм хэлэв

-За за яахав гэж артоломео хэллээ. Тэр хоёр хүүхэн сэргэв бололтой.

Машиныхаа буланг залж суусан Аymoг тэдэнтэй орхиод бти Пиани тийш эгэж ирэв. Хөсгийн цуваа хөдлөлгүй зогсож, дэргэдүүр нь цэргүүд тасралтгүй йцувна. Ороо орсоор л байв. Цуваа ингэж зогсох нь ихэвчлэн машины утас норсноос болдог, заримдаа ч иолрь хүн явуут унтсанаас болдог гэж би бодов. Тэрчлэн хэн ч явуут унтдаггүй хотод ч саатал гардаг шүү дээ. Ингэж саатахын учир гэвэл авто хөсөг, ердийн, хөсөг хоёрыг хольсноос болж байна. Тариачдын хөсөг тэрэгнээс ашиг бага гарна. Артогийн тэр хүүхнүүд сайхан юм. харч буйармид тийм ариун бүсгүйчүүд байх ёсгүй. Хоёулаа ариухан бүсгүй байна даа. ас тэд бишрэлтэй бололтой. Дайн үгүйсэн бол өдийд бид ор орондоо хэвтэж байгаа даа. Орондоо дахиж хэвтэнэ. Кэтрин одоо нэг цагаан даавуугаа дэвсэж,наг цагаан даавуугаа нөмөрсөн хэвтэж байгаа даа. Аль талаараа унтаж байгаа бол? Сэрүүн байгаа болов уу? Орондоо миний тухай бодож байж ч магадгүй. Салхилаач умрын салхи минь салхилаач. Салхи хөдөллөө. Үүлс нүүж ширүүн бороо асгарлаа. Шөнөжингөө боро орлоо. Үүл хурж шөнөжингөө бороо цутгана гэж чи минь мэдсэн биз дээ. ороо цутгахыг хараач. Хонгор минь энд надтай нэг оронд хэвтдэг ч болоосой. Хонгор Кэтрин минь байгаасай. Аянчин үүлс миний хонгорыг авчраасай. Салхи минь хонго Кэтринг минь надад авчраач. Ид хоёр учиралдлаа. Ертөнц дээр юм бүхэн учиралдлаа. Ороо оровч гал унтрахгүй.

-Кэтрин минь тавтай нойрсоорой.

Сайхан унтаарай гэж би чанга хэлэв

-Найз минь эвгүй байвал нөгөө талаараа хэвтээрэй гэж би хэлэв.

-Би чамд хүйтэн ус авчиръя. Удахгүй өглөө болно. Чи амардаа. Чамайг эвгүй байгаа байх гэхээс би зовох юм.

Хайрт минь унтаж үз.

Би сэрэхгүй унтаж байна гэж тэр хүүхэн хэлэв. Чи унтаагаараа ярьсан. Ие чинь муу байна уу?

-Чи энд байна гэж үү?

Тэгэлгүй яахав. Хаашаа ч явахгүй. идэнд өөр юм ер хамаагүй.

Чи минь ийм л сайн сайхан хүүхэн шүү. Чи шөнө явчихгүй биз?

-Яалаа гэж би явах билээ. Би дандаа энд байна. Би чамтагаа юу ч болсон үргэлж цуг байна.

-Хүүш чи...! Явъя гэж Пиани хэллээ.

-Би зүүрмэглэжээ гэж хэлээд би цагаа харвал өглөөний гурван цаг болж байв. Тэгээд нэг лонх барбера дарс авахаар би суудлын ар өөд зүтгэв

-Та зүүдэлж ярьсан гэж Пиани хэлэв

-Би англиар зүүдэлсэн гэж би хэлэв.

Бороо жаахан намждаж бид ч урагш хөдлөв. Үүрийн өмнөхөн бид дахин зогсож, үүр сайн цайсан хойно үзэхүл: бяцхан өндөрлөг дээр байх агаад тэртээ урагш ухрагсдын цуваа жирийн, цаагуур нь явган цэрэг цувж буй хөсөг дүүрэн зогссон засмал зам нилээд харагдана. Би дахин хөдлөв. Өдөр болсон болохоор хир түргэн яваагаа харж, ер Удинд хүрье гэвэл засмалаас гараад цэх замаар явах хэрэгтэй юм байна гэж би бодов.

Цуваанд шөнөдөө зам зуураас олон тьяриачин нийлж, гэрийн хогил ачсан морин тэрэг явж гудсан завсраас толь цухуй, ар талд нь нугас тахиа даруулсан байна. Бидний урдхантай яваа даачаан дээр оёдлын оёдлын машин бороонд ил тавьжээ. Хүн бүр үнэтэй цэнэтэй юмаа авч ваа аж. Борооноос нуугдан биеэ бүтээж зарим тэргэн дээр хүүхнүүд суух бөгөөд бусад нь холдохгүйг хичээн дэргэдүүр н алхална. Нохиод даачаан доогуур хоргодон дагаж гйнэ. Засмал замыг шавхай бүрхээд сувгаар ус дүүрч, модны цаадахь талын хөрс болон чулуужсан засмал дэндүү нойион, зууралданги учир шулуун явна гэхээс зүрх үхмээр байв. Би машинаас буж хажуу тийшээ гарах аятай зам хайж урагш хэсэг явав. Хажуу тийш гарсан зам олон тул эзгүй зам таарчих буй гэж би болгоомжлов. Тэдгээр замыг би олонтаа үзсэн боловч урьд нь үүгээр машинаар давхиут өнгөрдөг байсан тул адилхан замын алиныг ч мэдэхгүй балаа. Гагцхүү зорьсон газартаа хүрэх эсэх н замаа зөв сонгосноос болно гэж л би мэдэж байв. Эндүгээ эвстричууд хаана буй, мөн цагийн байдал ямар нь илэрхийгүй авч бороо арилбал цуваан дээгүүр онгоц эргэлдэж, хамаг юм өнгөрнө гэдгийг би баттай мэдэж байлаа. Хэдэн машин жолоочгүй хоцорч, хэдэн морь үхлээ ч гэсэн, замын хөдөлгөөн б үрмөсөн зогсох болно.

Бороо орох нь зөөрөлчжээ. Удахгүй бороо арилж ч магадгүй гэж би бодов. Тэгээд урагш жаахан явж, тал дундуур умар зүг одсон хоёр талаараа модтой нарийн зам хүрээд түүгээр явахаар шийдэж машиндаа яаран ирэв. Хаагуур гарахыг би Пинаид хэлээд Аймо, Бонелло хоёрт зааж өгөхөөр явав.

-Энэ зам хэрэв эзгүй байвал бид эргэж цуваандаа нийлнэ гэж би хэллээ.

-Эднүүсийг яахав? гэж Бонелло асуув Сайхь түрүүчүүд цуг суусаар аж. Тэд сахлаа хусаагүй боловч эл өглөөгүүрч гэсэн үнэхээр цэргийн хүн шиг харагдана.

-Машин түрэхээр болбол хэрэгтэй шүү дээ гэж би хэллээ. Тэгээд би Аймо тийш очиж шулуун замаар явах тухайгаа ярив.

-Энэ охин дэгдээхэнүүдийг яаж билээ? гэж Аймо асуув. Хоёр хүүхэн унтаж байв.

-Эд ашиг багатай. Харин машин түрэхэд туслах хүчин авбал дээр биз гэж би хэлэв.

-Энэ хоёр дээр сууг. Ар талд тэвшин дотор зай бий гэж Аймо хэллээ.

-Тэгвэл яахав тэгэг. Туслах хүчин харин хахархан хүн аваарай гэж би хэлэв.

-Торгон цэрэг гэж Аймо инээгээд Торгон цэргүүд хамгийн ханхар байдаг юм.

Тэдний цээжээр хэмжээ авдаг юм. Дэслэгч таны бие ямар байна? гэж асуув.

-Сайн. Чи яаж байна?

-Сайн. Их л өлсөж байна.

-Энэ замаар жаахан яваад зогсож юм ирье.

-Дэслэгч таны хөл ямар байна?

-Сайн байна гэж би хэлэв.

Гишгүүр дээр зогсоод урагш харахад, Пианийн машин цуваанаас гарч, нүцгэн мөчрийн сүүдэр туссанх зөрөг замаар эргэн, Бонелло дагаж Аимо бид хойноос нь явав. Тэр зам тариачны байшин ордог ажээ. Пиани, Бонелло хоёрын машиныг хашаан дотор орсон хойно бид очив. Урт намхан байшингийн үүдэн дээгүүр усан үзмийн иш саглайн унжина. Пиани хашаан доторхи худагнаас радиатораа дүүргэхээр ус авчээ. Бага хурдтай цдаан явснаас ус нь буцалж гүйцжээ. Тэр байшинээгүй аж. Би зам тийш эргэж харлаа. Тэр байшин толгойн орой дээр учир эргэн тойрон алсыг харж болох бөгөөд зам, хашлага, тал болон ухрагсад цувж буй засм алын дагуудахь модод бидэнд харагдана. Хоёр түрүүч байшинд оров. Хүүхнүүд сэрж, байшин, худаг болоод башингийн өмнө зогсож буй эмнэлги йн хоёр том машин, худгийн дэргэдэх гурван жолоочийг ажиглан харав. Нэг түрүүч байшингаас ханын цаг барьсаар гарч ирэв.

-Буцааж тавь гэж би хэллээ.

Намайг харснаа тэр эгэн ороод хоосон гарч ирэв.

-Нөхөр чинь хаачсан бэ? гэж би асуулаа.

-Бие касах газар явсан гээд тэр биднийг орхичих байх гэж айсан бололтой машины суудал өөд авирав.

-Дэслэгчээ, өглөөний цайгаа уух уу? Жаахан юм идэцгээх үү? Даан их удахгүйц байх гэж Бонелло асуулаа.

-Тийшээ явсан зам хаана хүрдэг бол?

-Нэг юманд хүрэх байхаа

-Тэгвэл сайнсан. За юм идэцгээе. Пиани, Бонелло хоёр байшинд оров.

-Орцгооё гэж хүүхнүүдэд Аимо хэлэв. Тэгээд тэр буухад нь туслах гэж гараа сарвайв. Том нь толгой сэгсэрч байна. Эзгүй орхисон байшинд тэр орохгүй нь мэдээж. Тэд бидний хойноос харсаар хоцров.

-Зөрүүд юмс гэж Аимо хэллээ.

Биднийг цуг байшинд ороход харанхуй цэлгэр агаад эзгүйрсэн шинжтэй. Бонелло, Пиани хоёр гал зуухны өрөөнд байлаа.

-Энд идэх юм алга. Цөмий нь цэвэрлэж авчээ гэж Пиани хэлэв.

-Хоолны ширээн дээр Бонелло толм цагаан бяслаг зүснэ.

-Бяслаг хаанаас олов?

-Зоориноос оллоо. Пиани бас дарс алим олсон.

-Өглөөний цайнд хүрэлцээтэй шүү дээ. Сүрлэн гэртэй том лонхны мдон бөглөөг Пиани сугалан тонгойлгож, зэс шанаганд дүүргээд:

-Зүгээргүйхэн ханхалж байна. Барто, сав ол гэв.

Хоёр түрүүч орж ирэв.

-Түрүүч нараа, бяслаг идэцгээ гэж Бонелло хэлэв. Бяслаг идэж, дарс ууж байснаа нэг түрүүч нь:

-Явах болсон бус уу? гэв.

-Явнаа, бүү яар гэж Бонелло хэлэв.

-Армийн ходоод бол армийн хөл нь гэж би хэллэ.

-Юу гэнээ? гэж түрүүч асуув

-Хоол идэх хэрэгтэй

-Гэхдээ цаг чухал шүү дээ.

-Нохойн гөлөгнүүд цадаж л дээ гэж Пиани хэлэв. Түрүүч нар муухай харав. Бид бүгдийг тэд үзн ядаж буй бололтой.

-Та зам мэдэх үү? Гэж нэг нь надаас асуув

-Үгүй гэж би хэлэв. Тэд бие биенээ харна.

-Одоо явахаас дээр юм алга гэж түрүүчийнх нь хэлэв.

-Бид одоо явнаа гэж би хэллээ.

Дахиад нэг аяга улаан дарс уухад минь алими, бяслаг идсэний дараа болоод

бүр ч амттай санагдав.

-Бяслгаа аваарай гэж хэлээд би гарав

Бонелло миний араас том лонхтой дарс барьсаар гарч ирэв

-Дэндүү том юм гэж намайг хэлэхэд тэр дарсаа харж харамсаад:

-Тэгвэл дашмагаа аль гэв.

-Дашмагаа дүүргэхэд нь үл ялих дарс чулуун шалан дээр асгарав. Тэгээд тэр лонхо өргөж, яг үүдэн дээр тавиад:

-Дарс олох гэж австричууд хаалга эвдлэх хэрэггүй боллоо гэж хэллээ.

-Одоо явцгаая. Пиани бид түрүүнд нь явъя гэж би хэллээ. Хоёр түрүүч хэдүйн Бонеллогийн дэргэд сууж, хүүхнүүд алим, бяслаг идэж, Аймо тамхи татна. Бид зэрэг замаар явлаа. Би нөгөө хоёр машин болон тариачны байшинг эргэж харлаа. Тэр намхан байшин тун аятайхан агаад хуаг нь сайхан төмөр хашлагатай юм. Урдахь зам нарийхан, шавхайтай бөгөө хоёр талаараа өндөр хаалттай болой. Манай хоёр машин араас цувран өвнө.

[Тор](#)

---

Бидний тооцоолсноор Удинээс арван километрийн зайтай замын нялцгар шавартб ид үдийн үед суув. Өглөөгүүр бороо зогссон бөгөөд гурван удаа онгоц ирж бидний дээгүүр нисэн алс зүүнтээ одохыг нь ширтэн гол засмал дээр бөмбөг дэлбэрэхийг сонссон билээ. Бид олон салаа замд төөрсөн боловч мухардалгүй тухай тухайд нь буцаж, замаа олж Удинд ойртсоор байлаа. Гэтэл Аймогийн машин төөрсөн замаас буцаж эргэх гээд ухрахдаа амын хажуугийн зөөлөн газарт дугуй нь шигдэж хий эргэсээр улам улам гүнзгийлж эх биеэрээ газарт тулав. Тэгээд дугуйны урдтай нь ухаж, мөчир дэвсээд, машинаа зам дээр гартал нь түлхэх хэрэгтэй болов. Бид бүгд машинаа тойрон зам дээр зогсоно. Хоёр түрүүч машины дэргэд очиж дугуй руу хараад эргэж үг ч дуугаралгүй замаар орж алхав. \_ Би тэдний хойноос явлаа.

-Хүүе, та нар мөчир хугалаад ир! гэж би хэлэв.

-Бид явах хэрэгтэй гэж нэг нь хэлэв.

-Ву гэсэн үг вэ? бушуухан мөчир хугалаарир гэж би хэлэв.

-Бид явах хэрэгтэй гэж нэг нь хэлэв. Нөгөө н үг үл дуугарна. Тэд явахаа яараад надыг ер харахгүй байв.

-Та хоёрыг буцаж, мачир хугалж ир гэж тушааж байна шүү гэж би хэлэв. Сахь түрүүч эргэж хараад:

-Бид явах хэрэгтэй: Цагийн дараа та нар тасдуулна. Бидэнд чи тушаах эрх байхгүй. Бидний дарга чи биш.

-Мөчир хугалж ир гэж би та нарт тушааж байна гэж намайг хэлэхэд тэд цаашаа харж замаар алхалсаар байлаа.

-Зогс! гэж би ширүүхэн хэлэв. Хоёр талаараа хашлага бүхий нялцгар замаар тэд явсаар байв. –Зогс гэж байна шүү! хэмээн би хашгирав. Тэд бүр ч хурдлав. Би бууныхаа гэрийг онгойлгон гар буугаа аваад илүү их ярьсныг нь хараалж гох дарав. Би оносонгүйд тэр хоёр гүйв. Би дахиад гурав бууахад нэг нь унав. Нөгөө нь халхавчин дундуур орж далдрав. Тэгээд түүнийг тал руу гйхэд нь би халхавч нэвт буудав. Сум дууссан тул би шинэ хавчаар хийв. Тэр түрүүч хэт холдсон тул буудаад нэмэргүй болжээ. Талын нагаа заад гараад тэр бөгтийн гүйнэ. Би хоосон хавчаартаа сум хийв. Бонелло ирээд:



-Алив би түүний учрыг олъё гэв. Би гар буугаа өгсөнд, инженерийн ангийн түрүүч түрүүлгээ харан хөндөлдөн хэвтэж буй зам тийш тэр явлаа. Бонелло бөхийгөөд толгой руу нь буугаа чиглүүлэн гохы нь дарахад дуу гарсангүй.

-Замгий нь тат гэж би хэлэв. Тэр замгий нь татаад хоёр буудав. Тэгээд түрүүчийн хөлөөс нь чирч замын хажууд гаргаад, халхавчинд тулгаж хаяад хүрч ирэхэд миний гар бууг өгөв.

-Новш гэж хэлээдтэр мөнөөхөн үхсэн түрүүчийг харан: Миний буудахыг дэслэгч та харав уу? гэв.

-Мөчир түргэхэн хугалах хэрэгтэй. Нөгөөхий нь би тэгж оноогүй гэж үү? Хэмээн би хэлэв.

-Үгшүй байхаа. Гар буугаартийм холоос тэгж онохгү йгэж Аймо хэллээ.

-Адгуусууд гэж Пиан хэлэв. Бид мөчир навч хугалж зөөв. Машиныхаа бүх ачааг буулгав. Бонелло урд дугуйны нь өмнө ухав. Бэлэн болсон хойно Аймо мотороо асааж, залгахад мөчир шавхай цацлан дугуй хий эргэв. Бонелло бид хоёр цуцатлаа түлхэвч машин байрнаасаа хөдөлсөнгүй.

-Барто, холхиул гэж би хэлэв. Тэр урагш хойш нь зүтгүүлэвч, зөвхөн дугуй нь л гүн шигдэж, м ашин нь эх биеэрээ дахин газар туаад ухсан нүхэндээ дугуй нь чөлөөтэй эргэх болов.

-Олсоор татаж үзье гэж би биеэ цэхлэнхэлэв

-Дэслэгчээ тэгээд юм болохгүй. Татах газар алга байна.

-Татаж үзье. Өөрөөр гарахгүй гэж би хэллээ.

Пиани, Бонелло хоёрын машин гагцхүү нарийн зам дагуу татаж чадах байгаа. Бид хоёр машинаа холбоод татав. Ухсан нүхэндээ зөвхөн дугуй нь эргэлдэнэ.

-Бүтэхгүй нээ, больё гэж би хашгирав. Пиани, Бонелло хоёр м ашинаасаа гарч ирэв. Аймо чбуув. Биднээс хориод ярдын зайтай чулуун дээр хүүхнүүд сууна.

-Дэслэгч ээ, одоо яах вэ гэж Бонелло асуув

-Дахиж мөчир дэвсээд үзье гэж би хэллээ.

-Би зам руу харлаа. Миний буруу байжээ. Би эднийг энд авчирсан билээ. Наран үүлийн цаанаас бараг ил гараад, халхавчийн дэргэд үхсэн түрүүч хэвтэнэ.

-Тэрүүний цэрэг цамц, цувыг дэвсье гэж би хэллээ. Бонелло тийшээ явж, би мөчир хугалж Пиани, Аймо хоёул дугуйн урд хооронд ухна. Би цувыг хоёр хуваан урж дугуйн доор шавар дотор дэвсэж мөчир асгав. Биднийг бэлдсэн хойно Аймо суудалдаа сууж мотороо асаав. Бид байдаг хүчээр түлхэвч дугуй хий эргэсээр яах ч нөхцөлгү йажээ.

-За, энэ мууг... гэж хэлээд:

-Бортоо чамд авах хэрэгтэй юм бий юу? гэв

-Аймо бяслаг, хоёр лонх дарс, цуваа авч Бонеллын машинд оров. Бонелло жолооны ард суугаад мөнөөхөн түрүүчийн цамцны халаасыг үзэв.

-Наад цамцаа хая. Бартогийн дэгдээхэйнүүдийг яах билээ, гэж би хэлэв

-Ард тэвшин дотор сууг л дээ. Бид даан их холдохгүй биз гэж Пиани хэлэв.

-Би машины арын хаалгыг онгйлгож

-За сууцгаа гэв.

Хоёр хүүхэн рж буланд суув. Тэр хоёр ер буун дуу сонсоогүй мт байв. Би эргэн харав. Урт ханцуй бүхий бохир цамцтай түрүүч зам дээр хэвтэнэ. Би Пианитай цугсууж, бид хөдлөв. Бид тал дундуур явах гэж бодсон юм. Талд машин эргэхэд би бууж урагш явав. Бид тэр талын нөгөө захаар гарсансан бол зам олох байсан юм. Даанч гарч чадсангүй. Газар дэндүү нойтон нялцгар байлаа. Машины дугуйны хагас нь шааврт шигдэж, яах ч аргагүй бүрмөсөн суухад нь бид тал дунд тэнд нь машинаа хаяад Удин орохоор явган явав.

Бид төв засмал замд орж болох зам дээр гараад би:

- Тийшээ яв. Тэнд хүмүүс бий гэж хүүхнүүдэд буцах зам зааж хэлэв
- Тэд намайг ширтэхэд нь би түрийвчээ гаргаж, арав, арван лир өгөөд:
- Тийшээ яв. Тэнд нөхөд, хамаатан чинь бий! Гэж хуруугаараа зааж хээлв.

Тэд ойлгоогүй боловч мөнгөө чанга атган, замаар орж явахдаа намайг мөнгөө авчих буй гэж айсан шиг эргэн эргэн харна. Алчуураараа толгойгоо чанга хулдаад айсан янзтай биднийг эргэн эргэн харсаар замаар явахад нь гурван жолооч маань инээлдэв.

-Дэслэгч та, хэрэв намайг нөгөө тийшээ явбал хэдийг өгөх вэ? гэж Бонелло асуув

- Дайралдвал ганц хэрэггүй, олон нь дээр гэж би хэллээ.
- Надад хоёр зуун лир өг. Би шууд эргэж австри очъё гэж Бонелло хэллээ.
- Тэнд чамаас цөмий нь авчихна эгж Пиани хэлэв.

-Дайн дуусах ч магадгүй гэж Аймо хэллээ. Бид замаар орж чадах чинээгээрээ хурдлан явав. Үүлэн нэвт наран гэрэлтэнэ. Замын дагуу ялмаа модон ургажээ. Моддын цаадтай тал дунд манай машин хоёр том хайрцаг адпил торойн харагдлаа. Пиани бас эргэж хараад

- Тэндээс машинуудаа авах гэж зам засах хэрэгтэй болж дээ гэж хэлэв.
- Ээ, чааваас гэж унадаг дугуй ч байдаг болоосой хэмээн Бонелло хэлэв
- Америлад дугуй ундага уу? гэж Аймо асуулаа.
- Унадаг байсан

-Сайн эд шүү. Унадаг дугуй сайхан эд шүү гэж Аймо хэлэв

-ээ чааваас унадаг дугуй ч байдаг болоосой. Би ч унахдаа муухан л даа гэж Бонелло хэлэв. Хааяа нэгэн газар буун дуу сонсдох мэт болоход би:

- Буудаж байна уу даа? гэж асуулаа.
- Мэдэхгүй гэж хэлээд Аймо чагнав
- Буудаж байх шиг байна гэж би хэлэв
- Хамгийн түрүүнд морин цэрэг тааралдана гэж Пиани хэллээ.
- Тэдэнд морин цэрэг байхгүй йбайхаа гэхэд

-Тэгвэл сайн, чөтгөр алгадмар гэж дээ. Мори н цэргийн аль нэг, новш нь нхамайг жадлаасай гэж би хүсэхгүй байна гэж Бонелло хэлээ.

-Дэслэгч та тэр түрүүчийг аятайхан болголоо шүү гэж Пиани хэлэв. Бид тун түргэн явцгаав.

-Би түүнийг буудсан. Энэ дайнд би хэнийг ч будаагүй юм. Би нэг түрүүч буудъя гэж бүх насаараа бдсон юм гэж Бонелло хэллээ.

-Үүрэндээ суугаа тахиаг буудсан. Чамайг будахад тэр аажуухан нисэж байсан гэж Пиани хэлэв.

-Ялгаагүй. Би энэ тухай ер мартаггүй. Би тэр новшийн түрүүчийг алсан.

-Чи юу гэж гнаманчлах вэ? гэж Аймо асуува.

-Лам багш минь, би нэг түрүүч аллаа, намайг ариутгаж хайрла гэж хэлнэ гэхэд гурвуул инээлдэв.

-Наадах чинь зоргоороо хүн гэж Бонелло хэллээ.

-Та нар үнэхээр зоргоор улс уу? гэж би асуулаа.

-Үгүй ээ, дэслэгч ээ. Бид нийгэмч улс. Бид цөм имолынхан.

-Та нар тэнд ер очогүй юу?

-Үгүй

-Ээ, харал даа! Дэслэгч минь тэнд сайхан газар шүү. дайны дараа тийшэ бидэгнд айлчилж очоорой. Тэнд үзэх юмтай шүү.

-Тэнд цөм нийгэмч улсууд уу?

-Нэг бүрчлэнгээрээ

-Хот нь сайхан уу?

-Яриангүй. Тийм хотыг та үзээгүй  
-Та нар яагаад нийгэмчид болсон бэ?  
-Бид бүгдээр нийгэмч улс. Тэнд хүн нэгбүрчлэн нийгэмч юм. Бид хэзээний нийгэмчид байсан улс.  
-Дэслэгч та очоорой. Таныг бид бас нийгэм хүн болгоно  
Зам гэнэт зүүн тийшээ дугуйрч, чулуун хана бүхий, жимсний цэцэрлэгийн дэргэдүүр намхан толгой өөд өгсөх бөгөөд уул өөд гарахдаа тэд яриагаа зогсов. Бид дөрвүүл зэрэгцэн, алхаа сааруулахгүйг хичээнэ.

[Тор](#)

---

Тэгээд бид гол руу очсон зам дээр гарав. Эзгүй орхисон ачааны машин, даачаа тэрэгний урт цуваа гүүр хүртэл замаар үргэлжилнэ. Хүн ер алга. Голын ус ихсээд гүүр нь дундаа дэлбэрч, чулуун гулдан нь гол дотор унаад дээгүүр нь булингарсан ус урсана. Гарам хайж бид эрэг дагуу явцгаав. Жаахан цаашилбал төмөр замын гүүр байдгийг би мэдэх бөгөөд түүгээр гарч болох байх гэж бодож явав. Зөрөг нойтон агаат шавхайтай аж. Хүн ер үзэгдэхгүй, гагцхүү орхигдсон хгшил машин байна. Голын эргээр нойтон бут, шавартай газраас өөр юм огт алга. Бид эрэг дагуу явж байтал төмөр зам ын гүүр харагдав.

-Яасан сайхан гүүр вэ! гэж Аймо хэллээ. Тэр нь ямагт ёроолоо гартал хатдаг гол дээр тавьсан урот төмөр гүүр билээ.

-Энэ гүүрийг дэлбэлээгүйдээр нь нөгөө талд нь түргэхэн гаръя гэж би хэллээ.

-Дэлбэлэх хүн байхгүй. Цөм явжээ гэж Пиани хэлэв.

-Энд лав мина бөмбөг зөөсөн байх

Дэслэгч та түрүүлж яв гэж Бонелло хэлэв.

-Ямар зоргоор эд вэ? Өөрөө түрүүлж яваг л дээ гэж аймо хэлэв

-Би явъя. Ганц хүний хөлөөр дэлбэрэхээр тийм мина бөмбөг зоосон байх гэж үү гэж би хэллээ.

-Ухаант хүн гэдгийг ойлгов уу? Чиний зоргоор гэдэг чинь биш дээ гэж Пиани хэлэв

-Би цэцэн байсансан бол энд байхгүйсэн гэж Бонелло хэлэв.

-Үнэн үг шүү, дэслэгч ээ гэж Аймо хэлэв.

-Тиймээ гэж би хэлэв.

Бид ч гүүрэнд тул ирлээ. Тэнгэр д ахин бүрхэж, боро дусална. Тэр гүүр тун урт агаад бөх бололтой. Бид төмөр замын шороо өөд авирав.

-Нэг нэгээрээ явъя гээд би гүүрэн дээр гарав. Мина байж магадгүй тэмдэг, тор утас болон хойж зам төмөр, дэр модыг харавч мэдэгдэх юм ер алга байна. Дэр модны завсар зайгаар доорхи голын булингартай ус жирэлзэн харагдана. Өминөх нойтон талын цагаан бороон дунд УБдин харагдана. Гүүр гарад би эргэж харав. Голын дээд өөд ойрхон бас нэгэн гүүр байлаа. Зогсоод харж байтал тэр гүүрээр шавар цацагдсан суудлын шар машин өнгөрөв. Тэвш нь өнөр тэр м аши н гүүрэн дээр гарад далдарсан авч жолооч болон дэргэд нь сууж яваа нэг хүн, ард нь сууж яваа хоёр хүний толгой харагдаж цөм герман төмөр малгай өмсчээ. Тэр машин гүүр өнгөрөөд модод болон зам дээр орхисон хөсгийн цаагуур даүлд оров. Гүүр гарч яваа Аймог хараад би тэдэнд хурдан явах дохио өгөв. Тэгээд би бууж төмөр замын далангийн ёроолд суулаа. Аймо хойноос бууж ирэв.

- Та нар машин харав уу? гэж би асуулаа.
- Хараагүй. Бид таныг л харж явсан
- Дээд гүүрээр германы штабын машин өнгөрсөн
- Штабын машин гэнээ?
- Тиймээ
- Сахиус минь!

Бусад маань ч ирж бид бүгдээр замын далангийн ёроолд шавхай дээр сууж дээдтэйх м одод, суваг болон зам ыг харцгаав

- Дэслэгч ээ бид туслагдаа юу?
- Бүү мэд. Лав л германы штабын м аши н энэ замаар өнгөрлөө.
- Дэслэгч та бүр эрүүл биз. Толгой чинь эргэхгүй байна уу?
- Битгий өдөөрэй Бонелло
- Жаахан юм ууцгаавал яасан юм бэ?

Хэрэв бид таслагдсан болбол ядахдаа ууцгаая л даа гээд Пиани бүснээсээ дашмагаа тайлж тагийг нь эрэгдэнх онгройлгов

-Хараач, хараач! гэж Аймо зам руу заав. Гүүрийн чулуун хашлаганх дээгүүр герман төмөр малгайд цухалзан үзэгдэж жигдхэн агаад онцын хурдан явж эрэг хүрэхэд нь унадаг дугуйн анги болох нь илэрхий болов. Эхний хоёр хүний улаан хацартай идэрхэн царайг би сайн харав. Төмөр малгай дух руу нь лав орж хацры нь хагасы нь хаажээ. Карбин буугаа унааг дугуйныхаа их биенд өлгөж, гар бөмбөгөө бариулаар нь бүснээсээ зүжээ. Төм өр малгай, саарал хувцас нь нойтон бөгөөд тэд ийш тийшээ харцгааж яарамгүй явна. Эхлээд хёр дараа нь дөрөв зэрэгцэж, ахиад хоёр дагаж тэгээд арав, арван хоёр, дахиад арав гэнэж, сүүлд нь нэг хүн тусдаа явна. Тэд хоорондоо үл ярилцана. Ярилцавч бид голын шуугианд сонсоогүй байж магад. Тэд замаар рж харагдахгүй болов.

- Сахиус минь гэж аймо хэллээ.
- Австричууд биш германууд байна гэж Пиани хэлэв

-Эднийг яагаад эн зогсоох хүнгүй байна. Энэ гүүрийг яагааддэлбэлээгүй байна? Далан дагууд яагаад пулемёт буу байхгүй байна вэ? гэж би хэлэв

- Дэслэгч та энэ үгээ бидэнд хэл гэж Бонелло хэллээ.
- Миний уурхүрсэн гэж жигтэйхэн

-Цөм галзуурчихжээ дээ. Тэр доор жижиг гүүрүүд дэлбэлээд энд яг засмал дээрх гүүрий нь орхидог байна шүү. Хаашаа орцгоогоо вэ? Эднийг зогсоох гэж оролдохгүй байгаа юм биз дээ?

- Дэслэгч та энэ үгээ бидэнд хэл гэж Бонелло давтав

Би дуугүй болов. Энэ ч үнэндээ надад хамаагүй. Би эмнэлгийн гурван машинаараа Порденон хүрэх ёстой байсан. Гэтэл чадсангүй. Одоо би өөрөө л Пердонон хүрэх хэрэгтэй. Би ер Уинд ч хүрч чадахгүй нь бололттой. За яая гэхэв. Гол нь таван байж суманд үхэхгүй, олзлогдохгүй бол барав.

-Чи дашмаг онгойлгож бай л уу? гэж би Пианиас асуулаа. Дашмагаа наад өгөхөд нь нэг сайн балгав

- Явцгаая. Гэхдээ яарах ч юу байхав. Юм идэцгээх үү? Гэж б хэлэв.
- Энд удаан байж болохгүй газар байна гэж Бонелло хэллээ.
- Зүйтэй явцгаая

- Энд нуугдацгаах уу?

-Голо өгссөн нь дээр. Тэд энэ гүүрээр явцгаах байх. Биднээс урьдаад тэд харчихвал тун муу юм болно.

Бид төмөр замын далан дагаж явлаа. Эргэн тойрон нойтон тал мэлти йж тэртээ урдахь толгойн цаана Удин бөуй. Толгойн орой дээрх цайзны дэвэр нь эргэн тойрон нураад цамхагийн цаг, гонх нь илэ харагдаж байна. Тал дунд ялма мод элбэг

ажээ. Урдтай нэг хэсэг төмөр замыг эвдэлж дэр моды н ухаж аваад далангийн ёроол руу хаяжээ.

-Доошоо бол, доошоо бол! гэж Аймо хэлэв. Бид далангийн ёроол руу орж нуугдав. Унадаг дугуйн шинэ отряд замаар өнгөрлөө. Тэд тун ойрхон өнгшөрөхийг би далангийн цаанаас харсан билээ.

-Тэд биднийг харсан мөртөө зогссонгүй гэж Аймо хэлэв

-Тэдэнд бид хэрэггүй. Тэд өөр юм хөөж яваа юм байна. Цочир тулгарчихвал л бидэнд аюултай юм олно гэж би хэллээ.

-Далдалсан замаар явбал дээрсэн дээ гэж Бонелло хэлэв.

-Яв, яв. Бид далан дагаж явна.

-Эндээс гарч чаднагэж та бодож байна уу? хэмээн Аймо асуулаа.

-Чаднаа. Эд цөөхөн. Харанхуй болохоор бид явна.

-Штабын машин юу хийж явсан гэж бодож байна?

-Бүү мэд дээ гэж би хэлэв. Бид далан дагаж явсан бөгөөд Бонелло шавар дундуур явж ядраад бидэнтэй нийлэв. Төмөр зам засмалаас холдож өмнө зүүг дугуйраад, зам дээр юу болж буй нь харагдахаа болив. Суваг гардаг жижиг гүүрийг дэлбэлсэн боловч бид гол нурууны үлдэгдлийг нь дамжиж гарлаа. Урдтай буун дуу сонсдоно.

-Сувагн гатлаад дахин бид замаа дагав. Тэр зам тал дундуур хотын зүүг шууд оджээ. Өмнөтэй өөр нэгэн зам харагдана. Унадаг дугуйчдын өнгөрсөн засмал зам умар зүүг эргэж мод шигүү суулгасан нарийн зам өмнө тийшээ салаалжээ. Өмнө зүүг эргэж хотыг тойроод Кампоформо, Тальямений засмалаар явах нь дээр юм гэж би бодлоо. Ухралтын гол замыг орхиод бид хажуугийн замаар нь явж болох юм. Тэгш талаар гаталдаг олон салаа замтайг санаад би далангаас буув.

-Явцгаая гэж би хэлэв. Хотын өмнүүр ордог замаар явъя гэж би бодсон билээ. Бид бүгд далангаас бууж явтал, өмнөөс буун дуу жижигнэж далангийн шаварт сум нь тусав.

-Буцаад гэж би хашгирлаа. Би налоуу гараар шаварт гулсан дээш гүйв. Жолооч нам өмнө минь явна. Харин би далан дээр хурдаараа гартал өтгөн бутнаас хоёр удаа буудаж, зам төмөр гарч явсан Аймо гуйван газар унав. Бид түүнийг нөгөө тийш нь гаргаж дээш харуулав.

-Цээжий нь өндөрлөөрэй гэж би хэлээ. Пиани биеий нь засан хөөлгөв. Тэр шавартай налуу газар дээшээ налж хэвтэх бөгөөд амьсгалахад нь цус гарна. Бид гурав тойрч бороонд явган сууна. Ар шилэнд нь сум тусаж дээш хаван баруун нүдний нь доогуур гарчээ. Хоёр нүхий нь таглаж ядаж байтал тэр амьсгаа хураав. Пиани толгойг нь газар тавиад боодлын жижигхэн самбайгаар нүүри йг нь арчаад

-Новшнууд! Гэж тэр хэлэв

-Энд германууд байх ёстой. Энэ лав германууд биш гэж би хэллээ.

-Италиуд italiani гэж Пиани зүхсэн янзтай хэллээ.

Бонелло дуугүй байна. Тэр Аймогийн дэргэд суугаад өөр юм харна. Далангийн доод руу унасан аймогийн малгайг Пиани авчирч нүүртий нь бүтээгээд дашмагаа гарагж:

-Уух уу? хэмээн Бонеллод барив

-Уухгүй гэж Бонелло хэлээд над руу эргэж

-Далан дагуу бидний хэн маань ч ингэж болно гэв

-Үгүй. Тал гатлах гээд л ийм боллоо гэж би хэлэв. Бонело толгой сэгсрээд

-Аймо алагдлаа. Дараа нь хэн бэ, дэслэгч ээ? Одоо бид хаачих билээ? гэв

-Италичууд буудлаа. Германууд биш гэж би хэллээ.

-Хэрэв энд германууд байвал лав бүгдийг буудна гэж Бонелло хэлэв.

-ИТаличууд бидэнд германаас аюултай. Тасарсан хэсэг бол юм бүгдээс айна.

Германууд бол яахаа мэднэ гэж би хэлэв

-Дэслэгч таны хэлдэг зөв гэж Бонелло хэллээ.

-Одоо бид хаачих билээ? гэж Пиани асуув

-Харанхуй болтол нэг газар хүлээсэн нь дээр. Хэрэв бид өмнө зүг гарч чадвал хамаг хэрэг бүтнэ.

-Нэгий нь дэмий алаагүй гэдгээ үзүүлж тэд биднийг бүгдий нь буудна. Би амиа өгөх дургүй байна гэж Бонелло хэлэв

-Уднд ойртож жаахан хүлээ. Тэгээд харанхуй болохоор явъя.

-Тэгвэл явцгаая гэж Бонелло хэллээ. Далангийн хойт талын хажууг дагаж бид буулаа. Намайг эргэж харахад далангийн буланд шавар дотор Ајмо хэвтэнэ. Тэртун жижигхэн харагдаж гар нь эгц ташаандаа бөгөөд жийсэн хөл нь ороолттой, шавхайдсан шаахайтай, агаа нүүр нь малгайгаар таглаатай байна. Тэр үнэхээр хүүр болсон харагдана. Бороо орсоор л байв. Би Ајмод их хайртай билээ. Амьдралдаа би ер тэгэж хүн хайрлаж үзээгүй. Түүний бичиг сэлт нь миний өвөрт явах бөгөөд ар гэртт нь би захиа бичих ёстой. Талын цаад захад тариачны байшин харагдана. Гадуур нь мод ургаж, тэр байшинд байр нэмэж барьсан болон хоёрдугаар давхан туждаа яс модон дээр нь босгосон сараалжтай аж.

-Хоорондоо зай барьж явбал дээр гэж хэлээд би: -түрүүнд нь би явъя гэв.

Тал дундуур явсан зөргөөр орж би тариачны байшин чиглэв

Байшин дотроос буюу модны цаанаас биднийг буудах болов уу гэж би тал дундуур явахдаа бодож байлаа. Би тэр байшинг сайн харж эгцлэн алхав. Хоёрдугаар давхрын саравч нхь өвсний саравчтай үргэлж бөгөөд яс модны завсраар өвс цухуйна. Хашаа нь чулуугаар бэхэлжээ. Модны мөчрөөс бороон дусал гоожно. Хашааны гол дунд хоёр дугуйтай хоосон том тэрэг бороонд, арал нь ёрдойн байна. Би хашаан дотуур явж сараалжин дор очиж зогсов. Онгорхой хаалгаар намайг ороход Бонелло, Пиани хоёр дагаж орж ирэв. Тэр дотуур харанхуй байв. Галын өрөөнд ороход том задгай голомт нь үнстэй агаад дээд талд нь хосон савнууд зүүжээ.

Би эргэж тойронгүй нэгжиж үзсэн боловч идэх юм болдсонгүй.

-Өвсний сарачинд байж азная. Пиани чи идэх юм олбол тийш нь аваачаарай гэж би хэлэв

-Юм хайя гэж Пиани хэллээ.

-Би бас хая гэж Бонелло хэлэв

-Тэг тэг. Би явж өвсний саравч үзье гэж би хэллээ.

Би хашаанаас дээш гардаг чулун шат олов. Хашаанаас хуурай үнэр үнэртэж, бороонд бүр ч аятайхан ажээ. Тэнд мал үгүй бөгөөд бодвол малаа тууж эндээс нүүсэн буйзаа. Өвсний саравч тэхий ундаа хүртэл өвстэй, дээвэртээ хоёр цонхтой, нэг нь банз хаастай нөгөө нь умар талдаа чимээ чагнах жижиг цонх байна. Тэжээлийн онгоцонд өвс хийдэг ховилтой цорго буланд нь байна. Мөн хадлангийн үед өвч ачсан тэрэг ирдэг хашааны дээгүүр харсан жижиг нээлгийтэй бөгөөд дээд талаар яс мод угсарчээ. Дээвэр дээр боро хаялах сонсдон, өвсний үнэр анхилна. Доош бууж явахад хашаан дотроос хуурай өтөг хамар цоргин ханхалж байлаа. Нэгбанз авч хаяад, өмнө талын цонхоор хашаан доторхийг харж болох бөгөөд нөгөө цонх нь умар зүг, тал руу харжээ. Хэрэв шат нь эвдэрхий байсан бол аль нэг цонхоор дээвэр дээр гараад буух буюу ховилтой цоргоор ч гулсан бууж болох ажээ. Өвсний саравч тм учир чимээ сонсдмогц өвсөнд орж нуугдаж болно. Ер нь л таатайхан газар бололтой. Хэрэв биднийг буудаагүйсэн бол бид өмнө зүг явах байсан гэж би бодлоо. Энд германууд байх ёсгүй, тэд өмнө зүгээс ирэх нөхцөлгүй бөгөөд Чивидалын замаар умар зүгээс ирж байгаа юм. Италичууд айхдаа дайралдсан бүгдээ буудах учир бүр ч в аюултай. Умар зүгийн ухарч буй зэвсэгт хүчний дотор итали хувцастай

герман цэргүүд их байна гэж бид өчигдөр шөнө цуваанд явахдаа сонссон билээ. Гэвч би итгээгүй. Дайны үед тиймэрхүү яриа үргэлж гардаг. Дайснууд голчуу тийм цуу тараадаг юм. Гермаы зэвсэгт хүчний толгойг эргүүлэхийн тулд герман цэргийн хувцас өмссөн тухай та ер олж сонсохгүй биз. Тийм хэрэг байдаг ч гэсэн тэртухай ярьдаггүй юм. Германууд тийм хэрэг хийнэ гэж би ер итгэхгүй байна.Тэдэнд тэгэх хэрэггүй буйзаа. Нэгэнт ухарч буй манай зэвсэгт хүчний толгойг эргүүлэх гээд тэд яах ч юм билээ дээ. Замын бариаа, цэргийн тоноос болж тийм яриа гарсан байхаа. Германы тухай тийм яриа гарах ч боломжтой билээ. Тэгээд ч ер биднийг хувцсаа сольсон герман гэж буудаж болох агаад Аymo-г ч тэгэж буудсан шүү дээ. Өвсний саравчинд хэвтэхэд өвс аятайхан анхилаад өнгөрсөө жилүүд мартагдана. Бид өвсөн дээр хэвтэн ярилцаж,өвсний саравчны дээвэр дэх гурвалжин нүхний ирмэг дээр болжмор суухад хийн буугаар буудна. Өвсний тухай мартаж, хам аг жодоог нь тайрч хаяад, ой байсан газар өдгөө хожуул, хуурай дархи үлдсэн цаг санаанд оров. Өнгөрсөн юм эргэж ирэхгүй. Урагш ахидаггүйсэн бол юу болох бол? Миланд дахин очих аргагүй. Хэрэв очвол яахсан бол? Умар зүг Удиний тэнд буун дуу сонсоно. Зөвхөн пулемётны дуу байна. Их бууны дуу сонсогдохгүй байгаа нь бас учиртай. Цэргийн хагас нь зам руу ирсэн бололт ой. Доошоо хартал хашааны харагхуй дотор Пи ани урт хиам сугавчилж, лаазтай юм,хоёр лонх дарса барьсан яваа харагдав.

-Тэнд шат байна. Наашаа гараад ир гэж би хэлэв

Тэгснээ би тусалъя гэж ухаараад буув. Өвсөн дээр би удаанхэвтсэнх болоод толгой эргэж, зүүрмэг юм шиг байлаа.

-Бонелло хаана байна? эгж би асуулаа.

-Учры нь хэлнээ гэж Пиани өгүүлэв

Бид шатаар гарч ирээд юмаа дэлгэн өвсөн дээр сууж, Пиани эрэгтэй хутга гарган нэг лонхны бөглөөг эрэгдэв.

-Лаагаар цардсан байна. Сайн дарс байхаа гэж тэр хэлээд инээвхийлэв

-Бонелло хаана байна? гэж би асуулаа. Намайг ширтэн харснаа Пиани:

-Дэслэгч тэр явчихсан. Бууж өгөхөөд шийдсэн гэв. Би дуугүй л байв.

-Алагдчих байх гэж тэр айсан.

Лонхтой архи барьсан хэвээр би дуугүй л байв.ь

-Дэслэгч ээ, бид ер нь дайтах дургүй юулс шүү дээ.

-Чи яагаад цуг яваагүй юм бэ? гэж би асуулаа.

-Таныг би орхих дургүй байсан юм.

-Тэр хаашаа явсан бэ?

-Дэслэгч ээ, мэдэхгүй. Яваад л өгсөн

-За яахав. Хиамаа хэрч гэж би хэлэв

Харанхуй дунд Пиани намайг ширтэнэ.

-Ярхьж байхдаа би хэрччихсэн гэж тэр хэллээ.

Бид өвсөн дээр сууж, хиам идэж, дарс уув. Тэр дарс хуучирч өнгөө алдсаныг үзэхүл лав хуримд хадгалсан бололтой. \_

-Луйжи чи энэ цонхоор хар. Би тэр цонхоор харна гэж би хэллээ.

Бид тус тусдаа лонхоор нь ууж байсанучир би өөрийнхөө лонхтойг авч, дээш гарч дахиад авсан дээр хажуулдан онигор цонхоор тэгрш талыг ш иртэн хэвтэв. Юу отож буйгаа би үл мэдэх бөгөд гагцхүү тал, боро ялмын нүцгэн модод харагдана. Дарс уувч бие сэргэхгүй байна. Тэр арсыг дэндүү удаан хадгалсан учир муудаад өнгө үнэрээ алджээ. Гадаа хүүшилж, тун түргэн харанхуй болов.

Бороотой учир түнэр харанхуй шөнө болно. Хав харанхуйлаад цонхоор харах хэрэггүйд би эгэж Пианийн дэргэд ирвэл тэр хэвтэж унтах тул сэрээлгүй дэргэд нь дуугүй суув. Тэр тм биетэй агаад тун бөх унтаж байна. Хэсэг зуур хүлээснээ сэрээж бид хоёр цааш явав.

Ту хачин шөнө байлаа. Юу болохыг үл мэднэ. Эсхүл үхэх үү, эсхүл буудуулж харанхуйд зогтах болов уу, гэвч юу ч тохиолдсонгүй. НХэгэнтээ замын хажуугийн сувгийн ард хажуулдаж бид германы батальоныг өнгөртөл хүлээгээд далд ороход нь босож засмалаар гаран умар зүг одов. Борооноор бид хоёр удаа германуудтай ойр тулгарсан боловч тэд ер анзаарсангүй. Бид хотын хойт талаар нь өнгөрөхдөө нэг ч итали хүнтэй дайралдалгүй явж, ухралтын гол зам дээр гараад Тальяментог чиглэн шөнөжин алхлав. Ухралтыг би урьд нь ийм өргөн хэмжээгээр ер ойлгодоггүй байжэ.н Зэвсэгт хүчний хамит бүх орноороо хөдөлжээ. Шөнөжин бид хрөсөг гүйцэн түрүүлж явахад хөл минь өвдөж ядралч улам хурдалсаар байв. Бонелло бууж өгөхөөд шийдсэн нь даанч дэмий санагдав. Бид хоёр арми дундуур туулахад аюул ер тохиолдсон үгүй. Хэгрэв Аймо алагдаагүйсэн бол огтын осолгүй явлаа гэж болно. Төмөр замын далан дагаж ив ил явахад ч бидэнд ер халдсан хүнгүй. Санаандгүй явтал гэнэтэд үхэл тулгарсан билээ. Бонелло хаана яваа бол гэж би бодов.

-Дэслэгч таны бие ямар байна гэж Пиани асуулаа. Цэрэг хөсөг дүүрсэн замын зах барин бид явж байв.

-Зүгээр

-Би алхахаас ядраад байна.

-Алхахаас өөр ажил одоо бидэнд байх биш дээ. Ондоон золвох юм алга.

-Бонелло дэмий юм хийлээ.

-Үнэхээр дэмий юм хийсэн

-Дэслэгч та, тэрнийгяана гэж бодож байна.

-Мэдэхгүй ээ.

-Та түүнийг олзлогдсон гэж бүртгэх үү?

-Мэдэхгүй ээ.

-Хэрэв дайн зогсохгүй бол, эцэг эх нь хэрэгт татагдана.

-Дайн зогсоноо. Дайгн дуусаадбид харьж явна гэж нэг цэрэг хэлэв.

-Цылом харьц явна.

-Бид цөм харьж явна.

-Дэслэгч ээ хурдан явъя гэж Пиани хэлэв. Тэд тэднэс түргэн өнгөрөх гэж боджээ.

-Дэслэг гэнээ? Хаана дэслэгч байна?

A basso gli ufficiali! Офицерууд сөнөтүгэй.

Намайг Пиани сугадаж:

-Таныг би нэрээр чинь дуудаж байя. Тэгэхгүй бол юу ч болж болно.

Офицеруудтай тооцоолсон удаа ч бий гэв.

Бид хурдлан явж тэр хэсгээс түрүүлэв. Би түрүүчийн яриагаа үргэлжлүүлж:

-Эцэг эхийг нь хэрэгт хролбогдуулахгүйг бодно гэв.

-Хэрэв дайн дуусвалч хамаагүй. Гэхдээ би дайн дуусна гэж бодохгүй байна.

Дайн дуусвал мөн ч сайхан байна даа гэж Пиани хэллээ.

-Уахгүй мэдэгэнэ ээ гэж би хэлэв.

-Дайн дуусна гэж би бодохгүй байна.

Одоо дайн дууслаа гэж хүн бүгд бодож байна. Би итгэхгүй байна.

-Viva la Pace<sup>24</sup>! Бид харьж явна гэж нэг цэрэг хашгирав.

-Хэрэв бид цөмөөрөө харьж яваасан бол яасан сайхан бэ? гнэж Пиани хэлээд:Та гэртээ харья гэж санаж байна уу? гэж асуув.

-Санаж байна.

-Бүтэхгүй. Дайн дууссан гэж би итгэхгүй байна.

---

<sup>11</sup> Энх тайван мандтугай! гэсэн итали иг



-Andiamo a casa<sup>25</sup>! гэж цэрэг хашгирав.

-Эднүүс буугаа хаяж байна. Явуут мулталж хаяж байна. Тэгээд хашгирч байна гэж Пиани хэлэв.

-Эд буугаа дэмий хаяж байна даа.

-Буугаа хаяихвал дахиад байлдуулахгүй гэж эд бодож байх шүүг байна.

Борооноор харанхуйд замын зах барин явахад минь олон цэрэг буугаа хаяагүй авч явах бөгөөд мөрөвчихсөн харагдана.

-Ямар бригад вэ? гэж офицер хашгирав.

-Brigata di Pace! Энхийн бригад гэж нэг нь хашгирав.

-Офицер дуугүй байв.

-Тэр юу гэнэ вэ? Офицер юу ярьж байна?

-Офицер сөнөтгүгэй!

-Хурдан явъя гэж Пиани хэлэв.

Зам дээр орхисон машинуудын дотор английн эмнэлгийн хоёр машин байлаа.

-Грицийнх байна. Би энэ машинуудыг мэнэ гэж Пиани хэлэв.

-Биднээс түрүүлсэн юм байна.

-Тэд эртэлж гарчээ.

-Хачин юм даа. Жолооч нь хаачаа вэ?

-УБрд л яваа биз.

-Германууд. Удиний тэнд байгаа болохоор бид цөм гол гарна гэжэ би хэлэв.

-Тэгнэ. Тэгээд ч бид дайн зогсохгү йгэж бодож байна хэмээн Пиани өгүүлэв.

-Германууд цааш явж болох байтал яагаад явахгүй байна. Хачин юм даа гэж би хэлэв.

-Бүү мэд. Энэ дайнд ер миний мэдэх юм алга.

-Тэд хөсөг хүлээж байгаа байлгүй дээ.

-Бүү мэд гэж Пиани хэллээ. Ганцаар явахдаа тэр ихэд биеэ барих юм. Бусад жолоочтой нийлэхдээ тун ам султайсан даа.

-Луйжа чи эхнэртэй юу?

-Эхнэртэй гэж та мэднэ шүү дээ

-Тэгээд чи бууж өгөөгүй юм уу?

-Тэгж ч болно. Дэслэгч та эхнэртэй юу?

-Байхгүй.

-Бонелло бас байгү.

-Юм бүгдийг эхнэртэй эхнэргүйгээр нь атилбарлаж болохгүй. Гэвч эхнэртэй хүн эхнэртээ очих гэж бодох нь зүй гэж би хэлэв. Эхнэли йн тухай ярихад надад таатайхан байв.

-Тиймээ.

-Хөл чинь яаж байна?

-Өвдөж байна.

Үүр цайхын өмнө бид Тальяментын эрозг хүрч, үерлэсэн голын хөвөө дагаж гүүр тийш явав.

-Энэ гол дээр жаахан амрах хэрэгтэй гэж Пиани хэллээ. Харанхуйд гол оволзож суваг нь тэлээд тун их устай харагдах бөгөөд модон гүүр нь гурав дөрвөн бээр шахам урт агаад өргөн чулуун ёроолоор гүн нарийнхан урсдаг ус нь эдүгээ бараг модон хашлагандаа тулсан ажээ. Эрэг дагуу явж бид гүүр гарч байгаа шлонтой нийлэв. Ус нь иэхссэн голоос хэдэн футын зайтай бороон дундуур алгууцр алхлан олны дунд шахцалдан урд талын сумны хайрцгийг арай л мөргөчихгүй явж тал тал

---

<sup>22</sup> Гэртээ гэсэн итали йг

тийш харан голын цаад талыг ажиглаж байв. Өдгөө бусадтай зэрэгцэн алхлахдаа би ихээхэн ядарснаа мэдэв. Гүүр гарахад аг таг өнгөрөв. Хэрэв өдөр нь энд онгоцоор бөмбөг хаясан бол юм болохсон биз гэж би бодов.

-Пиани! гэж би дуудав.

-Би энд байна, дэслэгч ээ гэх сонсдов.

Олонд тэр түрэгдэж надаас нилээд урд явсан болой. Хүмүүс дув дуугүй байлаа. Хүн болгон түргэн гарахыг боджээ. Бид ч гүүр гарах дөхөв. Гүүрийн үзүүрт хоёр талаар нь дэнлүүтэй офицер цуваан дунд яваа нэг хүнийг зааж, цагдаа очод тэр хүний мөрнөөс татан замын нөгөө талд аваачив. Бид офицеруудад тун ойртов.Цуваанд яваа хүн бүрийг харж, тэд хоорондоо үргээлж ярилцан, хүний нүүр гэрэлтүүлэх гэж урагшилна. Биднийг яг зэрэгцэхийн сацуу бас нэгэн хүнийг аваачив.

Дэнлүүний гэрэлд ханцуй дээрх таван хошууг нь харвал тэр хүн дэд хурандаа байлаа. Намхан нуруутай, тарган биетэй, буурал үстэй, тэр хүнийг цагдаа нар гүүрийн нөгө талд гарва. Офицеруудтай биднийг зэрэгцэн очиход тэр намайг их л харж байна. Тэгээд нэг нь намайг зааж, цагдаад юм хэлэхэд цувааны захын хүмүүстэй түлхэлцэн нэг цагдаа намайг чиглэж ирснээ захнаас минт барьж авахыг би мэдрэв.

-Юу болоов? гэж асуугаад би нүүр рүү нь цохи в. Малагй дорос нь цухуйж буй нүүр, өөд нь шөрвийлгөсөн сахал, хацры нь дагаж урсах цусыг би олж харлаа. Биднийг чиглэн олны ундуур бас нэг цагдаа зүтгэв.

-Юу болов? гэж намайг асуухад тэр хариу хэлсэнгүй. Хамрин намайг барьж авах гэв. Би гар буугаа авах гэж ар ташаандаа тэмтрээд:

-Офицер хүнд алдаж болдоггүйг чи одоо хүртэл мэддэггүй юм уу? гэв.

Нөгөө нэг нь миний ар талаас барьж гары минь цохиод арайл үе мулталчихсангүй. Эргэтэл түрүүчийнх нь хүзүүгээр зүүгдэв. Би өшиглөж, зүүн өвдгөөрөө цавь руу нь ёвров.

-Эсэргүүцвэл буудаарай гэх дуун сонсдов.

-Юу болж байна аа? гэж би хашгирах гэвч хоолой сайн гарсангүй. Тэгээд тэд намайг бүр замын зах руу гаргав.

-Эсэргүүцвэл буудаарай. Тийш нь аваач гэж офицер хэллээ.

-та нар юун улс вэ?

-Сүүлд мэдээрэй.

-Та нар юун улс вэ?

-Хээрийн цагдаагийнхан гэж өөр нэгэн офицер хэлэв.

-Энэ онгоцуудыг нисгэхийн оронд та нар намайг хүрээд ир гэж яагаад хэлж болсонгүй вэ?

Тэд хариу хэлсэнгүй. Бидэнд хариулах албагүй аж. Тэд хээрийн цагдаагийнхан байжээ.

-Үүнийг тийш нь аваачиж нийлүүл. Энэ италиар муу ярьж байхы нь сонсов уу? гэж түрүүчийн офицер хэллээ.

-Новш минь чам шиг л ярьж байна гэж би хэллээ.

-Үүнийг тийш нь аваачиж нийлүүл! гэж түрүүчийн офицер хэлэв.

Офицеруудын дэргэдүүр намайг гаргаж олон хүн зогсож буй голын эргийн задгайд аваачив. Биднийг явж байхад тэнд буу дуугаран дарь манасхийв. Биднийг очиход дөрвөн офицер зэрэгцээд өмнө талд нь хоёр цагдаагийн хооронд нэг хүн зогсоно. Цаахна нь байцаалгах гэж буй хэсэг хүнийг цагдаа нар манажээ. Байцааж буй офицерын дэргэд карбин буугаа тулсан дөрвөн цагдаа бас байна. Тэр цагдаа нар өргөн хүрээтэй бүрх өмсжээ. Намайг авчирсан хоёр цагдаа, байцаалгах гэж буй хүмүүс дунд намайг түлхэн оруулав. Байцаалгаж буй хүнийг харвал, цуваан дундаас авчирсан сайхь намхан тарган буурал дэд хурандаа байв. Офицерүүд байцаахдаа, их л албархаг, ширүүн бөгөөд буудахдаа, хариу буудна гэж санадаггүй итали хүний

бардам зам гаргана

-Ямар бригад вэ? гэхэд нь тэр хариулав.

-Ямар хороо вэ? гэхэд нь тэр хариулав.

-Яагаад хорооноосоо тасарсан бэ? гэхэд нь тэр мөн хариулав

-Офицер хүн ангиатайгаа ямагт хамт явах ёстойг чи мэднэ биз дээ? гэж асуув.

Тэр мэдэлгүй яахав дээ. Дахиад юм асуусангүй. Өөр офицер түүнтэй ярив.

-Чамаас болж чамтай адилхан зэрлэгүүд эх орны ариул хилийг цөмөрлөө.

-Байзаарай гэж дээд хурандаа хэлэв.

-Чам мэтийн урвагчдаас болж бидний ялах зам хаагдлаа.

-Та ер нь ухарч зсэн үү? Гэж эд хурандаа асуулаа.

-Италичууд ухрах ёсгүй.

Бид бороонд зогсож эд бүгдийг сонсож байв. Бид офицерүүдийн өөдөөс харж зогсх бөгөөд баривчлагсал бидний өмнө жаахан тусгайдуу байна.

-Хэрэв та нар намайг будах гэж байгаа бол ахиад байцаалгүй, шуу буудаж үзээрэй. Ингэж байцаах чинь дэмий гээд тэр залбирив. Офицерүүд ярилцсанаа нэг нь тэмдэглэлийн дэвтрийн хуудсан дээр юм бичээд:

-Ангиа орхисон тул буудан ална гэв

-Хоёр цагдаа ирж дэд хурандааг эрэг тийш аваачив. Толгой нүцгэн тэр өвгөн бороонд хоёр цагдаагийн дунд орж явсан бөгөөд би буудахы нь харсангүй, зөвхөн буун дууг нь сонсов. Тэд дараах хүний ньб айцааж байна. Тэр хүн бас ангиасаа тасарсан офицер байлаа. Учирлах гэхэд нь үөвшөөрсөнгүй. Өврийн дэвтрийн худсанд бичсэн ялын тогтоол уншаад тэр уйлж, түүнийг буудан алахад нөгөөдүүл дараачийн хүнийг байцааж байв. Байлцаалгаж дөнгөж дууссан хүнийг голын захад аваачиж буудах үед дарачийн хүнийг байцааж байх гэж тэд ямагт яарч буй ажээ. Үүнээс үзэхэд энд яах ч аргагүй нь илэрхий байлаа. Хүлээж байцаалгах уу эсхүл даруй зугтах арга бодох уу гэгээ би мэдэхгүй байв. Би итали цэргийн хувцастай герман болж таарах нь илэрхий байлаа. Хэрэв тэд ухаантайсан болоод ухаанаараа боддогсон бол юу бодож буйг нь би төсөөлж байлаа. Тэд цөм залуус агаад тэд эх орноо аварч буй ажээ. Тальяментад хоёрдугаар армийг дахин бүрэлдүүлж буй болно. Ангиасс л тасарсан байвал тэд хошууч болоод түүнээс дээш цолтой офицериыг ч буудан алж байлаа. Тэрчлэн итали цэргийн хцвастай германы ухуулагчдыг басяллаж байв. Тэд болон мөн хэдэн цагдаа төмөр малгай өмсжээ. Бусад цагдаа нь өргөн хүрээтэй бүрх өмссөн бөгөөд бид тэднийг онгоц гэж хочилдог билээ. Бид бороонд зогсож, нэг нэгээр маань гарган байцааж буудна. Алах ялаас амь хэлтэрсэн хүн өдий болтол нэг ч гарсангүй. Бусдын амьдралыг тооцоолохдоо тэд дэндүү хүйтэн хандаж хууль ззүйг үл хайхрах агаад гэтэл тэдний амьдралыг заналхийлсэн зүйл ер үгүй байна. Тэд одоо зам ын хорооны хурандааг байцааж байна. Бас л гурван офицер авчрав.

-Хороо чинь хаана байна? гэв.

Би цагдаа нарыг ажлаа. Шинэ барьж ирсэн хүмүүсийг тэд харж, бусад нь хурандааг харсаар байв. Би гэнэтэд ухасхийж хоёр сахиулын дундуур харайгаад гол руу бөхийн зугтав. Эрэг хүрээд буудрэн ус хүчтэй цацан орлоо. Ус тун хүйтэн байв. Би чадах чинээгээрээ усан доогуур шургав. Урсгал дагуу урсаж явлаа. Амьсгаага барьж ядталаа б усан дор шумба байлаа. Тэгээд дээшээ цухуйж амьсгаа авмагцаа дахин усан доор орлоо. Бүрэн хувцастай, шаахайтай тул усан дор шумбахад хялбар байна. Хоёрдахь удаа амьсгаа авахдаа би өмнөтэй урсаж буй гуалинг харж түүнийг гүйцэн нэг гараар зуураад ард нь толгойгоо нууж юм харахыг ч бодсонгүй. Эрэг рүү харах дургү йбайлаа. Эхлээд гүйхэд дараа нь ах түрүүн амьсгаа авахад буун дуу сонсдож билээ. Гүехэн усан доогуур хөвөхөд ч буун дуу сонсдож байв. Одоо буун дуу дуулдахгүй байна. Усан дээгүүр гуалин займарч би нэг гараараа зууран, эцэг тийш

харахад тун хурдан жиэрзэн өнгөрөх шиг болно. Голын захаарих ой өнгөрнө. Ус тун хүйтэн байна. Бут ургасан жижигхэн арал өнгөрлөө. Би гуалингаас хоёр гардан барьж урсав. Эрэг үзэгэхээ болив.

[Top](#)

---

Түргэн урсгалтай голоор хөвөхөд удсан удаагйг мэдэхүйеэ бэрх билээ. Удсан мэт санагдах боловч тун удаагүй байж ч болно. Ус хүйтэн агаад тун их байлаа. Үерлэх үед эрэг дээрээс хамагдсан янз брийн юм зөндөөн урсана. Аз блоход хүндхэн гуалин тааралдаж, би зуурч бариад хүйтэн усанд биеэ гэцлэн эрүүгээ модон дээр тавьж хоёр гараар барихад хялбарчилж ядна. Би шөрмөс татахаас айж, эрэг тийш урсаж очоосой гэж хүснэ. Холуур тахирлан урссаар байв. Үүр тэмдгэрч эргийн бут харагдахаар болов. Өмнө талд бут ургасан арал харагдаж усны урсгал тэр эрэг тийш чиглэв. Гутал хувцсаа тайчиж хаяад сэлж эрэг хүрье гэж бодож байснаа болив. Яаж ийгээд эрэг дээр гарна гэж би бат итгэж байсан бөгөөд гуталгүй болчихвол харин хэцүү болно. Юуны өмнө Местре хүрэх хэрэгтэй.

Эрэгт нэг ойртож, нэг холдож алгуур өхвөн хөвсөөр бүр ойртож бургасны мөчир танигдах болов. Гэтэл гуалин гэнэт эргэж эрэг ар талд гарав. Би усны эргүүлэгт оржээ. Тэгээд нэгэн байрандаа алгуур эргэлдэв. Эрэг дахин харагдаж бүр ойрхон болоход нг гараар гуалингаас барьж нөгөө гараар самран хөлөөрөө сэлж эрэг тийш ойртох гээд гуалингаа татаж дийлсэнгүй. Эргүүлэгшний дунд орчих вий гэж би ихэд айж байв. Тэгээд нэг гараараа гуалингаас барьж хөлөөрөө гуалинг жийж хүчлэн эрэг тийш үрэв. Эхлээд бут харагдсан болвч хүчин зүтгэл мань талаар өнгөрч би урсгалд автан нөгөө тийшээ хөвөв. Шахайнаасаа болж живэх нь гэж хачин их аймшиг төрөөд хамаг хүчээрээ устай тэмцэлдэж нэг хартал над руу эрэгж ойртож ирэх шиг болоход айхавтар хүн хөлөө татан эрэг хүртэл самчитж бургасны мөрөөс зууран арьж зүүгдэв. Татаад гарчих тамиргүй боловч живэхээс өнгөрсөн гэж бодож байлаа. Гуалингаас барьж явахдаа ч би ер живнэ гэж бодогүйсэн билээ. Хүчилснээс болж дотор балартахад мөчрөөс барьсан хэвээр түр хүлээгээд дотор онгойход жаахан ахиж, бас жаахан ам арч, бут тэврэн мөчрөөс зүүгдэж тэг тэгсээр уснаас гараад бургасан дундуур орж эрэг дээр гарав. Үүр бараг цайгаад хүн амьтан үзэгдэхгүй байв. Би газар хажуулдаж хэвтээд усны шуугиан, борооны чимээ чагнан байв.

Хэсэг байснаа босож эрэг дагаж явав. Лагизан хртэл нэг ч гүүр байхгүй гэж би бодпов. Барагцаалбал Сан-Битогийн нөгөө талд явж байна гэж би бодлоо. Тэгээд бицаашид хэрхэн тухайгаа бас бодов. Өмнө талд гол руу орсон суваг байна. Би тийш очив. Тэр орчинд хүнгүй тул би сувгийн эрэг дээр бутны ёроолд сууж шахайгаа тайлж усы нь асгав. Тэгээд цэрэг цамцаатайлж хажуу халааснаас нь баримт мөнгө сэлт нь нэвт норсон түрийвчээ авч цамцаа мушгив. Мөн өмдөө тайлж, шавхраад дараа нь дотуур өмд цамцаа тайлж усы нь базав. Биеэ би алгаараа нилээд илбэж барилж байгаад дахин хувцаслав. Би малгайгаа гээсэн байна.

Цэрэг цамцаа өмсөхийн өмнө би ханцуйнаас нь цэмбэн таван хошуудыг авч мөнгөтэ хамт хажуу халаасанд хийв. Мөнгө маань норсон боловч бүтэн байна. Би мөнгөө тоолж үзэв. Гурван мянга гаран лир бйалаа. Хамаг хувцас нойтон учир биенд наалдана. Бие сэргээх гэж би хоёр гараа даллаж үзэв. Би ноосон дотуурхувцастай тул, яваад байвал лав хатгалга тусахгүй биз. Гар бууг минь замд хураасан учир гэрий

нь би цамцан дотуураа нуув. Цувгүй болоод бороонд би даарч бамйлаа. Тэгээд би сувгийн эрэг дагаж явлаа. Үүр бүр цайгаад, эргэн тойрон нойтон, эзгүй уйтгартай ажээ. Эзгүй тал нойт дааж тэртээ захад нь гонх ёрдойно. Би замаар орж явлаа. Гээтл тэр замаар өмнөөс чиглэн явган цэргийн отряд айсуй явна. Би хазганан замын зах барьж явахад цэргүүд намайг ер тоолгшүй хажуугаар өнгөрөв. Тэд гол орж яваа пулемётын анги ажээ. Би цааш одов.

Тэр өөдр би Венецийн талыг тууллаа. Тэрхүү тэв тэгш нам дор газар нь бороонд бүр чмэлтийн харагдана. Тэнгис талдаа элсэн хошуу олонтой агаад зам багатай, тэ рталыг гатлахад, тэнгист цутгах голын адгаархэрэн суваг дагуух зөргөөр явна. Тэр талаар би умраас өмнө зүг чиглэн төмөр замын хоёр шугам, мөн олон зам огтлон гарч нэгэн зөргөөр орж явтал, элсэн тохой захлан одсон төмөр зам тааралдавю. Тэр нь Триест-Венецийн зам агаад өндөр бөх далантай, өргөн бат хос замтай юм. Цааш хэсэгхэн явтал түр зогсоол тааралдаж, харуул зогсож харагдав. Замын нөгөө талд элсэн тохой руу урссан гол гардаг гүүр байна. Гүүрийн тэнд бас харуул зогсоно. Тал дундуур би умар тийш эргэн явтал галт тэрэг яваа харагдав. Цэлгэр талд холоос харгдах галт тэргийг үзээд би, Портогруарогоо яваа энэ галт тэргэнд үсрэн гарчя болох болов уу гэж бодов. Тэгээд би харуул тийш хараад, далангийн ирмэг налан хэвтэв. Замын хоёр тал нэлэнхүйдээ харагдаж байлаа. Гүүрийн хажуудах харуу, зам дагуу намайг чиглэн хэд алхсанаа, эргэж гүүр тийш явав.

Өлсгөлөн би вээр галт тэрэг хүлээж хэвтэв. Холоос харагдах тэр галт тэрэг ихээхэн урт учир биеэ дааж ядан алгуур явах бөгөөд явуут дунд нь үсрэн гарч болмоор санагдана. Хүлээж ядан байтал галт тэрэг ч ойртон ирлээ. Галт тэрэг яг намайг чиглэн тодрон тодорсоор . Би эргэж харуул тийш харлаа. Харуул, замын нөгөө талын гүүрийн наад үзүүрт явж байна. Галт тэрэг хүрч ирэхдээ намайг харуулаас хаахаар байлаа. Тэгээд би галт тэрэг ойртохыг харав. Галт тэрэг уухилан явна. Тун урт аж.Галт тэргэнд манаа буй гэж бодоод би олж харъя гэтэл үзэгдчих байх гэж айгаад чадсангүй. Миний хэвтэж буй газарт галт тэрэг бараг зэрэгцэж толгой нь дэргэдүүр гарахдаа уухилан, доорхи газраа үлээн машинч нь ч харагдахгүй болж өнгөрөхөд бид босож, манаа нь цонхоор харсан ч сэжиг авахааргүй, замын дэргэд ойртон хэсэг зогсов. Ачааы хэдэн битүү вагон өнгөрлөө. Дараа нь дэгүүрээ брезент татсан эндхийнхний гондол гэж нэрлэдэг намхан задгай вагон залгаатай харагдав. Би тэр вагоныг бараг өнгөрмөгц үсрэн гараад хажуугийн бариулаас атган тогтов. Тэгээд би, гондол болон, дараагийн ачааны битүү вагоны хоорогндох тавцан дээр гарлаа. Намайг лав хүн олж хараагүйбайх гэж бодлоо. Тэгээд би залгур руу жийж бариулаас барин суув. Гүүр хүрч ирхийн үед харуул санаанд оров. Хажуугаар нь өнгөрөхөд харуул намайгхарлаа. Тэр бараг хүүхэд агаад тэндүү том төмөр малгай нүди й нь таглажээ. Ихэсэг янзтай харахад минь тэр эргэж, гат тэрэгний бригадын хүн гэж бодов бололтой.

Галт тэрэг өнгөрөн өнгөртөл тэр харуул тайван хэвээр харж байв. БӨрезент яаж бэхэлснийг үзэхээр би тонгойв. Зах нь цагилагтай бөгөөд олсоор уясан тул би хутгаа гаргаж огтлоод гара оруулж тэмтрэхэд бороонд норсон хатуу хөөнгө зүйл байна. Урагш харвал, урд талын-вьагоны тавцан дээр манааны цэрэг өөр тийш харж зогсоно. Тэр даруйд нь брезентэн доогуур шургав. Духаараа нэг юм мөргөж, нүд харанхуйлааад нүүр рүү цус урсах шиг болход улам цааш орж элэглэн хэвтэв. Тэгээд би эргэн босож брезентийг дахин бхлэв.

Би брезентэн дор тос, керосин ханхалсан зэвсэг дотор хэвтэн дугуйн түргээн, борооны чимээ чагнан байв. Гаднаас нэвтэрсэн бүдэг гэрэлд би брезентэн ууттай зэвсэг байхдаа гэж бодно. Духан дээр минь булдруу тогтжээ. Би цусы нь тогтоон, зогсоох гэж хөдлөлгүй хэвтээд шархы нь хөндөлгүй хатсан цусы нь маажихад

өвдөхгүй байлаа. Наад алчуур байсангүй тул брезентнээс гоожижбуй борооны усаар хатсан цусны үлдэгдлийг норгон хурууны өндгөөр угаагаад ханцуйгараа цэвэрлэн арчив. Намайг хараад хүн сэжиг авахгү йбайх ёстой. Местре хүрэхээс өмнө би буух хэрэгтэй. Яагаад гэвч тэнд хүн ирж зэвсэг шалгана. Энэ зэв сэг цөөн учир хүн төөрөөд байх юм алга байна. Би тун ч өлссөн байв.

[Тор](#)

---

Би брезентэн доорхи тавцангийн банзан дээр зэвсэг дунд, норсон, бээрсэн, ихэд өлссөн хэвтэнэ. Тэгээд би эргэн түрүүлгээ харан гараа дэрлэв. Өвдөг минь шархирна. Гэвч түүнд зовж гомдох юмгүй. Валентин хийдгээ сайн хийсэ. Би түүний хийж өгсөн энэ өвдгөөр ухралтын хагасыг явган туулж, Тальяментод хэс эг зуур сэлсэн. Үнэндээ тэрний хийж өгсөн өвдөг шүү дээ. Нөгөө өвдөг нь миний юм. Эмч хүн биенд чинь элдэв мю хийнэ. Тэгээд тэр нь чинийх бус болно. Толгой минь минийх, гэдэс дотор минь мөн минийх билээ. Одоо тэр гэдэс дотор тун их өлсөж, хамаг юм нь мушгиралдана. Толгой минь минийн боловч захирагдахгүй, юм бодоод л, өнгөрснийг дэндүү санагдуулах юм.

Би Кэтринг санаж болно. Гэвч дахин уулзах эсэхээ мэдэхгүй. Тэр хүүхнийг санаад бодоод байвал би галзуурч ч магадгүй. Би тэр хүүхнийг бодохгүй байх гэж хичээлээ. Яахав тэр хүүхний тухай түргэхэн бодъё. Яавах, дугуй удаахан эргэх зуурхан л бодъё. Гэрэл брезент нэвтлэн бүдэгхэн цацарна. Би Кэтринтэй хамт тавцангийн банзан дээр хэвтэж байна. Тавцангийн банзан дээр нойтон хувцастай хэвтэхэд хатуу агаад бодол арилж, зөвхөн мэдрэн байна. Дэндүү удаан уулзахгүй явжээ. Банз ёрон өргөнө. Дотор сэтгэл уйтгартай, гагцхүү нойтон хувцас бтищед нхалдаад, эхнэрийн оронд хатуу банз л байна.

Брезентэн дор зэвсэг дунд тун аятай таатай буй боловч бороо нэвтэрдэг брезент төмөр тос үнэртсэн брезентэн дугтуйтай зэвсэг ачааны тавцангийн банзанд урлаж болохгүй. Харин өдгөө дүрслэн бодох зүсгүй ч гэсэн өөр нэгэн хүнд чиний хамаг дурлал чиглэн буй. Дэндүү хүйтэн хурц харагаар өдгөө хий ширтэн банам даа. Хүйтэн ч гэхээргүй, харин хурц хоосон гэмээр аж. Нэг арми ухарч, нөгөө арми давшсаныг үзсэний эцэст түрүүлгээ харж хэвтээдхоосон харцаар хий ширтэн байнам даа. Түймэр гарахад тасгийнхаа бараг шатаг гэсэн худалдагч шиг би машин хүнээ сөнөх болгосон билээ. Гагцхүү эд агуур нь даатгал үгүй байжээ. Өдгөө тэгээ тэрнээсээ амсалцан байна. Одоо өөр хийх алба байхгүй. Далгүүр шат саны дараа, урьдын адил худалдагчид нь хувь нийлүүлэгчтэй ярилцаж байвал буудан алдагсан бол, дэлгүүр дахин онгоймогц худалдагчид эргэж ажиллана хэмээн хэн ч хүлээхгүй нь лавтай билээ. Хэрэв өөр ажил байгаад цагдаа баривчлаагүй йбол тэд өөр ажил хайх болно.

Хорсол, үүрэг хоёрыг минь цугт нь голын ус угаачихсан. Тэр ч байтугтай, захнаас минь цагдаа барьж авах үед л би үүргээ умартсан. Гадаад байдлаараа би уг хэрэгт нэн холбогдолгүй йболовч цэрэгхувцсаа тайлмаар санагдлаа. Тэгээд би сэтгэлээ л тайтгаруулах гэж таван хошуугаа ханз татав. Энэ ч нэр төрийн хэрэг биш. Би ер нь хүнд муу санаж яваагүй. Зүгээр л би тэр нэг юмыг алсан. Би тэднийг ер сайн яваасай гэж хүсдэг байсан. Тэдний зарим нь сайн санаатай зоригтой, тэсвэртэй, ухаантай байсан болоод ч амжилт олсон. Тэр ч одоо надад мар хамаа байх билээ. Харин энэ новшийн галт тэрэг бушуухан Местре хүрээсэй. Тэгвэл нэг юм идэж,

бодлоосоо ангижрах юмсан. Ангижрах ч ёстой.

Намайг буудан алуулсан гэж Пиани хэлнэ. Буудан алуулсан улсын өвөр түрийг нэжиж баримт бичгий нь авдаг. Миний баримт бичиг олдохгүй. Намайг живсэнд тооцож ч болно. Нэгдсэн Улсад юу гэж мэдээлэх болдоо. Шарх буюу өөр шалтгаанаар үхсэн гэнэ. Даанч их өлсөж байна даа Манай лам ясан бол доо. Ринальди яасан бол доо. Порденонд очсон болов уу. Цааш ухраагүй л бол тэнд бий. За даа, бид хоёр дахиад ер уулзахгүй биз. Дахиад би хэнтэй нь ч ер уулзахгүй биз. Тэр нэгэн амьдрал төсчээ. Ринальди тэмбүүрсэн нь үнэн гэж үү дээ. Яалаа ч цагт нь л эмнэвэл, тэр ч тийм хэцүү өвчин биш гэдэг дээ. Гэхдээ тэр санарна. Би ч бас сандарна. Ер хэн хүн сандарна.

Би бодох л гэж төрөөгүй. Би идэх гэж төрсөн. Хар чөтгөр гэж дээ. Идэж ууж Кэтринтэй унтах гэж төрсөн. Өнөөдөр ч магадгүй. Тэр ч худлаа. Тэгвэл маргааш сайн хооллож, цагаан даавуу дэвсэж, дахиад хаашаа ч явалгүй, дандаа хамт байх гэж үү дээ. Тун удалгүй явах болно биз. Тэр явна. Тэрнийг явна гэж би мэдэж байа. Хамт хэзээ явах вэе Чухам энэ тухай л бодох хэрэгтэй. Харанхуй болж байна Хаашаа явахаа бодож би хэвтэнэ. Явах газар зөндөө байна.

[Top](#)

---

### XXXIII

Милан хотод өглөө эргүүл, үүр цайхаас өмнө галт тэрэг буудалд ойртон хурдаа алгуур саамагч би үсрэн буулаа. Би далан гараад, нэгэн барилга дундуур явж, гудамжнаа гарав. Нэгэн зуушийн газар онгорхой тул кофе цай уухаар орлоо. Дарстай аяганы нойтон мөр, халбага дүрсэн кофе цайтай аяга харагдаж, тоостой хлилдсон өглөө эртийн үнэр татна. Лангууны дэргэд эзэн нь зогсож, хоёр цэрэг ширээний цаана сууна. Би лангуун тийш очиж, аяга кофе цай уугаад, зүсэм талх идэв. Сүлсэн кофе цай сааралтаж, хөөсий нь би талхны хальсаар хамав. Эзэн нь намайг ажиглана.

-Аяга граппа дарс уух уу?

-Үгүй ээ. Баярлалаа.

-Үнэ авахгүй гээд багахан аяганд түүргэн над руу дөхүүлээд:

-Фронтод сонин юу байна? гэж асуув

-Мэдэхгүй

-Эд согтуу байна гэж ширээний цаана суугаа хоёр цэргийг заав. Үнэхээр ч тэр хоёр согтуу аж.

-Фронтод сонин юу байна, яриач! гэж тэр хэлэв.

-Фронтын тухай би юу ч мэдэхгүй.

-Буухы чинь би харсан. Чи галт тэрэгнээс харайж буусан.

-Ухарч л байна.

-Би сонин уншдаг. Шинэ юм юу байна? Хэзээ дуусах вэ?

-Болоогүй байхаа

Банхгар лонхноо граппа дарс аягалаад

-Хэрэв та будлиантай бол би нууж чадна шүү гэвю.

-Над будлиантай юм байхгүй.

-Хэрэв будлиантай бол энд бай.

-Энд хаана нь?

-Манайд бай. Олон хүн бий. Будлиантай хүмүүс ер нь энд суудаг юм.

-Тийм хүн олон уу?

-Юун тухайгаасаа болно. Чи өмнөд америкийн хүн үү?

-Үгүй

-Испаниар ярьдаг уу?

-Бага зэрэг ярьдаг

Тэгээд тэр лангуугаа арчив.

-Одоо хил давахад хэцүү, гэхдээ болно.

-Би давах гээгүй.

-Тэгвэл энд хэдүй хүртэл ч байж болно.

Намайг ямар хүн болохыг мэдэж болно.

-Би одоо явъя. Би хаягий чинь марталгүй, эргэж ирье.

Тэр толгой сэгсрээд:

-Ингэж ярьж байгаа хүн ч эргэж ирдэггүй дээ.

-Би үнэндээ таныг будлиантай хүн гэж бодсон юм.

-Надад ер будлиан байхгүй. Гэхдээ танилынхаа хаягийг мэдэж байх таатай л

даа.

Кофе цайны үнэ төлж, би арван лир алнгуун дээр тавив.

-Надтай граппа дарс уугаач гэж би хэлэв.

-Уух албагүй.

-Уугаач

тэр хоёр аяганд хийв.

-Мартахгүй биз. Наашаа ирээрэй. Өр хэнд ч бүү итгэ. Чи эндсэйн байж болно.

-Би итгэж байна.

-Итгэж байна уу?

-Итгэж байна.

Тэр намайг ихэд анхааралтай харав.

-Тэгвэл би чамд нэг юм захия. Энэ хувцастайгаа битгий гадуур яв.

-Яагаад вэ?

-Таван хошууд мулталж авсан ор нь ханцуйн дээр чинь өнгө ялгарч харагдаад илхэн байна.

Би дуугүй л байв.

-Хэрэв чамд бичиг бахйгүй бол би олж өгч болно.

-Ямар бичиг вэ?

-Чөлөөний бичиг

-НХадад тийм бичиг хэрэггүй. Надад бий.

-За, хэрэв бичиг хэрэгтэй болбол би ямыг ч олж өгч чадна шүү гэж тэр хэлэв.

-Тийм бичиг ямар үнэтэй байх вэ?

-Ямар бичиг гэдгээсээ болно. Үнэ багатай.

-Одоо надад юу хэрэггүй гэхэд минь тэр мөрөө хавчисхийв

-Надад бүх юм ёсоороо бий гэж би хэлэв.

Тэгээд намайг харахад тэр:

-Би нөхөр чинь гэдгийг бүү мартаарай гэв.

-Мартахгүй.

-Дараа уулзъя.

-Заавал уулзана гэж би хэлэв

Тэндээс гараад би, буудлын түүгээр цэргийн эргүүл байж магадгүй газрыг тойрч, бяцхан цэцэрлэгийн хашааны гаднаас сүүх тэрэг олоод цэргийн эмнэлэг хүргэнэ үү гэж хөтчид хэлэв. Цэргийн эмнэлэг очоод хаалгачийн өрөөнд ороход хаалгачин гар барин угтаж, эхнэр нь намайг үнсэв.



-Эргээд ирэв үү? Эрүүл биз?

-Тиймээ

-Цайлсан уу?

-Цайлсаан

-Бие сайн биз дээ, дэслэгч ээ? Бие сайн уу? гэж эхнэр нь асууна.

-Сайн сайн.

-Бидэнтэй цуг цайлах уу?

-Зүгээр барлалаа. Баркли хүүхэн одоо энд бий юу?

-Сувилагч хийдэг англи хүүхэ

-Амраг нь гэж эхнэр нь хэлээд миний мөри йг илбэж инээмсэглэв.

-Байхгүй, явчихсан гэж хаалгачин хэлэв.

Дотор аягүй оргив

-Та сайн мэдэж байна уу? Өндөр, цагаан залуухан англи хүүхэн шүү дээ.

-Мэдэж байна. Стрез орхоор явсан.

-Хэзээ явсан бэ?

-Хоёр хоногийн өмнө, бас нэг англи сувилагч хүүхэнтэй явсан.

-За, би тан нараас нэг юм гуйя. Надтай уулзсан гэж хэнд ч битгий яриарай.

Үүнийг эрхэмлэж гуйя.

-Би хэнд ч хэлэхгүй гэж хаалгачин хэлэв.

Би түүнд арван лирийн дэвсгэрт гаргаж өгөхөд тэр буцааж түлхээд

-Хэнд ч хэлэхгүй гэж би чамд амласан. Надад мөнгө хэрэггүй гэв.

-Ноён дэслэгч, танд өөр юу хэрэгтэй вэ? гэж эхнэр нь асуув

-Өөр юм хэрэггүй гэж би хэллээ.

-Бид хэлгүй юм шиг л байя. Өөр юм хэрэгтэй болбол надад мэдэгдээрэй гэж хаалгачин хэллээ.

-За баяртай. Дараа уулзъя гэж би хэлэв.

Тэд хойноос минь харсаар үүдэнд зогсоно. Би сүйх тэргэнд сууж, нөгөөх дуулж сурч байсан танил Саммонс ынд очихор явав. Порт Маджентын ойролцоо хотын нөгөө захад Симмонс суудаг билээ. Намайг очиход тэр орондоо хэвтэж, нойр нь сайн ханаагүй бололтой байна.

-Генри чи яасан их эрт босдог юм бээ? Гэж тэр хэллээ.

-Би өглөөний гат тэргээр ирлээ.

-Ухрагсад юу болж байгаа юм бэ? Чи фронтод байсан уу? Янжуур татах уу?

Ширээн дээр хайрцагт бий.

Нэг ханандаа ортой, нөгөө буланд нь төгөлдөр хууртай, шүүгээтэй, ширээний том тасалгаа байна. Орны ойролцоох мухар сандал дээр би сууж Симмон ар дороо дэр ивж суугаад тамхи татна.

-Сам минь, миний үйлс бүтэл муутай байна гэж би хэлэв.

-Би чадилхан Миний үйлс дандаа бүтэлгүй. Тамхи татах уу? гэж тэр хэлэв.

-Үгүй. Шьейцари очиход юу хэрэгтэй вэ? гэж би хэллээ.

-Чамд уу? Италичууд чамайг хил гаргахгүй.

-Тиймээ. Тэрнийг би мэдэж байа. Швейцариуд яах бол? Швейцариуд яадаг бол доо?

-Тэд чамайг тэнсэн авна.

-Би мэдэж байна. Тэрний чинь нарийн учир нь ямар вэ?

-Ямар ч үгй. Тун хялбархан. Дуртай газраа явж болно. Шалгуулж байдаг уу% нэг л ти ймэрхүү юм байдаг байх. Юу болоов? Чамайг цагдаа мөрдөж байна уу?

-Одоохондоо мэдэгдсэн юм алга.

-Ярих дургүй болбл яахав. Сонсвол сонин л байхсан. Энд онцын юм болдоггүй

Пьяченцад би осолтой унасан.

-Яагаад тэр вэ.

-Яахав дээ, тун тааруухан юм болсон. Уг нь сайн л дуулсан. Би одоо энд Лирикод нэг үзээд алдъя гэж бэлдэж байна.

-Би даанч сонсох боломжгүй нь харамсалтай байна.

-Чи дуунд их дуртай юмаа даа. Үнэхээр хэцүү явдал тохиолдсон уу?

-Сайн мэдэхгүй л байна.

-Ярих дургүй бол яахав

-Чи тэр тамын фронтдоо байхгүй, яагаад энд ирэв?

-Миний хувьд боллоо гэж би үзсэн.

-Сайн байна. Би чамайг ухаан самуураагүй гэж мэддэг байса нюм. Би яаж чамд тус болох хэрэгтэй вэ?

-Та ажил ихтэй байна.

-Генри минь гайгүй, гайгүй. Би туслахдаа баяртай л байна.

-Чи бид хоёр нуруугаар адил юм. Чи явж надад энгийн хувцас худалдаж авч өгөөч. Надад хувцас бий. Гэхдээ цөм Ромд бий.

-Аа чи урьд нээрэн тэнд сууж байсан. Ёстой адгийн газар. Тийм газар чи яаж сууж байсан юм бэ?

Би уран барилгачин болох гэж байсан юм.

-Ёстой нэг таарахгүй газардаа. Юу ч бүү худалдаж ав. Хэрэгтэй бүгдий чинь би өгье. Яг л хувцаслаад өгье. Тэр хувцасны өрөөнд ор. Тэнд ханын шүүгээ бий. Сэтгэлдээ нийлсэн бүгдийг аваарай. Найз минь, юм худалдаж авах хэргүй.

-Сим минь, би худалдаж авч ч болох байна.

-Найз минь, юм хуалдаж авахаар явсанд орвл байгаа бүхнээ чам өгсөн нь дээр байна. Чи паспорттай юу? Паспортгүй бл хол явахгү йшүү.

-Тиймээ. Хуучин паспорт минь бий.

-Найз минь тэгвэл хувцасла. Хуучин сайхан Гелвецид очих хэрэгтэй.

-Тиймч амаргүй. Би бас Стрез очих ажилтай.

-Найыз минь, тэрнээс дээр юмгүй. Тэндээс завинд суугаад л шууд явж нөгөө талд нь гарна. Хэрэв би дуулахгүйсэн бол хамт явмаар байна. Явна чиг.

-Тэнд чи өөр хоолойгоор дуулж болох юм.

-Найз минь тэгнэ чиг. Би дуулж чадна шүү дээ. Ингээд л хачин даа.

-Чамайг дуулж чаддаг гэдэгт толгойгоо ч тавихад бэлхэн байна.

Тэр гэдийн хэвтэж, бас нэгэн янжуур татав.

-Толгойгоо ч тавиад яахав. Ямар ч гэсэн би дуулж чаддаг шүү дээ. Тун сонин юм даа.

-Би уулж чадна. Дуулах ч дуртай. Сонсон уу гээд тэр “Америкчууд” хэмээх дуунаас бахиран дуулахад нь хүзүү нь нугдайн судас нь гүрийв.

-Би дуулж чадна. Тэнд дуртайгаар нь дуулж чадна гэж тэр хэллээ.

-Сүйх тэргээ явуульъя гэв

-Найз минь хурдхан ирээрэй. Хамт сууж цайлья гээд тэр босож суниагаад гүн агаар татан амьсгалж биеийн тамирын дасгал хийж эхлэв. Би гадагш гарч, хөтөчид мөнгө төлөв.

[Top](#)

Энгийн хувцас өмсөхөд наадамд яваа юм шиг санагдана. Би цэрэг хувцас тун удаан өмссөн тул одоо хувцас бище барихгүй болод, өмдний хоёр гуя салбаганаад байх шиг санагдана. Би Миланаас Стрез орох билет худалдаж авав. Мөн бүрх худалдаж авлаа. Симийн бүрхийг би өмсөж чадахгүй юм. Харин костюм нь тун аятай байв. Тэр хувцаснаас тамхи ханхлаад галт тэргэнд суужу цонхоор харх үед миний шинэ малгай шив ши нэхэн, костюм хув хуучин санагдав. Цонхны цаанах нойтон газар мэт сэтгэлд уйтайн дээр надтай нэг тасалгаанд суусан нисэгчид намайг доорд үзэж ийм залуу хүн энгийн хувцастай явах нь сэжиглэлтэй гэж үзээд харах ч дургүй байна. Би ер гомдсонгүй. Урьд нь сан бл би тэднийг доромжилж зодоо үүсгэхсэн биз. Тэд Галларатад буув. Ганцаар үлдсэндээ би баяртай байв. Надад сонин байсан боловч би дайны тухай унших дургүй хүрэд! Ер уншсангүй. Дайны тухай би мартъя гэж шийдлээ. Би ганцаар тогтнох болов. Би ганцаардан цөхөрч явтал ашгүй галт тэрэг Стрез хүрч ирэв.

Галт тэрэгний буудал дээр зочид буудлаас төлөөлөгч байх болов уу гэтэл нэг ч байсангүй. Улирлын байдаг өөрчлөгдөөд галт тэрэг угтахаа больжээ. Дотроо хоёрхон цамц бүхий Симийн өгсөн хөнгөхөн чемоданыг барьж буугаад галт тэрэг хөдөлтөл замын хажуугийн тавцан дээр зогсов. Ямар зочид буудал онгорхой бол гэж би галт тэрэгний буудлын нэгэн ажилтгнаас асуудах Гранд-Отель, мөн Дезиль Борром болон жилжингээ хаадаггүй хэд хэдэн жижиг буудал онгорхой гэнэ. Би чемоданаа барин борон дундуур Дезиль Борром орохоор явж байтал сүйх тэрэг хажуугаар өнгөрөхөд нь хөтсийг нь дуудав. Сүйх тэргэнд сууж хүрэх үед шүхэр барьсан хаалгачин угтан гарч ирэв. Тэр тун уриалгахан байна.

Би сайн байр шилж орлоо. Саруул том тэр байрны цонхор нуурхарагдана. Нууран дээгүүр намхан манан татжээ. Нарны гээрлд онцын үзэсгэлэнтэй харагдах биз. Эхнэр ирнэ гэж би хэлсэн бөгөөд тэр тасалгаанд хоёр хүний өргөн ор, letto matrimoniale<sup>26</sup> торгон хөнжилтэй байна. Энэ буудал тун чамин аж. Би урт гудмаар явж, өргөн шатаар буугаад шөнийн гуанзанд оров. Гуанзы зөөгч миний хуучин танил агаад би өндөр сандал дээр сууж давсалсан бүйлс шарсан төмс авав. Мартин дарс хүйтэн бөгөөд цэвэр тунгалаг байв.

-Та in borghese<sup>27</sup> өмсөж энд юу хийж байна? гэж надад дахин мартин дарс наруулж өгөх зуураа зөөгч асуув.

-Чөлөөгөөр явна. Биеэ сайжруулах гэж чөлөө авсан юм.

-Энд одоо эзгүй байна.а Яагаад буудал хаахгүй байгааг би мэдэхгүй юм.

-Загасчилж байна уу?

-Би хэдэн том тулбага барьсан. Яг өдий үед том тулбага үргэлж таардаг юм.

-Миний явуулсан тамхийг авсан уу?

-Авсан. Миний явуулсан ил захидлыг чи аваагүй юу?

Би инээд алдав. Тэр захисан тамхий нь би явуулж чадаагүй билээ. Тэр нь гаансанд татдаг америк тамхи бөгөөд манай гэрээс ирэхээ больж, эсхүл нэг газар саатаад ч юм уу тасарсан юм.

-Би танд олж өгнө. Энэ хотод та, хоёр залуухан англи хүүхэнтий тааралдаагүй биз? Уржигдар тэд ирсэн юм гэж би хэлэв.

-Энэ буудалд тийм улс байхгүй.

-Тэд цэргийн эмнэлгийн сувилагчид.

-Сувилагчийн хувцастай хоёр хүүхэн харсан. Байзаарай., тэд хааа байгааг нь би мэдээд өгье.

---

<sup>11</sup> гэр билийн ор гэсэн итали иг

<sup>22</sup> энгийн хувцас гэсэн итали иг

-Нэг нь миний эхнэр, би уулзах гэж ирсэн юм.

-Нөгөө нь миний эхнэр.

-Би тоглогүй шүү.

-Дэмий би тоглож байна. Уучларай. Би ойлгосонгүй гэж тэр хэлэв.

Тэгээд тэр гарч, удаан явах зуур би давсалсан бүйлс шарсан төмс идээд лангууны арын толинд энгий хувцастай биеэ харав. Гэтэл зөөгч ирэв.

-Галт тэрэгний буудлын дэргэдэх жижиг буудалд бий гэнэ гэж тэр хэлэв.

-Сэндвич<sup>28</sup> танайд байдаг уу?

-Би одоохон утастай. Энд хүнгүй болоод бэлэн юм юу ч байхгүй.

-Бүр эзгүй байгаа юу?

-Гэхдээ ганц нэг хүн бий.

Сэндвич авчрахад би гурвыг идээд, дахин мартигн арс уув. Би тийм хүйтэн цэвэр юм урьд нь ууж үзээгүй мэт байв. Мартин дарсны амт соёл хүний мэдрэхүйг минь эгүүлэн ирүүлэв. Би тун удаан хугацаанд улаан дарс, талх бяслаг, муудсан кофе цай, грапп дарсаар тэжээл хийж явжээ. Навчит мод, хүрэл, толь, дунд өндөр сандал дээр би тавтайхан сууж, юу ч үл бодно. Надаас зөөгч юм асуулаа.

-Дайны тухай ярих хэрэггүй гэж би хэлэв Дайн их алс хол болж байгаа, эсхүл дайн огт болоогүй ч байж мэднэ. Энд дайн болоогүй. Миний хувьд дайн дуусчээ гэж би гэнэтэд бодов. Гэсэн ч дайн үнэхээр дууссан гэж надад итгэгдэхгүй байна. Хичээлээс зугтаагаад, одоо сургуульд юу болж байгаа бол гэж бодсон сурагч шиг л байна би.

Намайг буудалд нь очиход Кэтрин, Эллен Фергюсон хоёр үдийн хоолоо идэж суув. Ширээ тойрон сууж байхы нь би бүр гудмаас харлаа. Кэтрин цаг харж хөндлөн суух агаад үсний нь цаанаас хацар, сайхан хүзүү, мөрх нь харагдана. Фергюсон юм ярьж байснаа намайг ороход дуугүй болоод:

-Бурхан минь! гэв.

-Сайн байцгаана уу? гэж би хэлэв.

-Өө, чи ирээ юү? Гэж Кэтрин хэлээд нүүр нь туяарав. Баярласандаа тэр гайхаж ядна. Намайг үнсэхэд Кэтрин улайв. Би тэдний дэргэд суулаа.

-За, ийм байдаг байжээ. Юу хийж байна? Хооллосон уу? гэж Фергюсон хэлэхэд би:

-Үгүй гэлээ.

Зөөгч хүүхэн ирэхэд, аяга таваг авчирч өгөөч гэж би хэлэв. Кэтрин баяссан харцаар цаг ямагт намайг ширтэнэ.

-Юу болоод чи ийм муфти<sup>29</sup> өмсөө вэ? гэж Фергюсон асуув.

-Чи ямар нэгэн өөдгүй юманд холбогдоо биз.

-Би албанд орсон.

-Ферж минь инээмээр байвал, жаахан инээж үз.

-Чам айг харахад нэг их баясаад баймаар юм алга. Чи энэ хүүхнийг ямар юманзд унагаад байгааг чинь би мэднэ. Ер нь чамайг хараад баясах юм надад огт алга.

-Кэтрин над руу харж инээмсэглэн, ширээн доогуур хөлөөрөө намайг шүргэв.

-Ферж минь, намайг хэн ч ямар ч юманд унагаагүй. Би өөрөө л орсон.

-Би үүнийг зүгээр өнгөрөөж чадахгүй. Энэ чамайг л итали зан хар санаагаар тоглож хөнөөсөн. Америкчууд италиасаа бүр доор гэж Фергюсон хэлэв.

---

<sup>11</sup> Шар тос, хиам, загасны мах, бяслаг зэргийн нэгийг хавчуулсан талх

<sup>22</sup> Албаны хйн гэртээ өмсдөг хувцасны нэр

-Харин Шотландчууд төлөв улс шүү гэж Кэтрин хэлэв.

-Би энэ тухай яриагүй. Би энүүний итали зан, хар санааны тухай ярьж байна.

-Ферж минь, би тийм хар санаатай гэж үү?

-Тийм. Чи адгийн хар санаатан. Чи ёстой могой. Итали цэрэг хувцас, цув нөмөрсөн м огой.

-Би итали цэргийн хувцсаа тайлчихсан.

-Энэ чинь чий хар санааны хуурамч нотолгоо. Чи зунжингаа дурлалаар тоглоод, энэ хүүхнийг хүүхэдтэй болгоод одоо зайлах гэж байгаа биз дээ.

Би Кэтринг харж инээмсэглэхэд Кэтрин хариу инээвхийлэв.

-Бид хоёул зайлах гэж байна хэмээн Кэтрин хэллээ.

-Та хоёр таарах юм уу? Кэтрин Баркли, би чиний төлөөнөө ичиж байна. Чи яг л энүүн шиг хар санаатйа, ичгүүргүй, нэрээ боддоггүй амьтан юмаа гэж Ферж хэллээ.

-Ферж минь зүгээр. Надад бүү уурлаач дээ. Бид хоёр бие биедээ хайртайг чи мэднэ шүү дээ гэж Кэтрин хэлээд гары нь илбэв.

-Гараа ав гэж Фергюсон хэлэхдээ царай нь улайсан байв. Тэгээд тэр ийн өгүүлрүүн:

-Хэрэв чи ичгүүрээ алдаагүйсэн бол өөр л байхсан. Хэдэн сард жирэмсэлсний чинь бурхан мэдэж байхад, харин чи энэ доромжлогчоо эргэж ирлээ гээд инээдээр хамаг юмыг тоглоом жолгож өнгөрөөх гэж байдаг. Мөн ч таарчээ дээ. Чамд ер ичиих зовох юм гэж алга гээд уйлав. Кэтрин дэргэд нь очиж нэг гараар тэвэрч аргадаад босоход нь ажваас биеийн хэлбэрт нь өөрчлөгдсөн юм алга байлаа.

-Надад ч ямар хамаа байхав. Гэхдээ тун аягүй юм гэж Фергюсон мэгшив.

-За, за Ферж минь би ичиж байна. Ферж минь битгий уйл. Миний хайрт Ферж минь бүү уйл л даа гэж кэтрин аргадав.

-Би уйлаагүй байна эгж Фергюсон мэгшээд цааш ийн өгүүлрүүн: Би уйлаагүй байна. Чамайг үзэн ядлаа гээд энэ хүүхэн оролцох эрхгүй. Чи адгийн хар санаатай амеркийн итали гэж хэлэхэд уйлсандаа болоод нүд хамар нь улайсан байв.

Кэтрин намайг харж инээмсэглэв.

-Намайг тэвэрч байгаа үедээ энүүн рүү харж бүү инээ.

-Ферж минь, чи хатуу сэтгэлтэй юм даа.

-Би биеэ мэднэ. Намайг гэх хэрэггүй. Сэтгэл их догдлоод байна. Би хатуу сэтгэлтэй. Би биеэ мэднэ. Та хоёрыг жаргалтай байгаасай гэж би хүсэг гэж Ферж мэгшинэ.

-Бид хоёр жаргалтай байна. Чи миний хайрт Ферж шүү дээ гэж Кэтрин хэлэв.

Фергюсон дахин уйлаад

-Та хоёр одоогийн шиг л жаргалтай байх юм бол хэрэг алга. Тэгээд гэрлэх нь яасан юм бэ? Энэ чинь эхнэртэй юм биш үү? гэв.

-Үгүй гэж би хэлэв. Кэтрин инээмсэглэв.

-Инээх юмүй. Тийм юм тун элбэг байдаг гэж Фергюсон хэллээ.

-Ферж минь сэтгэли й чинь амрааж бид гэрлэнэ гэж Кэтрин хэлэв.

-Миний сэтгэлийг амраах ч яахав. Та нар өөрсдөө энэ тухай бодох хэрэгтэй.

-Бид их ажилтай байлаа.

-Тиймээ. Би мэдэж байна. Хүүхэд хийгээд завгүй байсан.

-Дахин уйлах байх гээтл харин гомдов бололтой.

-Одоо чи энүүнтэй явна биз дээ

-Явъя гэвэл нь явна гэж Кэтрин хэлэв.

-Би тэгээд яах билээ?

-Энд ганцаар үлдэхээсээ чи айж байна уу?

-Айж байна.

-Тэгвэл би та нартай байя.

-Энүүнтэйгээ л хамт яв. Одоохон та хоёр яв. Чамайг дахиад харах ч дургүй байна.

-Тэгвэл хоол идчихээд явъя.

-Одоохон яв.

-Ферж минь, аятайхан байгаач дээ.

-Эндээс одоохон зайл гэж байна шүү.

Хоёул зайлцгаа.

-Тэгвэл явъя гэж би хэллээ. Ферж үнэхээр намайг залхаав.

-Та хоёр явах гэж баяртай байгаа биз дээ.

Би ганцаар хооллох болж байна уу. Италийн нуурыг үзэхсэн гэж би эртний хүссэн минь энэ болов уу. Ай даа гэж тэр хүүхэн мэгшээд Кэтринг харж цацан ханиав.

-Хоол идптэл бид байна. Хэрэв чи хамт байя гэвэл, би чамайг орхихгүй. Ферж минь, би чамайг ганцаардуулж орхихгүй гэж Кэтрин хэлэв.

-Үгүй, үгүй. Та нар явцгаа. Та нар явцга, би тэнэг хүн. Намайг гэх хэрэггүй гэж нүдээ арчив.

Ийнхүү уйлахад зөөгч бүсгүй тун их сандрав. Өдгөө тэр өөр хоол авчрахдаа хамаг юм зохицон буйг хараад сэтгэл нь амсхийжээ.

Шөнө зочидб уудал дахь манай тасалгааны хаалганы гадаа талд нь эзгүй урт гудамж, дотор талд нь бидний шаахай, шалан дээр зузаан хивм байх бөгөөд цонхны цаана бороо орж, тасалгаанд гэрэлтэй баятай, тохитой байснаа харанхуй болж, тохитой орж, нимгэн цагаан даавууны баяр эхэлж, харьж ирсэн болон шөнө сэрэхэд ганцаар бус, хажуугийн хань хаашаач яваагүй хэвээр байх аятай сэтгэл бие эзлээ өөр ер бодох юм алга байна. Бид хоёр ядарч унтаад сэрэхдэ зэрэг сэрж, ганцаардах явдал үгүй аж. Эр нь ганцар байя гэлээ гэхэд эм нь бас ганцаар бая гэх агаадхэрэв тэр хоёр бие биедээ хайртай бол аль аль нь нэгэндээ гомдолтой болно. Бидэнд ийм явдал ер тохиолдсонгүй билээ. Бид хоёр хам т байхдаа ч олны дотор байхдаа ч нэг гэж сэтгэж сурсан юм. Амьдралд анх удаа ийм болсон. Би олон хүүхэн танина. Гэвч тээнтэй цуг байхдаа ч ганцардаж, тэрнээс дор ганцаардал гэж үгүй байсан. Гэтэл бид хоёр хэзээ ч ганцаардаагүй бөгөөд хамт байхдаа айхыг ер мэддэггүй билээ. Шөнө болоход юм бүхэ өдрийнхөөс өөр болно. Шөнийн юмыг өдөр тайлбарлах аргагүй. Яагаад гэвэл шөнийн явдал өдөр үгй. Хэрэв хүн ганцаардвал шөнийн цагт бүрч аймшигтай. Гэтэл Кэтринтэй байхад өдрөөс шөнө нь илүү байсан гэж даан их ялгагдах юмгүй. Ийнхүү энэ орчлонд хүмүүс үлэмжийн эрэлхэг болбоос энэ орчлон тэднийг эвдэж алах хэрэгтэй бөгөөд алдаг ч юм. Хүн болгоныг орчлон эвддэг, тэгээд ч олонхи нь эвдрэхдээ бэйждэг. Эвдрэхгүй гэсний нь орчлон хөнөөдөг. Хамгийн соры нь хамгийн ялдмы нь хамгийн зори гтойг нь рчлон ялгалгүй алдаг. Харин чи тэр гурвын аль нь ч бус аваас чамайггагцхүү онцын яарамгүй ална гээгт итгэж болно.

Өглөө сэрснээ би санаж байна. Кэтрин унтсаар, нарны гэрэл цонхоор тусаад, бороо хэдүйн арилжээ. Би орноос босож цонхон тийш очив. Доош харвал нуурын уснаа нар тусаж нуурын чулуун хашлага мод, хайрганцар асгасан зөрөгтэй, аястай зөв зассан нүцгэн цэцэрлэг үргэлжилж, наадтай нь уулс харагдана.

Би цонхоор харж зогсож байснаа эргэн үзвэл Кэтрин сэрээд намайг ширтэж байлаа.

-Найзаа, чи босчихоо юу? Яасан сайхан өдөр вэ! гэж тэр хүүхэн хэлэв.

-Сайхан байна уу?

-Жигтэйхэн. Шөнө яасан сайхан байв аа

-Юм идмээр байна уу? Хоёул юм идмээр байсан тул цонхоор гэрэлтсэн намырн шар нарны туяанд өвдөг дээрээ тосгууртай таваг тавьж бид хоёр орондоо холлов.

-Чи сонин уншихгүй яагаав? Цэргийн эмэлэгт байхдаа чи дандаа сонин уншдаг

байсан шүү дээ. ь

-Үгүй. Одоо дургүй байна гэж би хэлэв.

-Дайны тухай унших ч дургүй хүрмээр тийм муухай байсан уу?

-Дайны тухай унши дургүй байна.

-Даанч би чамтай цуг байсангүй дээ. Байсансан бол тэр бүгдийг мэдэхсэн.

-Хэрэв яримаар юм толгойд эвлэрч өгвөл би сүүл чамд яринаа.

-Чамайг энгийн хувцастай явааг чинь мэдвэл баривчлах уу?

-Намайг буудан алах байх

-Тэгвэл бид энд байх хэрэггүй, хил давъя

-Би бас бодсон юмаа.

-Явцгаая. Найзминь чи дэмий ингэж байх хэрэггүй. Чи Местрээс Миланд яж ирсэн бэ?

-Би галт тэргээр ирсэн. Тэгэхэд би цэрэг хувцастай байсан.

-Аюулгүй байсан уу?

-Гайгүй. Надад хуучин зам үнэмлэх байсан.

Местред би тоог нь засчихсан юм.

-Найз минь, агшин бүр, чамайг баривчилж магадгүй аюлтай байна. Би сэтгэл зовж байна. Яаж ингэж бйаж болох билээ дээ. Хэрэв чи баригдвал яаа?

-Энэ тухай бодсор байгаад ядарчихлаа. Одоо мартъя.

-Хэрэв чамайг баривчлахаар ирвэл чи яах вэ?

-Буудна.

-Бүү солиор. Эндээс явтлаа би чамайг буудлаас гаргахгүй.

-Хаашаа явах юм бэ?

-Хайз минь, учиртай байж үз. Чиний л явъя гэсэн газар явна. Харин одоохон яваад очиж болох газраа л олоорой.

-Нуурын цаад захад Швейцари орон бий. Тийшээ очиж болно.

-Тэгэх юмсан.

Үүлс ахин хурж, нуур харанхуйлав.

-Үүрд гэмтэн явах хэрэгтэй л юм биш болбол гэж би хэлэв.

-Найз минь бүү тэгж ярь. Чи гэмтэн болоод удсан гэж үү? Бд гэмтэн байх ч үгүй. Бид гайхалтай сайхан амьдарна.

-Би гэм хийсэн санагдаад байна. Би цэргээс оргосон.

-Найз минь, ухаантайхан байж үзээч, чи ер нь цэргээс оргоогүй. Энэ чинь зөвхөн италийн цэрэг шүү ээ гэхэд нь би инээв.

-Чи ухаалаг шүү. Жаахан хэвтэцгээе. Орондоо хэвтэхэд наад дандаа сайхан санагддаг юм.

Хэсэг зуур болоод Кэтрин ийн өгүүлрүүн:

-Чи өөрийгөө гэмтэн гэж бодохгүй байгаа биз. Тийм үү?

-Тийгүй ээ. Чамтай байхдаа тэгэж бодож чадахгүй байна гэж би хэллээ.

-Чи тун тэнэг жаал юмаа. Харин би чамайг задруулахгүй. Найзаа энэ өглөөгүүр бие зүдрээгүй тун сайн байна шүү.

-Их сайн байна.

-Чи ямар сайн эхнэртэйгээ даанч мэдэхгүй юм даа. Тэр ч надад хамаагүй. Харин би чамайг баривчлагдахгүй газар аваачиж, бид сайхан амьдрах болно.

-Одоохон явъя.

-Тэгье найз минь. Хаашаа л бол хаашаа хэзээл бол хэзээ.

-Элдэв юм бодохоо больё.

-Тэгье.

Бяцхаен буудлын зүг Фергюсоныг үдэж Кэтринх эрэг дагуу одоод би гуанзны тохилог ширэн сандал дээр сонин уншин сууж, зөөгчийг хүлээв. Тальяментод цэрэг тогтсонгүй, цааш Пиав хүртэл ухарчээ. Би Пиавыг санав. Фрхонт ордог төмөр зам Сан –доны орчин түүгээр ойртон гардагш бөгөөд тэнд гол гүнзгийрч нарийссэн, дөргөөн урсгалтай болж, адгаараа намаг шавартай, шуудуута, хэдэн сайхан зуслан байшинтай билээ.

Дайны өмнө нэгэн удаа би Кортинад Ампеццо орохоор Пиавын хөвөө уулаар хэдэн цаг явж Кодоре хүрээд зам холдон одсо н ювм. Тэр хэсэгт хадны сүүдийн цээл, нарийн цутгалан газраа тулбага ихтэй гол мэт санагдсан юм. Тэндээс цэрэг уруудахад хэцүү байх гэж бодож суутал зөөгч ирэв.

-Греффи гүн, таныг сурагласан гэж тэр хэлэв.

-Хэн гэнээ?

-Греффи гүн. Түрүүнд ирэхэд чинь энд байсан өвгөнийг санаж байна уу?

-Тэр энд байгаа юм уу?

-Ач охинтойгоо байгаа юм. Таныг ирсэн гэж би хэлсэн юм. Тантай шаариг тоглоё гэж байна билээ.

-Хаана байна?

-Гадуур явсан.

-Бие нь ямар байна?

-Залуужаад л байна. Өчигдар үдийн хоолны өмнөхөн шампан дарстай гурван коктейл найруулж уусан.

-Шаариг тоглохдоо ямар байна?

-Сайн. Намайг хождог юм. Таныг ирсэн гэж хэлэхэд тун их баярласан. Өөр тоглох хүн энд байхгүй.

Греффи гүн ерэн дөрвөн настай бөгөөд Меттрнихийн үеийн тэр буурал толгойтой буурал сахалтай өвгөн авхаалжтай хүн юм. Австри, Итали хоёр дипломат албаан хааж байсан түүний төрсөн өдрийн баяр Милан хотын дээдсийн амьдралд онцгой үйл явдал болдог билээ. Тэрбээр зуу наслах гэж хүсдэг бөгөөд шаариг тоглохдоо тэрхүү ерэн дөрөвтэй хатингар бие нь гарамгай хөнгөн шалмаг болдог юм. Би зун өнгөрөөгөөд Стрезид ирмэгцээ түүнтэй уулзаж шаариг тоглож шампан дарс уусан билээ. Тэр ер таатай заншил байлаа. Тэр намайг цэвэр арван таван хожлоор хожсон юм.

-Тэрнийг энд гэж чи надад хэлэхгүй яагаав?

-Мартсан байна.

-Өөр энд хэн бий вэ?

-Бусды н та танихгүй. Ердөө зургаахан хүн бий.

-Одоо чи юу хийж байна?

-Хийсэн юмгүй.

-Явж загас барив.

-Ганц цаг болно.

-Явъя. Дэгээ аваарай.

Тэр гадуур хувцсаа өмсөн бид хоёр гарч эргээс бугаад завь авч би сэлүүрдэж, завийн ирмэг дээр тэр сууж дэгээ бөөрөө. Үзүүртээ хүнд гохтой тийм дэгээгээр нуурын тулбага барьдаг билээ. Эрэг дагуу явахад, тэр зөөгч загасны уурга браьж, үе үе дугтарна. Нуурын зүгээс харахад Стрез тун зэлүүд агаад урт эгнэсэн нүцгэн мод,



том буудал, эзгүрйсэн зуслан үзэгдэнэ. Би Изола-Белла тийш чиглээд эргийн ёроолоор завиа залан, цавчим ханан хад тунгалаг усанд нь туссан гүнзгий газар ороод өнгөрөн гарч загасчдын арал тийш эргэв.

-Наран үүлэн цаагуур ороод, ус харлан мэлтийж\_, тун хүйтэн байв. Усан доогуур явж буй загаснаас усан дээрх дугуй тарахыг бид хэд хэд харсан боловч дэгээг нэг ч хөдөлгөсөнгүй.

Эрэг дээр завиа гаргаад дороо сэлбэж буй загасчдын арлы нзүг би сэлүүрдэв.

-Явж юм олж уух уу? гэсэнд

-Тэгье гэв.

Чулуун зогсоол тийгш намайгн завиа залахалд, мөнөөхөн зөөгч загасны уургаа татаж завийн ёроолд тавиад дэгээг нь завина гадаа хананд бэхлэв\_. Би бууж завиа уяв. Тэгээд бидп жижигхэн кофе гуанзанд орж модон ширээнээ очиж суугаад вермут дарс захиалав.

-Сэлүүрдэж ядрав уу?

-Үгүй.

-Буцахдаа би сэлүүрдье гэж тэр хэллээ.

-Би сэлүүрдэх дуртай.

-Хэрэв чи дэгээ баривал, аз таарч юуны магад

-Болноо.

-Дайнд ямар байв?

-Жигшилтэй.

-Би дайнд явах ёсгүй. Би Греффи гүн шиг хөгшин хүн

-Явах цаг ч ирж болно.

-Хойтон миний насны хүмүүс татагдана. Гэхдээ би явахгүй.

-Та юу хийх вэ?

-Гадаадад явна. Би дайнд явах дургүй. Би Абассинид дайнд орсон. Өөр хэрэггүй. Чи яах гэж явсан юм бэ?

-Бүү мэд. Тэнэгтээ тэр биз.

-Дахиад вермут дарс уух уу?

-Тэгье

-Буцах замдаа тэр сэлүүрдэв. Бид нуурын эрэг дагаж Стрезийг тойроод буцав. Би дохийсон уурга барьж, эргэлдэх дэгээний сулхан хөдөлгөөнийг мэдрэн, намар оройн нуурын хар ус, эзгүй эрэг ширтэж, сайхь нөхөр урот урт сэлүүрдэхэд завь урагш хурдлаад уурга чичирнэ. Нэг удаа загас дэгээ зууж, гэнэтэд уурга дхийгоод, дахин доргиход нь таттал, амьд тулбагын жин мэдэгдэв. Тэгснээ дахин уурга доргиж тулбага мултрав.

-Хүнд байв уу?

-Нилээд хүнд байлаа.

-Энд би нэг удаа ганцаар явж, уургаа зууж байтал мөн нэг загас дугтарч, арай л эрүү булгалчихаагүй.

-Хөлдөө уясан нь дээр. Тэгвэл уурга татахыг мэдээд шүдтэйгээ үлдэнэ гэж би хэллээ.

Ус руу гар дүрж үзвэл тун хүйтэн бая. Бид буудалтай бараг зэрэгцэн иржээ.

-Би явах боллоо. Арван нэгэн цагт би бэлэн байх ёстой L\*heeuze du cocktail!<sup>30</sup> гэж тэр хэлэв.

-За гэж хэлээд би уургаа гаргаж эвхэв. Сайхь нөхөр чулуун хананы бяцхан зогсоолд завиа тавиад гинжээр аргамжиж цоожлов.

---

<sup>11</sup> Коктейл найруулах ёе гэсэн франц ир

-Сэлмээр байвал надаас түлхүүр аваарай гэж тэр хэллээ.

-Баярлалаа.

Бид буудлын гуанзанд орж, тийм эрт дахин архи уумааргүй санагдсан тул би өрөөндөө очив. Цэвэрлэгч цэвэрлэж дуусаад Кэтрин ирээгүй байна Би хэвтээд юм бодохгүйг хичээв

-Кэтринг ирэхэд сэтгэл уужрав. Фергюсон доор хүлээж байгаа, бидэнтэй хамт цайлна гэж тэр хэллээ.

-Чамайг дургүйцэхгүй гэж би болсон юм гэж Кэтрин өгүүлэв.-

-Зүгээр

-Найз минь чи яагаав?

-Мээхгүй.

-Би мэдэж байна. Чамд хийх юм байхгүй.\_ Чамд ганцхан би л байна. Гэтэл би явчихсан байлаа.

-Үнэн

-Уучлаарай, найз минь. Юу ч үгүй болноо гэдэг аймшигтай юм шүү.

-Миний амьдрал үргэлж зав зайгүй байсан. Гэтэл одоо чамайг л байхгүй бл цулгай болжээ гэж би хэлэв.

-Би чамаас холдохгүй шүү дээ. Би хоёрхон цаг л яваад ирлээ. Чи хийх юм бодож олж чдахгүй байна гэж үү?

-Би загас барихаар зөөгчтэй явсан.

-Аятайхан байв уу?

-Аятайхан байлаа.

-Намайг байхгүй хойгуур миний тухай битгий бодож бай.

-Фронтод байхдаа би тэгэж хичээдэг байсан. Гэхдээ тэнд хийх юмтай.

-Халагдсан Отелло гэж намайг тэр өдөв.

-Отелло хар арьстан байсан. Түүээс гадна би харддаггүй. Өөр юм болохгүй. Зүгээр л ганцхан чам хайртай гэж би хэллээ.

-Тэгвэл одоо дуулгавартай болж, Фергюсонтой эвтэй байл даа .

-Намайг л хатгахгүй бол би Фергюсонтой хэзээд эвтэй байдаг.

-Түүнтэй эвтэй байж үз. Бидэнд бол их учир байна. Тэр чинь ганцаараа шүү дээ.

-Бидэнтэй адил байх гэж тэр бодоогүй байлгүй.

-Ухаантай гэхэд, найз минь чи юу ч мэдэхгүй байна даа.

-Би тэрүүнтэй эвтэйхэн байна.

-Тэгнэ гэж би бодож байна. Чи наддаа сайн шүү дээ.

-Гэхдээ тэр чинь энд суухгүй биз дээ.

-Үгүй. Би явуулж өгнө.

-Бид энд эргэж ирэх үү?

-Иргнэ. өөр хаачих юм бэ?

Фергюсонтой цайлахаар бид уруудав. Буудал болоод тохилог ресторан нь Фергюсоны сэтгэлд тун нийлжээ. Бид сайн цайл,ж хоёр лонх капри дарс ув. Ресторанд Греффи гүн орж ирж бидэнтэй мэндлэв. Хамт яваа ач охин нь миний эмэг эхтэй нилээд адил санагдав. Кэтрин Фергюсон хоёрт би тэдний тухай ярив. Миний яриаг сонссод Фергюсоны хоёрт би тэдний тухай ярив. Миний яриаг сонсоод Фергюсоны сэтгэл ихэд хөдлөв. Буудал үлэмж том агаад баян, гагцхүү эзгүй авч хоол нь амттай, дарс нь тун аятайхан учир байн байсаар бид бүгд дарсанд халж тун таатай болов. Кэтрин дээд зэрэгтээ хүрч тун жаргалтай болжээ. Фергюсон ихээхэн баясаж, би ч өөрөө ихэд сайхан боллоо. Дайлсны дараа Фергюсон буудалдаа очив. Тийнхүү цай уусны дараа тэр хүүхэн бага зэрэг хэвтэх хүсэлтэй гэнэ.

Орой болж байтал хүн ирж хаалга цохив.

-Хэн ба? Гэсэн

-Шаариг тоглох уу? гэж Греффти гүн асуулгаж байна гэв. Би фцаг харав. Цагаа би тайлж дэрэн дор тавьсан билээ.

-Намйзаа, яаах юм бэ? гэж Кэтрин шивнэв.-Очих л хэрэгтэй дээ гэв. Таван цагт арван таван минут дутуу байлаа.

-Таван цагт би шааригы өрөөнд байя гэж Греффи гүн хэлээрэй хэмээн би чанга өгүүлэв.

-Таван цагт арван тава. Минт дутуу байхад би Кэтринг үнсээд угаалгын өрөөнд хувцаслахаар орж, зангиа зүүхдээ толинд үзвэл энгийн хувцастай би хачин харагдав. Цамц, оймс худалдаж авах хэрэгтэй юм байна гэж би бодов.

-Чи чадах уу? Сам аваад өгөөч гэж Кэтрин өгүүлэв. Оронд хэвтэхдээ тэр тун ч сайхан харагдав.

Бүх үсээ нэгэн тийш унахаар бөхийгөөд тэр үсээ самнана. Гадна хэдүйн харанхуй болоод орны толгой дээрх дэнлүүний гэрэл түүний үс, хүзүү, мөрнөө тусна. Би дэргэд нь очиж, самтай гары нь хойш болгоод үнсэхэд толгой нь дэр налав. Би хүзүү, мөрий нь үнсэв. Дурлалын хүчинд болоод толгой минь эргэнэ.

-Би явмааргү йбайна.

-Би бас чамайг явуулмааргү йбана.

-Тэгвэл би явахаа бая.

-Яахав яв. Упалгүй эргээд л ирнэ биз.

-Оройн хоолоо энэ дээр идье

-За яв. Хурдан ирээрэй.

Намайг очиход Греффи гүн шааригны өрөөнд янз бүрийн цохилтын дасгал хийж, шааригны ширээн дээрээс туссан дэнлүүний гэрэлд тун жижиг харагдана. Тогломы ширээний захдуухан сүүдэрт мөстэй мөнгөн хувин дотроос хоёр ллонх шампан дарсны толгой цухуйна. Нам айг орохд Греффи, гүн цэхлээд, угтаа ирж гар барив

-Орж ирсэнд чинь би тун их баярлалаа. Надтай тоглох гэж ирсэн чинь сайн байна.

-Намайгн урьсанд чинь тун их таатай байна.

-Бие чинь сайн уу? Изонцод би чамайг шархадсан гэж сонссон. Одоо зүгээр биз дээ?

-Би бүр зүгээр. Таны бие сайн уу??

-Аа, би хэзээ ч эрүүл байдаг. Гэхдээ өтөлж байна. Өтөлсний тэмдэг мэдэгдэх боллоо.

-Тийм л байж дээ.

-Тиймээ. Жишээлж хэлье. Одоо италиар ярихад л хялбархан байна. Өөр хэлээр хэцүү байна. Биеэ шахавч, ядрахдаа италиар ярихад амар байна. Ингээд л үзэхэд би өтөлж байна.

-Тэгвэл италиар ярия. Би ч жаахан ядарлаа.

-Ай, хэрвээ чи ядарсан бол англиар ярихад амар байх ёстой.

-Америакаар

-Тиймээ, Америкаар. Тэг тэг америкаар ярь. Гайхалтай хэл шүү.

-Одоо би америк хүнтэй бараг дайралдахгүй байна.

-Тэдэнгүйгээр чи их уйдаж байгаа биз дээ. Нутгийн хүнгүйгээр, ялангуяа нутгийн хүүхэнгүйгээр үргэлж уйтгартай шүү. Би түүнийг биеэр мэднэ. Тоглох уу, эсхүл чи ядраад байна уу?

-Би ядраагүй. Тоглоомоор тэгж хэлсэн юм. Та надтай яаж тоглох вэ?

-Энэ завсар чи их тоглосон уу?

-Ер тоглоогүй.

-Чи их сайн тоглодог шүү. Арван хожлоор тоглоё.  
-Та надад цаасан малгай өмсгөж байна.  
-Арван таваар уу?  
-Тэгвэл сайн л байна. Гэхдээ л та намайг хожно.  
-Мөнгөтэй тоглох уу? Та мөнгөтэй тоглохыг дандаа голчилдог шүү дээ.  
-Тэье.  
-Зүйтэй. Би танд арван найман хожил өгье. Нэг хожлыг нэг франкаар тоглоё.  
Тэр тун сайхан тоглож, дунд хирд нь би зөвхөн дөрөвхөн хожлоор гүйцэв.  
Греффи гүн хонх дарж зөөгчи йг дуудаад  
-Нэг лонхтойг нь онгойлгож өгөөч гэснээ надад хандаж: Сэтгэл сэргээх нэг нэг аяга юм ууя гэв.  
Тэр дарс мөс мэт хүйтэн агаад хуурай сайн ажгуу.  
-Италиар ярьцгаая. Болно биз дээ. Одоо миний ядрал мэдэгдэж байна.  
-Бид цохихын хооронд дарс шимэн тоглолсоор тоглоомондоо болоод цөөхөн боловч италиар ярьсаар. Греффи гүн зуун хожилтой, би ерэн дөрвөн хожилтай болоход тэр инээвхийлэн мөри й минь алгадав.-  
-За одоо, нөгөө лонхтойг нь ууя. Чи дайны тухай ярьж өг гээд намайг суухыг хүлээв.  
-Өөр юм ярьж гэж би хэлэв.  
-Дайны тухай чи ярих дургүй байна уу? Яахав дээ. Сүүлийн үед ч юу уншив.  
-Уншсан юмгүй, дэндүү мулгуу болохоос айж байна гэж би хэлэв.  
-Үгүй ээ. Гэхдээ унших хэрэгтэй.  
-Дайны үед ямар зохиол гарсан бэ?  
-“Leufeu”<sup>31</sup> гэдэг ном гарсан. Нэг франц зохиолч Барбюсынх “Бүхнийг нэвт хардаг ноён Бритлинг” гэж тарсан.  
-Худал байхаа.  
-Юу худал гэж?  
-Тэр чинь бүхнийг нэвт хардаггүй юм. Тэр ном манай цэргийн эмнэлэгт байсан.  
-Тэгвэл чи юм уншсан л хүн юмаа.  
-Гэхдээ сайн юм уншаагүй.  
-“Ноён Бритлинг” зохиолд английн хөрөнгөтний сүнсийг тун сайн харуулсан гэж би боддог.  
-Сүнс гэдгийг би мэддэггүй.  
-Зайлуул: Сүнс гэдгийг хэн ч мэддэггүй. Чи Crouant<sup>32</sup> мөн үү?  
-Зөвхөн шөнөдөө л.  
Греффи гүн инээмсэглэн, хуруугаараа аягаа эргэлдүүлнэ  
-Нас ахих тусмаа бишрэлтэй болно гэж боддог байсан. Гэтэл тэгсэнгүй.  
Харамсмаар юмдаа гэж тэр хэлэв.  
-Үхсэний дараах амьдралыг та хүсдэг үү? Гэж би асууснаа үхлийн тухай дэмий дурсав гэж биеэ зэмлэв. Гэвч энэ үгэнд тэр дургүйцсэнх шинжгүй байлаа.  
-Яаж амьдрахаас болно. Энэ амьдрал тун таатай амьдрал мю. Би үүрд амьдрах гэж бодсон юм. Бараг ч санасандаа хүрч байна гээд тэр инээвхийлэв  
Мөнгөн хуви нтай шампан дарс болон хундагатай ширээний хоёр талд бид ширэн сандалд шигдэн сууж байв.  
-Хэрэв чи миний насыг насалбал, олон юм чам хачин санагдана.

<sup>11</sup> Гал гэсэн франц ир

<sup>22</sup> Сисэгтэн гэсэн франц ир

-Та хөгшин харагдахгүй байна.

-Би өтөлж байна. Савааны үзүүр шиг л хуруу минь хугарчихмаар санагддаг боллоо. Харин сэтгэлээр өтлөөгүй, цэцэ нэмэгдээгүй явна.

-Та цэцэн

-Хөгшин хүнийг цэцэн гэвэл үлэмж төөрөгдөл болно. Хөгшчүүл цэцэн биш, гагцхүү сэрэмжтэй байдаг.

Тэр чинь тун онцолмор цэцэн биш дээ.

Юа юугхамгаас эрхэмлэдэг вэ?

-Хайртай хүүхнээ

-Би бас адилхан. Яагаад гэвэл надад байгаа нь л тэр. Бас төсөн өдрийн тухайд бол надаас цэцэн байгаа. Төрсөн өдрийнхөө баярыг чи хийдэг үү? Гэж тэр инээмсэглэв. Бид хоёр дарс тулгаж уув.

-Дайны тухай та ер нь юу гэж боддог вэ? хэмээн би асуув

-Дэмий юм гэж би боддог.

-Хэн нь дийлж байна вэ?

-Италичууд

-Яагаад вэ?

-Арай залуухан үндэстэн юм.

-Залуу үндэстэн нь дандаа дийлдэг гэж үү дээ?

-Тодорхой үед дийлдэх чадвартай байдаг юм.

-Тэгээд яах вэ?

-Хуучин үндэстэн болно

-Та юунд өөрийгөө цэцэн биш гэж ярина вэ?

-Эрхэм дүү минь энэ чинь цэц биш ихэрхэл гэдэг юм.

-Надад бол үлэмжийн цэцэн санагаж байна.

-Арай ч тиймгүй. Би чамд эсрэг нотолсон жишээ хэлж болно. Гэхдээ энэ зөвтэй хэлсэн үг шүү. Шампан дарсаа бид ууж дуусаа юу?

-Бараг дуусжээ.

-Дахиад уух уу? Тэгээд би явж хувцсаа сольё.

-Болно байгаа.

-Үнэхээр дургүй байна уу?

-Тийм.

-Тэр босоод:

-Чамд их амжилт, аз жаргал, хамгий сайн сайхан эрүүл мэнд ерөөе гэв.

-Баярлалаа. Таныг үүрд амьдраасай гэж би ерөөе.

-Баярлалаа. Би итгэхийг зорьж байгаа юм. Та хэрэв сүсэгтэй болбол, намайг үхэхэд миний төлөө залбираарай. Энэ талаар сүсэгтэй болъё гэж бодоод чаадхгүй байна.

Түүний инээмсэглэх нь уйтгартай мэт боловч би итгэсэнгүй. иэр ихэ хөгжрөөд, нүүрэндээ дэндүү олон үрчлээ сууж, инээхэд нь бүр ч олон болж нүүрний нь өнгө айтраанд бүтээгдэнэ.

-Би ихээхэн сүсэгтэй болж магадгүй. Яалаа ч гэсэн, би таны төлөө залбирна гэж би хэлэв.

-Сүсэгтэй болно гэж би дандаа горьдсон. Манай гэр бүл ийнхэн цөм ихээхэн сүсэгтэй болж үхсэн. Гээтл би тийм болохгүй юм.

-Цаг нь болоогүй эрт байна.

-Дэндүү оройтсон ч байж болно

Би шүтлэгийн үе өнгөрөөсөн ч байж болно.

-Надад бол зөвхөн шөнөд л орж ирдэг

-Гэхдээ чи дурласан хэвээр байна. Энэ чинь бас л шүтлэгийн сэтгэл гэдгийг

санаарай.

-Та тэгэж бодож байна уу?

-Тэгэлгүй яахав гээд шааригийн ширээ тийш дөхсөнөө: Та надтай тоглосон чинь тун сайн байна гэв.

-Надад ч их таатай байлаа.

-Дээшээ хамт гаръя.

[Тор](#)

---

Шөнө нь ширүүн бороо орж, сэрэхэд цонхны шилийг бороо балбаж онгорхой цонхоор ус урсана. Гэтэл хаалга цохих сонсдож, би Кэтринг сэрээхгүйг хичээн, тун аяархан очиж тайлбал мөнөөхөн зөөгч, нойтон бүрхээ барьсаар, пальтотой зогсоно.

-Дэслэгч тантай ярих хэрэг гарлаа.

-Юу болоов?

-Чухал хэрэг боллоо.

Эргэж харвал, тасалгаанд харанхуй бөгөөд цонхны наад шалан дээр ус тогтжээ.

-За ор гэж хэлээд би хөтөлж, угаалгын өрөөнд орж, хаалга хаагаад гэрэл асаав. Би онгоцны ирмэг дээр сууж:

-Эмилио, юу болоов? Зовлон учраа юу?

-Үгүй ээ, надад биш, дэслэгч танд холбогдолтой юм.

-Аа, ти йм үү?

-Өглөө таныг ирж баривчлах гэнэ.

-аа, тийм үү?

-Би танд дуулгах гэж ирлээ. Би хотоор явж, кофе гуанзанд тийм яриа сонсло.

-Мэдлээ.

Өмнө минь тэр нойтон пальтотой, нойтон бүрхээ барьсаар дуугүй зогсоно.

-Яагаад намайг баривчлах болсон юм ол?

-Дайнтай л холбогдолтой юм байхаа!

-Юуг нь мэдэв үү?

-Үгүй. Гэхдээ урьд нь та энд офицер яваад одоо энгийн хувцастай ирсни йг би мэдэж байна. Одоо энэ ухарч байгаа үед хэнийг ч баривчлахад бэлхэн шүү дээ.

Би агшин зуур бодолхийлэв

-хэдэн цагт ирэх бол?

-Өглөөгүр гэнэ. ЦУагий нь тодорхой мэдэхгүй.

-Та юу гэж бодож байна?

Тэр ихэд норсон м алгайгаа нүүр гарын угаагуур дээр тавихад шалан дээр ус тасралтгүй дусалж байв.

-Хэрэв та ямар ч холбогдолгүй бол айх юмгүй. Гэхдээ хэзээ ч гэсэн ялангуяа одоо үед баривчлагдах болно гэдэг тааруухан зүйл шүү.

-Би баривчлагдах дургүй байна.

-Тэгвэл Швейцари яв.

-Яаж явах вэ?

-Миний зави йг ав.

-Нууран дээр шуурга болж байна гэж би хэлэв.

-Шуурга арилсан. Давалгаатай л байна. Гэхдээ та аргална биз.

-Бид хэзээ явах вэ?  
-Одоохон яв. Тэд өглөө эрт ирж мэднэ.  
-Юмаа яах билээ?  
-Эмхэлчих. Авгай тань хуцлаг. Юмы чинь би янзалъя.  
-Та хаана байх вэ?  
-Би эндээ хүлээе Би гудамд харагдах хэрэггүй.  
Би гарч хаалгаа хаагаад, унтлагын өрөөнд ороход Кэтрин сэрүн байв.  
-Цаана чинь юу болов найзаа?  
-Зүгээр. Кэт ээ. Одохон хувцлаад завиар Швейцари явах уу? гэж би хэлээ.  
-Чи явмаар байна уу?  
-Үгүй. Дахиад л хэвтмээр байна.  
-Юу болоов?  
-Намайг өглөөгүүр ирж баривчлах гэнэ гэж зөөгч хэлж байн.  
-Зөөгч солиороогүй биз?  
-Үгүй  
-Тэгвэл, найз минь, бушуухан хувцаслаад одоохон явъя. Зөөгч угаалгын өрөөнд байна уу? гээд тэр орны ирмэг дээр суухдаа нойрмог хэвээр байв.  
-Тиймээ.  
-тэгвэл би нүүр гараа угаахгүй. Найзаа цаашаа харж бай, би бушуухан хувцалчихъя  
Унтлагын цамцаа тайлахад нь цав цагаан нуруу нь харагдав. Тэгэд би гуйсан ёсоор нь буруу харав. Тэр хүүхэн жирэмслээд бүдүүрч эхэлсэн тул харуулах дургүй байжээ. Цонхны цаана бороо шуугихыг чагнасаар би хувцаслав. Надад эмхлээд байх юм бараг үгүй байлаа.  
-Кэт ээ, юм хийвэл миний чем оданд их зайтай байна шүү.  
-Би юм аа бараг хийчихлээ. Найз минь, би дэндүү тэнэг юмаа, зөөгч яагаад угаалгын өрөөнд суугаад байгаа юм бэ?  
-Чишш, бидний юмыг авч гаргах гэж хүлээж байгаа юм.  
-Яасан сайн юм бэ?  
-Тэр миний хуучин найз юм. Нэг удаа би гаансы тамхи явуулах гээд чаадагүй юм гэж би хэлэв.  
Онгорхой цонхоор би шөнийн харанхуйг харав. Нуур үзэгдэхгүй гагцхүү хав харанхуйд боро орж, харин салхи намджээ.  
-Найзаа, би бэлэн боллоо гэж Кэтрин хэлэв.  
-Сайн байна гэж хэлээд би угаалгын өрөөний үүдэнд очиж: Эмилио, ма энэ чемодануудыг ав гэв. Тэр, хоёр чем оданыг минь авав.  
-Бидэнд та ингэж тусалдаг сайн байна гэж Кэтрин хэлэв.  
-Авхай минь, энэ юу ч биш. Би та нарт туслах дуртай байна. Харин өөрөө л юманд холбогдохгүй юмсан гээд надад хандаж: Би энэ юм авч арын шатаар буугаад шууд завин тийш очно. Та хочр зугаалах маягаар тайван яв гэв.  
-Зугаалахад сайхан шөнө гэж Кэтрин хэлэв.  
-ийм шөнийг зэвүүн шөнө гэдэг юм.  
-Надад шүхэр байгаа нь юун сайн бэ? гэж Кэтрин хэллээ.  
Бид гудмаар яваад өргөн, зузаан хивстэй шатаар буув. Гадаа үүдний дэргэдэх өрөөндөө хаалгачин суух бөгөөд биднийг хараад тун гайхсан бололтой.  
-Та гарах нь уу? гэж асуув  
-Тэгье. Бид шуургатай үеийн нуур хармаар байгна гэж би хэллээ.-Танд шүхэр байхгүй юу? гэхэд нь  
-Байхгүй. Миний пальт о нэвтэрдэггүй юм гэж би хэлэв.  
Намайг тэр эргэлзэнгүй хараад: Би танд шүхэр өгье гэв. Тэгээд тэр гарч том

шүхмэр авчраад: Жаахан том л юм даа гэж хэлэв\_ Намайг арван лир өгөхөд тэр вээр: та дэндүү өгөлөгч хүнээ. Танд их баярлалаа гэв.

Тэгээд тэр бидэнд хаалга нээж бид гадаа борооноор гарав... ХРаалгачин, Кэтрин хоёр хари лцан инээмсэглэж тэр ийн өгүүлрүү: Гадаа шуурганд битгий удаарай. Та хоёр норчихно шүү гэв. Тэр зөвхөн туслагч бөгөөд англи хэлийг үсэгчлэн дуудах нүглээс хагацаагүй хүн бавй.

-Бид удахгүй ирнээ гэж би хэллээ.

Бид том шүхэр барьж зөргөөр ороод харанхуй нойтон цэцэрлэг дундуур засмал чиглэн цааш бут суулгасан эргийн цэцэрлэгрт гудамжаар явахад нуурын зүгээс намар оройн хүйтэн нойтон салхи үлээнэ. Ууланд лав цас орж буй. Завь уясан эрэг дагуу бид явж сайхь нөхрийн завь буй газар очив. Ус чулуунаас хар харагдпана. Модны цаанаас зөөгч гарч ирлээ.

-Чемоданууд завин дээро бий гэж тэр хэлэв.

-Завины чинь үнийг би өгье гэж би хэлэв.

-Чи хи чнээн мөнгөтэй вэ?

-Дэвтэй юмгүй.

-Надад чи сүүлд мөнгө явуулаарай.

Тэгвэл дэр биз.

-Хэдийг вэ?

-өөрөө л мэд

-Чухам хэдийг вэ?

-Сайн явж хүрвэл, таван зуун франк явуулаарай. Хүрвэл ч гайгүй л дээ.

-За

-Энд сэндвич бий. Гуанзнаас олдсон нь л энэ. Энд нэг лонх конъяк архи, эг лонх дарс бий гээд тэр боодолтой юм өгөв.

Тэр бүгдийг би чемодандаа хийгээд: эднүүсийн үнийг төлвө гэв.

-Тэг, тэг тавин лир өг гэхэд нь би түүнд өгөв.

-Сайн конъяк архи шүү. Авхайдаа бардан өгч болно. Авхай тань завинд сууг гэж тэр хэллээ.

Усны давалгаанд чулуун хананы дэргэд нэг хөөрч, нэг доош буун буй завийг тэр барьж Кэтриний суухад тэслэв. Кэтрин завинд ор жсуугаад цуваа нөмрөв.

-Хаашаа явахаа та мэдэж байна уу?

-Дандаа умар зүг барьж ячвна.

-Хаагуур явахаа мэдэж байна уу?

-Луйногоор

-Эхлээд Луйно, Коннеро, Каннабио, Транцано, тэгээд Бриссаго хүрвэл л Швейцари хүрлээ гэсэн үг. Монте Тамарыг алгасах хэрэгтэй.

-Одоо хэдэн цаг болж байна вэ? гэж Кэтрин асуув

-Дөнгөж арван нэг гэж би хэллээ.

-Хэрэв зогслтгүй сэлүүрдээд байвал өглөөний долоон цагт тэнд хүрч чадна.

-Тийм хол уу?

-Гучин таван километр

-Төөрөхгүйл байх хэрэгтэй. Ийм бороотойд луужин хэрэгтэй.

-зүгээр. Изола Беллыг чиглээд яв. Изолла Мадрег өнгөрөөд салхиа дага.

Салхи туугаад та нарыг Палланцад хүргэчихнэ. Тэнд гэрэл харагдахаар эргээ дагаад яваарай.

-Салхи эргэж мэднэ.

-Үгүй ээ. Энэ янзаараа гурав хоног салхилна. Яг Маттароноос салхилж байна.

Тэнд ус шавхдаг төмөр хувин байна шүү гэж тэ хэлэв.

-Одоо завины үнэнд бага ч болсон юм өгье.



- Хэрэггүй. Би азаа туршъя. Хэрэв хүрч чадвал надад бүрэн төлөөрэй.
- За тэгье.
- Та нарыг живчихгү йгэж бодож байна.
- Тэгвэл сйна. Салхиар чигээ барьж яв.
- За гээд би завинд харайн оров.
- Байрныхаа мөнгийг охисон уу?
- Орхисон. Дугтуйд хийж ширээн дээр тавьсан.
- Сайн байна. За сайн яваарай.
- Сайн суугаарай. Танд их баярлалаа.
- Живчихвэл юунд нь байрлах билээ.
- Юу гэж байна? хэмээн Кэтрин асуув.
- Биднийг сайн яваарай гэж байна.
- Сайн суугаарай. Туйлын их баярлалаа гэж Кэтрин хэллээ.
- Бэлэн үү?
- Бэлэн.

Тэгээд тэр бөхийж, биднийг түлхэв. Би сэлүүрээ усанд дүрж, түүнд гар даллан ёслв. Хариуд нь тэр болгоомжлох дохио өгөв. Буудлын гэрэл харангаа би сэлүүрдэж, түүнийг далд ортол нь цэх явахыг хичээв.э Эргэн тойронд жинхэнэ далай давалгаалж бид салхи сөрөн аялав.

[Тор](#)

Би нүүрээрээ ямагт салхи сөрж, харанхуйд сэлүүрдэнэ. Бороо зогсоод хааяа салхины аясаар дусална. Кэтрин завин дотор сууна. Сэлүүрээ усанд дүрэхэд ус үл үзэгдэнэ. Сэлүүр маань урт боловч ирмэгт бэхэлсэн оосоргүй байлаа. Би сэлүүрээ усанд дүрж татаад гарган зөөж дахин усанд дүрээд аль болохор хөнгөн сэлүүрдэхийг хичээнэ. Сэлүүрээ зөөхдөө би, аясын салхитай тул халбагы нь эргүүлдэггү йбайв. Гар минь аль блох хошуу цэврүтэй гэж би бодож явав. Завь хөнгөн тул сэлүүрийн аясыг сайн дагана. Харанхуй усан дээгүүр би завиа урагш хөөхөн зэгдэх юмгүй, гагцфхүү удахгүй Палланци хүрнэ гэдэгт итгэнэ.

Гэтэл Палланци харагдсангүй. Өмнө зүгээс салхилаад харанхуйд Палланцийн наад хошууг би өнгөрөн, гэрэл ч үзсэнгүй. Сүүлдээ бү алсад бараг эрэг дээр гэрэл харагдсан нь Интра ажээ. Ер удтал бид гэрэл ч үзсэнгүй эрэгшч харсангүй, гагцхүү харанхуйн дунд долгион дээгүүр гулсан шаргуу урагшилна. Ихэвчлэн долгионд завь өргөгдөж харанхуйд би агаар хий сэлүүрдэнэ. Нуур догшин хэвээр байла. Би сэлүүрдсээр л байв. Гэтэл усан дээр сүглийсэн эргийн хаданхошуунд гэнэт биднийг арай л нялчихсангүй. Тэр хадыгдавалгаан мөргөж өндөрт цацагдан эргэж унана. Би баруун сэлүүрээ хүчээр дарж, зүүнээрээ эзэрэг самардан эргээс холдов. Хад харгдахаа больж бид хуучин хэвээр нууран дээр хөөвв.

- Бид нөгөө тиалд нь ирж байна гэж би Кэтрин хэллээ.
- Бидэнд Палланци харагдах ёстой байсан бус уу?
- Хошууны цаана хоцорсон
- За, найз минь, ямар байна%?
- Зүгээр
- Би жаахан ээлжилж чадна шүү.
- Яах юмбэ? Хэрэггүй.

-Хөөрхий Фергюсон минь, өглөөгүүр буудалд ирэхэд нь бид үгүй байна даа гэж Кэтрин хэлэв

-Тэр ч гайгүй хэрэг. Гаалийн манаанд харагдалгүй, харанхуйгаар явж Швейцарийн эрэг хүрэх вэ гэдэг л гол байна гэж б хэллээ.

-Одоо хол уу?

-Гучин киллометр орчим байна.

Би шөнөжин сэлүүрдэв. Алга минь холгоод сэлүүр атгахад хэцүүхэн байна. Хэд дахиж бид арай л эрэг мөргөсөнгүй. Төөрч цаг алдах буй гэж айхдаа би эрэгт тун ойрхон явсан юм. Голцуу бид эрэг дагуух зам, мод, цаадтай уулс харагдахаар ойрхинуур явав. Бороо зогсоод, үүлс салхинд туугдаж сар гарч эргэн харвал кастаньолын урт хар хошуу болон, дан цагаан байшингуудтай нуур, сарны гэрэл туссан алсын цаст оргил үзэгдэнэ. Төдөлгүй тэнгэр дахин бүрхэж нуур блон уулсын оргил харагдахаа больсон авч рой гэрэлтэй хэвээр агаад эрэг үзэгдэнэ. Эрэг дэндүү тод харагдах тул, Палланцийн зам дээр гаалийн манаа байвал, биднийг харчихна гэж болгоомжлон би завиа холдуулав. Дахин сар гарахад эргийн чанадахь уулын хажуугийн цагаан байшингууд болон моддын завсраар гэрэлтсэн цагаан зам харагдав. Би зогсолтгүй сэлүүрдэв. Уур өргөсөөд, нөгөө эргийн уулын хормойд гэрэл харагдлаа. Тэр лав Луйно буйзаа. Нөгөө эргийн уулын хоорондуур шовх шовх ан харагдах тул энэ лав Луйно гэж би мэдэв. Хэрэв тийм аваас бид түргэн сайн явсан байна. Би сэлүүрээ авч завин дотор тавиад дээшээ харж хэвтэв. Би сэлүүрдэж тун их ядарчээ. Гар мөр, нуруу өвдөөд алга холгосон байна.

-Хэрэв шүхэр дэлгэвэл яах вэ? Шүхэр рүү салхи үлээж завь туухгүй болов уу гэж Кэтрин хэллээ.

-Чи залж чадах уу?

-Чадна байх.

-Энэ сэлүүрийг сугандаа хавчаад, завины ирмэгт сан шахаж залж үз. Би шүхэр барья.

Тэгээд би хэрхэн сэлүүр барихыг зааж үзүүлэв. Би завины хошуун тийш харан, хаалгачны өгсөн том шүхрийг авч дэлгээд хөөргөж, хоёр үзүүрээс нь барин, суудпалтай холбосон бариул эдэр суулаа. Шүхэр рүү салхи хөөрөгдөж хамаг хүчээр үзүүрээс нь чангаахад завь урагш гүйх нь мэдэгдэнэ. Шүхэр гараас минхь дэрвэн дэрвэн байна. Завь нэн түргэн явна.

-Бид яг л нисэж байна гэж Кэтрин хллээ. Намдад шүхрийн ирм эгээс өөр юм харагдахгүй байна. Шүхэр татан дэрвэж бид даган урагш дүүлэх шиг санагдана. Би хөлөө бэхлээд, шүхрийн үзүүрээс улдам бат зууран явтал гэнэт нэг юм доргиж өрөөсөн тал нь дух руу минь цохиход, салхинд татагдан оройноос нь барих гэж ородтол дуу чимээ гараад салхин үлээгдэн дүүрэн тэлсэн далбаа бүхий газар би, мөнөөхө сандлаас холбосон бариул дээро эргэж задарсан үзхэотэйгээ суув. Тэгээд би бариулы нь сандлаас тайлж шүхрээ зави ны ёроолд тавиад сэлүүр авахаар Кэтрин тийш ирвэл тэр хөхөрнө. Зэтрин гараас минь барьж хөхөрсөөр байв.

-Юу болоов? Гээд би сэлүүрээ тэрнээ авав.

-Чи сая мөн чинээдэмтэй байлаа.

-Гайхах юмгүй.

-Найз минь бүү уурла. Үнэхээр инээдтэй байсан. Чи лам хорин фут өргөн болчихоод, шүхрийн үзүүрээс тун идэвхтэй барьж байсан... гээд инээсээр муурч унах шахна.

-Одоо би сэлүүрдэнэ гэсэнд

-Амарч, конъяк архи уугаач. Ийм сайхан шөнө бид, ийм их газар явлаа гэв.

-Давалгаа дагуулж завиа тавих хэргтэй гэхэд

-Би архи гаргая. Тэгээд чи жаахан ам ар гэв.

Би сэлүүр өргөж, бид авалгааны асаар ганхав. Кэтрин чемодан уудалж, надад лонхтой конъяк архи өгөв. Би жижиг тонгоргоор бөглөөг нь аваад сайн балгав. Тэр конъяк архи хатуу бөгөөд бүх биеэр халуу оргиж дулаацан сэргээд би сайн конъяк архи байна гэвэ. Сар дахиад л үүлэн цаагуур орсон авч эрэг үзэгдэж, өмнөтэй алс нууран дээр зам заасан сум харагдаж байлаа.

-Кэт ээ, даарч байна уу?

-Би тун сайн байна. Хөл л жаахан оршиж дээ.

-Европын усы нь шавхаад хөлөө жий. Завины тулгуур хяхнах, суудал доорхи ёроолын миодонд хутгуур хавирахыг чагнан би дахин сэлүүрдэж эхлэв.

-Хутгуур аваад өгөөч, ус уумаар байна гэж би хэллээ.

-Бохир байх аа.

-Зүгээр. Би усаар зайлчихъя.

-Тэгээд Кэтрин завин дээгүүр хутгуур зайлах сонсдоод надад дүүрэн устай өгөв. Конъяк архи уугаад би ихэд цангасан бөгөөд мөс мэт хүйтэн ус уухад шүд хага ташна.

Эрэг тийш харвал зам заасан сум ойртож байлаа. Урд хошууны тэнд гэрэл харагдав.

-Баярлалаа гэж хэлээд би хутгуур буцааж өгөв.

-Дахиад уухгүй юу? Яах вэ? гэж Кэтрин хэллээ.

-Чи идэх юм идээч.

-Үгүй ээ. Би өлсөөгүй байна. Өлсөхийн цагт л холтой байх хэрэгтэй.

За, яахав

Мөнөөхөн алсаас сум гэж харсан нь урт өндөр хошуу байлаа. Тэр хошуур тойрох гэж би нуурын дунд руу оров. Нуур тэнд арай ч ярвигтай байлаа. Сар дахин гарлаа. Хэрэв эрэг дээрээс *guardia di finanza hgjr* харж байгаа болбол манай завь усан дээр харлан байх байлаа.

-Кэт ээ, чи ямар байна?

-Тун сайн байна. Бид хаа явна вэ?

-Найман милээс илүү үлдээгүй байх.

-Хөөрхий минь. Бас л их сэлүрдэх нь байна шүү дээ. Чи минь амьтай л байна уу даа?

-Зүгээр. Сайн. Харин алга л холгочихжээ. Бид ямагт умрыг зүглэн явна. Баруун талын уулс шувтарч, бэл нь намхан эрэгтэй залгав. Миний бодоход тэнд лав Каннобио буй. Энэ орчинд *guardia* тун их тааралддаг аюултай тул би эргээс нилээд холуур явлаа. Урдтай нөгөө талд өндөр бөмбөгөр уул байна. Би ядарчээ. Багахад сэлүүрдэх үлдсэн боловч хүчин алдарсан цагт бас л хол байна.

Тэр уулыг өнгөрөөд таван милдь явж баймааж нь Швейцарын усанд хүрнэ. Сар хэдүйн шингэжээ. Сар шингэхээс өмнө тэнгэр дахин харанхуйлсан бөгөөд нэн харанхуй болов. Би эргээс зайдуу явж, үе үе амран, салхи цохин үзлээхээрсэлүүрээ өргөн байв.

-Алив би жаахан сэл??рдье гэж Кэтрин хэлэв.

-Зүгээр хэрэггүй.

-Дэмий юм. Тустай ч байх. Хөл ингэж оршихгүй биз.

-Кэт ээ, чи зүгээр, чамд хэрэггүй байх.

-Дэмий. Алгуур сэлүүрдвэл, залуу бүсгүйн жирэмсэнх үед ашиг тустай шүү.

-За тэгвэл, энд суугаад, алгуур сэлүүрд. Би чиний суудалд очъё. Чи дараа нь миний суудалд ир. Нааш ячвахдаа ирмэгээс бариарай.

Би пальтоныхоо захыг босгон сууж Кэтриний сэлүрдэхийг харна. Тэр сайн сэлүүрдэх авч сэлүүр нь дэнхдүү уртдаад эвгү йбайна. Би чем одан онгойлгож, хоёр сэдвич идээд конъяк архи уув. Бие сэргээд ирэхээр нь дахин уулаа.

-Ядрахаараа хэлээрэй гэж би хэлэв

Тэгээд жаахан байгад би:

-Сэлүүрээр гэдсээ бүү цохь гэж хэлэв

-Хэрэв тэгвэл, амьдрал арай хялбар байхсан биз гэж сэлүүрдэх зуураа тэр хэлэв. Би дахин коньяк архи уув.

-Ямар байна?

-Зүгээр

-Ядрахаараа надад хэлээрэй.

-За

Би дахин коньяк архи уугаад завины ирмэгээс барьж дунд нь очив.

-Хэрэггүй. Надад аятайхан байна.

-Зүгээр, тийшээ очиж суу. Би сайн амарлаа.

Коньяк архи уусны дараа би хэсэг зуур хөнгөн сайн сэлүүрдэв. Тэгээд сэлүүр мань алдарч эхлэв. Сүүлдээ гар бүр сулраад коньяк архины дараа дэндүү хүчээр сэлүүрдсэнээс болж аман дотор цөмсний эмзэг эвгүй амт амтагдана.

-Балга ус өгөөч гэж би хэлэв

-Хуви нхгаар чболно гэжээ.

үүри йн өмнө бороо шиврэв. Салхи намдаж, нуурын тохойрон орсон уул өөдөө биднийг халхлав бололтой. Үүр цайх ойртсоныг мэдэд би биеэ засаж суугаад сэлүүр дээрээ хэвтэв. Хаана яваагаа би үл мэднэ. Гагцхүү Швейцарын хэсэгт түргэн орохыг хүснэ. Гэрэл орох үед бид эрэгт тун ойр байлаа. Чулуун хясаа, модод харагдана.

-Энэ юу вэ? гэж Кэтрин хэлэв. Би сэлүүрээ өргөөд чагнав. Нууран дээр завины мотор дуугарна. Бид эрэгт бүр тулж зогсов. Чимээ нь ойртсоор, бороон дунд биднээс холгү ймоторт завь харагдав. Түүн дээр дөрвөн guardia di finanze сууж, Альпийн буучдын бүрх өмсөж, захаа босгон, карбин буу үүрсэн явах бөгөөд энэ өглөө эртүүр дөрвүүл зүүрмэглэсэн харагдана. Тэдний захан дээрх шар тэмдэг болон малгайд нь ямар нэгэн шар юм байна. Мотороо түжигнүүлсээр завь цаашлан одож бороонд харагдахгүй болов.

Би нууран дунд руу орло. Хил тун ойртсон бололтой. Замаас харуул буцаах буй гэхээс би зовж байлаа. Эрэг дөнгөж харагдахтай шүгүйтэй явж бороон дундуур дөчин таван минут сэлүүрдэв. Дахин нэг удаа бид моторт завий дуу сонсож, нөгөө эрэгт гаран чимээгүй болтол нь хүлээв

-Кэт ээ, бид Швейцарит ирсэн шиг байна гэж би хэллээ.

-Үнэн үү?

-Швейцарын цэрэг харагдахаас нааш тодорхой хэлж болохгүй байна.

-Эсхүл швейцарийн хөлөг онгоц

-Швейцарийн хөлөг онгоц гэхийн хэрэггүй. Бидний сонссон тэр моторт завь, лав швейцарийн хөлөг онгоц мөн биз.

-Хэрэв бид Швейцарит ирсэн бол адаглаад өглөөний цай ууна. Швейцари тун сайхан тос, жимс, талхтай.

Үүр бүр цайгаад шиврээ бороо орно. Өмн өзүгээс салхилсан хэвээр агаад нууран дээгүүр биднээс холдон одох цагаан давалгаа дэл татан харагдана. Бид Швейцарт лавтай иржээ. Эрэг талын соны цаадтай жижигхэн байшингууд харагдаж, цаахна нь чулуун байшинтай, суурин толгой дээр зуслангйн байшин сум байна. Эрэг дагуух зам дээр манаа буй эсэхийг лавлан харвал хэн ч үл үзэгдэнэ. Гэтэл зам нууранд бүр ойртоод, замын хажуугийн кафе гуанкнаас цэрэг гарч ирж харагдав. Тэр цэрэг бүэг ногоон хувцастай, герман цэргийнх шиг төмөр малгайтай, улаан хацартай чийрэг нүүртэй тачирхан шрви гор сахалтай юм. Биднийг тэр цэрэг харав.

-Тэр цэргийг далла гэжү би Кэтринд хэллээ. Кэтринг даллахад, тэр цэрэг

сулхан инээмсэглээд хариу даллав. Би алгурхан сэлүүдэж, суурины дэргэдүүр өнгөрөв.

-Бид хэдүйн Швейцарит ирсэн шиг байна гэж би хэллээ.

-Найз минь, лавтай мэдэх хэрэгтэй.\_ Биднийг хил дээрээс буцаахгүй л бол боллоо.

-Хил ард хол хоцорсон. Энэ гаалийн салбар байх. Бриоссаго блов уу гэж би бодож байна.

-Энд италичууд байдаг болов уу? Гаалийн салбарт хөрш орныхон дандаа их байдагсан.

-Дайны цагт тиймгүй. Одо италичуудыг хил гарахад зөвшөөрөхгүй йбиз.

Тэр тун тохи тойхон хот агаад зогсоолд нь загасчдын олон завь зогсож, шонгоос тор зүүжэ. Намар оройн зөөлөн бороо орж энд борооноор ч хөхүүн цэвэр байна.

-Тэгвэл зогсоолд зогсож цай ууя гэхэд нь

-Тэгье гэлээ.

Би зүүн сэлүүрэ хүчлэн дарж,эрэг хүрээд зогсоолтгү йзэрэгцэн хөдөлн зогсож сэлүүрээ авч, төм өр цагирганаас татан нойтон чулуун дээр хөл тавьж Швейцарын газар дээр гиш гэв. Тэгээд завиа уяад Кэтринг татах гэж гар сарвайв.

-Кэт ээ, ир. С айхан санагдаж байна.

-Чемодануудаа яах вэ?

-Завиндаа орхиё

Кэтрин гарч ирж, бид хоёр цуг Швейцари оров.

-Яасан сайхан орон бэ! гэж тэр хэллээ.

-Нээрэн сайхан байна уу?

-Хурдан явж цайлъя.

Үнэхээр сайхан орон шүү? Үүгээр явахад аятайхан гэдэг нь

-Хөл минь мэдээ алдтл оршихсон байна. Лав аятайхан байх аа. Найзаа тэр муу италиас холдож энд ирчихээд байгаагаа чи бод л доо.

-Тиймээ. Үнэхээр тийм. Би юмиыг ингэж ер тодорхой мэдэж байсангүй.

-Энэ байшинг хараач. Ямар сайхан талбай вэ? Тээр тэнд цай ууя.

-ямар сайхан бороо орно вэ? Италид ийм бороо ер ордоггүй. Сэргэмээр бороо байна.

-Найзаа чи бид хоёр ирье гэсэн газраа ирлэ. Чи бид хоёр ирье гэсэн газраа ирээд байна шүү дээ.

Бид кофе гуанхзанд орж цэвэрхэн модон ширээний дэргэд суугав. Би согтсон мэт байв. Хормогч зүүсэн аятай цэвэрхэн хүүхэн гарч ирээд юу хэрэгтэй вэ гэж асуулаа.

-Зөөлөн талх, жимс, кофе цай гэж Кэтрин хэлэв.

-Одоо дайны үе болоод зөөлөн талх алга

-Тэгвэл зүгээр талх

-Хуурсан талх авах уу?

-Тэгье

-Бас хайрсан өнөг авна

-Ноёнтонд хэдэн өндөг шарав вэ?

-Гурав.

-Найзаа дөрөв бол дээр

-Дөрвөн өндөр

Тэр хүүхнийг всан хойно би Кэтринг үнсэж гары нь чанга гэгч атгав. Бид бие биенээ ширтсэнэ тал тал тийшээ харав

-Найзаа, сайхан байгаа биз дээ?

-Тун сайхан байна эгж би хэллээ.  
 -Зөлөөн талх байхгүй дээ яахв. Би шөнөжингөө зөөлөн талх босо н юм. Гэхдээ яахав. Бүр палгүй хэрэг гэж Кэтрин хэлэв.  
 -Биднийг тун удахгүй баривчлах байх.  
 -Найзаа энэ тухай бүү бод. Бид урьдаж цай ууна. Цайлсны дараа баривчлагдахад зовлон багатай. Баривчлаад ч яах юм билээ. Би Британы харъяат, чи америкийнх бидэнд ямар ч зөрчил байхгүй.  
 -Чамд паспорт бий юу?  
 -Байлгүй яахав. За энэ тухай ярихаа больё. Баясацгаая.  
 -Би байдгаараа баясаж байна гэж би хэллээ.  
 Бүдүүн саарал муур сүүлээ эгцлээд тасалгаан дундуур бидний ширээ рүү ирж хөлий минь эвхрэн тойроод шиншин самардана. Би бөхийж үсий нь илбэв. Кэтрин над руу харж баясгалантайяа инээвхийлээд: Кофе уу гэв.  
 Цай уусны дараа бид хоёрыг баривчлав. Бид суурин дотор хэсэг зугаалаад зогсоол тийш чемоданаа эргэн очиход завины дэргэд цэрэг манаа зогссон байлаа.  
 -Энэ таны завь уу?  
 -Тиймээ.  
 -Хаанаас ирсэн бэ?  
 -Нуурын нөгөө талаас ирсэн.  
 -Надтай явцгаах хэрэгтэй байна даа.  
 -Чемоданаа яах билээ?  
 -Аваад явж болно гэв.  
 Би чем оданаа барьж, Кэтрин надтай зэрэгцэн, араас цэрэг дагаж, гаалийн хуучинб айшин тийш очив. Гаалийн газар нэн туранхай агаад дайчин янзын дэслгч биднийг шалгаав  
 -Ямар үндэстэн бэ?  
 -Би америк, хүүхэн англи  
 -Паспортаа үзүүл.  
 Би паспортаа өгөв. Кэтрин паспортаа цүнхнээсээ гаргаж өгөв. Тэр удаан шалгаж үзсэнээ:  
 -Яагаад та нар Швейцарит завиар ирээ вэ?  
 -Би биеийн тамирчин. Сэлүүрдэхэд би дуртай. Бололцоо л гарвал би сэлүүрдэж байдаг хүн гэж би хэллээ.  
 -Яагаад наашаа ирээ вэ?  
 -Өвлийн спорт хийхээр ирсэн. Бид, өвлийн спорт оролддог жуулчин улс  
 -Энд өвлийн спорт хийх газар байхгүй  
 -Бид мэднэ. Өвлийн спорт хийж болох газар явж очихоор ирсэн  
 Италид та юу хийж байсан бэ?  
 -Би уран барилга судалж манай гэргий урлаг судалж байсан.  
 -Яагаад тэндээс та нар явах болоов?  
 -Би өвийн спорт хийх гэсэн юм. Дайны үед уран барилга судлахад хэцүү байнха.  
 -Энд сууцгааж бай гээд тэр дэслэгч бидни паспортыг авч, дотор хаалгаар орлоо.  
 -Найзаа чи, зүйргүй хүн юм. Хэлснээрээ л бай. Чи өвлийн спортод дуртай биз гэж Кэтрин хэллээ.  
 -Чи урлаг бага зэртэг мэднэ би з дээ?  
 -Рубенсийг мэднэ гэж Кэтрин хллээ.  
 -Мах ихтэй гэж би хэлэв  
 -Тицианыг мэднэ гэж Кэтрин хэллээ.

Тицианы үе. Бас Мантеньяг мэдэх үү? Гэж би хэлэв.

-Хэцүү юм бүү асуу. Гэхдээ би мэднэ. Тун аймшигтай гэж Кэтрин хэлэв.

-Тун хэцүү хадаасанд түм цоорсон гэж би хэллээ.

-Чиний эхнэр тун сайн байгаа биз дээ. Би захиалагчидтай чинь урлагийн тухай ярьж чадна гэж Кэтрин хэлэв.

-За ирлээ гэж би хэлэв.

Гаалийн байшингийн гүнээс туранхай дэслэгч бидний паспортыг барьсааргарч ирэв.

-Тан нарыг би Локарно явуулах боллоо.

Сүйх хөлсөлж ав. Та нарыг цэрэг хүргэнэ гэж тэр хэллээ.

-Болноо, борлно. Завиа яах билээ? гэж би хэлэв.

-Завий чинь хураасан. Наад чемоданд чинь юу байна вэ?

Тэрвээр хоёр чемоданы юм сыг үзээд конъяк архитай лонхыг гаргав.

-Надтай нийлж уухгүй юу? гэж би асуув

-Үгүй. Баярлалаа гээд эгцлэн хичнээн мөнгөтэй вэ? гэв.

-Хоёр мянга таван зуун лир.ь

-Танай гэргийд хэд бий вэ?

Кэтринд мянга хоёр зуу гаран байсан юм. дэслэгчийн сэтгэл ханаж харьцаа нь зөөлрөв.

-Хэрэв өвлийн спорт оролдог бол хамгийн аятай газар Венген шүү. Миний эцэг Венген тун сайхан буудалтай. Жилжингээ онгорхой байдаг м гэж тэр хэллээ.

-Тун сайн байна, хаягий нь танаас авч болох болов уу гэж би хэлэв.

-Би нэрийн хуудсан дээр бичиж өгье гээд тэр тун хүндэтгэж нэрийн хуудсаа өгөөд: та нарыг Локарнод цэрэг хүргэнэ. Паспорты чинь тэр цэрэгт өгнө. Ингэхээс л өөр аргагүй байна. Локарнод очоод сэргийлэхээс зөвшөөрөл, эсхүл пиу олодоно гэж би бодож байна гэв.

Хоёр паспорты минь тэр цэрэгт өгч, бид чемоданаа аваад, сүүх тэрэг олохоор суурин тийш одов.

-Хүүе! Гэж дэслэгч цэргийг дуудамад нутгийн аялгаар юм хэлэв. Сайхь цэрэг винтовоо үүрээд бидний чемоданыг барив.

-Сайхан орон байна гэж Кэтрин хэллээ.

-Юм бүхэн туршлагатай.

-Танд их баярлалаа гэж би дэслэгчид хэлэв.

Тэр гар даллан үлдэв:

-Таны тусын тулд гэж тэр хэллээ. Бид харуулаа дагаж суурин оров.

Хөтчийн дэргэд урд суудал лдээр цэрэгтэй зэрэгцэн сууж бид сүйх тэргээр Локарно оров. Локарнод хамаг юм амжилттай бүтэв. Биднийг бацаасан боловч паспорт болон мөнгөтэй учир тун хүндэтгэж байв. Тэд ядахдаа миний ганцхан үгэнд ч итгээгүй байж болно. Ямар тэнэг хэрэг вэ гэж би бодовч шүүхэд байгаатай ялгалгүй байлаа. Энд ямар чухаалаг дүгнэлт хэрэггү йзөвхөн хэлбэрийн төдий яриа, нэмэлт тайлбаргүй үг л хэрэгтэй юм. Бид паспорттой бөгөөд мөнгөө үрэх гэж яваа улс. Тиймээс бидэнд түр хугацааны пиу олгов. Тэр пиуг хэзээ ч хурааж болно. Бид очсон газар болгондоо сэргийлэхэд бүртгүүлж байх ёстой юм.

Хүссэн тийшээ бид явж болох болов уу? Ер бид хаашаа явах хүсэлтэйсэн билээ?

-Кэт ээ, чи хаашаа явмаар байна вэ?

-Монтрэд

-Тун сайхан хот. Та нарт таалагдах хот гэж би бодож байна хэмээн байцаагч хэлэв.

-Локарно бас их сайхан хот шүү. Та нарт Локарно их тохирно гэж би бодож

байна. Энэ их сйхан хот гэж нөгөө байцаагч нь хэллээ.

-Өвлийн спорт ородож болох газар л бидэнд тохирно.

-Монтред өвлийн спорт хийдэггүй.

-Уучлаарай, би Би Монтрегийн хүн байнха. Мнтре-Оберланд-Бернскийн төмөр замын тэнд өвлийн спортод тохи рох аятайхан газар бий. Та эсэргүүцвэл буруу юм болно гэж эхний байцаагч хэлэв.

-Би эсэргүүцээгүй. Зүгээр л Монтред өвлийн спорт хийдэггүй гэж байна.

-Би эсэргүүцэж баримтаар гнотлох гэж байна хэмээн түрүүчийн байцаагч хэлэв.

-Би тэр баримты чинь цуцална.

Би нотоллгоотой эсэргүүцнэ. Би Монтрегийн гудамжаар luge<sup>33</sup> унаж гулгаж байсан. Би олонгулгасан luge бол өвлийн спортын нэг төрөл шүү дээ.

Хоёр дахь байцаагч над руу хандаж:

-Та өвлийн спорт гэхдээ luge хэлээгүй биз дээ?

Локарнод байвал онцгой тавтай байх биз. Энд эрүүл агаартай орчин тойрондоо үзэсгэлэнт газартай. Энд тун тааламжтай байх болно гэв.

Ноёнтон өөрөө Монтред очих хүсэлтэй гэсэн.

-luge гэж юу билээ? хэмээн би асуув

-Энэ хүн luge гэж ер сонсоогүй байна шүү дээ.

Миний асуулт хоёрдахь байцаагчид ихэд нийцэж тэр бардамнав.

-luge гэж яг л тобогган<sup>34</sup> чарга даа хэмээн түрүүчийн байцаагч өгүүлэв

-Эсэргүүцэх хэрэгтэй боллоо. Одоо дахиад эсэргүүцэх хэргтэй боллоо гэж хоёр дахь байцаагч толгой сэгсрэн: тобогган чарга luge хоёр их ялгаатай. Канадын хавтгай банзан тобогган чарга нэг өөр. Жирийн гулгууртай luge нэг өөр. Юуны өмнө тодорхой ярих хэрэгтэй гэв

-Тобогган чаргаар гулгаж болно биз дээ гэж би асуулаа.

-Тобогган чаргаар гулгаж бололгүй яахав. Тобогганаар гулгаж бүрэн болно. Монтред Канадын дээд зэргийн тобоогган чарга худалддаг юм. Ах дүү Окс тобогган чарга наймаалдаг юм. Тэд өөрсдөө тобогган чарга авдаг улс гэж түрүүчийн байцаагч хэлэв. Хоёр дахь байцаагч эргэж:

-Тобогган чаргаар гулгахад тусгай Pjste<sup>35</sup> хэрэгтэй. Монтрегийн гудамжаар тобогган чаргатай гулгаж болохгүй. Та хаана буусан бэ? гэв.

-Бид хаана буухаа мэдэхгүй йл байна. Бид дөнгөж Бриссогаас ирээд, сүйх тэрэг гудамжинд хүлээж байна гэж би хэллээ.

-Та Монтред очих дургүй йбайна гэж үү? Тэнд очвол зөөлөн агаартай өвлийн спортоор оролдоход хол явах хэрэггүй йболно гэж түрүүчийн байцаагч хэллээ.

-Та үнэхээр өвлийн спорт сонирхож байгаа бол Энгадин юм уу Маррен оч гэсэн энэ зөвлөгөөг би эсэргүүцэхээс аргагүй болж байна. гэж хоёрдахь байцаагч хэллээ.

-Монтрегийн тэндэх Лез-Авенд өвлийн ямар ч спортод сайхан таарна.

Мнтрегийн тэр эх оронч дургүйцэхдээ нөхрөө хялайн харав.

-Эрхмүүдээ. Бид явах хэрэгтэй. Манай гэргий их ядарлаа. Монтре яваад азаа үзье гэж би хэлэв

-Таны тэгэж шийдсэнд баяр хүргэе гэж түрүүчийн байцаагч гары минь барив

-Локарногоос явсандаа та сүүлд нь гэмших болно доо. Ямар ч гэсэн Монтред та сэргийлэхэд очоорой гэж хоёр дахь байцаагч хэллээ.

---

<sup>11</sup> Швейцарийн жижиг чарга гэсэн франц иг

<sup>22</sup> Ганц ерген банзан тулгууртай зэтгэр хошуутай чарга.

<sup>11</sup> зам гэсэн франц иг



-Сэргийлэхийн талаар тэнд тохирохгүй юм байхгүй. Оршин суугчид таныг онцын найр тавин баяртай угтана гэж түрүүчийн байцаагч надад сэнхрүүлэн хэлэв.

-Та хоёрт их баярлалаа. Та нарын зөвлөгөө надад их тус боллоо гэж би хэлэв.

-Баяртай гэж Кэтрин хэллээ.

-Та хоёрт их барлала гэв.

Хаалга хүртэл тэд мэрхийн үдхдээ локарногийн эх оронч дурамжхан байв. Бид шатаар бууж сүйхэнд суулаа.

-Ээ бурхан минь гэж дээ. Тэндээс эртхэ явж болохгүй байсан гэж үү? Хэмээн Кэтрин өгүүлэв. Нэг байцаагийн зааж өгсөн буудлын хаягийг хөтчид өгөв. Хөтөч жолоогоо барив

-Чи цэргийн тухай мартжээ гэж Кэтрин хэлэхэд харвал сүйхний дэргэд мөнөөхөн цэрэг зогсож байлаа. Би түүнд арван лир өгөөд надад өөр швейцари мөнгө алга даа гэж хэллээ. Тэр талархан ёслоод одов. Сүйх тэрэг хөөлж бид буудалд ирлээ.

Монтрегийн тухай тэр чамд юу гэх гээд байгаа юм бэ? Үнэхээр чи тийшээ явъя гэж бодож байна уу? хэмээн би Кэтринээс асув

-Эхлээд бодогдсон нь л тэр. Тэнд зүгээр. Ууланд байр олж сууж болно гэж тэр хэлэв.

-Унтмаар байна уу?

-Унтаад л явна

-Сайн унтацгаая. Хөөрхий муу Кэт минь Ийм л шөнө таарлаа шүү дээ.

-Ялангуяа чамайг шүхэр барьж суухад надад их инээдтэй байсан гэж Кэтрин хэлэв.

-Бид Швейцарт ирлээ шүү дээ.

-Зүүд шиг л байна.

Сэрэхээр л худал болмоор санагдана.

-Надад ч бас тийм.

-Гэхдээ, энэ үнэн шүү дээ? Милан хотынгалт тэрэгний буудал дээр би чамайг үдэж байгаа биш шүү ээ.

-Үгүй байхаа.

-Тэгж бүү ярь. Би айж байна. Хэрэв тийм байвал яана.

-Би согтуу юм шиг болчихоод байна гэж хэлэв.

-Гараа үзүүлээч.

Би хоёр гараа үзүүлэв. Мах нь гартлаа холгосон байлаа.

-Хажуу талдаа шарх алга гэж би эхлсэнд

-Бүү тэрсэл гэв

Би тун их ядраад толгой эргэж түрүүчийн сэргэсэн бүхэн арилав. Сүйх тэрэг гудамжаар жирийнэ.

-Гары нь хөөрхий гэж Кэтрин хэлэв

-Бүү хөнд. Хаана яваагаа мэдэхгүй ямар балай юм болж байнаа. Хөтөч өө! Бид хаашаа явж байна? гэж би хэлэв. Хөтөч морио зогсоогоод:

-Метрополь буудалд очиж явна. Тийшээ очно гэсэн биш билүү? гэв

-Тийм, тийм Кэт минь, ёсоороо мөн гэж би хэллээ.

-Найзаа ёсоороо байна. Сэтгэл бүү зов. Бид сайн унтаад, маргааш чиний согтуу байдал арилна.

-Би согтуу болжээ. Энэ өдөр туждаа инээдмийн дуурь шиг л байна. Өлсөж ч байх шиг байна гэж би хэлэв.

-Найзаа чи, ядарсан л байна. Ядаргаа арилна.

-Буудлын үүдэнд сүйх тэрэг очиж зогсоход бидний чемоданыг зөөхөөр нэг хөвүүн гарч ирлээ.

-Гайгүй болж байна гэж би хэллээ. Гүүрэн дээрээс бид буудал тийш очив.  
-Гайгүй болж байна гэж би хэллээ. Гүүрэн дээрээс бид буудал тийш очив.  
-Гайгүй болно гэж би бодсон юм. Чи зүгээр л ядарсан байна. Унтах хэрэгтэй.  
-Яав ч бид Швейцарит иржээ.  
-Тиймээ, бид үнэхээр Швейцарит иржээ. Чемодан барьсан хөвүүнийг дагаж бид буудалд оров.

[Top](#)

---

### XXXVIII

Тэр намар тунх орой цас унав. Бид уулын энгэрийн нарсан дундах бяцхан м одон байшинд суух бөгөөд шөнөдөө хүйтэрч угаагуурын хоёр домботой ус өглөөгүүр зайртсан байдаг байв. Хатагтай Гүттинген өглөө эрт тасалгаанд орж ирж цонх хаагаад өндөр шавар пийшэнд гал түлнэ. Нарсанх түлээ тачигдан шатаж, гал дүрэлзэн хатагтай Геттинген дахин бүдүүн түлээ, халуун устай домбо барьж рж ирнэ. Тэгээд тасалгаа дулаацахад тэр авгай өглөөний цай авчирна. Орондоо өндийн цайлж, нуур блон нуурын цаад францын талын эрэг дэх уулсыг бид харна. Уулын оргилд цас тогтоод нуур төмрийн өнгөөр сааралтана. Байшингийн хаагаар зам өнгөрөх бөгөөд замын хонхор, хагалсан газар хүйтэнд чулуу мэт хатуураад, төгөл дундуур зам эгч дээш гарч уул ороон, нуга, саравч хөндийн эхний ойн чөлөөн дэх овоохой тийш одно. Тэрхүү гүн хөндийгөөр гол урсаж нууранд цутгана. Хөндийн зүгээс салхилахад голын ус чулуунд шуугих нь сонсдоно.

Бид дандаа замаас гарч нарсан төгөл дундуур, зөргөөр явна. Төгөл дотор газар зөөлөн агаад зам дээрх шиг хүйтэнд хатуураагүй байна. Бидний гутлын ул сөртөн хадаастай учир хадаас нь хөлдүү газар шаагаад замаар явахад харин ч сэргэлэн таатай тул тэрхүү хатуу газар бидэнд саад болдоггүй байв. Төгөл дундуур явахад ч мөн таатай билээ.

Бидний суудаг байшингаа доош нуурын захын бяцхан талбар хүртэл цавчим бөгөөд нарлаг өдөр бид саравчинд сууж уулын энгэрээр явсан зам хардагсан. Мөн өвөл болж мөчир хатсан усан үзмийн мод бүхий нөгөө уулын энгэр, чулуун хашаагаар тусгаарласан тал, усан үзмийн модноос доош нуурын эргийн нарийн талбар дээр хотын байшин харагдана. Нуурын арал дээрх хоёр мод загасчдын завины хос дарвуул мэт үзэгдэнэ. Нуурын цаад талын уулс цавчим агаад хурц ирмэгтэй. Нуурын өм нө хязгаарт хоёр уулын сэрвэн хоорогдох Роны урт хөндийн цаад захад Дан-дю-Мидийн уулс хөндөлдөнө. Тэрхүү цаст өндөр уул тэр хөндийд ноёловч дэндүү алс учир сүүдэр үл тусгана.

Нарлаг өдөр бид саравчинд цайлж, бусад цагт дээд давхрын банзан ханатай, буландаа том пийшинтэй бяцхан тасалгаанд хооллоно. Хотоос бид сэтгүүл, ном худалдан авч, хөзрөөр хоёр хүн тоглох олон тоглоом сурлаа. Пийшинтэй бяцхан тасалгаа бидний гуанз, зочдын өрөөг хавсардаг байв. Тэнд хоёр тохилог зөөлөн сандал, сэтгүүл, ном тавьдаг жижиг ширээтэй бөгөөд аяга таваг хураасны дараа хоолын ширээн дээр бид хөзөр тоглоно. Monsieur, хатагтай Гүттинген хоёул доод давхарт суух агаад тэр хоёрын яриа оройд дандаа сонсдоно. Тэр хоёр бас ихээхэн жаргалтай ажгуу, нөхөр нь зочид буудалд ерөнхий зөөгч, эхнэр нь цэвэрлэгч хийж мөнгө хурааж энэ байшинг авсан ажээ. Хүү нь бол ерөнхий зөөгч болох гэж бэлдэж байгаа гэнэ. Доод давхарт дарс, шар айраг наймаалдаг байртай бөгөөд үдшийн цагт

зам дээр даачаа тэрэг зогсож, эрэгтэйчүүд аяга юм уух гэж шатаар байшинд орох нь ямагт сонсдоно.

Бидний тасалгааны гадаа гудамд түлээний хайрцаг байх бөгөөд би тэндээс хагалсан түлээ авч пийшинд хийнэ. Бид орой болтол суудаггүй байлаа. Унтлагын том өрөөнд бид унтдаг байв. Гэрэл асуулгүй тайчаад, би цонх онгойлгож гадаа шөнийн байдал, хүйтэнхд, цонхны дэргэдэх нарс харснхаа бушуухан орондоо орно. Гадаа шөнө болж, агаар тийн хүйтэн тунгалаг ахуйд орон байх таатай. Бид бөх унтаж, хэрэв шөнө би сэрвэл, сэрсэн учраа мэдээд дэрээ тун болгоомжтой засаж Кэтринг сэрхээлгүй, дахин, унтахдаа нимгэн хөжлийн хөнгөнд сэтгэл бүр тавтай болно. Дайн гэгч, өөр сургуульд очиж тоглосон хөл бөмбөгийн тэмцээн адил өнгөрсөн санагдана. Гэхдээ сонинд бичсэнээс үзвэл ууланд аанай тулалдаан болсоор бөгөөд өдий хүртэл цас унаагүй аж.

Би дандаа уулын хажуу даган бууж Монтред очдог билээ. Бидний байшингаас уруудсан зэрэг буй авч, дэндүү цавчим учир бид голцуу замаар явахыг чухалчлан тал дундуурхи хөлдөж хатуурсан өргөн замаар явж, усан үзмийн чулуун хашааны хоорондуур гарч, замын хажуугийн тосгоны байшин дундуур бууна. Тэнд гурван тосгон байв. Хоёрыг нь Шернэ, Фонтаниван гэх бөгөөд нэгийг нь нэрийг мартжээ. Тэгээд мөн л тэр замаар явж, шонд мөчир бүрийг нь барьж уясан усан үзмийн тариалан дун, уулын хормойд буй хуучин чулуун chateau дэргэдүүр өнгөрнө. Хамаг мөчир бараатан хатаад газар элхий цасаар дутагдаж, тэртээ доор төмөр мэт зэгэл нуур толийно. Chateau хүрээд зам уруудан нийлээд огцом болж, явсаар баруун тийш эргэж, том чулуу дэвссэн тун цавчин замаар шууд орж Монтре очно.

Монтред танин хүн бидэнд ер байхгүй. Бид нуурын хөвөөгөөр явж буй хүн үй олон цахлай, ойртмогц салхич шувуу харна. Эрэг хавьцаа, бяцхан хар ахууна сүрэглэж усан дээр мөр татуулан хөвнө. Хот ороод бид гол гудамжаар дэлгүүрийн цонх харж явлаа. Тэнд олон том буудал байвч өдгөө хааллттай боловч дэлгүүр цөм онгорхой тул орсон газар болгон ихээхэн баяртай байна. Кэтрин үсээ засуулах гэж нэгэн их сайн үсчинд оров. Тэр үсчний эзэгтэй тун ялдам угтсан бөгөөд Монтред буй бидний ганц танил тэр болов. Кэтринг үсээ засуулж дуустал би пивоны газар орж суугаад, Мюнхены хар пиво ууж сонин уншив. Би “Корьере делла сера” болон Парисаас ирдэг англи, америкийн сонин уншлаа. Хамаг зарлал нь хэвлэлийн будаг нүүгэлтээд бөгс арчиж боломгүй болжээ. Тааруухан уншлага боллоо. Ер нь юм бүгд тааруухан байгаа шүүдээ. Би буланд сууж, том аягатай хар пиво ууж, цаасанд боодолтой pretzls<sup>36</sup> задалж иднэ. Pretzels шорвог аятайхан амттай бөгөөд пивонд амт оруулна. Нэргэлтийн тухай би уншив. Кэтрин орж ирнэ гэж бодсон чинь орж ирсэнгүй тул би сониноо байранд нь тавьж, пивоны үнэ төлөөд Кэтринг хайхаар гарав. Хүйтэн бүрхэг өвлийн өдөр болоод ханын чулуу ч хүйтэн харагдана. Кэтрин аанай үсчинд байв. Үсийг нь эзэгтэй янзалж, би сууж ажиглав. Сэтгэл минь догдлон, Кэтрин инээмсэглэж надтай ярилцах бөгөөд догдолсондоо миний хоолой жаахан парчигнана. Тэнд дулаан таатай бөгөөд Кэтриний үсийг гурван толинд би харж, хавчлага нь аятайхан тохирчээ. Тэгээд эзэгтэй үсийг нь янзалж дуусахад Кэтрин тольдож жаахан өөрчилж хавчаарыг нь сугалж сольсноо босов.

-Дэндүү их удлаа шүү.

-Ноёнтон танд их сонин байсан. Тийм биздээ, Ноёнтоон? гэж эзэгтэй инээвхийлэв.

-Тиймээ гэж би хэллээ.

Бид гарч гудамжаар явав. Хүйтэн бүрхэг агаад салхи үлээнэ.

---

<sup>11</sup> Германд хийдэг печенийн терлийн боов

-Би чамд хичнээн хайртайг чи мэдэхгүй шүү дээ гэж би хэллээ.  
-Одоо бид их сайхан байна биш үү? Одоо хоёулаа нэг газар орж цайны оронд пиво ууя. Тэгэх үү? Бяцхан Кэтринд пиво их тустай. Пиво уувал хүүхэд хэт томрохгүй гэж Кэтрин хэллээ.  
-Бяцхан Кэтрин, залхуу охин? гэж би хэлэв.  
-Ухаалаг охин болно. Их зөвөөр явна Пиво уувал хүүхэд хэт томрохгүй их ашигтай гэж эмч надад хэлсэн гэж Кэтрин өгүүлэв  
-Нээрэн чи битгий томруул, хэрэв хүү төрвөл морь уралдагч болог  
-Хэрэв хүү төрвөл, бид үнэндээ гэрлэх хэрэгтэй болж байна шүү дээ гэж Кэтрин хэлэв. Бид пивоны газар булангийн ширээний цаана сууж байв. Гудамжинд бүрэнхийлэв. Хэдүй эрт боловч бүрхэг өдөр тул эрт үдэш болов.  
-Тэгвэл одоо гэрлэе гэж би хэллээ.  
-Үгүй. Одоо тусгүй. Дэндүү илэрхий юм болно. Бүртгэх товчонд би ийм эрт очихгүй гэж Кэтрин хэллээ.  
-Урьд нь гэрлэж байх маань ч яав даа.  
-Тэгвэл сайн л байхсан. Гэхдээ, найз минь, тэгэх цаг бидэнд байсан уу даа.  
-Бүү мэд  
-Би тэгвэл нэг юм бодож байна. Ийм хүндэт ахайтан болж би бүртгэх товчоонд очихгүй.  
-Чи яаж ахайтан байх юм бэ?  
-Найз минь, мөнөөсөөн мөн. Анхны чинь хүүхэд үү гэж надаас үчин хүүхэн асуусан. Би хоёр хүү, хоёр охинтой гэж хариулсан.  
-Хэзээ гэрлэх билээ?  
-Дахиад нарийхан болохоороо гэрлэе Ямар сайхан ханиуд вэ? гэж хүн болгон бодмоор том хурим хийхсэн гэж би хүсэж байна.  
-Чи гомдохгүй биз?  
-Найз минь, би юундаа гомдох билээ дээ?  
Миланд би өөрийгөө хүүхэн болсон гэж бодож байх үедээ нэг удаа л сэтгэл аягүй байсан. Таван минут болоод л мартагдсан. Гол нь тэнд тасалгааны муугаас болсон юм. Би муу эхнэр гэж үү?  
-Чи гайхамшигтай эхнэр  
-Тэгвэл, найз минь хэлбэрийн төдий юмыг март. Би нарийсаж эхлэхээр л гэрлэе  
-Тэгье  
-Би дахиад пиво уувал яах бол? Эмч хэлэхдээ, чиний аарцаг чинь бага юм гэсэн. Тийм учраас бяцхан Кэтринг томруулахгүй байх хэрэгтэй.  
-Өөр юу гэсэн бэ? гэж би тэвдэнгүй асуув  
-Өөр юм хэлээгүй. Найзаа миний цусны даралт тун сайн юм. Миний цусны даралтыг үзээд эмч гайхсан  
-Бага аарцагны талаар өөр юу ярьсан бэ?  
-Огт юм хэлээгүй. Цанаар явж болохгүй л гэж хэлсэн  
-Зүйтэй.  
-Урьд нь цанаар явж байгаагүй бол одоо эхлэхэд оройтсон гэж хэлсэн. Бас цанаар явж болно, унаж л болохгүй гэж хэлсэн.  
-Чиний эмч их доогтой хүн юм.  
-Үнэндээ сайн эмч шүү. Хүүхэд төрүүлэхдээ тэр эмчийг дуудна.  
-Бид гэрлэж болох уу гэж чи түүнээс асуув уу?  
-Үгүй. Бид гэрлээд дөрвөн жил болж байна гэж би түүнд хэлсэн. Найзаа, би чамтай суувал америкийн иргэн болно. Америкийн хуулиар, хэрэв бид гэрлэвэл хүүхэд хууль ёсны болдог биз дээ.

-Чи хаанаас уншсан бэ?

-Номынх санд Нью-Йоркийн “Уорлд Алманак”-аас уншсан.

-Чи ёстой эрдэнэс юмаа.

-Би Америкийн иргэн болохдоо их дуртай. Найзаа, чи бид хоёр америк явна. Тиймээ. Би Ниагарын хүрхрээг үзмээр байна.

-Чи ёстой эрдэнэ юм.

-Өөр бас үзмээр юм байсан юмсан одоо мартчихжээ.

-Ярганы газар уу?

-Үгүй, бич мартчихжээ

-Вулвортын өндөр байшин уу?

-Үгүй

-Их Каньон уу?

-Үгүй. Гэхдээ үзнээ.

-Тэгээд, юу юм бэ?

-Аа, тийм, алтан хаалга! Хаана байдаг юм бэ?

-Сан-Францискод

-Тэгвэл тийшээ очъё. Ер нь би Сан-Франциског үзмээр байна.

-Их сайн. Бид тийшээ явна.

-Тэгвэл одоо уулын оргил өөд явъя. За юу?

-Тав өнгөрөөд галт тэрэг явна.

-Тэгвэл түүгээр явъя.

-Тэгье. Би бас жаахан пиво ууя.

Бид тэндээс гараад, гудамжаар явж буудлын шатаар өгсөхөд нэн хүйтэн байлаа. Роны хөндийгөөс хүйтэн салхи үлээнэ. Дэлгүүрийн цонхонд гэрэл асна. Өндөр чулуун шатаар өгсөж, бид дээд талын гудамжинд гараад өөр шатаар буудалд очиход гэрэл гэгээ болсон цахилгаан галт тэрэг зогсож байлаа. Том цагны нүүрэн дээр явах цагийг заажээ. Цагийн зүү, зургаа арвыг зааж байв. Би буудлын цагийг харлаа. Зургаа тав болж байна.

Биднийг суухад жолооч мөнгө хураагч хоёр цайны газраас гарч ирэв. Би сууж, цонх нээв. Гэрэл гэгээ болсон вагонд бөгчим байсан боловч, цонхоор хүйтэн тунгалаг агаар орно.

-Кэт ээ, чи ядрал уу? гэж би асуулаа.

-Үгүй. Бие сайхан байна.

-Удаан явахгүй ээ

-Би явах дуртай байна. Найзаа, надад бүү зов. Миний бие сайн байна.

Зулын хорин тавнаас гурав хоногийн өмнө, өглөө сэрэхэд цас орж байв. Пийшинд гал хүгэнэн, бид орондоо хэвтээд цас хаялахыг харна. Өглөөний цайны дараа хатагтай Гүттинген хэллээ. Цонхоор харахад замаас цааш юу ч үзэгдэхгүй тал талаас шуурч бударна. Би дахин орондоо орж, бид хэвтэнгээ ярилцав.

-Цанаар явах юмсан. Би цанаар явж болдоггүй яасан хяслантай юм бэ? гэж Кэтрин хэллээ.

-Чарга олж зам уруудаж гулгая. Машинаас аюулгүй шүү.

-Доргихгүй юу?

-Үзье л дээ.

-Доргихгүй бол сайнсан.

-Ингэхийгээд цасанд гарч зугаалж болно.

-Хоолны өмнө явбал, хоолонд сайн болно гэж Кэтрин хэлэв

-Би үргэлж л өлсөж байх юм.

-Би бас адилхан

Шуурганаар бид гарлаа. Гадаа хунгар тогтоод хол явж блондгүй байв. Би түрүүлэн зам гаргаж явсаар буудал хүртэл нилээд удлаа. Нүд харж боломгүй цас хаялна. Буудлын дэргэдэх жижиг мухлагт ороод бие биенийхээ цасыг шүүрдэж арилгаад

Урт сандал дээр суун Вермут дарс захив.

-Өнөөдөр их шуурч байна гэж зөөгч бүсгүй хэлэв

-Тийм байна.

-Энэ жил орой цас орлоо.

-Тэглээ

-Нэг зүсэм шоколад идэх үү? Эсхүл өглөөний цай болж байгаа юу? Би дандаа өлсөж байх юм гэж Кэтрин хэлэв.

-Нэгийг идээч гэж би хэллээ.

-Самартай нь их амтлаг. Би самартайд нь илүү дуртай гэж зөөгч бүсгүй хэлэв

-Би дахиад вермут дарс ууя гэж би хэллээ.

Харихаар гарахад бидний явдаг зөрөг цасанд дарагдаад хуучин мөр байсан газар дөнгөж мэдэгдэм хонхор үлджээ. Нүд харж боломгүй, нүүр рүү цас хаялна. Бид хувцсаа цэвэрлээд цай уухаар суув. Moniseur Гүттинген биднийг цайлав.

-Маргааш цанаар явж болно. Генри гуай та цанаар явах уу? гэж тэр хэлэв

-Үгүй. Гэхдээ би сурах юмсан.

-Та амархан сурч болно. Зулсарын баяраар манай хүү ирнэ. Тэрүүгээр заалга.

-Сайн байна. Хзээ чухам ирэх вэ?

-Маргааш орой.

Үдийн хоолны дараа, бяцхан тасалгаанд зуухны дэргэд сууж цас орохыг цонхоор харж байснаа Кэтрин ийн өгүүлрүүн:

-Найзаа чи, нэг тийшээ очиж эрэгтэйчүүлтэй нийлж цанаар гулгавал яасан юм бэ?

-Яах юм бэ?

-Чи ер нь өөр хүмүүстэй уулзах дургүй байна гэж үү?

-Чи өөр хүмүүстэй уулзмаар байна уу?

-Үгүй.

-Би бас үгүй

-Би мэдэж байна. Чамд бол өөр хэрэг

Би төрөх гэж байгаа болохоор ингээд зүгээр байх нь аятайхан байна. Би дэндүү тэнэгрээд, дэндүү их юм донгосоод байх шиг байна. Чи явбал дээр байх.

Тэгэхгүй бол би чамайг залхаачихна.

-Намайг яваг гэж чи бодож байна уу?

-Үгүй. Надтай байгаасай гэж хүсэж байна.

-Тэгвэл би хаашаа ч явахгүй.

-Нааш ир. Би толгой дээрх болдрууг чинь барьж үзье гэж хэлээд хуруугаа хүргэснээ:

-Том болдруу байна шүү. Найзаа чи сахлаа ургуулбал яасан юм бэ? гэв

-Ургуулмаар байна уу?

-Яахав, зүгээр зугаатай. Сахалтай ямар харагдах бол гэсэн юм.

-За тэгье. Сахал тавья. Одоохон энэ агшнаас эхлээд л ургууллаа. Энэ ч бас санаа шүү. Одоо би хийх ажилтай боллоо.

-Хийх юм огт байхгүйдээ ч зовж байна уу?

-Үгүй. Би тун хангалуун, тун таатай байна. Чи яаж байна?

-Надад сайхан байна. Гэхдээ одоо намайг ийм байхад чамд уйтгартай болов уу гэж би зовж байна.

-Кэт минь! Би чамд ямар их хайртайг чи гадарлах ч үгүй юм даа.

-Одоо ч гэсэн үү?  
-Одоо ч тэр. Хэзээ ч тэр. Би бол дүүрэн жаргалтай байна. Энд бид сайхан байгаа биз дээ?  
-Их сайхан байна. Гэхдээ чи нэг л тайван бус санагдах юм.  
-Үгүй. Би дандаа фронт, янз бүрийн хүн санах юм. Гэхдээ зовсон юмгүй. Би юуны ч тухай удаан боддоггүй.  
-Хэнийг чи санадаг вэ?  
-Ринальди, лам бас бус хүнийг санаад, харин удаан боддоггүй. Дайны тухай би бодох ч дургүй. Миний тооцоо дууссан.  
-Одоо чи юу гэж бодож байна?  
-Юу ч бодоогүй.  
-Чи юм бодож байсан. Хэл л дээ.  
-Ринальди тэмбүүрсэн нь үнэн болов уу? гэж бодлоо.  
-Тэгээд тэр үү?  
-Тиймээ.  
-Тэр тэмбүүрсэн юм уу?  
-Бүү мэд  
-Чамайг өвдөөгүйд би баярлаж байна.  
Чи тийм өвчнөөр өвдсэн үү?  
-Би хүйтэнтэж байсан.  
-Битгий тэгж яриач. Найзаа. Их өвдөж байсан уу?  
-Их өвдсөн.  
-Би бас өвдөж үзэх юмсан.  
-Бүү худал хэл  
-Үнэн гэм. Чиний л амссан бүгдийг би амсах юмсан. Чиний мэддэг хүүхэн бүгдийг би мэдэх юмсан. Тэгээд чамтай явахдаа тэдэнд бардах юмсан.  
-Энэ чинь сайхан хээрг  
-Хүйтэндэж айсан чинь сайхан хэрэг үү?  
-Үгүй. Цас орж байхыг хараач!  
-Чамайг харвал надад дээр байна. Найзаа, чи үсээ тавиач  
-Яаж?  
-Жаахан урт ургуулж  
-Урт л байна шүү дээ  
-Чи жаахан ургуулчих, би тайрчихъя.  
Тэгээд хоёулаа яг адилхан үстэй больё. Харин нэг нь хар, нөгөө нь цайвар л байна биз.  
-Үсээ тайруулахад чинь би дургүй байна.  
-Зугаатай ч байж болно. Шөнө оронд их саад болоод, үснээсээ залхаж гүйцлээ.  
-Ийм надад таатай байна.  
-Богтино үстэй бол чамд таагүй юу?  
-Магадгүй юм. Одоогийнхоороо надад таатай байна.  
-Богинодоо илүү ч байж болно. Бас бид хоёр адилхан болно шүү дээ. Найзаа чамд их хайртайдаа би чам шиг л болмоор санагдах юм.  
-Тийм л байна шүү дээ. Чи бид нэг цогц  
-Шөнөд л тийм байдаг  
-Шөнөд юм болгон сайхан  
-Энэ би, энэ чи огтоос ялгаж болохооргүй болох юмсан. Чамайг битгий яваасай гэж бодох юм. Би яах нь вэ гэж тэгэж хэлсэн юм. Явмаар санагдаж байвал яваарай. Харин түргэхэн ирээрэй. Найзаа, чамайг байхгүйд би өөрийгөө амьд байна ч гэж санадаггүй.

-Би хэзээ ч явахгүй. Чамгүй бол надад бахдах юм юу ч байхгүй. Ямар ч амьдралгүй болно гэж би хэллээ.

-Чамайг амьдраасай гэж би хүсдэг. Чамайг хамгийн сайхан амьдраасай гэж би хүсдэг. Энэ чинь бид хоёрын амьдрал гэсэн үг шүү дээ. Тийм биз?

-Би тэгвэл, сахлаа ургуулах уу, болих уу?

-Ургаг. Сахлаа тавь. Их сонин байна. Шинэ жилээр ургачихсан байж ч магад

-Шатар тоглох уу?

-Өөр тоглоом дээр

-Шатар л тоглоё

-Тэгээд өөр тоглоом тоглоё.

-Тэгье.

-За тэгье.

Би бялдар авч шатар өрөв. Гадаа цас дарсаар л байна.

Шөнө дунд би гэнэт сэртэл, Кэтрин бас сэрүүн байв. Цонхоор сар гэрэлтэж, цонхны хөндлөвчийн сүүдэр орон дээр тусна.

-Чи сэрүүн байна уу, найзаа?

-Сэрүүн байна. Нойр чинь хүрэхгүй байа уу?

-Би дөнгөж сэрээд, анх чамтай уулзахдаа ямар солиотой байснаа бодлоо. Санаж байна уу?

-Чи бага зэрэг солиотой байсан.

-Одоо надад тийм явдал хэзээ ч тохиолдохгүй. Одоо би бүх талаар сайхан байна. Чи энэ үгийг их сонин хэлдэг юм. "Сайхан" гээд хэл дээ чи.

-Сайхан

-Чи ялдамхан. Би одоо солиотой биш, харин дээдийн дээд жаргалтай.

-За унтдаа гэж би хэлэв

-За тэгье. Хоёул зэрэг унтъя.

-За тэгье.

Бид тэр дороо унтсангүй. Би элдэв юмны тухай бодож, унтаж буй Кэтрин болон нүүрэн дээр нь туссан сарны гэрлийг ажиглаж нилээд удаан хэвтлээ. Тэгээд мөн унтжээ.

[Тор](#)

---

Нэгдүгээр сарын дундуур миний сахал ургаж гүйцсэн бөгөөд дүн өвлийн хүйт орж хурц нартай өдөр, хүйтэн хахир шөнө болдог боллоо. Замаар дахин явж болохтой болов. Уулаас доош гулссан чарга, гуалингийн өмөөр цас хатуу гөлгөр болж, Монтре хүртэл эргэн тойрон цастай байв. Нуурын цаад уулс цайраад Ронын хөндий цасанд дарагджээ. Бид уулын нөгөө талаар Бэн дел-Альяз хүртэл урт аян хийв. Кэтрин уландаа сөртөн хадаастай гутал өмсөж, хурц ган үзүүртэй таяг тулж, давхацтай явав. Давхац өмсөхөд бүдүүрсэн нь мэдэгдэхгүй байлаа. Бид алгуур явж, Кэтринийг ядрахад замын дэргэдэх гуалин дээр амарна.

Бэн дел Альязид түлээчдийн орж юм уудаг модны хажуугийн мухлагт бид пийшингийн дэргэд дулаацан сууж, халуун ногоо болон нимбэгтэй халаасан дарс уув. Тэр дарсыг Glühwein гэх бөгөөд, дулаацах буюу бусдын эрүүл мэндийн төлөө хундага өргөхөд тун сайхан эд билээ. Мухлагт утаатай харанхуй бөгөөд гадаа



гарахад хүйтэн агаар уушиг төөнөж, амьсгалахад хамрын үзүүр мэдээ алдана. Бүх цонх нь гэрэлтэй мухлагийг бид эргэж харав. Үүдэнд нь түлээчдийн морьд газар цавчлан дулаацаж, толгой сэгчинэ. Хамрын үс нь цантаад, амьсгалахад нь агаарт уур савсана. Буцахад зам гөлгөр гулсамтгай, тохой хүртэл мөс морины шээсэнд ягаарсан бөгөөд тэндээс гуалин гулсгадаг зөрөг салаалжээ. Түүнээс цааш зам ой дундуур орох агаад битүү цасанд хучигджээ. Үдэш харих замдаа бид хоёр удаа үнэг үзэв. Энэ сайхан нутагт, гадуур явах бүрий сэтгэл ихэд сэргэх юм.

-Чи сайхан сахалтай юм. Яг л түлээчдийн шиг байна. Чи тэр алтан ээмэгтнийг харсан уу? гэж Кэтрин хэллээ.

-Тэр чинь янгир агнадаг анчин. Тэд сонороо сайжруулах гэж ээмэг зүүдэг юм гэж би хэллээ.

-Нээрэн үү? Үнэхээр тийм гэж үү? Миний бодоход, янгирын анчин гэдгээ хүн бүгдэд мэдүүлэх гэж зүүдэг байх. Энд янгир үржүүлдэг юм уу?

-Тийм. Даы-де-Жаманы цаана үржүүлдэг юм.

-Үнэг дайралдаад сонин байна.

-Үнэг сүүлээрээ биеэ тойруулж унтахад нь дулаахан байдаг юм.

-Аятайхан байх ёстой доо.

-Би тийм сүүлтэй болохсон гэж дандаа боддог. Хэрэв бид үнэг шиг сүүлтэй бол яахав?

-Тэгвэл яаж хувцаслах билээ?

-Тохирсон хувцас захиалах юмуу, сүүлийг юманд боддоггүй, ронд очих хэрэгтэй.

-Одоо бид ямар ч юуны ч холбогдолгүй оронд байна шүү дээ. Энд бид хэнтэй ч уулзалгүй сууж байгаа нь сайхан биш гэж үү? Найзаа, чи хэнтэй ч уулзах хүсэлгүй гэсэн шүү дээ. Тийм биз дээ?

-Тиймээ

-За түр сууя. Би жаахан ядарч байна.

Бид хоёр гулаин дээр зэрэгцэн суув. Өмнөх зам ой руу оржээ.

-Хүүхэд бидэнд саад болохгүй биз? Чи юу гэж бодож байна?

-Болохгүй. Болгох ч үгүй

-Мөнгө юу болж байна?

-Мөнгө зөндөөн. Би сүүлчийн чекээр мөнгө авсан.

-Танайхан чамайг эрэхгүй биз? Чамайг Швейцарит байгаа гэж одоо тэд мэдэж байгаа шүү дээ.

-Магадгүй. Би аргалж захиа бичнэ.

-Чи бичээгүй юм уу?

-Үгүй. Зөвхөн үсэг зураг чех илгээсэн.

-Би чиний төрлийн хүн байгаагүй минь л яамай.

-Би цахилгаан явуулна

-Чи тэндээ дургүй юм гэж үү?

-Хэрэлдсээр байгаад хуучин хайраас юу ч үлдээгүй юм.

-Тэд надад таатай баймаар санагдах юм. Тэд надад лав их таатай байна байх аа.

-Тэдний тухай ярихаа больё. Яриад байвал миний сэтгэл зовох болно гэж хэлснээ би хэсэг зуур болоод амарсан бол явъя гэв

-Би амарлаа гэв

-Бид замаар орж цааш явав. Хэдүйн бүрэнхий болоод хөлийн доор цас чихарна. Хуурай хүйтэн агаад маш цэлмэг шөнө болв

-Чиний сахал надад их сайхан санагдаж байна. Ёстой гоё оо. Харахад хатуу ширүүн юм шиг үнэндээ зөөлхөн, их аятайхан юм гэж Кэтрин хэллээ.

-Сахалгүй байснаас чамд энэ нь илүү байна уу?

-Илүү байна. Найзаа, би бяцхан Кетринг гартал үсээ тайрахгүй ээ. Би одоо дэндүү бүдүүрээд ахайтан шиг л болжээ. Хүүхэд төрсөн хойно би нарийсна, тэгээд заавал үсээ тайруулна. Чи тэгээд хахь өөр шинэ хүүхэнтэй болно. Хоёулаа цуг явж тайруулах юмуу эсхүл би ганцаар яваад, сонинтой ирнэ гэхэд нь би дуугүй л байв.

-Чи хориглохгүй биз дээ? Тийм үү?

-Үгүй. Надад таатай ч байж болно

-Чи ийм л сайн шүү! Би нарийсахаараа тураад, чамд таалагдахаар тун сайхан болчихвол, чи дахи ад надад дурлана

-Чөтгөр гэж! би чамд дээдээр дурлаж байна. Өөр яах юм бэ? Би бүр унаж үхэх юм уу гэж би хэлэв.

-Тийм. Чи бүр унаж үхээсэй гэж би боддог.

-За яахав тэгье. Би ч бас тэгж боддог гэж би хэллээ.

[Top](#)

---

Бид сайхан амьдарч байв. Нэг, хоёрдугаар сар өнгөрлөө. Сайхан өвөл болж, бид тун жаргаж байлаа. Бүлээн салхи үлээж нэг хэсэг дулаараад, цас ялбайн, хаврын уур орсноо, цаг ямагт цэлмэн хүйтэрч өвөлдөө буцаж оров. Гуравугаар сард өвөл өөрийн эрхгүй бууж өгөв. Шөнөдөө бороо орж, өглөөжин үртгэлжлээд, цас шавхайтав. Уулын бэлээр уйтгартай боллоо. Нуур болон хөдийн дээгүүр үүлс хурна. Уулын өндөрлөгт бороо орно. Кэтрин түрийтэй бөмбөгөн шаахай, би ноён Гүттингений бөмбөгөн гутлыг өмсөж шүхэр барин замын хөстэй хутгалдсан шавхай, усан дундуур орж буудлын дэргэдэх мухлагт өглөөний цайны өмнө Вермут дарс уухаар явав. Цонхны цаана бороо орох сонсдоно.

-Хот орж суух уу, яах вэ? гэсэн

-Чи юу гэж бодож байна? хэмээн Кэтрин асуув

-Өвөл өнгөрвөл, бороо орно. Энд тав муутай болно. Бяцхан Кэтрин хэзээ гарах вэ?

-Сар орчим, илүүтэй болоод гарна.

-Монтред очиж сууж болох л юм

-Лозаннед очвол яасан юм бэ? Тэнд эмнэлэгтэй шүү дээ.

-Лозаннед ч бол. Дэндүү том хот уу даа гэж би бодсон юм.

-Бид том хотод ч хамт байж болно. Лозаннед лав сайхан байхаа.

-Хэзээ очих вэ?

-Хэзээ ч яахав. Дуртай цагтаа л очъё, найзаа хэрэв чи дургүй бол явахгүйч байж болно

-Тэнгэрийн байдлыг харж азная.

Гурван өдөр бороо оров. Буудлаас доош уулын энгэрт огт цасгүй болов. Замаар нялцайсан шавхай дүүрэн урсав. Ус чийг ихдээд гэрээс гарахад хэцүүхэн байлаа. Борооны гуравдахь өглөө бид хотод шилжихээр шийдэв

-Зовох юмгүй, monieur Генри! Урьдчилж хэлсэнгүй гэх зүйл ер үгүй. Тэнгэр нэгэнт ийм болсон хойно та нарыг явна гэж би бодож байсан юм гэж Гүттинген хэллээ.

-Хатагтай бид эмнэлэгт ойр байх хэрэгтэй гэж би хэлэв.

-Тэгэлгүй яахав. Хүүхэдтэйгээ цуг бас ир гэж тэр хэллээ.

-Байр олдвол ирнээ.

-Хавар энд тун их сайхан. Ирвэл та нарт таалагдана. Одоо цоожтой байгаа том тасалгаанд хүүхдээ асрагчтай суулгаж, хатагтай та хоёр нуур тийш харсан энэ тасалгаандаа орж болно.

-Би урьдаар танд бичнэ гэж би хэллээ. Бид юмаа бэлдээд үдийн хоолны дараа эхний галт тэргээр явав. Ноён хатагтай Гүттинген хоёул биднийг буудал хүргэж, нөхөр нь бидний юмыг чарган дээр тавьж шавхай дундуур чирч авчрав. Тэр хоёул буудлын дэргэд бороонд зогсож, биднийг үдэн даллана.

-Их сайн улс шүү гэж Кэтрин хэллээ.

-Бидэнд их сайн байсан гэж би хэлэв.

Монтред бид Лозаннийн галт тэргэнд суусан юм. сууж байсан уулаа галт тэрэгний цонхоор харъя гэтэл үүл хаагаад байлаа. Галт тэрэг Вевед зогсоод цааш явлаа. Замын нэг талд нуур, нөгөө талд нойтон бараан тал, нүцгэн ой, нойтон байшингууд байна. Бид Лозаннед ирж багахан буудал тийш эргэхэд бороо орсоор байв. Гинжин оосортой зэс түлхүүр барьсан, жижүүр хувцастай хаалгачин цахилгаан шат, шалны хивс, гялалзсан тоногтой цагаан угаагуур, төмөр ор, бүрэн төхөөрөмжтэй унтлагын том өрөө бидэнд Гүттингенийнхээс ирсний дараа ер бусын чамин харагдав. Манай өрөөний цонх, дээгүүрээ төмөр тор бүхий ханан хашлагатай нойтон цэцэрлэг тийш харсан аж. Огцом гудамжны нөгөө талд мөн тийм тортой хашаа бүхий буудал байна. Цэцэрлэгийн усан санд бороо дуслахыг би харан байв.

Кэтрин бүх гэрлийг асааж юмаа янзалж эхлэв. Би содтой Виски архи захиалаад галт, тэрэгний буудаас худалдаж авсан сониноо барин орон дээр хэвтэв. Өдгөө 1918 оны гуравдугаар сар бөгөөд германууд францад довтолж байв. Кэтринийг тасалгаан юмаа янзалж дуустал би содтой виски архи ууж сонин уншив.

-Найзаа, би одо юу төхөөрөх хэрэгтэй болсон гэж чи бодож байна? гэж Кэтрин хэлэв

-Юу вэ?

-Хүүхдийн юмс. Ер нь хүн бүр өдийгөөс хүүхдийн юм бэлддэг.

-Худалдаад авч болно шүү дээ.

-Тэгнээ тэгнэ. Маргааш л явж авъя. Юу юу авахаа мэдэх хэрэгтэй.

-Чи л ёстой. Чи сувилагч байсан шүү дээ.

-Тиймээ. Гэхдээ цэргүүд, эмнэлэгт хүүхэдтэй ирэх нь их ховор шүү дээ.

-Би яагаав? гэхэд тэр намайг дэрээр цохиод содтой виски архийг минь цалгиулаад асгачихав

-Би чамд одоо дахиад зхиад өгье, уучлаарай гэж тэр хэллээ.

-Бага үлсдэн байсан юм нааш ир дээ!

-Үгүй. Энэ тасалгааг би нэг л юмтай адилхан болгомоор байна.

-Юутай?

-Чи бид хоёрын гэртэй.

-Антантын далбаа хатга

-Дуугүй байж үз

-Дахиач хэлээч!

-Дуугаа тат!

-Чи хүн гомдоочих бий гэсэн шиг болгоомжилж хэлэх юм гэж би хэллээ.

-Тэгсэн юм алга

-За, тэгвэл нааш ир дээ.

-За яахав гээд хажууд ирж орон дээр суугаад: Найзаа одоо би чамд сонин биш шүү дээ. Би пивоны торх шиг л байна гэв

-Худлаа. Чи сайхан. Чи их сайн

-Би бол чиний болгоожмгүйгээсээ болж гэрлэсэн эрэмдэг хүүхэн

- Худал, чи улам гоё болж байна
- Найзаа, би дахиад нарийсна шүү дээ.
- Чи одоо туранхай байна.
- Чи уусан биз дээ.
- Нэг аяга содтой виски архи уулаа.
- Одоо дахиад виски архи авчирна. Хоол энд авчирч аль гэж захих уу? гэж тэр хэллээ.

- Тэгвэл сайнсан.
- Өнөө орой тэгвэл бид ердөө гарахгүй. За юу. Орой өрөөндөө сууя.
- Тоглоё гэж би хэллээ.

-Би дарс ууна. Ямар ч гэм байхгүй. Энд манай цагаан капри дарс байгаа байх гэж Кэтрин хэлэв

- Байгаа биз. Ийм буудалд итали дарс байнга байдаг юм гэж би хэллээ.

Хаалгачин үүд цохиж, мөстэй аяга виски архи болон содтой бяцхан лонх тавиур дээр тавиад авчрав.

-Баярлалаа. Энд тавьчих. Хоёр хүний хоол, хоёр лонх хуурай цагаан капри дарс мөсөнд хийж авчирч өгөөч гэж би хэллээ.

- Шөлтэй хоол захих уу?
- Кэт ээ, чи шөлтэй хоол идэх үү?
- Идье
- Нэг шөл
- Мэдлээ.

Тэгээд тэр гарч үүд хаав. Би сониноо сөхөж, дайны тухай үзэнгээ мөстэй виски архитай аяганд содтой ус алгуур хийв. Виски архинд мөс бүү хий гэж захидаг байж л дээ. Мөсий нь тусгай авчирвал сайнсан. Тэгвэл аягад хэдүй хир виски архи буйг мэдэж, султгачилгүй содтой усаа тааруулахсан. Нэг лонх виски архи худалдаж аваад содтой ус, мөс хоёр авчир гэж захих хэрэгтэй юм байна. Тэгвэл дээр. Сайн виски архи ч аятайхан эд шүү. Амьдралын нэгэн их аятай үзэгдэл шүү.

- Найзаа чи юу бодож байна?
- Виски архины тухай
- Чухам юу гэж?

-Виски архи яасан сайхан эд вэ гэж бодож байна гэхэд Кэтрин нүүрээ хувиргаад:

- За яахав гэж хэллээ.

Тэр буудалд бид гурван долоо хоног аятайхан суув. Ресторан гуанз голцуу хүнгүй, бид ихэвчлэн өрөөндөө хооллодог байв. Бид хотоор явж, трамвайгаар Уши орж, нууран дээгүүр зугаална. Хавар болсон шиг дулаахан байлаа. Уулан дахь байрнаас ирсэндээ бид харамсана. Гэвч хаврын амьсгал хэдхэн өдөр үзэгдээд дахин зэвхий хүйтэн, саармаг үе эхлэв.

Хүүхдэд хэрэгтэй бүхнийг Кэтрин худалдаж авлаа. Би биеийн тамирын танхимд очиж, амралт зугааны журмаар боксын дасгал хийнэ. Кэтринг орондоо хэвтэж байх хоронд тийшээ би голцуу өглөөд очно. Хавар ойртсон тэр үед зодооны дараа тун аятайхан, хаврын агаар амьсгалж гудамжаар явахад сэтгэл сэргэлэн, кафе гуанзанд орж хүмүүс харж сонитн уншиж, вермут дарс ууж суух, тэгээд буудалдаа ирж, Кэтринтэй өглөөний хоол идэх таатай билээ. Биеийн тамирын танхимын боксын багш сахалтай, тун ончтой хурдан хөдөлгөөнтэй бөгөөд хүн довтлоход нэн их айдаг хүн байв. Биеийн тамирын танхимд байхад тун аятайхан агаар, гэрэл сайтай билээ. Би үнэн сэтгэлээсээ оролдож, олсон дээгүүр харайж, олон төрлийн зодоонд дасгал хийж, гэдэсний булчин сайжруулах дасгал хийж, онгорхой цонхоор шалан дээр туссан

нарын зурвасхан гэрэлд хэвтэх бөгөөд зодоогоор багшийгаа бас айлгана. Эхлээд би урт нарийн толины өмнө дасгал хийж чаддаггүй байв. Яагаад гэвэл сахалтай боксчинг харахад хачин санагдана. Сүүлдээ харин ч инээдэмтэй боллоо. Би бокс оролдож эхлүүтээ сахлаа хусах гэтэл Кэтрин зөвшөөрсөнгүй. Кэтрин бид хоёр ямагт сүйхэнд суж орчны газар үзнэ. Тэнгэрийн сайханд тийнхүү явах таатай. Үдийн хоол идэж байж болох хоёр сайхан газар бид олсон юм. Кэтрин их явж чадахаа байжээ. Тосгоны замаар би Кэтринтэй явахдаа их дуртай байв.

Хэрэв сайхан өдөр байвал бид тавтайяа өнгөрөөнө. Ер бид цаг муу өнгөрөөж байсангүй. Хүүхэд төрөх тун ойртжээ. Тэр учраас биднийг нэг юм хөөгөөд ч байгаа юм шиг, бид хоёр цуг байвал зохих цагаасаа нэг ч цаг алдаж болохгүй юм шиг санаа төрдөг болсон болой.

[Top](#)

---

Өглөөгүүр гурван цагийн үед сэртэл Кэтрин орондоо хөлбөрөн байгаа сонсдов.

-Кэт ээ, бие чинь эвгү йбайна уу?

-Найзаа, базлаад байх шиг байна.

-Жигд байна уу?

-Яг ч жигд биш ээ.

--Хэрэв жигдрээд ирвэл, эмнэлэгт очих хэрэгтэй.

Тун их нор хүрээд би унтчихжээ. Төдөлгүй ыби дахин сэрэв.

-Чи эмч утасдана уу. Эхэлж ч байж мэднэ гэж Кэтрин хэллээ.

Би босож эмч рүү утасдав.

-Ойр ойрхон уу, Кэт ээ?

-Арван тав орчим минутын зайтай.

-Тэгвэл эмнэлэгт оч. Би одоо хувцаслаад бас тийш очлоо гэж эмч хэллээ.

Би утсаа өлгөөд дараа нь хөлсний тэрэг дуудах гэж галт тэрэгний буулын гарааш руу удасдахад, удтал хүн ирж утас авахгүй байв. Гэтэл нэг хүн таарч одоохон машин явуулахаар амлав.н Кэтрин хувцаслав. Чемоданд нь хүүхийн хувцас болон эмнэлэгт хэрэгтэй бүх юмс хийлээ. Бид гудамд гарч, би цахилгаан шатчинг дуудлаа. Хариу байсангүй тул би доош буув. Тэнд шөнийн жижүүрээс өөр хүн байсангүй. Би өөрөө цахилгаан шатанд сууж дээш гараад Кэтриний чемоданг оруулахад, Кэтрин орж бид уруудав. Шөнийн жижүүр хаалга онгойлгож бид гол саравчны шатны хажуу дахь чулуун хашлага дээр сууж хөлсний тэрэг хүлээв. Цэлмэг шөнө болоод тэнгэрд одод харагдана.

Кэтрин тун их догдолжээ.

-Ингэж эхэлсэнд нь би баярлаж байна. Одоо удахгүй хамаг юм ар талд үлдэнэ гэж тэр хэлэв.

-Сайн байна.

-Би айхгүй. Харин, хөлсний тэрэг түргэхэн ирээсэй.

-Гудамжинд машины чимээ сонсдон, чийдэнгийн гэрэл харагдлаа. Хөлсний тэрэг саравчинд тулж зогслоо. Би Кэтринд туслан суулгаж, жолооч чемоданы нь урд талын суудалд тавив.

Эмнэлэгт ирэхэд би чемодан авч, бид оров. Тэнд сууж байсан нэг хүүхэн Кэтриний нэр, овог, нас, хаяг, төрөл төрөгсдийн гэрчилгээ баримт, шашны талаар дэвтэрт бүртгэв. Ямар ч шашингүй гэж Кэтринг хэлэхэд тэр хүүхэн дэвтэртээ тэр үгийн дараа зураас татав. Кэтрин овгоо Генри гэж хэллээ.

-Би тасагт оруулж өгье гэж тэрхүүхэн хэлэв.

Бид цахилгаан шатаар өгсөв. Тэр хүүхэн цахилгаан шат зогсож бид гараад гудмаар түүнийг дагав. Кэтрин миний гараас чанга барина.

-За энэ таны тасаг хувцсаа тайчаад оронд орж хэвт Унтахдаа өмсдөг цамц энэ байна гэж тэр хүүхэн хэллээ.

-Надад унтахдаа өмсдөг цамц бий гэж Кэтрин хэлэв

-Энэ нь арай эвтэйхэн болов уу гэж тэр хүүхэн хэлэв.

Би гарч гудамд байсан сандал дээр суув.

-Одоо орж болно гэж сувилагч хүүхэн үүдэнд зогсоод хэлэв

Нарийн орон дээр Кэтрин, жирийн даавуугаар хийсэн болов уу гэмээр дөрвөлжин хээтэй унтлагын цамц өмссөн хэвтэх агаад намайг харж инээмсэглэнэ.

-Одоо сайн базалж байна гэж тэр хэллээ. Сувилагч гары нь барьж цаг харж базлахы нь хэмжинэ.

-Сая хүчтэй базаллаа гэж Кэтрин хэлэв. Нүүрий нь харахад илэрхий байлаа.

-Эмч хаана байна? гэж би сувилагчаас асуув

-Доор унтаж байгаа Цаг нь болохоор ирнэ. Хатагтай биеий чинь би янзална. Та ахиад гарч байхгүй юу гэж сувилагч хэллээ.

Би гудамд гарлаа. Эзгүй гудамд хоёр цонх, цооштой эгнэсэн олон хаалга байна. Тэндээс эм ханхална. Би сандал дээр сууж шал ширтэн Кэтриний төлөө залбирна.

-Орж болно гэж сувилагч хэлэхэд би оров

-Найзаа, чи юу? гэж Кэтрин хэллээ.

-Яаж байна? гэхэд

-Одоо бүр ойр ойрхон өвдөж байна гэв.

Тэр нүүрээ барайлгаснаа инээвхийлэв

-Ёстой нэг боллоо. Сувилагч аа, дахиад нуруун доогуур гараа хийгээч.

-Тэгвэл ямар байна уу? гэж сувилагч асуулаа.

-Чи одоо яв даа, найзаа, явж юм олж ид. Их удаж магадгүй гэж сувилагч хэлсэн хэмээн Кэтрин өгүүлэв

-Анх төрөхөд голцуу уддаг юм гэж сувилагч хэлэв

-За явж юм олж ид. Миний бие сайн байна. Тийм биз дээ гэж Кэтрин хэллээ.

-Бас жаахан байя гэж би хэлэв. Тогтмол хэмжээтэй базалж байснаа холдов. Кэтрин ихэд догдлоод, их өвдөхөд нь сайн базалж байна гэнэ. Базлах нь буурахад, тэр гайхан цөхөрнө.

-Найзаа, чи яв даа. Чамайг байхад бие жаахан баригдаад байна гэж тэр хэлээд, царай нь эвгүй болов. Тэгээд ийн өгүүлрүүн:

-За, одоо арай илүү боллоо. Би элдвийн илбэ үзүүлэлгүй төрдөг сайн эхнэр байх дуртай. Найзаа явж цайлаад хүрээд ир. Чамайг байхгүйд би уйдаггүй. Ийм сайн сувилагч байна гэв.

-Цай уугаад ирэхэд бүрэн болно гэж сувилагч хэлэв

-За, би явъя. Баяртай найз минь.

-Баяртай. Сайн цайлаарай. Намайг бодож цайлаарай гэж Кэтрин хэлэв

-Хаана цайлж болох вэ? гэж би сувилагчаас асуулаа.

-Манай энэ гудамжинд, яг талбайн тэнд кафе гуанз бий. Тэр онгорхой байгаа биз гэж сувилагч хэлэв.

Гэрэл орж байв. Эвгүй гудамжаар явж би кафе гуанз хүрлээ. Цонх нь гэрэлтэй байна. Би орж бүрээстай лангууны дэргэд зогсоход надад худалдагч өвгөн, аяга цагаан дарс, нэг зөөлөн боов өгөв. Өчигдрийн тэр боовыг би дарсанд хийж, дараа нь нэг аяга кофе уулаа.

-Ийм өглөө эрт та юу хийж яваа хүн бэ? гэж өвгөн асуулаа.

-Эм нэлэгт эхнэр төрж байна.

-Аан! За, аз жаргал ерөө

-Дахиад нэг аяга дарс өгөөч

Тэр өвгөн лонхоо дэндүү тонхойлгож хийгээд лангуун дээр жаахан асгав. Би уугаад мөнгий нь төлж гарав. Гудамжинд байшин болгоны гадаа хиог зөөгчийг хүлээсэн хогтой хувин байна. Нэг хувинг нохой үнэрлэнэ.

-Эндээс чамд юу хэрэгтэй вэ? гэж би нохойноос асуугаад, тэр хувинд нохойд хэрэгтэй юм буй эсэхийг үзэхээр бөхийхөд дээд талдаа зөвхөн кофе цайны шаар, хог, хэдэн хагдарсан цэцэг байлаа.

-Гөлөг минь юу ч алга гэж би хэллээ. Тэр нохой нөгөө талд гарав. Эмнэлэгт ирээд би шатаар өгсөж Кэтриний байсан давхарт гарч, гудмаар явж үүдэнд нь хүрч хаалга цохивол хариу алга тул хаалгыг нээж харсанд тасалгаа эзгүй агаад гагцхүү Кэтриний чемодан сандал дээр тавиастай, тэрлэг нь өлгөөстэй байна Би гудамд гарч хүн хайсанд өөр нэгэн сувилагч харагдав.

-Хатагтай Генри хаана байна?

-Дөнгөж сая нэг хүүхнийг төрөх газар аваачсан.

-Хаана вэ?

-Би заагаад өгье гээд тэр хүүхэн намайг дагуулж, гудам ны буланд очив. Төрөхийн үүд онгорхой, Кэтрин ширээн дээр цагаан даавуугаар бүтээгээтэй байв. Ширээний дэргэд сувилагч зогсож, нөгөө талд нь өндөр шилэн савны орчим эмч зогсоно. Эмч% төмөр хоолойд бэхэлсэн бөмбөгөн баг барьж байна.

-Би танд халааз өгье. Та орж болно. Нааш ир гэж сувилагч хэлэв. Тэгээд тэр надад цагаан халааз өмсүүлж, захы нь ард нь холбон битүү зүүгээр хатгав.

-Одоо орж болно гэж хэлэхэд нь би тасалгаанд орлоо.

-Найзаа, чи ирээ юу? Удаахан л байна гэж Кэтрин хоолой чавчран хэллээ.

-Та ноён Генри юу гэж эмч асуув

-Тийм эмчээ яаж байна?

-Тун сайн болж байна. Базлах үед нь хийгээр амьсгалуулах гэж бид ирсэн юм хэмээн эмч өгүүлэв.

-За алив гэж Кэтрин хэллээ.

-Эмч нүүрэнд нь бөмбөгөн баг өмсүүлж, нэг хүрд эргүүлсэнд Кэтрин тун түргэн амьсгалав. Тэгээд тэр багаа түлхэхэд нь эмч аппаратаа таслав.

-Хүч багатай байна. Саяхан нэг их хүчтэй болсон. Намайг эмч биегүй юм шиг л болгосон. Тийм үү эмч ээ! гэж хоолой нь хачин сонсдоно. "Эмч" гэдэг үгийг их өргөж дуудна. Эмч инээмсэглэнэ.

-За, алив гэж Кэтрин хэллээ. Тэр нүүрэндээ бөмбөгөнө цагийг шахан барьж түргэн түргэн амьсгалав. Бага зэрэг ёолж сонсдоно. Тэгээд багаа зайлуулж инээмсэглэв.

-Хүчтэйхэн боллоо. Их хүчтэй боллоо. Найзаа, чи бүү зовоорой. Яв даа. Дахиж цай уугаад ир гэж Кэтрин хэллээ.

-Би энд байя гэж би хэллээ.

Бид өглөөний гурван цаг орчимд эмнэлэгт ирсэн боловч өдөр дунд Кэтрин аанай л төрөх газар хэвээр бөгөөд базах нь бас багасаад ихээхэн ядарч шаналсан царайтай ч сэргэлэн байв.

-Найзаа, би ч ер хэрэг алгаа. Харамсалтай юм даа. Тун амархан болно гэж бодож байсан юм. За одоо дахиад л... гэж хэлээд гараа сунгаж баг авч нүүрэн дээрээ тавив. Эмч мөнөөхөн хүрдийг эргүүлж ажиглана. Тэгэхийгээд базлахаа зогсов

-Ингэж зогсох юм гэж хэлээд Кэтрин инээмсэглэж, энэ хий надад их аятай байна. Гайхалтай эд байна шүү гэв.

-Бид жаахан аваачъя гэж би хэллээ.

-Одоо дахиад өвдөх нь гэж Кэтрин яаран хэлэв. Эмч хүрд эргүүлж цаг харна.

-Ямар зайтай базалж байна? гэж би асуув

-Минут орчим

-Та өлсөж байна уу?

-Би одоо явж цай ууя гэж тэр хэллээ.

-Эмчээ, та заавал юм идэх хэрэгтэй. Ингэж удаан байдаг яасан зовлонтой юм бэ дээ. Миний нөхөр хийгээр амьсгалуулж чадахсан болов уу? гэж Кэтрин хэлэв.

-Тэгж болно. Хоёрын тоо хүртэл эргүүлээрэй гэж эмч хэллээ.

-Мэдлээ гэж би хэлэв. Хүрдэн дээрээ зүүтэй бөгөөд бариулаар эргүүлдэг юм байлаа.

-За одоо гэж Кэтрин хэлээд нүүрэндээ баг нааж барив. Би хоёрын тоо хүртэл хүрдий нь эргүүлж, Кэтринг багаа авахад нь буцаав.н Надад хийх ажил эмч өгсөнд би их баярлав.

-Найзаа, чи хий шахав уу? гэж Кэтрин асуугаад, гары минь илбэв.

-Тийм, би гэсэнд

-Чи мөн ч сайн юм даа гэв.

Хийгээр амьсгалаад тэр бага зэрэг согтжээ.

-Би хажуугийн тасалгаанд юм иднэ. Эхэлмэгч л намайг дуудаарай гэж эмч хэллээ.

Эмч юм идээд хэсэг зуур болсноо хэвтэж тамхи татав. Цаг явсаар л байна. Кэтрин бүр ядарчээ.

-Намайг чи төрж чадна гэж бодож байна уу? хэмээн тэр асуулаа.

-Чадалгүй яахав.

-Чадах чинээгээрээ үзье. Би дүлэх л юм. Тэгээд буцчих юм. Одоо бас өвдлөө.

За түргэн аль.

Хёр цагт би юм идэхээр гарч явав. Кафе гуанзанд хэдэн хүн суух бөгөөд ширээн дээр кофе цай киршвассер дарстай хундага байна. Би нэгэн ширээнээ очиж суув

-Юу байна гэж би зөөгчөөс асуулаа.

-Хоёрдугаар хоол дууссан

-Шөлгүй хоол байхгүй юм уу?

-chouroute<sup>37</sup> хийж болно

-Тэгтэл пиво choucroute хоёр авъя.

-Аягыг авах уу, хагас аягыг авах уу?

-Аяга цагаан пиво авъя

Зөөгч нэг хувь Sanerkrout<sup>38</sup> татсан мах, зайдас, дарс шингээсэн байцаатай авчрав. Би байцаа идэж, пиво уув. Өлссөн гэж жигтэйхэн. Би гуанзанд буй хүмүүсийг ажиглав. Нэг ширээн дээр хөзөр тоглоно. Хажуугийн ширээнд хоёр эрэгтэй хүн сууж тамхри ататаж ярилцана. Гуанзанд битүү утаа дүүрчээ. Өглөөгүүр миний цайлсан лангууны тэнд одоо, нэг өвгөн, мөн хүмүсст өгч буй зүйлсийг ажиглан кассны дэргэд суугаа хар хувцастай бүдүүн авгай, мөрөвтэй нэг хөвүүн гурвуул байлаа. Тэр авгай хэдэн хүүхэдтэй бол, яаж төрүүлсэн бол гэж би бодно.

Би chouc route идэж дуусаад, эмнэлэг тийш буцав.

Гудамжинд маш цэвэршээд хогтой хувин алга болжээ. Үүлтэй өдөр боловч наран гарах янзтай. Би цахилгаан шатаар өгсөж гараад гудмаар явж, цагаа халааза

---

<sup>11</sup> Байцаатай зайдас гэсэн франц иг.

<sup>22</sup> Дарсан байцаа гэсэн герман иг



тавьсан Кэтриний тасалгаанд оров. Халаазаа өмсөөд ар захы нь сүлбээрлэж толинд харав. Би яг л сахалтай өвгөн болжээ. Би гудмаар явж төрөхөд очив. Хаалга нь түгжээтэй тул тогшсонд хариу үл дуугарна Бариулы нь мушгиад орвол Кэтриний дэргэд эмч сууж, тасалгааны нөгөө буланд сувилагч юм хийнэ.

-Нөхөр чинь ирлээ гэж эмч хэлэв.

-Найзаа, ийм сайхан эмч байх гэж Кэтрин тун хачин дуугаа өгүүлээд цааш яриьсан нь: Эмч наадд сайхан шог ярьсан. Их өвдөхөд бүр мэдрэлгүй юм шиг болгосон. Сайн эмч. Та сайн эмч юмаа гэв.

-Чи мансуурчээ гэж би хэлэв.

-Би мэдэж байна. Гэхдээ энэ тухай ярихын хэрэггүй гэж хэлснээ Кэтрин: Бушуухан аваад аль бушуухан аль гэв.

Тэгээд баг зууран барьж, түнхэлзтэл түргэн түргэн амьсгалав. Тэгээд гүн сүүрс алдахад нь эмч зүүн гараа сунгаж багий нь авлаа.

-Тун хүчтэй өвдлөө гэж Кэтриний хэлэх нь хачин сонсдоно. Тэгээд тэр: найзаа би одоо яасан ч үхэхгүй. Үхэхээр хүнд аюулы нь давсан. Чи баярлаж байна уу? гэв.

-Бүү л дахиасай.

-Дахихгүй. Гэхдээ би айгаагүй шүү. Найзаа, би үхэхгүй.

-Чи тэгэж тэнэг юм хийхгүй. Чи үхэхгүй. Нөхрөө ганцаардуулж орхихгүй гэж эмч хэлэв.

-Үгүй ээ, үгүй. Би үхэхгүй. Би үхэх дургүй. Үхнэ гэдэг тэнэг хэрэг. За дахиад өвдлөө. Алив түргэн өгөөрэй гэв.

Тэгээд хэсэг зуур болоод эмч ийн өгүүлрүүн:

-Генри гуай та, хэдэн минут гарч бай. Би эхнэрий чинь үзье гэв

-Эмч яаж байгаагий нь үзэх гэж байна. Чи сүүлд ороод ирээрэй. Болох уу, эмчээ гэж Кэтрин хэлэв.

-Болноо. Би хүн явуулъя гэж эмч хэллээ.

Би төрөхөөс гарч гудмаар яваад Кэтринг хүүхдээ гаргасны дараа авчрах ёстой тасагт орж сандал дээр суугаад тасалгааны байдлыг ажиглав. Цай уух гэж явахдаа худалдаж авсан сонин халаасанд байсан тул гаргаж уншив. Гадаа харанхуй болж байлаа. Би сонин унших гэж гэрэл асаав. Хэсэг уншиж байснаа больж, гэрэл унтраагаад харанхуй болж буйг цонхоор харав. Эмч яагаад намайг ир гэж хэлүүлэхгүй байна вэ. Миний байхгүй нь дээр байсан юм бловуу. Намайг явуулах гэж тэр лав бодсон биз. Би цагаа харлаа. Хэрэв дахиад арван минут болоход хэн ч ирэхгүй бол би тийшээ заавал очно.

-хөөрхий муу. Кэт минь дээ. Хамт унтахад сүүлдээ ямар их гамшиг ирдэг байна даа. Ингээд л яах ч аргагүй болдог байна даа. Нэг нэгэндээ дурласны эцэс нь энэ үзэ дээ. Амьсгалуулах хий гарсан нь бас л их хэрэг. Үүнээс урьд ер ямар байсан бол доо? Эхлээд л тээрэмд орсон юм шиг болно. Жирэмсэн байхдаа Кэтрин харин их хөнгөн явсан шүү ашгүй дээ. Эмзэглэж ч байгаагүй. Хамгийн сүүлчийн мөч хүртэл ер тэглээ ингэлээ гэсэн юмгүй байсансан. Тулгарч ирээд л болохоо байлаа даа. Зайлах ч замгүй биз. Эр эмийн явдал гэж энэ дээ. Тавь дахин гэрлэсэн ч энэ л янзаар байна. Хэрэв үхчихвэл яах билээ. Үхэхгүй байх аа. Одоо төрөхөөс болж үхэх явдал байхгүй болсон. Эргүүл цөм л ингэж боддог. Гэтэл үхчихвэл яах билээ? Үхэхгүй байх аа. Хэцүү л байгаа даа. Анхны төрөлт голдуу хүндрэлтэй гэдэг. Хэцүүхэн л байгаа даа. Их хэцүү байсан гээд сүүлд би ярина. Тийм ч хэцүү байгаагүй гэж Кэтрин хэлнэ. Хэрэв үхчихвэл яах билээ? Үхэх ёсгүй. Хэрэв гэнэт үхчихвэл яах билээ? Тэгэх ёсгүй гэж байна шүү. Би тэнэглэ! Зүгээр л хэцүүхэн байгаа. Энэ чинь зүгээр л байгалиас засан шаналгаа шүү дээ. Эхний төрөлт голдуу хүндрэлтэй байдаг шүү дээ. Гэтэл гэнэт үхчихвэл яах билээ? Үхэх ёсгүй дээ. Яагаад үхэх ёстой билээ. Үхэх ямар шалтгаан байна вэ? Зүгээр Милан хотын шөнийн бүтээгдэхүүн болсон хүүхэд төрөх

ёстой. Одоо түүнээс болж цөхөрч байна. Гэтэл хүүхэд төрчихнө. Тэр хүүхдээ асарна. Тэгээд хайрлаж эхэлнэ. Төрөхөд аюултай юм байхгүй. Хэрэв гэнэт үхчихвэл яана вэ? Үхэх ёсгүй. Хэрэв гэнэт үхчихвэл яах билээ? Тэгвэл яах билээ? Гэнэт үхчихвэл яах билээ?

Гэтэл эмч орж ирлээ.

-Эмч ээ яаж байна?

-Яагаа ч үгүй

-Одоо тэгээд яах вэ?

-Яах ч юмгүй. Би сая сайн үзлээ... гээд шинжилгээний дүнгийн талаар тодорхой ярьж: Тэгээд жаахан хүлээжээ. Урагш болохгүй байна даа гэж хэлэв.

-Тэгээд яавал зохих вэ?

-Нэг бол гардаж авна. Эсхүл хагалж авна. Ийм л хоёр зам байна. Гардаж авахад задрах аюул их бий. Хүүхэд ч бүр хамаагүй болно. Эхдээ бас их аюултай.

-Хагалахад хир их аюултай вэ?

Хэрэв үхчихвэл яах билээ?

-Жирийн төрөхтэй л ойролцоо

-Та өөрөө хийх үү?

-Тэгнэ. Хэрэгтэй хүн дуудаж, юм бэлдэхэд цаг орчмын хугацаа хэрэгтэй. Цаг ч хүрэхгүй.

-Танд яавал дээр байна.?

-Би хагалгаа л дээр гэж үзнэ. Хэрэв энэ миний эхнэрсэн бол би хагалгаа л хий гэнэ.

-Сүүлдээ яах вэ?

-Яах ч юмгүй. Сорви үлдэнэ.

-Халдвар гарах уу?

-Гардаж авахад халдвар илүү их гардаг аюул бий.

-Зүгээр хүлээвэл яасан юм бэ?

-Хэзээд л юм хийх хэрэгтэй болно.

Хатагтай Генри одоо их тамирдаад байна. Аль болох л хурдан мэс засал хийвэл дээр шүү.

-Тэгвэл аль болох л хурдан хий гэж би хэллээ.

-Одоохон юмаа янзалъя гэв.

Намайг төрөхөд ороход, Кэтрин том цагаан даавуугаар бүтээлэгтэй, их цонхийж ядраад ширээн дээр хэвтэж, дэргэд нь сувилагч байна.

-Чи зөвшөөрөв үү гэж Кэтрин асуулаа.

-Тэглээ.

-Сайн байна. Цагийн дараа л зүгээр болно. Найз минь би бүүр тамирдаад байна шүү. Одоо чадал алга. Алив түргэлээч. Нэмэр алга. Бурхан минь нэмэр алга.

-Гүн амьсгал

-Амьсгалж байна. Бурхан минь, ердөө тус алга. Тус алга.

-Өөр хий өгөөч гэж би сувилагчид хэлэв

-Наадах чинь шинэ тавьсан юм.

-Найзаа, би их тэнэг шүү дээ. Энэ чинь ердөө тус болохгүй байна гэж Кэтрин хэлээд уйлав. Тэгээд тэр ийн өгүүлрүүн:

-Би хэнд ч гэм болохгүйгээр хүүхэд төрүүлье гэж бодсон юмсан. Одоо надад ерөөсөө тамир алга. Бүр хүчгүй болжээ. Хий огт тус болохгүй байна. Найзаа, хий огт тус болохгүй байна. Үхсэн ч яахав, бушуухан л зүйл дуусаасай. Найз минь дээ бушуухан л зүйл дуусгах арга хийж үзээч. Дахиад л өвдлөө. Ээ, ээ, ээ гэж баг өмссөн эхнэр эхэр татсанаа. Тус болохгүй байна. Тус болохгүй байна. Тус болохгүй байна гэж гурав хэлээд найз минь бүү зов. Битгий уйл. Бүү зов. Чадал минь тасарчээ.

Хөөрхий минь дээ. Би чамд дэндүү хайртай. Одоо нэг оролдоод үзье. Өөр аргагүй юм болов уу? Өөр л нэг жаахан дэмжээд өгвөл учир байна санж.

-Би энэ хийг чинээнд нь тултал шахаад нэг үзье. Тэгвэл болох байх.

-За одоо шах

-Би хүрдий нь тултал эргүүлэв. Гүн татан амьсгалахад нь баг барьсан хуруу нь базална. Би аппарат унтрааж багий нь авав. Кэтрин туйлдаж ядарсан байв.

-Найзаа, яасан сайн болов оо: Чи минь ийм л сайн даа.

-Тэсэж үз. Чи минь зоригтой шүү дээ. Би дандаа ингэж бас чадахгүй шүү дээ.

Чамд хор ч болж болно.

-Найз минь зориг алдарчээ. Би бүр туйлдаж гүйцжээ. Одоо л би мэдэж байна.

-Хүн бүр л ийм болдог шүү дээ.

-Энэ ч их аюултай юмаа. Бүр туйлдтал нь шаналаах юм.

-Нэг л цаг хүлээх байна.

-Яасан сайн юм бэ! Найзаа би үхэхгүй Тийм биз?

-Үгүй. Чамайг үхэхгүй гэж би амлана.

-Би чамайг ганцаарангий чинь орхиод үхэх дургүй байна. Гэхдээ их ядраад үхмээр санагдаж байна.

-Бүү дэмий юм бод. Хүн бүрд л тэгж санагдаг юм.

-Тэгэж л санагдаад байна даа.

-Тэгэхгүй. Тэгэх ёсгүй.

-Хэрэв тэгвэл?

-Би тэгүүлэхгүй.

-Одоо нэг үзье. Алив түргэхэн гэснээ дахиад л ийн өгүүлрүүн

-Би үхэхгүй. Би биеэ барьж чадна.

-Чи үхэхгүй шүү дээ.

-Чи цуг байх уу?

-Тэгнэ. Гэхдээ би харж чадахгүй

-Сайн байна. Хамрин чи бүү гараарай.

-Үгүй, үгүй. Би хаашаа ч явахгүй.

-Чи минь ийм л сайн. Одоо дахиад нэг үзье. Бас дахиад тус болохгүй байна!

Би эхлээд гурван тоо, дараа нь дөрвөн хүртэл хүрдий нь эргүүлэв. Эмч хурдхан ирээсэй гэж бодогдов. Хоёроос дээш тоо хүртэл эргүүлэхээсээ би айсан юм.

Тэгтэл өөр нэгэн эмч, хоёр сувиагч ирж, Кэтринг дугуйтай дамнуурган дээр тавиад бид түргэн явж, цахилгаан шатанд ороод зай тавьж, хананд шахан зогсоцгоож дээш өгсөн гарч, талбарт буугаад, гудмаар бөмбөгөн дугуйтай явж мэс заслын өрөөнд оров. Баг зүүж малгай өмссөн болохоор нь би эхлээд эмчийг таньсангүй. Тэнд мөн нэг өөр эмч, бас сувилагчид байлаа.

-Надад ямар нэг юм өгөөч. Надад ямар нэг юм өгөөч. Эмчээ, нөлөөлж чадах хэмжээний юм өгөөч гэж Кэтрин хэлэв. Нэг эмч нүүрэнд нь баг хийв. Хаалгаар шагайж харвал, мэс заслын бяцхан дугуй талбар хурц гэрэлтэнэ.

-Та тэр хаалгаар орж тэнд сууж хүлээ гэж надад нэг сувилагч хэллээ.

Хашлаганы цаана урт сандлууд байх бөгөөд тэндээс цагаан ширээ, дэнлүү харагдана. Би Кэтринг харав. Нүүр нь баганд хаагдаад хөдлөлгүй хэвтэнэ. Дамнуургы нь урагш түрэхэд би эргэж гудмаар явав. Орох үүдэн тийш хоёр сувилагч яаран явна.

-Хагалгаа хийнэ. Одоо хагалгаа хийх гэж байна гэж нэг нь хэлэв. Нөгөө нэг нь инээгээд:

-Бид яг цагтаа иржээ. Овоо шүү гэж хэлэв. Тэгээд тэд хаалгаар оров. Бас нэгэн сувилагч яарч ирээд:

-Ор, ор. Та ор гэж хэллээ.

-Би энд хүлээе гэв

Тэр хүүхэн яаран оров. Би гудмаар хойш урагш хөлхөв. Орохоос айдас хүрнэ. Цонхоор харвал гадаа харанхуй бөгөөд цонхны гэрэлд бороо орж харагдана. Тэгээд би гудамны нөгөө үзүүрийн нэгэн тасалгаанд орж шилэн шүүгээнд буй лонхны бичгийг уншив. Тэндээс гарч, эзгүй гудамд зогссоноо мэс заслын өрөөний хаалгыг харлаа.

-Хоёрдахь эмч, нэг сувилагч дагуулан гарч ирэв. Тэр эмч, дөнгөж өвчсөн чандага мэт юм хоёр гардан барьж гудмаар яаруухан өнгөрөөд өөр хаалганд оров. Би тэр хаалганд хүрч очвол, тэд нялх хүүхдийг оролдон байв. Эмч, тэр хүүхдийн хөлөөс өргөн надад харууллаа.

-Зүгээр үү? гэсэнд

-Сайхан хүү. Таван кило хүрэх байх гэв.

Тэр надад ер юман чинээн санагдсангүй.

Надтай тэр ямар ч холбоогүй мэт бөгөөд надад эцгийн хайр огтоос төрсөнгүй.

-Хүүгээ бахархахгүй байна гэж үү? Хэмээн сувилагч асуулаа. Тэр хүүхдийг тэд угааж юманд хулдана. Бяцхан бараан нүүр, бараан гар харагдавч, дуу ер гарахгүй, огтоос хөдлөхгүй аж. Эмч дахиад түүгээр оролдож, тун халамжилсан янзтай байна.

-Үгүй энэ эхийгээ алах шахлаа шүү гэж би хэлэв.

-Энэ муу хүүхэд түүнд ямар юмны нь буруу байх билээ. Та хүүтэй болохсон гэж хүсээгүй юм уу?

-Үгүй гэж би хэлэв. Эмч аанаа түүгээр оролдсон хоёр хөлөөс нь өргөн алгаар илэн цохилно. Би түүнийг бүр харахаа больж гудамж гарав. Би орж хармаар санагдав. Би гол хаалгаар орж, хэдэн гишгүүр уруудав. Хашлаганы дэргэд сууж байсан сувилагчид намайг ойрт гэж дохив. Би толгой сэгсэрлээ. Миний байсан газраас сайтар харагдаж байв.

Надад Кэтрин үхсэн юм шиг санагдлаа. Тэр үхсэн янзтай харагдана. Надад харагдаж буй нүүрийн хэсэг нь зэгэл сааралтана. Доод талд нь дэнлүүний гэрэлд хямсаагаар хавчсан, зузаан захтай өргөн урт шархыг эмч оёж байна. Өөр эмч багт нь наркоз хийнэ. Баг өмссөн хоёр сувилагч багаж авч өгнө. Энэ байдал нь хатуу шүүлтийг үзүүлсэн зураг мэт ажээ. Тэнд байж би бүгдийг харж болох боловч хараагүйдээ их баярлана. Эхэлж зүсэхэд нь би лав харж зүрхлэхгүй байсан биз. Гэвч одоо би, тэрхүү гуталчны уллах ажилтай төстэй, хурдан шалмаг гарын хөдөлгөөнөөр шархны зах нийлж, хөндөлдсөн өргөн зүсэм үлдэж буйг хараад баяртай байна. Шархны зах нийлж гүйцэхэд би гудамд гарч дахиад л урагш хойш холхив. Жаахан байтал эмч гарч ирэв

-За яаж байна? гэсэнд

-Зүгээр, та харсан биз дээ? гэв

Тэр эмч ядарсан харагдана.

-Та нарын оёхыг харсан. Их урт огтолсон санагдсан.

-Тэгэж санагдав уу?

-Тийм, сорви нь сүүлдээ тэгшрэх үү?

-Тэгшрэхгүй яахав

-Хэсэг болоод дамнуурга гулсан гарч ирж гудмаар тун түргэн явж цахилгаан шатан тийш очив. Би зэрэгцэн дагав. Кэтрин ёолно. Доор тасагт нь оруулж оронд нь хэвтүүлэхэд би хөлийн нь тэнд сандал тавьж суув. Сувилагч бас байв. Би босож дэргэд нь очив. Тасаг дотор харанхуй байв. Кэтрин гараа өгөв.

-Найзаа, чи энд байна уу? гэж тэр хэллээ. Дуу нь маш сульдаад ядарсан байна.

-Би байна

-Ямар хүүхэд вэ?

-Чишш, бүү яриарай гэж сувилагч хэллээ.

-Хүү, урт, тарган, бараан хүүхэд

-Бие нь зүгээр үү?

-Зүгээр. Сайхан хүү гэж би хэлэв

Намайг сувилагч гайхсан янзтай харав.

-Би жигтэйхэн ядарчээ. Хамаг бие хачин өвдөөд байна. Найзаа чи яаж байна?

гэж Кэтрин хэлэв

-Сайн байна. Бүү яриарай.

-Чи минь сайн шүү. Найзаа хамаг бие өвдөөд байна. Хэнтэй адилхан хүүхэд вэ?

-Үрчийсэн хөгшний нүүртэй, өвчсөн чандага шиг юм байна билээ.

-Та гарч бай. Хатагтай Генри ярьж болохгүй гэж сувилагч хэллээ.

-Би гудамд байя гэж би хэлэв

-Явж юм иддээ.

-Үгүй. Би гудамд байя

Би Кэтринг үнсэв. Нүүр нь тун их зэвхийгээд ядарсан, зовсон байна.

-Түр уулзъя гэж би сувилагчид хэлэв. Надтай цуг сувилагч гудамд гарч ирэв.

Хаалганаас жаахан холдоод би:

-Хүүхэд нь яасан бэ? гэж асуулаа.

-Та мэдээгүй гэж үү?

-Үгүй

-Амьгүй хүүхэд байсан

-Үхсэн байсан гэж үү?

-Амьсгаа оруулж чадагүй. Хүй нь хоолойгий нь ороочихсон байсан.

-Үхсэн байсан хэрэг үү?

-Тиймээ. Харамсалтай юм даа. Сайхан том хүүхэд байсан. Би таныг мэдсэн гэж санасан.

-Үгүй. Та хатагтай руу ор доо гэж би хэлэв.

Төмөр утсан үдээстэй сувилагчдын бүртгэл дээр нь хэвтэж буй жижиг ширээний өмнөх сандал дээр сууж би цонхоор харав. Цонхны зурвас гэрэлд цайлалзах бороо, хав харанхуйгаас өөр гадаа харагдах юм ер алга. Ай хөөрхий, хүүхэд нь үхсэн байдаг байжээ. Тэгээд л эмч тийм ядарсан байж шүү дээ. Яагаад тэд тэр тасалгаанд оролдоод байв аа? Амьсгаа орж амьдарна гэж горьдсон хэрэг байх нээ. Би сүсэгтэн биш боловч тэр хүүхдийг гэрээслүүлэх хэрэгтэй. Ганц ч удаа амьсгал аваагүй бол яана? Ялгаагүй тэр хүүхэд Кэтриний биеэс салаад ер амьдарсангүй. Гэдсэндээ хөдлөхийг нь би дандаа мэдэрдэгсэн. Сүүлийн хэд хоног хөдлөөгүй. Тэгэхэд л амьсгаа хурааж дээ. Хөөрхий зайлуул! Би тэр хүүхэд шиг амьсгаа хураах маань ч яавдаа. Харамсах ч юм биш дээ. Энэ бүх үхлийг үзэхгүй байх байсан боловч харамсаад яахав. Одоо Кэтрин үхнэ. Ингээд л бүх юм үхлээр дуусдаг байжээ. Яагаад тэр билээ. Бүү мэд Мэдэж ч амжихгүй. Ердөө л чи амьдралд шидэгдэж, хувь тавилангаа амсаж, эн түрүүнд л гэв гэнэтэд алагдана. Аймо шиг тэнэсэн суманд өртөж алагдана. Эсхүл Ринальди шиг тэмбүүрнэ. Ер эрт орой хэзээ боловч алагдана. Чухам үүнд итгэж болно. Суугаад үхлээ хүлээ.

Нэгэнтээ би ойд түр амрах зуур шатааж буй түүдэг рүү шоргоолж язганасан шиндүү хийж билээ. Шиндүү шатахад шоргоолжнууд гадна талаар нь гүйж, галтай гол руу нь бөөгнөрөөд тэндээсээ буцаж, шиндүүний уг руу гүйлдэв. Уган дээр нь дэндүү олноор шавааралдаад галд унаж эхлэв. Зарим нь зайлж амжаад түлэгдсэн, утагдсан биетэй, хаашаа яваагаа мэдэхгүй буцаж мөлхөнө. Ихэнх нь гал руу мөлхөөд

тэндээсэ бас буцаж, хүйтэн уг дээр шахцалдан галд унана. Гал дотроос тэр шиндүүг авч, шоргоолж газар гарч болохоор зайлуулж хаявал ариун үйл болно гэж тэгэхэд би бодож байж билээ. Тэгээд олны амьдралтай бас адил юмдаа гэж санаж байж билээ. Тэгэхийн оронд харин би виски дарс хийж усаар найруулах гэсэн төмөр аягаа зайлж усы нь шиндүүн дээр асгасан юм. Халуун шиндүүн дээр цацсан ус гагцхүү шоргоолжнуудыг уураар утсан буйзаа.

Би гудамд сууж Кэтриний байдлын тухай мэдээ хүлээнэ. Сувилагч гарч ирэхгүй л байв. Хэсэг суугаад би босож хаалганд нь очиж, чимээгүйхэн нээж харав. Гудамд хурц гэрэлтэй, тасалгаанд харанхуй тул эхлээд юу ч үзэгдэхгүй байв. Тэгтэл орны дэргэдэх сандал дээр суугаа сувилагч блон дэрэн дээрх Кэтриний толгой, цагаан даавуун дор гулдайсан биеийг олж харав. Сувилагч амандаа хуруугаа хүргэж чимээгүй гэсэн дохио өгөөд, босож үүдэнд хүрч ирхэв.

-За яаж байна? гэж би асуулаа.

-Зөв зүгээр байна. Та явж хооллоод дараа нь ирж болно шүү дээ гэж сувилагч хариулав.

Би гудмаар явж, шатаар буугаад эмнэлгийн хаалгаар гарч, бороон дундуур харанхуй гудамжаар, кафе гуанз тийш явав. Кафе, гуанз хурц гэрэлтэй, ширээ дүүрэн хүнтэй байлаа. Суудал олж ядан байтал, зөөгч, ирж миний нойтон хувцас малгайг аваад, нэгэн ахимаг хүн пиво ууж, оройн сонин уншиж буй ширээний сул суудлыг заав. Би тэнд сууж, өнөөдөр ямар Plat lu jour<sup>39</sup> буйг зөөгчөө асуув

-Тугалын мах байснаа дуусчихлаа

-Өөр ямар хоол байна?

-Шарсан өндөр, бяслагтай өндөг, бас choucroute идсэн гэж би хэллээ.

-Тийм, тийм, Өнөө өглөө та choucroute идсэн гэж тэр хэллээ.

Тэр хүн дунд хийрийн насны бөгөөд халзан толгойныхоо үсийг гөлийтөл самнасан, аятайхан царайтай болой.

-Юу авах вэ? Шарсан өндөг үү, бяслагтай өнөг үү?

-Шарсан өндөг, пиво авъя гэж би хэллээ.

-Demi-blonde

-Тийм гэж би хэллээ.

-Би санаж байгаа биз. Өглөөгүүр та бас Demi-blonde захисан шүү дээ гэж тэр хэлэв.

Би шарсан өндөг махтай идэж пиво уув. Дугуй тавагт дор нь марххийж дээр нь өндөг тавьж өгчээ. Их халуун хоол учир нэг хэрчим үмхээд, пиво балгаж амаар хөргөхөд хүрэв. Өлсөж байсан тул дахин нэг хоол заахиж аяга пиво уулаа. Би ер юм бодолгүй, зэргүүдээ хүний барьж буй сонинг л уншиж байлаа. Фронт дахь английн хэсгийн цөмөрсөн тухай тэр сонинд бичжээ. Тэр хүн намайг сонингоо уншиж буйг мэдээд эргүүлэв. Би зөөгчөөс сонин гуйя гэж бодсон боловч эв нь олдохгүй байлаа. Тэнд халуун бөгчим аж. Ширээ тойрон суугаа улс ихэнхдээ танил юм. Хэдэн ширээний цаана хөзөрдөж байв. Ундаан зөөгч лангуу ширээ хоёрын хооронд хурдавчилна. Хоёр эрэгтэй хүн орж ирээд суудал олохгүй миний ширээний эсрэг зогсоход би пиво захив. Би бас л гарах болоогүй. Эмнэлэгт эргэж очиход эрт байна. Би юу ч бодохгүй амгалан тайван байх гэж хичээнэ. Орж ирсэн хоёр хүн хэсэг зогсож байгаад босох хүн үгүйд гарч одов. Би бас пиво уулаа. Өмнөх ширээн дээр сав суулга хураав. Өөдөөс минь хаж суусан хүн саравчаа авч гэрэнд нь хийгээд сонингоо эвхэж халаасанаа шургуулан ликер архитай хундага барьж ийш тийшээ харна. Гэтэл би явмаар санагдав. Тэгээд би зөөгчийг дуудаж мөнгө төлөөд пальтоогоо өмсөж,

---

<sup>11</sup> Тогтмол хоол гэсэн франц ир

малгайгаа аван гудамжинд гарч, бороон дундуур явж эмнэлэгт ирэв.

Дээд давхрын гудамд сувилагчтай дайралдав.

-Би сая таныг сураглаж буудалд утасдлаа гэж тэр хэлэв.

Дотор минь өмрөх шиг болов.

-Юу болоов?

-Хатагтай. Генри цус алдсан

-Би орж болох уу.

-Одоо болохгүй. Эмч тэнд байна.

-Аюултай юу?

-Тун аюултай.

Тэгэж хэлээд сувиалагч орж хаалга хаав. Би хаалганы хажуу гудамд сууна. Дотор минь бр цөлмөрч гүйцэв. Бодох ч юм алга. Бодох чадал ч алга. Би Кэтринг үхнэ гэж бодож, бүү үхээсэй гэж залбирна. Бүү үхүүлж үзээч. Ээ бурхан минь бүү үхүүлж үзээч. Хүссэн бүхний чинь би биелүүлнэ. Гагцхүү түүний минь бүү үхүүлж үзээч. Ээ, ариун бурхан минь түүний минь бүү үхүүлж үзээч. Ээ ариун бурхан минь, түүний минь бүү үхүүлж үзээч, Ээ бүү үхүүлж үзээч. Бурхан үхэхгүй юм хийж хайрлаач. Би бүхнийг гүйцэлдүүлнэ. Гагцхүү түүний минь л бүү үхүүлж үзээч. Чи хүүхдий нь авлаа шүү дээ. Түүний минь л бүү үхүүлж үзээч. Хүүхдий нь авах ч яахав. Гагцхүү түүний минь л бүү үхүүлж үзээч. Бурхан минь ээ, ариун бурхан минь, түүний минь л бүү үхүүлж үзээч.

Сувилагч хаалга нээж намайг ор гэж дохив. Би дагаж орлоо. Намайг ороход Кэтрин харсангүй. Би орны нь дэргэд очив. Эмч орны нь нөгөө талд зогсоно. Кэтрин намайг хараад инэмсэглэв. Би орон дээр нь тонгойж уйлав.

-Хөөрхий минь дээ гэж Кэтрин тун аяархан хэлэв. Нүүр нь цонхийжээ.

-Кэт ээ, зүгээр ээ. Удахгүй бүх зүгээр болно гэж би хэллээ.

-Удахгүй би үхнэ гэж тэр хэлэв. Хэсэгдуугүй байснаа. Би үхэх дургүй байна гэж хэллээ. Би гараас нь барив.

-Надад бүү хүр гэж тэр хэлэв. Би гары нь тавив. Тэгээд тэр инээмсэглэж Хөөрхий минь, хүрэхээр л хүр дээ гэв

-Кэт ээ, зөв зүгээр болно. Зөв зүгээр болно гэж би мэдэж байна.

-Юу ч болж мэднэ гээд би чамд захиа бичих гэснээ бичээгүй юм.

-Би лам дуудах уу, өөр хүн дуудах уу?

-Чи л байвал боллоо гэж тэр хэлэв

Тэгээд хэдэн минут болсноо –Би айхгүй байна. Харин үхэх л дургүй байна гэв

-Ингэж их ярьж болохгүй гэж эмч хэлэв.

-За больё гэж Кэтрин хэлэв

-Кэт ээ, юу хэрэгтэй байна? Чамд юу өгөх вэ? гэхэд минь Кэтрин инээмсэглээд: зүгээр гэв. Тэгээд хэдэн минут болсноо. Чи өөр хүүхэнтэй яг л над шиг байх уу? Бидний ярьдагийг ярих уу? Хэл дээ гэв

-Хэзээ ч үгүй

-Харин би чамайг хүүхэнтэй болоосой гэж бодох юм.

-Надад өөр хүүхэн хэрэггүй.

-Та дэндүү их ярьж байна Monsieur Генри гарвал таарна. Сүүлд дахиад орж ирж болно. Та үхэхгүй. Дэмий юм бүү ярь гэж эмч хэллээ.

-За гээд Кэтрин –Би шөнийн цагаар чамтай уулзаж байя гэв. Тэр тун зовж ярьж байлаа.

-Та одоо гар даа. Энд ярьж хэрэггүй гэж эмч хэлэв. Кэтрин над руу нүд ирмэв. Царай нь бүүр цонхийжээ.

-За яах вэ би гудамд байя гэж би хэллээ.

-Найзаа бүү гомдорой. Би дуслын төдий ч айхгүй байна. Даанч хатуу тоглоом

юм даа гэж Кэтрин хэлэв.

-Хайрт минь чи зоригтой хүүхэнсэн гэж би хэлэв.

Би гадаа гудамд хүлээв. Удаан хүлээсний эцэст сувилагч гарч ирэв.

-Хатагтай Генри их муу байна. Би төлөөнөөс нь айж байна гэж тэр хэллээ.

-Үхчихэв үү?

-Үгүй. Гэхдээ ухаан алджээ гэв. Янз нь дахин дахин цус алдаад тогтохгүй байх шиг байна. Би тасалгаанд орж үзэхээс нь өмнө Кэтриний дэргэд зогсов. Дахиад тэр ухаан оролгүй байсаар эцэслэв

Гудамд гараад би эмчээс:

-Өнөөдөр яах вэ? гэж асуув

-Яах ч хэрэггүй. Таныг буудалд тань хүргэх үү?

-Зүгээр, хэрэггүй. Би энд бас жаахан байя.

-Юу гэх ч үг алга даа.

-Тиймээ. Юу ч гэх үг алга гэж би хэллээ.

-Баяртай. Ер нь би таныг хүргэж өгөх үү? тэж тэр хэлэв.

-Зүгээр баярлалаа.

-Өөр яах ч аргагүй байв. Мэс засал тийм боллоо... гэж тэр хэлэв.

-Энэ тухай яриад ч яахав гэж би хэллээ.

-Би таныг буудалд тань хүргэж өгмөөр байна.

-Зүгээр, баярлалаа.

Тэгээд тэр гудмаар явж, би тасалгааны үүдэнд эргэж ирэв.

Одоо хэрэггүй гэж нэг сувилагч хэлэв.

-Болно гэж би хэлэв

-Болохгүй. Арай болоогүй.

-Хэн хэн нь эндээс зайлцгаа гэж би хэлэв

Тэднийг зайл гэж хөөгөөд хаалга хааж, гэрэл асаахдаа би ингээд ч нэмэргүй юм даа гэж болоо. Хөшөөтэй л салах ёс гүйцэтгэх лугаа адил ажээ. Хэсэг зуур байгаад би гарч шатаар бууж, бороон дундуур буудал тийшээ явав.

[Тор](#)

Эх сурвалж:

[www.e-pada.com](http://www.e-pada.com)

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf хэлбэр уруу хөрвүүлсэн:

The Weatherman

<http://weatherman.blog.banijq.net/>